

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
9 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 181
1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	10 – 26
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	26 – 181

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 81 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Д.Батлут, Ж.Баясгалан, Д.Ганмаа, Л.Мөнхбаатар, Д.Пүрэвдаваа, А.Ундраа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: С.Одонтуяа, Л.Энхнасан;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Ч.Лодойсамбуу;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан – 1 цаг 35 минут, Н.Алтаншагай – 48 минут, С.Амарсайхан – 56 минут, Д.Батбаяр – 2 цаг 08 минут, Ж.Батсуурь – 46 минут, Н.Батсүмбэрэл – 18 минут, Б.Батцэцэг – 46 минут, Ж.Бат-Эрдэнэ – 11 минут, Х.Болормаа – 02 минут, Ж.Галбадрах – 01 минут, А.Ганбаатар – 15 минут, Д.Ганбат – 10 минут, Ц.Даваасүрэн – 12 минут, Т.Доржханд – 1 цаг 12 минут, Б.Дэлгэрсайхан – 01 минут, Б.Жаргалан – 14 минут, Ж.Золжаргал – 14 минут, Ц.Мөнхбат – 2 цаг 03 минут, Ц.Мөнхтуяа – 03 минут, П.Наранбаяр – 06 минут, Р.Сэддорж – 05 минут, Н.Учрал – 08 минут, Д.Цогтбаатар – 32 минут, Ж.Чинбүрэн – 53 минут, Б.Чойжилсүрэн – 07 минут, Л.Энх-Амгалан – 49 минут, Б.Энхбаяр – 15 минут, Ж.Энхбаяр – 42 минут, Р.Эрдэнэбүрэн – 2 цаг 15 минут.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд

Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Ууганбаяр, А.Энхбат, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Захиргаа, санхүүгийн газрын дарга Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Г.Ганболд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Батжаргал, П.Батчимэг, Ч.Номин, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Түвшин, Ц.Мөнхтуяа, Д.Ганбат, С.Эрдэнэбат, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Ууганбаяр, А.Энхбат, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Захиргаа, санхүүгийн газрын дарга Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Г.Ганболд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Б.Пүрэвдорж, Д.Үүрийнтуяа, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Х.Ганхуяг, Х.Булгантуяа, Г.Лувсанжамц, Д.Бум-Очир, Б.Бейсен, П.Сайнзориг, Р.Батболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд

Э.Бат-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 17 минут үргэлжилж, 13 цаг 17 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 28 минутад эхлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Үдээс хойших хуралдааныг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан даргалж, 15 цаг 28 минутад Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Д.Рэгдэл, Х.Булгантуяа, Н.Наранбаатар, Ө.Шижир, Да.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Т.Мөнхсайхан, А.Ариунзаяа, Б.Мөнхсоёл, М.Ганхүлэг, С.Зулпхар, С.Эрдэнэбат, Л.Соронзонболд, П.Ганзориг, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 51 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 112 гишүүн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

Ирц 64.3 хувьтайгаар өнөөдрийн нэгдсэн чуулган эхэлж байна.

Өнөөдөр 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдааны чуулганаар өчигдөр хэлэлцэж байсан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг үргэлжлүүлэн хэлэлцэхээр байгаа.

Өчигдөр Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууссан.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлэх нэрсээ өгч, өчигдөр чуулганы хуралдаан дууссанаар өнөөдөр үргэлжлэхээр байгаа. Нэрсийг нь гаргаадахаарай.

Өнөөдөр нийтдээ 5 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ.

Гуравт, “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Дөрөвт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Тавд, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачилгаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэгд. Монгол Улсын засаг цаазат захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 7 гишүүн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Батсайханы Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нийтэлсэн.

Уг өргөдөл 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33 мянга 083 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэхээр байгаа.

Улсын Их Хурлын гишүүд нэр өгсөн дарааллын дагуу үргэлжлүүлэн үг хэлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен.

Б.Бейсен: Гишүүдийн өглөөний мэндийг хүргэе.

Төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсөвтэй холбоотой хэд хэдэн саналаа хэлье.

Эрүүл мэндийн салбарын өр зээлтэй холбоотой асуудал дээр Сангийн яамныхан маань анхаарах шаардлагатай байх гэж бодож байна. Гишүүд та дэмжээрэй. Ялангуяа Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой өр зээл их байна. Жилийн эцэст улам нэмэгдэх байх. Эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээ доголдож байна. Үүнтэй холбоотой. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь дутуу. Ард иргэд маань эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайн авч чадахгүй байна.

Тийм учраас энэ дээр нэлээн анхаарах. Эрүүл мэндийн яамныхан маань энэ дээр Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлт дээр анхаарах шаардлагатай байгаа.

Одоогийн байдлаар эрүүл мэндийн салбарынхан маань нэхэмжлэлээ эрүүл зүгээр идээлээгүй болгоод, идээтэй болгох мэт бичээд нэхэмжлэл явуулж байна. Энэ чинь Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авах аюул тулгараад байна.

Тийм учраас энэ эрүүл мэндийн салбарын өр зээлийн асуудал дээр онцгой анхаараач гээд энэ төсөвтөө тусгаач гэж хүсмээр байх юм. Үүний тулд эрүүл мэндийн салбарын эмнэлгүүдийн бүтэц, орон тооны шинэчлэлийг Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шинэчлэн тогтоохгүй бол энэ чинь гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой аймгийн эрүүл

мэндийн салбарын удирдлагууд дур мэдэн орон тоо батлаад орон тооны хэтрэлт байгаа. Энэ дээр анхаараач ээ гэж хэлмээр байх юм.

Хоёр дахь асуудал. Энэ орон тооны цомхотголын асуудал байгаа. Хаврын чуулган дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд маань 14 мянган албан хаагчийг цомхотгоно гэсэн.

Гэтэл харж байхад яам, Тамгын газрын улсууд цомхотголд орох нь бага. Харин жирийн хот тохижуулах юм уу, олон нийтийн цагдаа, нийгмийн ажилтан цомхотгох аюулд хүрээд байна. Үүний цаана өвөл халаалт ирнэ. Өвлийн идэшний юу байна. Бас хүндрэлтэй асуудал үүсэх гээд байна. Энэ дээр онцгой анхаарахгүй бол энэ ажилчид хэлмэгдэж байна. Нөгөө талаар баруун аймгууд дээр энэ жил зуншлага муу болсон.

Тийм учраас энэ аймгуудад тэр орон тооны цомхотголын асуудал дээр анхаараад, аль эсвэл хасахгүй байх юм уу. Бусад дээр Сангийн яамныхан маань, Засгийн газар анхаарах шаардлагатай байгаа юм.

Нөгөө талаар эрүүл мэнд, боловсролын салбарын хөрөнгө оруулалтаар онцгой анхаарахгүй бол Боловсролын сайд ч ярьж байна, Эрүүл мэндийн сайд ч ярьж байна. Спорт заалгүй гадуур хичээллэж байгаа асуудлууд байж байна. Жишээлбэл, Цэнгэл сумын 3 дугаар сургуулийн спорт заал. Сургууль биш. Сургууль гэдгээр хассан байна. Спорт заалгүй гадаа хичээллээд байна шүү дээ. Хүүхдүүд. Энэ дээр анхаарах шаардлагатай байгаа юм.

Гол нь эргэж эрүүл мэндийн салбар дээр яримаар байх юм. Одоо энэ хотын клиникийн том эмнэлгүүд дээр харвалт, зүрхний шигдээсийн зарим нэг эмнэлгийн хэрэгслүүд байхгүй болоод гаднаас авчирч байна.

Нөгөө талаар тархины харвалт дээр судас доторх бөглөх эмчилгээ байхгүй учраас тархины хагалгаанд ил орж байгаа асуудлууд гарч байна. Үүнтэй холбоотой хүндрэл гарч, эрүүл мэндийн салбарынхан маань, эмч нар маань хэцүү асуудал тулгараад байгаа учраас энэ дээр төсөв дээр нь анхаараад нэмж өгөх талын асуудал байна.

Нөгөө талаар 2026 оны төсөв дээр эрүүл мэндийн салбарынхны цалинг нэмэхгүй бол 35 жил ажиллачхаад 1 сая 700-аас 1 сая 900 мянган төгрөгийн цалин авч байна шүү дээ. Энэ бол үнэхээр амьдралд нь хүрэлцэхгүй байгаа. Инфляцын өсөлт, өргөн хэрэглээний барааны өсөлт, түлш шатахууны өсөлт, халаалт, цахилгааны өсөлттэй холбоотой маш хүнд байдалтай байгаа.

Тийм учраас энэ дээр анхаарна уу гэдэг саналаа хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат. С.Эрдэнэбат гишүүн байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая.

Улс орны төсвийн ирэх оны хүрээний мэдэгдэл, дараа онуудын төсөөллөө бид ярьж байна. Мэдээж, эдийн засаг, нийгмийнхээ үндсэн үзүүлэлтүүдийн бодит боломж, хуулиар тусгайлан зохицуулсан уялдаа, хязгаарууддаа багтаад төсвийн хүрээний мэдэгдлээ боловсруулж орж ирсэн байна.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдэлдээ тулгуурлаж бид төсвөө боловсруулж байгаа. Энэ талаасаа бид нэлээн их цагаа авч байна л даа.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг хангах хүрээнд бодмоор, анхаармаар байгаа ийм зүйлүүд байгаад байгаа юм. Гишүүд маань тал бүрээс нь нэлээн нухацтай ярилаа. Олон сайхан санаа юмнууд өчигдөр гарна лээ.

Тэгэхээр энэ улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, том төслүүд, бүтээн байгуулалтын ажлуудаа бид өрнүүлж байгаа. Гадаад улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд тодорхой төслүүд дээрээ хөрөнгө, санхүү татаж байгаа. Зээл. Үүнийхээ ашиглалтыг бид сайжруулах ёстой. Жишээ нь, газрын тос боловсруулах үйлдвэр гэхэд 2027 оны нэгдүгээр улиралд бараг багтааж ашиглалтад оруулахаар зорьж байгаа. 1.7 тэрбум долларын зээл ашиглалт байгаа. Одоогийн байдлаар 30 орчим хувийн ашиглалттай гэж урьдчилсан тооцоо гардаг.

Тэгэхээр үлдэгдлийг 2026 он дээр ахиу ашиглах ёстой. Бид. Тэгж байж сая энэ үйлдвэр төлөвлөгдсөн хугацаандаа ашиглалтад орох ёстой. Үүнийгээ дагаад тодорхой төсвийн тэнцлийн зөрүү буюу алдагдал гарч байгаа. Би үүнийг зөв гэж ойлгож байгаа. Энэ төсвийн алдагдал гэдэг бол ямар агуулга, ямар бүтцээр гарч ирж байна гэдгийгээ илүү харж, ирээдүйд энэ улс оронд хөгжлийг дэмжих, бас нэмүү өртөг, төсөвт төвлөрөх орлогын бааз суурийг өргөтгөхөд чиглэсэн, өөрөө өөрийгөө аваад явчхаар ийм арга хэмжээнүүд рүүгээ бид аль болохоор өртөг хямдтай эх үүсвэрүүдийг татаж дайчлах, түүнийгээ бүрэн, богино хугацаанд ашиглах асуудал руугаа анхаарлаа төвлөрүүлж ажиллах ёстой.

Тийм учраас би энэ талаас нь харж энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ер нь бид тооцоо судалгааг нь хэлэлцүүлгүүдийн түвшинд дахиж нэг анхаарч хянаж үзээд дэмжих нь зүйтэй юм байна гэсэн ийм бодол санаатай байна гэдгээ нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, эдийн засгийг төрөлжүүлжүүлэх, олон тулгууртай болгох тухай их ярьцгааж байгаа. Бид хэд.

Тэгэхээр энд энэ боловсруулах гэдэг юм уу, аж үйлдвэрийнхээ хувьсгалын чиглэлийн юмыг жоохон ахиу явуулмаар байна.

Ингэхийн тулд тооцоо, судалгаануудаа нэлээн нарийсгамаар байх юм. Заримдаа би бодоод байх юм. Энэ бидний бариад байгаа бодлого дэндүү бодлогын чиглэл дээрээ тулгуурлагдчихаад ажлын баримт бичиг талынхаа юмыг орхигдуулаад байгаа юм биш биз дээ.

5 жилийн үндсэн чиглэл гэж ер нь байх юм уу? Эсвэл 5 жилийн төлөвлөгөө байх юм уу? Төлөвлөгөө нь өөрөө харилцан баланс, тэнцлүүдээ барьсан, тооцоо судалгааны хавсралтуудаа хангасан, тэгээд түүнийгээ барьж ажиллаж байж энэ улс орны хөгжил илүүтэй урагшлах ёстой юм биш биз дээ? Энэ юмнуудыг ер нь бид бодох ёстой юм биш байгаа гэсэн ийм бодол санаа байгаад байх юм. Зүнийг нэг анхаармаар гэж.

Дараагийн нэг зүйл. Энэ өнгөрч байгаа зун нэлээд нутаг орнуудаар гантай, дан дамаа газар тариалангийн бүс нутаг бол нэлээн гантай орчихлоо. Өнөө... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг.

П.Батчимэг: Эрхэм гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе.

Монгол Улсын ирэх жилүүдийн макро эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогын талаар энэ намрын чуулган нээгдээд хоёр өдөр бид ярилцлаа.

Намрын чуулган эхэлсэн өдрөөс эхлээд манай намын завсарлага авсан гол шалтгаан нь хөгжлийн дунд хугацааны бодлого буюу Монгол Улсын ирэх 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэж батлаагүй байхад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, тэр хүрээнд төсвийн орлого, зарлага, тэнцлийн талаар хоёр, гурван жилийн төлөвлөгөөг ярьж эхэлж байгаа нь зарчмын хувьд буруу гэж үзэж байгаа юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.6-д Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, энэ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг гээд заасан байгаа.

Би нэг юман дээр л их гайхаад байгаа юм. Ирэх жилүүдийн энэ хөгжлийн бодлого, чиглэл, стратеги ярьж тодорхойлоогүй байж төсөв, санхүү, хөрөнгө

оруулалт, энэ талаар урьдчилан яриад, хуваарилаад сууж байгаа нь гайхал төрүүлж байна.

Хэрвээ хувийн хэвшилд Та бүхэн өөрсдөө ажиллаж байсан бол хэзээ ч ийм зүйл хийхгүй байх гэж би бодож байна. Иймд нэг бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулах ёстой. Ингэж байж хөгжлийн төлөвлөлт, энэ чиглэлгүйгээр төсвийн хүрээгээ баталж байж сурцгаах хэрэгтэй байна.

Бид эхлээд Засгийн газрын өргөн мэдүүлсэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцсэний дараа ирэх 2026 оны төсвийн төслийг ярих байтал хоёр өдөр энэ төслийг л холиод л хэлэлцээд эхэлсэн. Ийм зарчмаа зөрчөөд явж байгааг энэ байдал илтгэж байгаа юм.

Тэгэхээр энэ талаар дэгийн тухай хуулиар нэг мөсөн зохицуулахгүй бол ерөөсөө болохгүй нь гэж харж байна. Жилийн жилд л төсөв, тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ингээд зэрэг хэлэлцүүлээд байдаг энэ гажиг тогтолцоогоо ер нь хэзээ өөрчлөх юм бэ? Засгийн газар Ерөнхий сайд, Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд нар ирэх жилийн төсвийн төслөө боловсруулаад Улсын Их Хуралд орж ирж танилцуулж байна.

Гэтэл төсвийн төсөл нь тэтгэвэр нэмэх 6 хувь, НӨАТ, буцаан олголт 2-оос 5 хувь гэснээс өөр тийм онцгой зүйл ерөөсөө харагдахгүй байна.

Эдгээр нэмэгдлүүд чинь нэг хүнд 100 мянган төгрөг ч хүрэхгүй. Ингээд энэ нь инфляцад идэгдээд ямар ч үр дүнгүй болох нь харагдаж байгаа юм. Үүнийгээ л их том зүйл, шинэчлэлт, реформ, эхлэлт гээд яриад байгаад болохгүй л дээ.

Тэгээд татварын нөгөө цогц реформ, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн шинэчлэл бодлогууд хаана байгаа юм.

Сүүлийн 8 жилийн хугацаанд энэ олон зүйлийг хийх хугацаа зөндөө л байсан шүү дээ. Энэ хугацаанд та нарын яриад байгаа энэ гоё гоё үгтэй уриа лоозон, энэ мөрөөдлийн үлгэрийг Монголын ард түмэн дийлэхгүй эхнээсээ ядуурах нь ядуураад, бүр ядуураад, өвчин зовлон нь баригдаад үхдэг нь үхээд дуусаж байна.

Хэзээ энэ бүхэн чинь эхлэх юм бэ? Сайд нар аа. Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, хэн хариуцлага хүлээх юм бэ? 2026 оны төсвийн бодлого нь хүний хөгжил, хувийн хэвшил... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү. Ц.Баатархүү гишүүн байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе.

Энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдлийг яг энэ орж ирсэн байдлаар нь цааш нь дэмжих боломжгүй байна гэж үзэж байгаа. Үүнд гурван шалтгаан байна.

Нэгдүгээрт, нүүрсний орлого болон экспортлох биет хэмжээгээ хэт өндрөөр төсөөлсөн байна.

Мэдээж бид бүхэн 90 сая тонн нүүрс экспортлоод нүүрсний үнэ 70 доллар байгаад хэлж байгаагаараа орлогоо олж чадвал бидний хувьд ашигтай, улсын хувьд ашигтай. Хэдий тийм боловч нийгэм, эдийн засгийн байдал ямар байгаа билээ, олон улсын нөхцөл байдлыг таашгүй байгаа энэ үед улс эх орон бол няхуур хандах ёстой.

Хоёрдугаарт, энэхүү төсвийг аж ахуйн нэгж, ард иргэдээ бодсон төсвийн бодлоготой байна гэж харахгүй байна. Яг өнөөдрийн байдлаар энэ төсөв дээр орлогоо нэмэгдүүлэхийн тулд 1.3 их наяд төгрөгийн татварын болон нийгмийн даатгалын орлого нэмэгдүүлсэн байна.

Эдийн засгийн сайд болон Ерөнхий сайд эдийн засгаа дэмжихийн тулд хувийн хэвшлээ дэмжинэ, чөлөөт эдийн засгийг дэмжинэ. Тэр дундаа татварын дарамтыг аж ахуйн нэгж дээр байлгахгүй. Цаашлаад данс хайж байгаа байдлыг зогсооно гэдэг ийм зүйлийг ярьсан.

Гэтэл яг өнөөдрийн байдлаар энэ орж ирж байгаа татварын орлогын болон нийгмийн даатгал даатгалын орлогын нэмэгдэл нь буцаад аж ахуйн нэгжүүд дээр өндөр ачаалал өгөх, үүнээс гадна татварын байцаагч нар татвараа бүрдүүлэхийн тулд дансаа үргэлжлүүлэн хаах, цаашлаад торгууль тавих ийм нөхцөл бүхий бодлоготой орж ирсэн байна.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 100 гаруй мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Энэ үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс 20 гаруй мянга нь алдагдалтай ажиллаж байна.

Дахиад дээрээс нь 16 мянган аж ахуйн нэгж татвар дээр дансаа хаалгасан байна.

Тэгэхээр энэ өндөр татварын орлогыг бүрдүүлэхийн тулд дахиад эдгээр аж ахуйн нэгж дээр дарамт бий болно гэж харж байгаа учраас энэ эрсдэлийг хаах, ам ажил хоёроо нийлүүлэх хэрэгтэй байна гэж харж байна.

Гуравдугаарт, нөгөө талдаа төсвийн алдагдал нь өндөр орж ирж байна гэж харж байна.

Хамгийн гол нь төсвийн алдагдлаа зээлээр санхүүжүүлэхээр орж ирсэн. 1.4 их наядын зээл болон үнэт цаас гаргахаар орж ирж байна. Ингэснээр дахиад мөнгөний бодлого чангарч, дахиад аж ахуйн нэгж ард иргэдээр дарамт ирэхээр ийм төсөв байна гэж харж байгаа учраас энэхүү төсвийг төсвийн хүрээний мэдэгдлийнх нь түвшинд цааш нь дэмжих боломжгүй гэж харж байна.

Тэгэхээр зарчмын хувьд санал хэлэхэд эхлээд төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг баталчхаад цаашлаад төсвөө ярилцах нь зүйтэй гэж бодож байна. Хэрвээ төсвийн хүрээний мэдэгдэл дээр өөрчлөлт орвол дахиад яах юм. Төсвөө бид яаж хэлэлцэх юм бэ.

Тэгэхээр үүнийг Улсын Их Хурлын даргаас зарчмын хувьд авч хэлэлцэхийг хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт гишүүн, сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга өөрөө орсон юм байна.

Улсын Их Хурлын гишүүн байхгүй байна. Бадамдоржийн Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ жилийн төсөв мөнөө л бас том төсөв орж ирсэн. Мэдэж байгаа. Эндээс урсгал зардлаа хасаад цаана нь 8 их наяд төгрөг хөрөнгө оруулалтын зардалд үлдэж байгаа. 8 их наяд төгрөг гэдэг бол бас хангалттай том бүтээн байгуулалтыг хийх боломжтой. Бид энэ үнийн дүнгээр эрчим хүчнийхээ асуудлыг нэг жилийн төсвөөрөө бүтэн шийдэх боломж байна шүү дээ.

Тэгэхэд ийм боломжоо бид энэ жижиг жижиг, сум болгонд нэг жижиг жижиг байшин, хоёр сумын хооронд жижиг зам холбоод энэ том хөрөнгө оруулалтынхаа төслийг үрэн таран шагай шиг тарааж хаях гээд байх юм.

Сүүлийн 20-иод жил бид тасралтгүй маш их татаас өгсөн. Энэ татаасуудын үр дүн өнөөдөр ямар байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар өнөөдөр хэр хөгжсөн юм. Бид өнөөдөр улаан буудайгаа бид импортоор авах дээрээ тулаад байна шүү дээ. Арьс, шир маань хаягдаад байна.

Гэтэл энэ олон жил бид энэ татаас өгсөн үнийн дүнгээ бодоод үзэхэд хэчнээн том бүтээн байгуулалт хийх боломжтой байсан бэ гээд харагдана. Өнөөдөр энэ жилийнхээ хөрөнгө оруулалтыг бид эдийн засгийнхаа чөлөөт бүсүүдийг дэмжих, энэ аж үйлдвэржилтийн паркуудыг дэмжих асуудал дээрээ нэлээн хангалттай сайн тавиад өгмөөр байна.

Эдийн засгийн чөлөөт бүс гээд л аль олон жилийн өмнө Замын-Үүдийн чөлөөт бүс, Цагааннуур, Алтанбулаг гээд чөлөөт бүсүүдийг эхлүүлсэн. Одоо

болтол дуусгаагүй байна. Жил болгоны төсөв дээр маш жоохон жоохон мөнгө тавиад энэ ажил чинь явахгүй байна.

Сүүлийн үед аж үйлдвэржилтийн паркууд гээд байна. Энэ төсвүүдээ бүгдийг нь бөөгнүүлж байгаад энэ аж үйлдвэржилтийнхээ энэ салбар луу оруулж ирмээр байна. Хөдөө аж ахуйгаа дэмжмээр байна. Ингэж байж манай эдийн засаг уул уурхай, нөгөө талд нь хөдөө аж ахуй гээд хоёр тулгуурт эдийн засаг хөгжих гээд байгаа юм.

Энэ тал дээр бид анхаарч ажиллахгүй бол гишүүн болгон, эсвэл Засгийн газрын орон нутгаас орж ирсэн жижиг жижиг төслүүдийг ингээд дэмжээд яваад байх юм бид том хөгжлийнхөө бодлогыг барьж авч чадахгүй байна.

Бусад улс орнуудын хөгжлийг л бид харж байгаа. Тэд нар үсрэнгүй хөгжиж байна.

Гэтэл бид өнөөдөр энэ тулга тойрсон жижигхэн шийдлүүдээсээ болоод том төсвүүдээ багасгаж оруулж ирээд, ингээд хөгжлийн бодлого нь удаашраад саараад байна.

Тэгэхээр энэ тал дээр манай эрхэм гишүүд, Засгийн газрын гишүүд анхаарч ажилламаар байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Улсын төсөв дээр бүх талаар нь бүгдийг нь харахад хоёр чухал коммент хэлмээр байгаа.

Нэгдүгээрт нь, нийгмийн эрүүл мэндийн зардлыг хасаад байхгүй. Тэгээд нийгмийн эрүүл мэнд чинь уг нь зардал хэмнэх ёстой ийм төрлийн үйл ажиллагаа. Хэдий чинээ урьдчилан сэргийлнэ төдий чинээ эмнэлэг барих зардал багасах ёстой. Тэгээд эрүүл мэндийн салбарын зардлаа харахаар нийгмийн эрүүл мэндийн зардал нь аягүй бага мөртлөө эмнэлэг барих зардал нь нэмэгдээд байгаа.

Тэгэхээр өвдөөд ирээд өвдчих. Тэгээд ирэхээр нь бид эмчилье гэдэг ийм буруу харсан гурвалжинтай ийм тогтолцоотой байж болохгүй гэдгийг хэлмээр байгаа юм.

Хоёр дахь санал. Нийгмийн хариуцлага байгаа. Өнгөрсөн жил бид аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт 1 хувь гээд яриад байгаа.

Гэтэл тэрийг аж ахуйн нэгж, байгууллага болон жинхэнээсээ нийгмийн хариуцлага хийдэг төрийн бус байгууллагууд яаж авч тэр харилцаанд орох тухай асуудал нь одоо болтол цэгцгүй, зохицуулалтгүй хэвээрээ л байгаа. Тэгснээ юу гэдэг юм төрөөс өөрсдөө хийх ёстой ажлуудынхаа заримыг нь улсын

төсөвт суулгаагүй орхисныгоо нийгмийн хариуцлага гэж нэрлэснээ та нар энэ дээр дэмжлэг үзүүлнэ үү гэдэг ийм юмыг нийгмийн хариуцлага гэж яриад байх юм.

Тэгэхээр манай улс өөрөө нийгмийн хариуцлагын үзэл баримтлал байхгүй. Төрийн бус байгууллагынхаа тухай хуульдаа гар хүрээгүй. Тэрийгээ сэглэсээр байгаад 20 гаруй жил болсон.

Тэгэхээр энэ 1 хувийн орлогын албан татварын хөнгөлөлт гэдэг дээр жинхэнэ нийгмийн хариуцлага хийж байгаа төрийн бус байгууллагууд, жижиг төрийн бус байгууллагууд шалгуурыг нь хангахгүй, тэр барьж байгаа дүрэм журамд нь нийцэхгүй ийм төсөөлөлтэй ийм төсөв байгаад байгаа гэсэн үг.

Гуравт нь, дахиад нэг юм хэлмээр байгаа нь яах вэ, өнгөрсөн жилийг бодвол нэг сайн зүйл нь энэ ном дээр өнгөрсөн жил ийм байсан юм. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх гэдэг гарчигтай байснаа вебсайтад байршуулсан. Тэгэхдээ санал ирээгүй гэдэг ийм өгүүлбэртэй байсан. Би бүр тэрийг санаж байна. Энэ жил яах вэ авууштай зүйл нь 8400 гаруй хүнээс санал авсан юм байна. Гэхдээ тэр саналыг авснаа яг хүн нь хэд байсан юм, төрийн бус байгууллага нь хэд байсан юм. Саналын тэр нэг юу гэдэг юм чансаа гэдэг юм уу ангилал дээрээ манайх жоохон дутагдалтай ажилласаар л байгаа. Нэгэнт боож багличихсан төсөв дээр санал өгсөн нь яг хэр хөдөлсөн юм бол доо. Тэр бол жоохон эргэлзээтэй.

Тийм учраас зун би хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ба улсын төсөв хэлэлцүүлэг хийж байж өнөөдөр энэ асуудлыг бас зарим төсөв яригдаж байгаа гэсэн үг.

Хамгийн сүүлд нь энэ нэг том зузаан ном харагдаад байгаа биз. Гэтэл яг задлаад ингээд харахаар яамны тэр нөгөө үйл ажиллагааны шалгуур буюу хавсралт 1 дээр байгаа зүйл, заалтууд маш товчхон байгаа. Арван гуравхан ажил төлөвлөхөөд тэрийг ингээд харахаар хэцүү. Бусад дэлгэрэнгүй нь улсын нууц юм шиг ингээд харуулахгүй, мэдүүлэхгүй ийм байгаа. Энэ дээр чинь яаж төсвөө, саналаа өгөх юм бэ. Үйл ажиллагааны шалгуур дээр жишээлбэл яаж хэмжих юм бэ.

Тэгэхээр ахиад ил тод байдал, хүртээмжтэй байдлыг шаардаж байна. Дараа жил илүү сайжруулмаар байна. Үүнийгээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Өнөөдөр хэдүүлээ төсвийн хүрээний мэдэгдэл, ирэх 3 жилийн асуудлыг ярьж байна.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл өөрөө төсөвтөө ярьчаарай ирэх 3 жилийн эдийн засгийн прогнозын тухай эдийн засгийн болон мэргэжлийн

хэлэлцүүлэг хийхээсээ илүү 70, 80 хувь нь ерөөсөө төсөв рүү орчхоод болохгүй байгаад байх юм. Тэгээд энэ хоёрыг ингэж салгаж хийж байхгүй бол болохгүй байгаад байна.

Тэгэхээр ирэх 3 жилийн төсвийг, төсвийн хүрээний мэдэгдлийг ярихдаа мөчлөгийн асуудал гэж ярьж байгаа учраас цаашдаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийг мэргэжлийн түвшинд болгох зайлшгүй шаардлага байгаад байгаа юм.

Одоогийн байгаа энэ 9 үзүүлэлттэй. Тэгээд дээр дээрээс нь жил болгон төсөв хэлэлцэх болгондоо өөрчилдөг энэ байдал нь бид ирэх 3 жилийн прогнозгүй. Тэгээд төсвөө дагасан байдлаараа явдаг. Ингээд төсвөө дагасан байдлаараа ирэх чиглэлгүй, баримжаагүй болохоороо төсөв өөрөө бүтээмжгүй болдог.

Тэгээд энэ инфляц хэдэн хувьтай байх вэ гэдэг асуудал хамгийн чухал. Инфляцыг яг өнөөдөр энд ярих цаг үед бид төсөв ярьдаг, төсвийн зардал ярьдаг. Ингээд бид эргээд үр дүнд нь гарахаараа инфляцдаа ороогдсон байдаг. Өнөөдөр төсвийн орлого чинь 31.6 их наяд. Үүний 77 хувийг урсгал зардалдаа зарцуулж байгаа. 24 их наядыг нь. Тэгээд энэ 24 их наяд нэг жилдээ ороод л гардаг ийм л урсгал зардал л даа.

Тэгээд энэ зардлаа бид багасгаж чадахаа байсан. Яагаад гэхээр энэ зардлын чинь бараг 81 гаруй хувийг нь нь тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, эрүүл мэнд, эмчилгээний үйлчилгээ, боловсролын үйлчилгээ гээд зардлууд эзэлдэг.

Тэгэхээр энэ нийгмийн суурь болох энэ тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын тогтолцооны сууриа бүр сууриар нь өөрчлөхгүй бол урсгал зардлын чинь 70, 80 хувийг нь эд нар эзэлчхээд цаашдаа ерөөсөө хөрөнгө оруулалт ч хийх боломж байхгүй, цаашдаа үүнийг бууруулах ч боломжгүй гэсэн ийм байдлаар бид өнөөдөр хандаад байгаа юм.

Ер нь энэ эдийн засгийн мөчлөгийн асуудлыг бид ярихдаа мөчлөггүй үеийн тогтвортой эдийн засгийн өсөлт нь хэд юм, мөчлөг болсон үеийн нөлөөллийг хараад тэгээд энэ нөлөөллөөс нь хасаж ялгаж гаргаж ирж байж бид энэ төсвийн хүрээний мэдэгдлээ ярихгүй бол үнэндээ энэ төсвийн хүрээний мэдэгдэл биш төсөв болоод дуусаад байгаа юм.

Алсын чиг баримжаагүй зардлууд дандаа зардал болоод, энэ нь инфляц үйлдвэрлээд байна.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдлийг 15-аас 20 үзүүлэлттэй олон улсад хэрэглэдэг болгох. Тэгээд хавар төсвөөс тусдаа хэлэлцдэг болгох. Энэ урсгал зардлууд дээр нь бүтэн шинэчлэлүүдийг хийж байж бид цаашаа 3

жилийн баримжаатай болох юм. Үүнийг цаашдаа Эдийн засаг, хөгжлийн яамнаас шаардаж явах болно гэдгээ хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Харамсалтай байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслөөс үзэхэд ирэх онд боловсролын салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 4.2-хон хувийг зарцуулах юм байна. Уг нь Монголын төр 2023, 2024 онуудад 5.1, 5.2-т хүргэсэн.

Гэтэл энэ хүргэсэн юунаасаа ухраад 4.2-хон хувийг боловсролын салбартаа зарцуулж байгаа нь үнэхээр харамсалтай байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүний 4.74, 2026 онд 4.22 гээд буураад явах нь. Гэтэл өнөөдөр “Боловсролын жил” гээд худлаа ярьчихсан. Зарлачихсан. Тэгээд багш нарт энэ боловсролын жилд нь хийж байгаа ямар ч тийм сэтгэлд нь нийцэх хүрэх ийм гоё хийж байгаа ажил байхгүй байна. Зүгээр нэг хэдэн Азийн хөгжлийн банкны 150.0 сая доллар зээлээд хэдэн барилга барина гээд л яриад байгаа юм. Энэ барилга барина гээд байгаа нь эд нарын мөнгө угаах л арга байх.

Цалин нэмэхэд эд нарт ашиггүй. Барилга, байшин барихад, ном тендер шахахад эд нарт ашигтай.

Тийм учраас барилга барина гэж чичрээд байгаа нь яг харагдаж байгаа юм. Нэгэнт төсвийг алдагдалтай баталж болоод байгаа юм чинь төсвийн тусгай шаардлагуудаа зөрчихгүйгээр Засгийн газраас ирэх 2026 оныг боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан боловсролын салбарт зарцуулах төсвөө нэгдсэн төсвийн орлого, зарлагаа сайн тооцож бай байгаад дотоодын нийт бүтээгдэхүүний ядаж 5 хувьд хүргэх боломж байна уу.

Одоо тэгээд Ерөнхий сайд нь төсөв ярьж байхад байхгүй. Сайдын суудал ярихаар бүгдээрээ сууж байдаг гэж би өчигдөр хэлсэн. Тийм ээ. Энэ үгээ дахиад давтаад хэлье.

Ард түмний ажил, ахуй амьдралтай холбоотой асуудал ярингуут энэ танхим нь хоосон байж байдаг. Хэдхэн хүн сууж байдаг. Боловсролын салбарын төсвийг 2024 оны хүрсэн түвшин буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.2 хувьд хүргэхэд дахиад 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлага байгаа.

Тэгэхээр боловсролын салбарын мянга мянган багш, ажилтны төлөөлөл болсон жирийн багш гишүүний хувиар 2026 оны боловсролын салбарын төсвийг дахиад 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналуудыг төсвийн хүрээний мэдэгдэл болон 2026 оны улсын төсвийн хэлэлцүүлгийн үеэр Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд гаргах болно гэдгээ үүгээр мэдэгдье.

Улс эх орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө, боловсролын салбарын хөгжил дэвшлийн төлөө бусад Улсын Их Хурлын гишүүдийг дэмжиж өгөхийг уриалж байна.

Жирийн ардын хүүхдийн хувьсах зардлыг хасахдаа нүд нь цавчдаггүй хэрнээ хувийн сургуулиудаа дэмжих болохоор нүдээ ухаад өгөхөөс буцдаггүй олон арван тэрбум төгрөгөөр дэмждэг хувийн сургуулийн төлөөлөл Боловсролын сайдтай байгаад харамсаж байна.

Эгэл ардын хүүхдүүдийн сурч боловсрох эрх, эрх чөлөөний эсрэг үйлдсэн энэ гэмт хэрэг чинь төрийн өмчийн 100 гаруй сургуулийн 300 гаруй мянган хүүхэд, 600 гаруй мянган эцэг, эх, 15 мянга гаруй багш, ажилтны эрх ашиг хохирч байгаа гэдгийг Их Хурлын гишүүддээ дуулгахад үнэхээр харамсалтай байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг надаас авч болно шүү гишүүд ээ.

Ингээд багш нарын урам зоригтой ажлаа үргэлжлүүлэн хийхэд энэ Монголын төрд төлөөлөл болж байгаа 126 гишүүн минь нэгдээд дэмжээд өгөөч гэдгийг хүсмээр байна.

Манай энэ парламентад боловсролын салбарыг дэмждэг 42 гишүүн байгаа. Цаана нь ч дахиад байгаа байх. Би бүгдэнгээр нь тойруулаад зураагүйдээ хүлцэл өчье Та бүхнээсээ. Ямар ч байсан 42 гишүүн надтай нэгдээд боловсролын... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Та бүхнийхээ амгаланг эрье.

Энэ улсын төсвийн хүрээний мэдэгдэл бид ярьж байна л даа.

Тэгэхээр бид энэ намуудын амлалтыг ярих ёстой болчхоод байгаа юм. 2024 онд Та бүхэн маань юу амлалаа. Уг нь Монгол Ардын нам, Ардын нам л байсан л даа. Одоо танай дарга нар чинь авлигачид, хулгайчид л болсон байна. Одоо тэр амлалт хамаагүй юу. Нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувь байна гэсэн шүү дээ. Улсын төсөв. Одоо 30 хувь байна. Үүнийгээ жил болгон хоёр хоёр, гурав гурван тэрбумаар буулгахгүй л бол тэр амлалтдаа хүрч чадахгүй нь.

Дээр нь нэмээд энэ төрийн өмчтэй компаниудыг нэмэхээр хувийн хэвшлийн ажиллах орон зай байхгүй болчихжээ. Татвар нэмэхгүй гэсэн хаана байна. Татвар нэмж байна шүү дээ. Хүн амьдрахын арга алга болсон байна. Өр багасгана гэсэн хаана байна.

Энд алдагдаад алдагдалтай төсөв батална гэдэг чинь өр нэмэгдэнэ л гэсэн үг. Энэ амлалтдаа хүрээч ээ. Тэгэхгүй бол ингээд залилан хийгээд бид та нарт шаардлага тавих ёстой. Тэр шаардлагаа тавихгүй байгаа. Ингээд явж чадахгүй нь.

Энэ Улсын Их Хурал 126 гишүүнтэй болсон байгаа. Та нар алийн болгон нэг энэ Засгийн газрын нэг хуулийн хэлтэс шиг явах юм бэ. Үүнээс чинь болж улс орон хохироод дууслаа шүү дээ. Улсын Их Хурал юм бол Улсын Их Хурал шиг байа.

Одоо нэг дампуураагүй салбарыг хэлээдэх дээ та нар. Эрүүл мэндийн салбар чинь ямар байна. Даатгал нь байхгүй. Хүмүүс эмчилгээндээ орж чадахгүй байна. Боловсролын салбарыг хар л даа. Сурах бичиг алга. Цалин байхгүй. Багш нар байхгүй. Нэг танхимд 60, 70-аараа сууж байна. Үгүй ийм л байна шүү дээ.

Тэгээд нөгөө эрчим хүчний салбараа хар. Реформ хийлээ гэсэн. Хаана байгаа юм. Байхгүй. Хэд хэдэн станцууд дэлбэрлээ.

Үгүй, тэгээд юу билээ. Тэр Т.Доржханд Арабаар яваад л миний араас баахан хөрөнгө оруулалт орж ирлээ гээд байсан. Тэр нь хаана байгаа юм. Мянган нэгэн шөнийн үлгэр дээр нэг гуталчин Маруф араас бараа ирж байгаа гээд л яриад л хуураад л яриад яваад байдаг. Яг л тэрний үлгэр байна шүү дээ.

Үгүй, энэ хүмүүстээ хариуцлага тооц л доо. Яагаад хариуцлага тооцохгүй байгаа юм бэ? Энэ ард түмний амьдрал чинь бүр уначихлаа шүү дээ. Өшөө юу хүлээгээд байгаа юм. Хар л даа.

Тэр хэдэн мега төслүүд чинь бүгд худлаа. Ямар ч биелэгдэж байгаа барьж байгаа юм алга. Тэр утаагүй түлш гээд байсан. Эхний нэг, хоёр жил гайгүй байсан. Одоо хар л даа. Гадаадаас түлшээ татаж байна шүү дээ. Үгүй ийм л байна шүү дээ. Энэ улс орон чинь.

Тэгээд үүнийг хараад дуугүй байгаад ингээд байх юм уу. Тийм юм байхгүй. Тэр мөчлөг сөрсөн, мөчлөг дагасан дагасан гээд. Дандаа л худлаа ярина. Өөрсдөө хэрэгтэй болохоор мөчлөг дагаж байна л гэнэ. Хэрэгтэй болохоор мөчлөг сөрж л байна гэнэ.

Тэгээд хоёр, гурван жилийнхээ дараах юмыг харж чадахгүй. Энэ төсвийн төсөөлөл. Одоо 2025 оны төсөв биелж байгаа нь хаана байгаа юм. Өнөөдөр л гэхэд алдагдалтай л байна шүү дээ.

Одоо хүмүүсийнхээ тэтгэврийг нэм. Хуулиа хууль баталсан шүү дээ. Бид. Тэтгэврийг 9 хувиар нэмэх ёстой. Юун 6 хувь бэ. Тийм юм байхгүй шүү дээ. Энэ чинь инфляц 8 хувьтай байхад чинь.

Тэр багш нарын цалинг хар л даа. Бага ангийн багш, цэцэрлэгийн багш нарын цалин бусад газруудад хамгийн өндөр байдаг шүү дээ. Сая 200, сая 300 мянган төгрөгийн цалинтай багш нар яаж ажиллах юм. Энэ Монгол Улсын ирээдүй үнэхээр бүрхэг болчихлоо шүү дээ. Ийм хүүхдүүд цаашаа төрөөд яах юм.

Тэр хувийн сургуулиудыг яагаад ялгаж бариад байдаг юм бэ. Тэр эх, эцэг нь өөрийнхөө хүүхдэд мөнгө төлөөд сургаж байхад тэр хувьсах зардлыг нь алагчлалгүй өг л дөө.

Харин энэ Их Хурлын гишүүд, төрийн алба хааж байгаа газар, хэлтсийн дарга нараас бусад бүх хүмүүсийн хүүхдүүд улсын сургуульдаа явах эрхтэй. Тийм хуулийг би өргөн барина гэж бодож байгаа. Энэ Ц.Мөнхтуяа гишүүн бид хоёр өргөн барих байх. Тэгж таарах байх. Та бүхэн дэмжээд өгөөрэй. Тэгж байж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Төсвийн хүрээний мэдэгдлээ ирж байгаа учраас нэг хэдэн санал хэлье.

Төсвийн урсгал зардлыг 24 хувьд барина гээд одоо энэ тоог бодож байгаад авчирч ирээд тавьсан. Одоо эргээд юм шийдье гэхээр энэ олон гишүүд хэлж байна. Цалин хөлс нэмье, тэтгэвэр, тэтгэмж нэмье гээд энэ олон шаардлагууд их ирж байна.

Тэгээд энэ болгоныг шийдье гэхээр бид өөрөө өөрсдөө тээг тавиад төсвийнхөө урсгал зардлыг 24 хувьд барина. 24.1 болчихоод байна. Үүнээсээ илүү нэмэхгүй гэдэг нэг ийм байдалтай байгаад байгаа.

Тийм учраас үүнийг би өөрчлөх шаардлагатай. Үнэхээр тэр багш нарынхаа, эмч нарынхаа, ахмадуудынхаа тэтгэвэр, цалинг нэмье гэвэл энэ төсвийн хүрээний барьсан энэ нэг хуурай тоогоо эргэж харвал яасан юм бэ. Нэг.

Хоёрдугаарт, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын санг төсвийн бүрэлдэхүүнд оруулж байгаад тэгээд урсгал зардал гэж үзээд ингээд яваад байгаа юм. Энэ хоёр сан чинь өөрөө даатгал төлөгчдийн тусдаа бие даасан байх ёстой сан байхгүй юу.

Тэгэхээр төсвийнхөө бүрэлдэхүүнд орсноос болоод урсгал зардал мэтээр харагдаад, тэгээд ингээд урсгал зардлыг өндөр мэт харагдуулаад байгаа юм.

Нэг талаараа хүүхдийн тоо өсөж байгаа. Боловсролын сайд хэлж байна лээ. 29 мянган хүүхдээр энэ жил өсөж байгаа гэж. Эрүүл мэндийн үзлэг үйлчилгээний тоо нэмэгдэж байгаа. Сүүлийн гурав, дөрвөн жилийн дотор үнэгүй үздэг үзлэг шинжилгээ бол хоёроос гурав дахин өссөн. Ачааллыг нь нэмээд

байгаа. Энэ бол сайн. Гэхдээ цаашдаа үүнийгээ хэвээрээ барьж явъя гэвэл бид ийшээ эрүүл мэндийн салбар болон боловсролын салбар луу зардал, төсөв хөрөнгийг нь нэмж өгөхөөс аргагүй.

Одоо манай зарим гишүүд нэг амаараа болохоор урсгал зардлыг хас, тана гэж хэлчхээд нөгөө амаараа болохоороо цалингаа нэм гээд байх юм. Энэ чинь ерөөсөө нэг л зүйл шүү дээ.

Тийм учраас хэдүүлээ бүгдээрээ санал нэгтэй байгаа бол урсгал зардлаа хатуу тоондоо барьдаг юмаа засаад, тэгээд цалин хөлс тэтгэвэр, тэтгэмжээ энэ салбаруудад нь төсвийг нь нэмээд өгье өө гишүүд ээ.

Хоёрдугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс чухал юу өгсөн байна лээ. Бид чинь Ирээдүйн өв сангийнхаа мөнгийг Англи, Францын банкнуудад 3.3-аас 4.3 хувиар хадгалж байгаа. Өөрсдөө гадаадаас мөнгө авч бонд босгох болохоороо 6, 7, 8 хувиар авч байгаа. Энэ дундын хүүгийн зардал чинь өөрөө төсвийн зардлыг өсгөөд байна гэж. Энэ бол бодит дүгнэлт.

Ахмадууд маань тэтгэврийн зээлийг 18, 19 хувиар авч байна. Бид өөрсдийнхөө мөнгийг гадаадад хадгалах болохоороо 3, 4 хувиар хадгалж байгаа юм.

Тэгээд энэ дээр манай Монголбанк болон Сангийн яам маневр зохицуулалт хийх боломж байна уу?

Бид өөрсдөө гадаадад бага мөнгөөр хадгалчхаад буцаж авахдаа өндөр мөнгөөр аваад байгаа чинь өөрөө энэ төсвийн зардалд нэлээн хувь эзлээд байна шүү дээ гэдгийг би анхааруулж хэлмээр байна.

Дараагийн асуудал нь авах ёстой татваруудаа ер нь авч чадаж байна уу? Олох ёстой орлогуудаа авч чадаж байна уу? Нөгөө Оюу Толгойн татварын авлагууд юу болсон бэ?

Өчигдөр бараг олон улсын арбитрын шүүх дээр унавал 1 их наядыг бараг эргэж төлөх хэмжээнд орчхож магадгүй гэдэг зүйлийг ярьж байна лээ. Алт хамгийн өндөр байгаа. Алтны үнэ түүхэндээ байгаагүйгээр. Алт тушаалт эрс багассан байна. Татвар төлөлт нь эрс багассан байна. Үүнийг дагаад.

Тийм учраас энэ алтны уул уурхай энэ байгаль орчин сүйтгээд байгаа энэ том компаниуд нь ашиг олж байгаа компаниуддаа арга хэмжээ авдаггүй юм уу. Энэ хууль хяналтын байгууллагынхан хаагуур нь ажилладаг юм бэ. Алтаа тушаахгүй. Тэгээд бид энд цалин тавих мөнгө байхгүй, тэтгэвэр нэмэх мөнгө байхгүй сууж байдаг.

Тийм учраас нөгөө талаасаа энэ төсвийнхөө орлого талынхаа юмыг дайчилж байгаа юм уу, үгүй юм уу. Тэгээд ийм саналуудыг хэлмээр байна.

Тэгээд энэ олон санал гомдол, хүсэлт ирүүлээд байгаа боловсролын салбарынхан байна, эрүүл мэндийнхэн байна. Ажил хаялт, тэмцэл дээр тулчихсан байж байна. Ахмадууд гадаа жагсаал цуглаан хийгээд суучихсан байж байна. Тэтгэврийн зээлийг нь тоглоом шиг арилжааны банкнууд руу хийгээд хаячихсан.

Би бол Монголбанкны захирал бол хариуцлагагүй мэдэгдэл хийж байна гэж бодож байгаа юм. Ахмадын тэтгэврийн зээл Монголбанканд хамаагүй болсон гээд яриад сууж байгаа байхгүй юу. Бусад зээл нь хамаатай. Ийм зүйлийг би анхааруулж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд төсвийн хүрээтэй холбогдуулан үг хэлж байна.

Өнөөдөр чуулган эхлээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж байхад нэг ч сайд байсангүй. Одоо орж ирж байх шиг байна.

Уг нь 2026 онд Монгол Улс хэр их мөнгө зарцуулах гэж байгаа вэ, хэр их мөнгө олох гэж байгаа вэ, хэр их өр тавих гэж байгаа вэ, ямар алдагдал хүлээх гэж байгаа вэ, түүнийгээ санхүүжүүлэх гэж яаж зээл авах гэж байгаа вэ гэдэг чухал баримт бичгийг Улсын Их Хурлаар батлуулах гэж байгаа гэж би ойлгож байгаа.

Гэтэл энэ цаг үед Засгийн газрын сайд нар нь, ялангуяа эрхлэх асуудлыг нь хариуцсан бүр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар эрхлэх асуудлыг нь хариуцсан сайд нарын чуулганы танхимд суухгүй байна гэдэг бол үнэнийг хэлэхэд ард түмний татварын мөнгөнд үл хүндэтгэлтэй хандаж байгаа нь нэг их илэрхийлэл юм биш үү. Та бүхэн өөрсдөө үүн дээрээ анхаарал хандуулаарай.

Би нэг хэдэн үг хэлье гэж бодсон юм Улсын Их Хурал 2025 оны 05 сарын 30-нд 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг баталсан.

Тэр үед бид алдагдалгүй төсөв, төсвийн хүрээ 2026 онд баталж өгч байсан байна.

Бидний хувьд 3 сарын хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд асар их зүйл өөрчлөгдсөн биш 3 сарын хугацаанд үнэнийг хэлэхэд Орос, Украйны дайн гараад 3 жил гаруй болж байна. Трамп хоёр дахь удаагаа Ерөнхийлөгч болоод худалдааны тариф тогтоох нь тодорхой болоод нэг жил болсон байна.

Манай хамгийн том худалдааны түнш, хамгийн тогтвортой эдийн засгийн бодлоготой, тогтвортой эдийн засгийн өсөлттэй улс. Гэв гэнэт 3 сарын дотор бодлогоо эрс өөрчлөөгүй байх гэж би бодож байна.

Тэгэхээр энэ бүгдэд тааруулаад ялангуяа хамгийн тогтвортой байх ёстой энэ хуулиудаа тогтвортой сахиад явах ийм сахилга бат манай Засгийн газарт байх ёстой юм биш үү.

Эдийн засгийн хүнд үеийг эдийн засгийн тэлэх бодлогоор, төсвийн бодлогоор явуулна. Бид явуулахаас өөр аргагүй гэж байна. Төсвийн бодлого хэрвээ зөвхөн төсвийн бодлогыг тэлж эдийн засгийг тэлэх бодлогыг явуулах юм бол мөнгөний бодлогод чинь ямар ч ажиллах орон зай үлдэхгүй. Энэ бол сүүлийн 20, 30 жилийн ерөнхийдөө бидний давтагдсан гол алдаануудын нэг нь энэ. Одоо зээлийн хүү ямар байгаа вэ. Та бүхэн харж байгаа байх. 2026 онд улсын төсөв дээр 1 их наяд орчим төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийхээр билээ. Энэ бол бүгд гадаад валют болж гадагшаагаа гарна гэсэн.

Тэгэхээр энэ бүгд дээр Та бүхэн өөрсдөө дүн шинжилгээгээ хийгээрэй.

Тэгээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Шинэ дэгийн дагуу бүх Байнгын хороод хэлэлцэхээр байгаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Засгийн газар 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг ажлын хоёр өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байгаа.

Ардчилсан намын бүлгийн зүгээс үг хэлэх бүлгийн дарга нь байхгүй байгаад байна.

Горимын санал. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би горимын санал гаргана.

Улсын Их Хурлын гишүүд бид өнөөдөр Үндсэн хуулиа зөрчөөд сууж байна. Төсвийг буцаах горимын саналтай байна. Үндсэн хуулийн 25.7 дээр улсын төсөв, засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын улсын төсвийг батална гэж байгаа.

Өнөөдөр аудитын дүгнэлт дээр ч байгаа. 6.4.Монгол Улсын 2021-2025 оны хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, төлөв, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталсан. 2026-2030 он батлагдаагүй.

Одоо бид ямар ч төлөвлөгөө, хөтөлбөргүйгээр өнөөдөр төсөв батлах гэж байгаа. Энэ бол Үндсэн хууль зөрчиж байгаа явдал.

Үндсэн хууль зөрчөөд үүнийг үндсэндээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4.4 дүгээр зүйлийг бид зөрчөөд төсөв явах юм бол Улсын Их Хурал Үндсэн хууль дээр очно.

Энэ хурлыг хууль бусаар удирдсан дарга нар бүгдээрээ хусагдана. Гишүүд бид бүгдээрээ Үндсэн хууль зөрчинө. Хуулиа л дагадаг байх даа. Хуулиа дагацгаая.

Өнөөдөр ажил чухал байна. Цаг алдахгүй. Өнөөдөр тариалангийн цаг гээд л бид яншаад л, үглээд л байдаг. Засгийн газар нь биднийг үл ойшоогоод л, үл тоогоод л байдаг. Засгийн газар ажлаа хийх гэж оролдож байж болно. Тэгэхдээ нэг зүйл хэлье.

Ард түмэн Улсын Их Хурлын гишүүдийг сонгосон болохоос биш сайд нарыг сонгоогүй шүү. Эцсийн эцэст хариуцлагыг гишүүд үүрдэг. Засгийн бүх эрх ард түмнээс эх үүсвэртэй гэдэг бол сайд нараас эх үүсвэртэй гэсэн үг биш шүү. Төрийн дээд эрх мэдлийг Улсын Их Хурлын гишүүд авсан юм бол авсан шиг байх хэрэгтэй. Хуулиа дээдэлье.

Хурлын дарга аа, хурал удирдаж байгаа дарга аа. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд маш их яншиж байгаа. Төрийн өмчийн компаниуд 22.8 их наядын өр төлбөртэй байна гэдэг бүгд авлигал гэж ойлгож байна.

Энэ талаараа ямар ч шийдвэр гаргаагүй байж байж яншиж байгаад л одоо алх цохих гэж байна.

Өнөөдөр улсын төсөв, хөрөнгө оруулалт, хөтөлбөрүүд 40 хувь нь ямар ч санхүүжих эх үүсвэр байхгүй. Үүнийг эрэмбэлэх нь хэн гээч. Засгийн газар, сайд нар. Дараа нь Улсын Их Хурлын гишүүд бид бүгдээрээ эрэмбэлүүлэх гээд гүйнэ, гуйна. Өнөөдөр та нар ард түмний мандатыг, онцгой бүрэн эрхийг, төсөв батлах онцгой бүрэн эрхийг бүлэглэлүүдэд найр тавин өгч байна.

Хамт олон минь ээ, Засгийн газраар тоглож магадгүй. Болно. Би эсэргүүцэж байна тэгэхдээ. Их Хурлаар хэзээ ч тоглож болохгүй шүү. Энэ бол ард түмний сонгосон сонголт. Ямраар ч бай бид ажлаа хийх ёстой.

Ингэхээр олон юм ярихгүйгээр энэ их өртэй, төрийн өмчийн компаниудын энэ олон их наядын найр, найрласан зүйлүүдийг, төсөл, хөтөлбөрийн дутуу эрэмбэлэх эрхийг Засгийн газарт найр тавьж өгч болохгүй.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийг үндэслээд, 25.7-г үндэслээд төсвийг буцаах горимын саналыг гаргаж байна. Хураалгаж өгнө үү.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу бид өнгөрсөн хавар шинэчлэн баталж, ялангуяа төсвийг хэлэлцэх дэгийг нэлээн нарийн тодорхой болгосон.

Үүнтэй холбоотойгоор энэ жил 09 сарын 15-нд намрын чуулган эхэлж эхний шатанд Улсын Их Хурлын гишүүд, иргэд, олон нийт ч гэсэн төсвийн тухай нарийн мэдээллүүдийг Засгийн газрын сайд нараас, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асууж дараагийн хэлэлцүүлгүүдийг явуулаад хоёр дахь шатад буцаж ирж үргэлжлүүлэн энэ хуульд нийцэж байгаа эсэх, өөрөөр хэлбэл үргэлжлүүлэн хэлэлцэх эсэхийг санал хураалтаар шийдэхээр дэгт оруулж шийдвэрлэсэн байж байгаа.

Тэгэхээр Ч.Ариунхур дарга, сая энэ асуудлыг бас нэлээн олон гишүүд яриад байгаа юм. Сая энэ Улсын Их Хурлын, өчигдөр төсвийн хүрээ хэлэлцэхэд, төсвийн төслийн танилцуулга явахад бас нэлээн олон гишүүд энэ асуудлыг ярьж байсан. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ч.Ариунбаяр дарга.

Ч.Ариунхур: Гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт улсын төсөв, түүний гүйцэтгэл, хэлэлцэх журмыг зохицуулсан байгаа.

Төсвийг таван үе шаттайгаар хэлэлцэхээр дэгт тусгасан. Одоо энэ нэг дэх хэлэлцүүлэг явагдаж байгаа.

Төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд, 70.5-д ингэж заасан байгаа. Хоёр дахь хэлэлцүүлэг дээр.

Нэгдсэн хуралдаан Төсвийн байнгын хороо танилцуулга хийсний дараа төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна гэж байгаа.

Тэгэхээр төсвийн төслийг буцаана гэдэг бол горимын санал биш. Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатад энэ санал хураалт яг явагдахаар байгаа. Дэгийн хуулийн дагуу.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын Тамгын газар үүн дээр хууль зүйн дүгнэлт нэгмөсөн гаргаад, Та бүхэн минь танилцуул. Тэгэх үү? Тэгэхгүй бол ингээд Улсын Их Хурлын гишүүд янз бүрийн ойлголттой байгаад байна. Тэр нь бол зохисгүй.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд, аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор, төсвийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга нар тус тус танилцуулсан байгаа.

Одоо танилцуулга, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

Тамгын газрынхан. Ажлын хэсэг орж ирмээр байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамныхан.

Ажлын хэсгийн гишүүдийг Ардчилсан намын бүлгээс завсарлага авахын өмнө Та бүхэнд танилцуулсан байгаа.

Ингээд дарааллын дагуу Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна. Энэ ирцээрээ эрэмбэлэгдэх шиг боллоо.

Ардчилсан намын зүгээс Ардчилсан намын завсарлага дуусаж, сая С.Ганбаатар гишүүн үг хэллээ.

Одоо ингээд Улсын Их Хурлын гишүүд өгсөн нэрийн дагуу асуулт асууна.

Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Бид өнөөдөр 2026 оныхоо төсвийг хэлэлцэж байна. Нийгэм үнэндээ хар бараан мэдээгээр дүүрэн. Сэтгэл зүйн хувьд ч гэсэн маш тийм таагүй үед байна. Бид ер нь ямар нийгэм рүү яваад байна гэдгээ хаана хаанаа дүгнэх хэрэгтэй байна.

2026 онд бид хөгжлийн төлөвлөгөөгөө яаж зөв явуулах вэ, яах вэ гэдэг энэ нөхцөл байдал дээр бид үнэхээр асуух ёстой асуултууд маш олон байна.

Тэгээд өнөөдөр энд Улсын ерөнхий прокуророос хэн ирсэн байгаа юм болоо? Жаргалсайхан Ерөнхий прокурор байгаа юм болов уу? Ажлын хэсэг дээр хэн байгаа юм бол? Асуумаар байна.

Сүүлийн үед хурц, олон хүний сэтгэлийг өвтгөсөн ийм хэргүүд гарч байгаа боловч ер нь бид энэ хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа ямархуу байгаа дээр ил тод дүгнэлт хийх цаг нь болсон байна.

Өргөдлийн байнгын хорооны даргаар 7 сард томилогдоод ажиллаж байна. Манай Байнгын хороон дээр ирж байгаа хамгийн их өргөдөл гомдол бол мэдээж эмч нар, багш нарын цалин, тэтгэмж гээд нийгмийн асуудлууд байгаа.

Хоёр дахь ирж байгаа хамгийн их гомдлууд бол дандаа шударга бусаар шүүлгэсэн, дандаа хонгил руу чирүүлсэн, эрх нь зөрчигдсөн, шударга ёс энд алдагдсан байна гэсэн энэ асуудлууд явж байна.

Тэгээд Цагдаагийн ерөнхий газрын дарга байгаа бол би асуумаар байгаа байхгүй юу. Тэгээд прокурорын шинэчлэл ер нь хэзээ хийх вэ? Та бүхэн маань юу хийж байна?

Би прокурорын төсвийг харлаа л даа. Ер нь ингээд л жил жилийн үед Хууль зүйн байнгын хороо прокурорын төсөв нэг их хэлэлцэгдэхгүй ороод батлагддаг. Бүгдээрээ мэднэ.

2022 он. Дөнгөж 4 жилийн өмнө прокурорын нийт төсөв 60 тэрбум л байсан юм байна. Тэгээд 4 жилийн дараа 2026 онд 143 тэрбум, бараг 144 тэрбум гээд хоёр аравны хэд дахин ч юм ихэссэн байна.

Хөрөнгө оруулалтын зардал гээд жилд л 25 тэрбум тавьж байна. Баахан газар цементээр байшин барьж байна.

Энэ 4 жилийн хугацаанд Та бүхний төсөв хоёр дахин ихэссэн шиг Монгол Улсад шударга ёс тогтоох асуудал хоёр дахин ихсэж чадсан юм уу? Би бол урвуу хамааралтай. Харин ч эсрэгээрээ явж байна гэж бодож байна. Хууль хяналтын байгууллагынхан эрх мэдэлтэй, эсвэл баян цатгалан хүмүүст илүү өөрөөр үйлчилж байна. Энгийн ардын хүүхдүүдэд өөрөөр үйлчилж байна гэдэг шүүмжлэл маш их гарч байна.

Сүүлийн дөрөв, таван жилд хамгийн их сэтгүүлчдийг хорьж, ял эдлүүлж торгосон. Хамгийн боломжгүй, чадамжгүй энэ хүн хүмүүс шоронд сууж байна. Боломжтой чадалтайнууд нь чөлөөтэй явж байна. Энэ нийгэмд хуульч хүний нарийн нүдээр гэхээс илүүтэйгээр нийгэмд энэ асуудал түгчээд байна. Энэ дээр ер нь та бүхэн шинэчлэл хийж байгаа юм уу? Барилга байшин, цемент цутгахаас өөр шинэчлэл хийж байна уу? Шударга ёсыг та нар тогтоох асуудал дээр хэр сайн ажиллаж байгаа гэдэг дээр дүн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн асуултад 4 номерын микрофон дээрээс харуулах уу?

С.Гансэлэм: Эрхэм гишүүдийн энэ өглөөний мэндийг хүргэе.

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм байна. Гишүүний асуултад хариулъя.

Прокурорын байгууллагын төсөв 2022, 2023, 2024 онуудад тодорхой хэмжээний, 2022 онд тухайлбал 60 тэрбум, 2023 онд 72, 2024 онд 110 гээд тодорхой хэмжээний өсөлтүүдтэй байгаа.

Эдгээр өсөлтүүд маань ямар зүйлүүдтэй холбоотой вэ гэхээр мэдээж нэгдүгээрт үнийн өсөлт, инфляц, тогтмол зардлуудын өсөлттэй холбоотой зардлууд байгаа.

Хоёрдугаарт, 2024 онд нийт прокуроруудын цалин хөлс нэмэгдсэн. Мөн прокурорууд ажилчдын цалин хөлс 6 хувь нэмэгдсэн зэрэг нөхцөл байдлуудтай холбоотойгоор төсөв, урсгал зардлууд инфляцтай холбоотойгоор тодорхой хэмжээнд өсөж ирсэн.

2026 оны төсвийн төслийн хувьд прокурорын байгууллагаас Сангийн яаманд 165.4 тэрбум төгрөгийн санал хүргүүлснээс Сангийн яамнаас Засгийн газарт 119.8, Засгийн газраас Улсын Их Хурал 119.6 гээд нэлээдгүй хэмжээгээр хасаж төсвийг ирүүлсэн байгаа.

Миний хувьд прокурорын байгууллагын хэмжээнд төсөв, санхүү хариуцаж байгаа учраас энэ хэмжээнд би хариултыг танд өгч байна. Гишүүнд.

Х.Булгантуяа: О.Номинчимэг гишүүн нэмж тодруулъя.

О.Номинчимэг: Тамгын газрын Хэрэг эрхлэх газрын дарга нь ирсэн юм байна.

Тэгэхээр эндээс томилогдсон албан тушаалтан биш байгаа учраас. Төсөв дээр та бүхэн яах вэ хэлж байна л даа. Инфляц гээд. Тэгээд 2022 он 60 тэрбум байж байгаад одоо 143 тэрбум. Тийм ээ. Хоёр дахинаас илүү байна шүү дээ. 2022 онд ард иргэдийн цалин, энгийн хүмүүсийн цалин амьжиргаа хэд байсан

үүнээс хоёр дахин ихсэж чадсан уу гэдэг дээр үгүй шүү дээ. Тэгэхэд ийм төрийн байгууллагуудынх нь, хууль хүчний байгууллагуудынх нь төсөв мөнгө нь ихсээд байдаг, цементээр баахан байшин бариад байдаг. Энэ яг болох юм уу?

Энэ жилийн орж ирж байгаа төсвийг чинь харахаар бараа, үйлчилгээний бусад зардал гэдэг юуг чинь харахаар 5 дахин ихэсчихсэн байгаа байхгүй юу. Бараа, үйлчилгээний зардал, бэлтгэлийн зардал ч гэж байх шиг 5 дахин ихэсчихсэн. Яг үүгээрээ та бүхэн үнэхээр прокуроруудад чадавхжуулах, сургалт, судалгаа хийх, шударга ёсыг тогтооход хэрэгтэй юм хийж чадаж байна уу?

Төсөв нь нэмэгдээд байдаг. Энэ чинь үр дүн нь гарахгүй байна. Улс төрч нар яах вэ хариуцлага хүлээгээд... /минут дуусав/

Х.Булгантуяа: С.Гансэлэм дарга нэмж хариулъя. 4 номер.

С.Гансэлэм: 2022 оны төсөв дээр түрүүн хэлсэн. 60.5 тэрбум төгрөг байсан бол энэ жил 165.4 төгрөгийн санал хүргүүлснээс Засгийн газраас Улсын Их Хуралд 119 тэрбумыг одоогоор хянаж хүргүүлээд байгаа.

Энэ дээр бид бүхэн дээр тавигдах зардлууд маань гэх юм бол хөрөнгө оруулалтын зардал дээр тодорхой хэмжээний 29 тэрбум төгрөгийн зардал байгаа. Эдгээр зардлууд маань юу вэ гэхээр дүүргүүдийн нэгдсэн барилга, эрүүгийн хэргийн архив, Сүхбаатар аймаг, Булган аймгийн дандаа шилжих хөрөнгө оруулалтын л цөөхөн хэдэн, 4 барилгын л ийм зардлууд байгаа. Шинээр хөрөнгө оруулалт, барилга байшин дээр тодорхой хэмжээнд зардал тавигдаагүй.

Прокурорын байгууллагын хэмжээнд сургалт, судалгааны хүрээлэн ажилладаг. Энэ дээр прокуроруудын сургалт, мөнгө угаах, авлига гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой хэмжээний сургалтуудыг прокуроруудын дунд жил болгон... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ төсвийг харж байхад гурван том эрсдэл байна. Дээрээс нь гурван маш том хүндрэл байна.

➤ **Нэгдүгээрх нь,** нүүрсний үнийн эрсдэлийн асуудал байгаа.

Тэгэхээр өнгөрсөн жил 15 тэрбум долларын экспорт хийсний 9 тэрбумыг нь зөвхөн нүүрснээс олсон.

Тэгэхээр энэ 7 сар, 8 сард нэг жоохон нүүрсний үнэ өндийсөн. Энэ дээр баярлаад цаашдаа өндийнө гэж бодоод байх шиг байна. Тийм юм байхгүй шүү дээ. Яагаад гэвэл нэгдүгээрт Хятадын дотоодын нүүрсний уурхайнуудад бүгдэд

нь шалгалт орж, нэлээн олон хүн асуудалд орж, түүнээсээ болж жоохон ажил нь саатсан.

Хоёрдугаарт нь, Хятадад үер бууснаас болж нүүрсний уурхайнуудын үйл ажиллагаа саатсаны улмаас үнэ жоохон өсөөд, одоо буцаад 9 сардаа ерөнхийдөө гаднаас авахгүй. Энэ Хятад чинь нийтдээ 3.5 тэрбум тонн нүүрс хэрэгтэй. Түүний 3 тэрбумыг нь өөрсдөө гаргадаг улсууд шүү дээ.

Тэгээд одоо энэ нүүрс чинь 9 сард ер нь бол гаднаас нэг их авахгүй, үнэ өсөхгүй гэдэг ийм л зүйлийг ярьж эхэлж байгаа.

► **Хоёрдугаарх нь**, шатахууны хангамж, үнийн эрсдэл байгаа.

20 гаруй үйлдвэр дроноор буудагдчихсан. Одоо Оросын Холбооны Улсад нийтдээ 20 гаруй мужид шатахууны хязгаарлалт хийж байгаа.

Тэгэхээр энэ бол маш том эрсдэл болж хүрч ирнэ шүү. Энэ дээр анхааралтай байгаарай.

► **Гуравдугаарх нь**, гурил, хүнсний ногооны үнийн эрсдэл байгаа.

Хойд нутгаар гантай байсан учраас нэг их сайн ургац авч чадаагүй.

Тийм учраас гурил талхны үнэ өсөх магадлалтай байна. Хүнсний ногооны үнэ өсөх магадлалтай байна.

Энэ гурав чинь инфляцыг бий болгож, орлого буурах нөхцөл байдал бий болох нь байна шүү гэдгийг хэлье.

Гурван хүндрэл байна. Орлого тасарч байгаа.

► **Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого** эхний 7 сарын байдлаар 1.2 их наядаар тасарсан байж байгаа. Оны эцэс гэхэд 2 их наядаар тасрах магадлалтай байна.

► **Төсвийн зарлага** чинь 1.6 их наядаар хэтэрсэн явж байгаа.

► **Төсвийн тэнцэл** ер нь нь 1.3 их наядаар, бүр оны эцсээ гэхэд 2 их наядаар тасрах ийм магадлал байж байна.

Орлого талдаа нэлээн асуудал үүсэх нь.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнэ унасан болон бусад зүйлээс болоод аж ахуйн нэгжүүдийн чинь орлогын татвар 1.1 их наяд төгрөгөөр тасарчхаад байж байна.

АМНАТ-ын орлого чинь 1.2 их наядаар тасарчхаад байж байна.

Ийм ийм хүндрэлтэй асуудал байгаа учраас ирэх оны төсөв дээр энэ орлого олох тэр зүйлүүдээ. Дээрээс нь ханшид нөлөөлөх тэр бүх зүйлүүдээ тодорхой шийдэж явахгүй бол асуудал үүсгэнэ шүү.

Х.Булгантуяа: Б.Пүрэвдорж гишүүн үг хэллээ дээ. Тийм ээ.

Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе.

Монгол Улсын төсөв монгол хүний амьдралын чанарыг сайжруулж, дээшлүүлэхэд л чиглэх ёстой. Манай Засгийн газар хүний хөгжлийг хамгийн том мега төслөө гэж зарласан. Ерөнхий сайд. Хүний хөгжлийн үндэс суурь нь өөрөө эрүүл мэнд, боловсролын асуудал.

Тэгээд төсөвт тавигдсан зардлууд дээр харахад энэ чиглэлээр хэдэн зүйлийг тодруулах шаардлага байгаад байна.

Нэгдүгээрт, Эрүүл мэндийн даатгалын сан өнгөрсөн жилийн төсөв хэлэлцэж байхад ч асууж байсан. Энэ өр төлбөрөөсөө хэзээ гарч хэвийн хэвийн үйл ажиллагаа явуулдаг болох вэ?

Өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын сангаас болоод даатгалаар хөнгөлөлттэй үйлчилгээ авах ямар ч боломжгүй. Очер дараалал үүссэн. Маш олон шат дамжлага дамждаг болсон. Хувийн эмнэлгүүд бараадсан ийм л нөхцөл байдалтай байна.

Тэгээд энэ өр төлбөрийн асуудлыг хэзээ эцэслэн дуусгаж, энэ эмнэлгүүд нь гадна талдаа өр төлбөргүй, даатгалын сангаасаа бүрэн санхүүждэг энэ тогтолцоо нь яг хэдэн сараас эхэлж хэрэгжих юм бэ? 2026 оны төсөв дээр энэ бүрэн туссан уу, үгүй юу? Нэг.

Хоёрдугаарт, боловсролын асуудал дээр. Боловсролын сайд П.Наранбаяр сайдаас асуумаар байх юм. Сайд нь эзгүй байна. Орон нутагт сургуулийн хүрэлцээ Улаанбаатар шиг биш гэж өчигдөр төсвийн хүрээ ярьж байхад сайд хэлж байна лээ. Уучлаарай тийм биш. Өнөөдөр Улаанбаатар хотын энэ сургуулийн хүрэлцээгүй, нэг анги танхимдаа 60, 70-аараа сууж байгаа нөхцөл Эрдэнэт хотод ч байна. Эрдэнэтийн хүүхдүүдийг стандартын дагуу сургуульд суулгадаг болоход дахиад 8 сургууль хэрэгтэй.

Гэтэл өнөөдөр энэ төлөвлөсөн төсвийг нь харахаар эхэлсэн байгаа 2 сургуулийнхаа ажлыг л санхүүжилтийг нь зогсоосон байх юм. Одоо яах юм тэгээд энэ. Үргэлжлүүлж дуусгахгүйгээр.

Рашаант болон Говил багт байх ёстой 250 хүүхдийн 2 сургууль төсөв нь байхгүй. Үргэлжилж чадахгүй. Шинэ юм гуйгаагүй шүү дээ. Ядаж хуучин ажлаа дуусгаж өгөөч. Энэ яагаад хасагдсан юм бэ? Нэг тодорхой хариулт авмаар байна.

Олон жил үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд, 8, 9 жил болж байгаа ажлууд, 10 жил болж байгаа ажил ч байна. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар хоёрыг л би хүний хөгжлийн хувьд онцолж байгаагийн хувьд авч үзсэг юм. Энэ хоёр салбар дээр үргэлжлээд байгаа энэ олон жилийн хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа асуудлууд хэчнээн ажлууд байгаа юм бэ? Үүнийг эрэмбэлж гаргасан уу? Төсөл нь зогссон хэчнээн ажил байгаа юм? Хэчнээн компанитай холбоотой хэдэн тэрбумын асуудал байгаа юм? Үүнийг гаргаж өгөөч.

Мөн төрийн албан хаагчийн 36 сарын тэтгэмжийг он дамжуулна гэдэг ийм томъёолол орж ирсэн. Энэ хүнийх нь тоог он дамжуулах гээд байна уу? Авах ёстой төсөв мөнгийг нь хувааж тавих гээд байна уу?

Сүүлийн асуудал энэ ахмадын тэтгэврийн асуудал дээр тодорхой өөрчлөлт, энэ тэтгэврийн сангийн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хэн хариулах вэ? Боловсролын сайд байхгүй байна. Эрүүл мэндийн сайд эхлээд хариулъя. Боловсролын сайдаа дуудмаар байна. С.Бямбацогт сайд аа. Энэ чинь боловсролын асуудал хамгийн халуун сэдэв болоод гишүүн болгон бараг асуух байх.

Эрүүл мэндийн сайд, Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн даатгалын асуудал бол ноцтой байна. Тусламж, үйлчилгээ жигд хүртээмжтэй байж чадахгүй байна. Тэр ч утгаараа өчигдөр Засгийн газар нөхцөл байдлын танилцуулгыг хийсэн. Тухайлах юм бол байгаа төсөв нь өөрөө хязгаарлагдмал. Тэгсэн хэдий ч ялгаварлан байдлаар санхүүжилтийг шилжүүлдэг байдал нь илэрсэн.

Ийм учраас энэ байдалтай холбоотойгоор Засгийн газрын тэргүүнд хэлсэн. Энэ Ерөнхий газрын даргыг солих асуудлыг танилцуулсан. Энэ асуудлаар Засгийн газар сонсоод тэгээд энэ асуудлаа шийдэх эрхийг нь шилжүүлсэн байгаа.

Тэгэхээр одоо бид сонсголын үйл ажиллагаа эхэлнэ. Дараа нь сонгон шалгаруулалт зарлана.

Тэгэхээр байгаа төсвөө ижил тэгш хамгийн их шаардлагатай байгаа улсууд нь санхүүжилтийг нь хийхгүй бол ялгавартай ханддаг. Аль болохоор л боломжтой газрууд нь санхүүжилтийг нь 100 хувь өгөөд, хамгийн их ачаалал

үүрдэг эмнэлгүүд нь болохоор санхүүжилт нь очдоггүй бөөн өр үүсдэг. Энэ байдал ч гэсэн орон нутгуудад бүх аймгуудад тохиолдож байгаа явдал.

Тийм учраас энэ нөхцөл байдлыг арилгахаар бид үнэхээр сэтгэлтэй хүн тавихгүй бол болохгүй байна.

Одоо Т.Мөнхсайхан сайд 2025 оны эхний улиралд 316 тэрбум төгрөгийг нь хасаад өгсөн шүү дээ. Ямар ч өргүй болгоод өгсөн. Тэгтэл одоо дахиад 148 тэрбум төгрөгийн өр үүссэн. Тэгээд ахиад цаана нь ахиад 130, 140 тэрбум төгрөгийн өр үүснэ гээд байж байгаа байхгүй юу. Энэ болохгүй. Ийм замбараагүй байдлаар ингээд өр үүсгээд, тэгээд л энэ Засгийн газар төлчихдөг юм гэдэг ийм байдлаар хандаж байгаа хандлага нь өөрөө асар буруу байгаа юм.

Тийм учраас байгаа мөнгөө зөв зарцуулдаг сэтгэл дутаад байна гэж дүгнэсэн.

Х.Булгантуяа: Боловсролын яамны Төрийн нарийн байна уу? Ирсэн үү. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд бид хөрөнгө оруулалтуудыг нэмж байгаа.

Тэгээд эрхэм гишүүн таныг энэ боловсролыг дэмжиж үг хэлж байгаад талархал илэрхийлье.

Орхон аймагт хүн амын тооны өсөлтөд тооцоолсон төлөвлөлтөөр нийт 940 суудлын хүчин чадалтай 4 сургууль хэрэгцээтэй гэж гарсан. Эхнээс нь шийдэхээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бид 960 хүүхдийн хүчин чадалтай нэг сургуулийн төлөвлөлтийг оруулсан байгаа.

Би өөрөө Орхон аймагт очиж ажиллаж байхад бас энэ хүн амын нягтаршил ихтэй болсон сургууль, цэцэрлэгийн хүр хүрэлцээ бага байгааг бол яг олж бид өөрсдөө очиж үзсэн байгаа.

Тэгээд ер нь ийм байдлаар бид Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барих юм бол энэ бол ер нь нэлээн дулаан... /минут дуусав/

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайдад нэмж микрофон өгье.

П.Наранбаяр: Ингэх юм бол энэ сургууль маань өөрөө пассив технологи ашигласан, бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан, тэгш хүртээмжтэй ийм орчин бүрдүүлсэн сургуулиуд баригдана.

Дутуу оруулсан байгаа энэ 2 сургуулийн асуудлыг бид мэдэж байгаа. Энэ хүрээндээ ярилцаад ер нь энэ удаад бид 198 төсөл, хөтөлбөрийг ер нь гүйцээх, дуусгах санхүүжилтийн эх үүсвэрийг тавьсан байгаа.

Орхон аймаг нэлээн өндөр хэрэгцээтэй байгаа гэж үзэж байгаа учраас энэ юманд нь оруулаад ингээд явах боломжтой гэж харж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бусад асуудлууд дээр Б.Жавхлан сайд нэмж хариулах уу? Төрийн албан хаагчдын 36 сар, ахмадын тэтгэврийн асуудал.

Б.Жавхлан: Тийм. Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Иргэд ч тэр, ер нь хойтон тэтгэвэрт гарах нас нь дөхөж байгаа төрийн албан хаагч нар ч гэсэн үүнийг нэлээн асууж байгаа.

Тэгэхээр үүнд санаа зовох зүйлгүй. Бид хөгжлийн төлөвлөгөөндөө урсгал зардлаа 24 хувьд бариул гээд үүрэг авсан байгаа.

Тийм учраас маш их зардлууд бид хэмнэх, зохицуулалт хийх, түр хойшлуулах арга хэмжээнүүдийг авахаас өөр аргагүй. Харин төрийн албан хаагч нарын нэг удаагийн тэтгэвэрт гарахад нь өгдөг тэтгэмж хуульд ямар ч өөрчлөлт ороогүй. Оруулах төлөвлөгөө ч байхгүй байгаа.

Тийм учраас олгох ёстой. Төрийн үүрэг нь энэ байгаа юм. Харин эх үүсвэрийнхээ боломжид тааруулаад ирэх жил 50 хувийг нь өгнө. Он дамжуулаад үлдсэнийг нь өгөх ийм зохицуулалт хийж байгаа.

Энэ бол анх удаа хийж байгаа зохицуулалт... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Тийм. Анх удаа ингээд нэг цочром хийж байгаа зохицуулалт биш. Өмнө нь зөндөө л хийж байсан ийм зохицуулалт.

Тэгэхээр хойтон тэтгэвэрт гарах сар, улиралыг төсвийн ерөнхийлөн захирагч нар үүнийгээ тааруулж зохицуулах хэрэгтэй. 10, 11, 12 сард тэтгэвэрт гарч байгаа улсуудад тал мөнгөө аваад, талыг нь он гараад авч болно. Эсвэл тэтгэвэрт гарах улсуудыг ажлын байрыг нь үргэлжлүүлж 2027 он руу шилжүүлэх гэх мэт. Мөн оны эцэс рүү гардаг төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэмнэлтийг төсөв дотроо зохицуулалт хийгээд нэмж олгох гэх мэт маш олон хувилбар, боломжууд байгаа.

Тийм учраас эндээс айхтар тэгж хохирол гарахгүй гэдгийг албан ёсоор хариуцлагатай хэлье.

Тэтгэвэр дээр бол өчигдөржингөө л хэдүүлээ үүнийг тайлбарлалаа даа. Бид ирэх жил хуулийн дагуу нэмж байгаа том дүнтэй цорын ганц санхүүжилт маань энэ байгаа. 6 хувь гэдэг бол бага мөнгө биш.

Х.Булгантуяа: Д.Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Эрүүл мэндийн сайдаас тодорхой тодруулж асууя.

Төсөв нь байгаад хариуцсан хүмүүс нь хангалтгүй ажилласнаас Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд ийм гажуудал үүсжээ. Хүнээ солихоор 2026 онд Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой асуудал үүсэхгүй нь гэж үзэж болох уу? Энэ байгаа мөнгөөр. Нэг.

Хоёрдугаарт, Боловсролын сайд. Би таны оруулаад ирсэн төсөв дотор хасагдсан байгаа 2 сургуулийн дутуу барилгыг хэлээд байгаа юм.

Тэгээд боломжтой гээд байх юм. Одоо хэн нэмэх вэ? Та төсөвтөө багтаасангүй шүү дээ.

Гуравт нь, энэ тэтгэврийн тогтолцоотой холбоотой асуудал дээр бид өнөөдөр хэдэн хувь нэмэх вэ гэдэг асуудлыг жил болгон яриад сууж баймааргүй байна. Тэтгэврийн сангийнхаа менежмент, удирдлага, энэ хууль эрх зүйн орчныг Засгийн газраас хэзээ өргөн барьж, хэзээ өөрчлөх юм бэ? Улс төрчдийн шийдвэр гараад л энэ сан чинь ер нь дампуурдаг тогтолцоо руу орох гээд байна шүү дээ. Улс төрийн шийдвэр үндэслээд.

Тэгэхээр энэ дээр ямар өөрчлөлт бодож байгаа юм бэ?

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд эхлээд хариулъя. Тэгээд Б.Жавхлан сайд хариулах уу?

Ж.Чинбүрэн: Д.Үүрийнтуяа гишүүн ээ, хүнээ солиод мэдээж бүх юм шийдэгдэхгүй шүү дээ.

Тэгэхээр 2026 онд бид энэ төсөвтэй холбоотой эрүүл мэндийн даатгалыг бэхжүүлэх, сайжруулах хөтөлбөр давхар өгсөн байгаа. Ингээд Сангийн яамтайгаа тохироод бид хэд энэ даатгалын тогтолцоо цоорхой шүүр шанага шиг болчихоод байгаа энэ шүүр шанаганы цоорхойг нь битүүлэх ажлыг 2026 онд хийнэ.

Мөнгө хүрэхгүй. Хангалттай биш. Тэгэхдээ ядаж хулгайлдаггүй, цоорхой нүхээр нь гоождоггүй л байвал энэ болно.

Хүний манлайлал чухал. Сэтгэл чухал. Би түрүүн хэллээ. 2025 онд мөнгө дутаагүй. Бүхэл бүтэн 316 тэрбум төгрөг. Тэр өр төлөөгүй байсан бол энэ чинь хангалттай хүрэх гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас энд гол нь сэтгэл дутаад байна.

Хоёрт, алагчлахгүй байх хэрэгтэй. Энэ жоохон хиймэл оюун ухаан оруулах, нэхэмжлэхийг хүн хоорондоо харьцдаг биш хиймэл оюун ухаан, цахим системээр харилцдаг баймаар байна шүү дээ. Авлигалын тогтолцоог байхгүй болгоё.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя. Тэгээд П.Наранбаяр сайд.

Б.Жавхлан: Ж.Чинбүрэн сайд хоёулаа үүнийг үнэнийг нь хэлье.

Ирэх жилийн төсвөөр Эрүүл мэндийн даатгалын сангийн энэ өр төлбөр үүсээд байгаа асуудал цэгцлэгдэхгүй. Амжихгүй. Менежмент нь дутаад байна уу, мөнгө нь дутаад байна уу.

2025 оны төсөв дээр жишээ нь энэ өр төлбөртэй асуудал нь ковидоос хойш энэ яваад байгааг дуусга гээд уг нь төсвийг нь хангалттай тавьсан байгаа юм. Гэтэл дахиад өр төлбөр үүснэ гээд байгаа юм.

Сая Ж.Чинбүрэн сайд очоод шалгалт хийсэн. Хамгийн эхний шалгалтын дүнгээр л гэхэд энэ жилийн зарцуулалтыг нь харахад хамгийн их масс ачаалалтай нөгөө улсын эмнэлгүүдийнхээ асуудлыг шийдэх биш нөгөө хувийн эмнэлгүүдийнхээ асуудлыг бүгдийг нь шийдчихсэн байгаа юм.

Тэгэхээр тэнд сэтгэл дутаад байна уу, мөнгө дутаад байна уу. Энэ асуудлыг эхлээд цэгцлэх хэрэгтэй. Энэ менежментийг нь сайжруулах ёстой.

Сая яг энэ Ж.Чинбүрэн сайдын хэлж байгаа шиг одоо тэр мөнгө хийгээд байдаг, хийгээд байдаг. Нэг ёроолгүй сав шиг цаашаагаа асгараад байгаа юм.

Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо анх... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж 1 минут.

Б.Жавхлан: Энэ гүйцэтгэлд суурилсан Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо 2021 онд анх эхлэхэд төсөв нь 1.2 байсан юм. Ирэх жил 2.2 болж байгаа. Хоёр дахин нэмэгдсэн байгаа.

Тусламж, үйлчилгээ хоёр дахин нэмэгдсэн үү. Эрүүл мэндийн салбарын, анагаах ухааны салбарын үр дүн, эрүүл мэндтэй холбоотой асуудлууд хоёр дахин сайжирсан уу. Энэ бүгдийгээ маш сайн эргэцүүлж харж энэ дээрээ яг сангийн даатгалын яг сонгодог тогтолцоогоо эрс шинэчлэл хийх ёстой гэдэг дээр салбарын сайдтай санал нийлсэн. Энэ рүү бүх ажлуудаа чиглүүлээд явах ёстой. Тийм.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Түрүүн цаг хавчигдаад уучлаарай жоохон дутуу хариулчихлаа.

Тэгэхээр Орхон аймагт Рашаант, яг Эрдэнэтийн тэр Рашаант, Говил гээд 2 баг дээр тус тус 2 сургууль, 1, 1 сургууль баригдаж байгаа. Тэгээд энэ 2020 оноос хойш баригдаад одоо хүртэл орон нутаг руу эрх нь шилжчихсэн. Одоо хүртэл дуусдаггүй. Энэ барьж байгаа компаниуд нь ажлаа орхиод явсан гэсэн ийм ноцтой зүйлүүд гарсан.

Гэхдээ бид Үндэсний аудитын газарт 109 ийм төсөл, арга хэмжээг явуулснаас 59 дээр нь дүгнэлт нь гараад хүрээд ирсэн. Тэр нь дуусахаар туссан. Одоо энэ дүгнэлт нь энэ хугацаанд нь ороод ирвэл бид төсөвт нь тусгаад дуусгуулахаар ажиллаж болно.

Тэгэхээр зэрэг энэ Үндэсний аудитын газраас дүгнэлт гарахыг хүлээж байгаа. Ийм нөхцөл байдалтай байгаа.

2024 онд Орхон аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн ийм нөхцөл байдалтай байгаа. Ер нь дуусгахгүй бол энэ бол бүх хүүхдүүд хохирч байна. Өөрсдөө, орон нутаг өөрөө хохирч байгаа ийм л нөхцөл байдалд байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Д.Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: П.Наранбаяр сайд аа, аудитын дүгнэлт нь гарсан байхгүй юу даа. Гарсан учраас би хэлээд байгаа шүү дээ. Гарчихсан. Аудит дүгнэлтээ гаргаад, магадлал ороод энэ барилгыг дуусгахад ямар хэмжээний мөнгө хэрэгтэй вэ гэдэг нь тодорхой болсон асуудал.

Нэг нь 2019 онд, нэг нь 2020 онд эхэлсэн хоёр ажил. Энэ ажлыг дуусгах асуудлыг Та аудитын дүгнэлт гарвал оруулна л гээд байх юм. Нэгэнт таны багцад багтахгүй бол яаж орох юм? Аудитын дүгнэлт гарсан гэдэг мэдээлэл нь ирсэн байна шүү дээ. Надад.

9 сарын 01-нээс хойш гарсан байвал тэгээд одоо яаж оруулах юм? Эсвэл таны багцаас зарчмын зөрүүтэй санал гаргах боломжтой юм уу? Та болно гээд байх юм. Үүнийг нэг тодорхой болгоод өгөөч.

Надад өнөөдрийн байдлаар ирсэн мэдээллээр аудитын дүгнэлт нь гарсан байна. Энэ чинь сайдын багц юм байгаа биз дээ.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Саяын таны яг нэр дурдсан тодорхой төсөл, арга хэмжээний хувьд Засгийн газар хугацаандаа төсвөө өргөн барих үед буюу 9 сарын 01-нээр Үндэсний аудитын газраас дүгнэлт ирээгүй учраас өргөн барьсан төсөвт багтаагүй.

Одоо энэ төсвийн асуудал Засгийн газрын гараас гарсан. Их Хурлын мэдэлд ирсэн.

Тийм учраас бид энэ дээр коммент хэлэх ямар ч арга алга.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа.

Б.Найдалаа: Төсөвтэй холбоотой нарийн зүйлсээрээ Байнгын хороо дээрээ асуучихна. Өнөөдөр бол яг энэ чуулган дээр нэг асуумаар бас нэг чухал зарчмын зүйл байна.

Одоо бид ингээд төсөв зоочхоод алдагдалтай, алдагдалгүй гээд. Тэгээд түүн дээрээ маргалдаад байгаа. Тоон дээр маргалдаад байгаа байхгүй юу. Гол нь энэ төсвийн цаана нь агуулга байгаа, схем, бүтэц байгаа, зохион байгуулалт байгаа. Тэр талыг нь шинэчлэх талаар ямар ажил хийж байгаа вэ гэдэг талаас асуух гэж байна.

Жишээлбэл, төсвийн хөрөнгө оруулалт сүүлийн 10 жилд 8 дахин өссөн байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн сүүлийн 20 жилд 2005 оноос хойш 10 дахин өссөн байгаа.

Яг энэ чинээгээр эдийн засгийн өсөлтийн чадавх бүрдсэн үү, иргэдийн орлого сайжирсан уу гэдэг л яг бид нарын гол асуулт байгаад байгаа юм л даа.

Төсвийн хөрөнгө оруулалтын гол үр дүн бол ердөөсөө л эдийн засаг төрөлжөөд, иргэдийн орлого тараад бүгдээрээ өндөр болсон байх ёстой. Энэ байхгүй байгаад байгаа байхгүй юу. Яг л адилхан нөгөө уурхайгаараа тэжээгдсээр, уул уурхай нүүрснээс хамааралтай байгаад байгаа юм.

Тэгэхээр хөрөнгө оруулалтын үр өгөөж ямар байна вэ? Энэ дээр ямар нэгэн дүгнэлт шинжилгээ хийж байна уу? Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын эрэмбийг яаж хийж байгаа вэ? Энэ дээр дүгнэлт хийхгүй бол Монгол Улс хэзээ ч ямар ч баяжсан хөгжихгүй. Тэгээд энэ дээр ямар дүгнэлт хийж байгаа юм.

Нэгт нь, улсаа биш улс төрийг харж байгаад эрэмбэлээд байх юм бол Монгол Улсад ахиц гарахгүй.

Хоёр дахь нь, төрийн албыг 9 хувиар орон тоог цомхотгоё гэсэн байгаа. Зөв. Үүнийг дэмжиж байна. Харин дахиад тооцоо судалгаа, шинжилж дүгнэлт хийхгүйгээр хавтгайруулаад боловсрол, эрүүл мэндээс бусад гэж байгаад хасаж

байгаа нь зарим газраа эмзэг тусаж байна лээ шүү. Яг аль нь чухал юм, аль нь илүүдэлтэйг дүгнэлт хийхгүйгээр зүгээр хавтгайгаар хасах юм бол энэ үр дүнгүй.

Хэрвээ ингээд хассан ч гэсэндээ ирэх жилүүдээс дахиад л гараад ирнэ. Тэгээд энэ бол төрийн албаны яг тэр эрэмбэлсэн, судалсан шинжилгээгүйгээр хийх юм бол энэ үр дүнтэй ажил болохгүй. Зөвхөн нэг удаагийн дүр эсгэсэн ажил болно гэж бодож байна.

Бас нэг зүйл байна. Одоо жишээлбэл бид яг төсвөө нэмээд байдаг. Хуучин тэр бүтэц байна. Жишээлбэл, суман дээр байгаа соёлын төвүүд, сургууль, ер нь зүгээр нийгмийн чиглэлтэй тэр төвүүд яг бүтэц нь 1985 оныхоороо байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл социализмын үеийн зорилгоор байгаад байгаа юм. Бүтцээрээ.

Тэгэхээр энэ хуучин бүтцээ шинэчлэхгүйгээр хөрөнгө хийгээд байх юм бол хэзээ ч бид зардлаа дийлэхгүй. Хөрөнгө оруулалтыг нь ч дийлэхгүй, урсгал зардлыг нь ч дийлэхгүй. Ийм болохоор түрүүний хэлдэг төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж ингээд муу гараад, яг эдийн засгийн өсөлтийг бий болгохгүй нүүрснээс өөр орлогогүй ядуу хэвээрээ байгаад байгаа.

Тэгэхээр яг энэ “сум” гэж яг юу юм? Энэ дээр яаж амьдрах юм?

- Нийгэм өөрчлөгдсөн байна.
- Иргэд өөрчлөгдсөн байна.
- Технологи өөрчлөгдсөн байна.

Тэгэхээр XXI зууны Монгол Улсын “сум” гэж ямар байх юм, “баг” гэж ямар байх юм гэдгээ шинэчилж тогтоохгүй бол тэрийгээ дагуулаад нөгөө “сумын төв”, “сумын сургууль”, “сумын эмнэлэг”, сумын... /минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайд эхлээд хариулъя. Тэгээд тодруулъя.

Н.Учрал: Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулиар бид их олон бодлогын баримт бичигтэй юм.

Түрүүн С.Ганбаатар гишүүний хөндөөд байгаа 5 жилийн үндсэн чиглэл бол хуулиар 10 сарын 31-ний өмнө Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ингээд энэ 5 чиглэл бол 8 зорилтот хөтөлбөртэй.

Тэгэхээр энэ зорилтот хөтөлбөрийн нэг нь өөрөө “хүний хөгжлийг дэмжсэн бодлого”. Үүнд нийцсэн “улсын жилийн төлөвлөгөө” гаргаад, улсын жилийн төлөвлөгөөнд төсөв нийцэж байна уу эсэх дээр зөвшөөрөл Эдийн засаг, хөгжлийн яамнаас олгодог.

Яг үүний дагуу улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд байгаа хөгжлийн төслүүдийг эрэмбэлэх ажлыг сая Засгийн газар хийж дуусгасан. 4 бүлэг, 14 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Энэ олон улсын аргачлал.

Ингээд 1-ээс 5 оноогоор энэ үзүүлэлтүүдийг дүгнэдэг. Үүнд макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, төслийн бэлэн байдлын үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэр, нийгмийн нөлөөллийн үнэлгээ буюу SOCIAL IMPACT нь ямар байх вэ гэдэг дээр.

Ингээд энэ нөлөөллийн үнэлгээнүүдийг хийж дуусаад, энэ хүрээндээ ач холбогдол өндөртэй эхний 40 төсөл гээд эрэмбэ гарсан. Энэ төслүүд нь:

- ажлын байр нэмэгдүүлэх,
- шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх,
- технологийн агууламж шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих чиглэлийн ийм төслүүд.

Тэгэхээр энэ төслүүдийн санхүүжилтийг улсын төсвөөр бүгдийг нь шийдэх бололцоогүй учраас “улсын жилийн төлөвлөгөө”-нд улсын төсвөөр санхүүжих **126** төслийн

- **76** төсөл нь улсын төсвөөс,
- **50** төсөл нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр

хэрэгжүүлнэ гэдэг зорилгоор энэ үе шатууд хүнд суртлуудыг төсөв дагасан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар өөрчилж, 21 аймагт бие дааж нутгийн өөрөө удирдах байгууллагаараа дамжуулж төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд хэрэгжих бололцоог нээж байгаа.

Ингээд бид энэ төслүүдээ эрэмбэлсэн бол эргээд дүгнэнэ. Үүний үр дүнд Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын ажлын хэсэг дээр яригдаж байгаа. Бид цаашдаа жилийн төлөвлөгөө ч байсан, 5 жилийн чиглэл ч байсан ерөөсөө индикаторуудаа заана. Тэгээд индикаторууд нь гэвэл шалгуур үзүүлэлтүүд.

Ингээд ажил хийсэн гэдэг нь зүгээр нэг уулзалт хийгээд, зургаа авхуулаад тавьсныгаа 100 хувь гэж үнэлдэг биш, тэр зорилтот түвшинд хүрсэн үү гэдэг нэг дээр нь үнэлгээ өгдөг ийм зарчим руу шилжинэ.

Тийм учраас “төлөвлөлт”, “төсөвлөлт”, “хяналт-мониторинг” гээд дизайн хийгээд, “мониторинг” хийгээд “үнэлгээ” хийх. Энэ бол бүтэн циклээр явна гэж ингэж зорьж байгаа.

Тийм учраас хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 10 дугаар сарын 30-нд 5 жилийн чиглэлийг барих үед бид оруулж ирэх ёстой. **“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”** гээд.

Тэгэхээр түүн дээрээ хөрөнгө оруулалтуудыг хэрхэн, ямар үе шаттайгаар зохион байгуулах вэ гэдгийг оруулна. Үүнд нийцэж байж тэр гадаадын зээл, тусламжууд авах эсэх, аль аль төслүүдийн ямар санхүүгийн эх үүсвэрээр шийдвэрлэх вэ эсэхийг нь харилцан үнэлээд явдаг ийм зарчим руу шийдэж байгаа.

Тэгээд төсвийн эх үүсвэрийг бол макро агуулгаар нь “хөрөнгө оруулалтын зардал”-д хийвэл тэр “үржүүлэгчийн нөлөө”, “үр дүн”, “урсгал зардал”-д хуваарилсан бол ямар үр нөлөөтэй вэ гэдэг агуулгаар нь бид харах ёстой.

Тэгээд энэ утгаараа бид энэ үнэлгээнүүдийг хийж дууссан. Эрэмбүүдийг гаргасан.

Засгийн газрын 14 мега төслийг бас 5 ач холбогдолтой төсөл, тэр санхүүжилт олох 4 төсөл түр хугацаанд дараа жил биш тэрний дараа жил рүү хойшлох, эхний 5 төслийн хэрэгжилтийг хангуулахад Засгийн газрын зүгээс арга хэмжээ авч ажиллах гэсэн чиглэлүүдээр эрэмбэлсэн.

Х.Булгантуяа: Б.Найдалаа гишүүн нэмж тодруулъя. Б.Жавхлан сайд нэмж хариулт.

Б.Жавхлан: Энэ минут жоохон багадаад байна шүү.

Улсаа биш улс төрөө харвал бүтэхгүй гэж байгаатай 100 хувь санал нийлж байна. Тийм. Одоо яг ингэж явдаг бол үгүй мөн сайн байна.

Одоо энд хөрөнгө оруулалтууд дээр янз янзын л юм яригдах байх. Манай сумын, манай багийн тийм гүүр болохгүй байна, манай сургуулийн дээвэр нурсан, болсонгүй гээд тийм л юм уг нь бага яривал таны ярьж байгаатай санал нийцэх байгаа юм. Тэр чиглэл рүүгээ энэ хурал явж байгаа байх гэж найдаж байгаа.

Эдийн засгийн бүтэц ярьж байна. Бид маш олон жил ярьж байгаа. Эдийн засгаа төрөлжүүлэх ёстой. Уул уурхайгаас хамаарлаа багасгах ёстой гээд. Хамгийн гол юм юу вэ гэхээр энэ дээр зүгээр л дэд бүтэц. Өөр юу ч бодоод хэрэггүй. Энэ зөв чиглэл рүүгээ бид явж байгаа.

2026 оны төсвөө харъя.

- Нэгдүгээрт, эрчим хүч байна.
- Хоёрдугаарт, зам байна.

Эд нар нь хүссэн хүсээгүй өөрөө дэд бүтэц том дүнтэй учраас ингээд явчхаж байгаа юм. Сүүлийн жилүүдэд.

Энэ том дүнтэй яваад ирэнгүүт үгүй энэ чинь юу болж байна. Боловсрол хоцорсон байна, эрүүл мэнд хоцорсон байна. Гэнэт... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр хөрөнгө оруулалтын ерөнхий бүтэц маань зөв чиг хандлага руугаа явж байгаа. Улс төржиж байгаад хазайж байгаа тэр хазайлтууд нь ер нь хэр байх нь яг өнөөдөр л энд шийдэгдэнэ.

Тийм учраас зөв чиглэл рүүгээ явж байгаа гэдэг дээр би итгэлтэй байгаа гэдгээ хэлье.

Тэр 9 хувь бол мэдээж эмзэг. Хүнийг ажилгүй болгоно, ажлаас нь хална, цөөлнө гэдэг хүнд хэцүү. Гэхдээ нөгөө юу гэдэг билээ “дайн гэдэг чинь хүсээд байгаа юм биш, тулаад ирвэл буцах юм биш” шүү дээ. Одоо тэгээд нэгэнт Их Хурал дээрээс хөгжлийн төлөвлөгөө дээрээ оруулсан, эхэлсэн юм чинь төсвийн ерөнхийлөн захирагч нар маань энэ төсөв дотроо багтаагаад энэ менежментээ зөв л хийгээсэй.

Тэр сумын бүтэц гэдэг зөв өө. Энэ чинь ер нь 80 хэдэн оныхоороо биш бүр 30-аад оныхоороо явж байгаа шүү. Энэ аймаг, сумын бүтэц чинь. Тэр үед өртөө маань, тээврийн хэрэгсэл маань ерөөсөө морин өртөө л байсан учраас морин өртөөний хүрэх зайгаар энэ сумдынхаа газрын зургийг хийсэн юм. Одоо чинь тээврийн хэрэгсэл маань бараг дрон болчихлоо.

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд. Тэгээд Т.Доржханд сайд.

Ж.Чинбүрэн: Монгол Улсын өргөн уудам дэлгэсэн тэрлэг шиг энэ нутагтаа эзэнтэй байлгах том бодлого бол үндэсний том зорилго.

Тэр утгаараа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ өнцөг булан бүрд хэнийг ч орхигдуулахгүй хүрдэг байх нь өөрөө их чухал. Тэр ч утгаараа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сум, багаар байх нь зөв гэдэг дээр би Эрүүл мэндийн сайдыг төлөөлж байгаа хүний хувьд зөв гэж боддог. Тухайлах юм бол 2009 онд гарсан H1N1 халдварын үед 10 сард Монгол Улс яаж сандарч байлаа. Сая 2021, 2022 онд 2 жил дамнасан ковид цар тахлын үед яав.

Энэ босоо эрүүл мэндийн тогтолцоо, тэгээд өнцөг булан бүрд хүрдэг тусламж, үйлчилгээ олон олон иргэдийн амь насыг аварсан учраас энэ тогтолцоо эрүүл мэндийн салбарын хувьд зөв шүү.

Тийм учраас бидний бодлого бол сум, баг болгон эмчтэй байх, тоног төхөөрөмжтэй байх, хөлдөө унах унаатай байлгахын төлөө хичээж ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Х.Булгантуяа: Т.Доржханд сайд.

Т.Доржханд: Б.Найдалаа гишүүн эдийн засаг цаашаагаа яах юм бэ, бүтэц ямар байх юм бэ гэдэг дээр л асуугаад байна л даа. Би санал нийлж байгаа юм нь юу вэ гэхээр сүүлийн 4 жил яг энэ асуудлыг л хөндсөн.

Монгол Улс том газар нутагтай, цөөхөн хүн амтай.

Дэлхий дээр том газар нутагтай, цөөхөн хүн амтай хөгжсөн улс байдаггүй. Хоёрхон улс л байгаа.

▷ Нэг нь, Канад байгаа.

▷ Нэг нь, Австрали байгаа.

Австрали бол нийт том газар нутгийнхаа 2-хон хувь дээр л ажиллаж амьдарч, дэд бүтцээ угсардаг.

Канадын хувьд тэр тавьсан цементэн замын хэмжээ нь Монголоос бага. Манайх том газар нутагтай гээд 330 хувааж хаяад, тэгээд тэнд 500 хүнтэй сумын төв рүүгээ цахилгаан эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд байх ёстой гээд явсныхаа 70 жилийн үр дүнд шилжих рублиэр 10 тэрбум долларын өртэй болсон.

35 жилд бид өөрсдөө менеж хийгээд явж байна гээд чадахгүй. Дандаа л төсвийн алдагдалтай. Маш хүнд байгаа.

Одоо тэгэхээр үүнийгээ бид засаг захиргаа, нутаг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Т.Доржханд сайд 1 минут.

Тэгэхээр цаашаагаа яаж хөгжих юм бэ гэхээр том газар нутгийн давуу тал бол газрын доороо байгалийн нөөцтэй давуу талтай. Үнэн. Гэхдээ нөгөө талдаа бид бүх тийшээ дэд бүтцийг тараагаад байршуулах юм бол энэ бол ямар ч боломж байхгүй. Дэлхий дээр ингэж хөгжсөн нэг ширхэг ч улс байхгүй.

Тэгвэл одоо бид төвлөрөл рүүгээ явах ёстой. Ингэхийн тулд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлээ хийж байж эдийн засгийн асуудлыг шийднэ. Энэ бол Үндсэн хуулийн асуудал болдог. Тэгээд өмнөх 4 жил энэ асуудлыг гаргаж ирээд шийдэж чадаагүй.

Цаашаагаа бид том зургаараа хөгжье гэж байгаа бол энэ зохицуулалтаа Үндсэн хуульдаа оруулж, эдийн засгийн зохицуулалтуудыг оруулж байж л энэ асуудлаа шийдэхгүй юм бол үе үеийн парламент төсөв дээрээ асуудал үүсгэдэг, тойргоос сонгогдсон гишүүд нь зовлон ихтэй. Тэгээд тэнд төрийн үйлчилгээг яаж хүргэх вэ л гэдэг асуудал дээр эргэлзсээр байгаад л, хий эргэсээр байгаад л таарна.

Тэгэхээр цаашаа хөгжье гэх юм бол энэ рүү зоригтой л орох хэрэгтэй. Ийшийгээ харин явж байгаа зүйл нь бид бүсчилсэн хөгжил рүү явж байгаа.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр орон нутгийн, ялангуяа сумын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн шинэчлэлийн асуудал бол бас төрийн үйлчилгээг хэрхэн ард иргэддээ тэгш, хүртээмжтэй үргэх вэ гэдэгтэй шууд холбогдоно.

Боловсролын хувьд ер нь бага боловсролыг багийн хэмжээнд нь, сумын хэмжээнд нь олгоод, тэгээд хүн амын нягтаршил, хэрэгцээг нь харж суурь боловсролыг мөн сумын хэмжээнд нь олгоод, ахлах сургуулийн хэмжээнд сум дундын ахлах сургууль. Түүн дээрээ дотуур байрыг нь бүрдүүлсэн нөхцөл байдалтайгаар гэсэн ийм байдлаар явах нь өнөөгийнхөө нөхцөл байдалд бид төсвийг оновчтой зарцуулахад илүү зохицох юм болов уу гэсэн байдалтай хардаг.

Ийм учраас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлнэ гэсэн том бодлого явж байгаа.

Ерөөсөө суманд 12 дугаар ангигүй сумууд байж байна шүү дээ. Тэгээд бас багшгүй. Ийм нөхцөл байдал дунд бид сум дундын ахлах сургуулийг хөгжүүлэх... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Найдалаа гишүүн нэмж тодруулъя.

Б.Найдалаа: Ойлголоо. Түрүүн Т.Доржханд сайдын хэлж байгаа тэр санааг л хэлээд байна л даа.

Дэд бүтцэд хөрөнгө оруулах нь зөв. Зүгээр хаана юм? 360 сумдаа эв ижилхэн хуваагаад хөрөнгө оруулах юм бол бид элс рүү ус хийсэнтэй адилхан болоод байгаа юм. Үр дүн үзэхгүй байгаа юм.

Суман дээр буруу ойлгочих вий. Сум гэж байгаа нь сумыг заавал миний санаа бол цөөлнө гэхдээ биш. Сум гэдэг газар сургууль ямар байх юм, эмнэлэг ямар байх юм. Яавал хооронд нь уялдуулах юм. Түүнээс чиг үүрэг гээд яам болгон өөрийн нэг салбартай юм шиг болоод, пирамид үүсгээд тэрийгээ төсвөөс санхүүжүүлээд уралдах юм бол үр дүнгүй болоод байна. Иргэд үүнийг хүсэхгүй байна. Өөрсдөө хэлж байна.

Соёлын төвийг өөр болгомоор байна. Нийгмийн ажилтнууд нь авчихмаар байна. Нөгөө соёлын довтолгооны биш, орчин үеийн нийтийн төв болгомоор байна гэсэн санаа явж байна лээ. Энэ дээр ажиллах хэрэгтэй байна.

Тэгээд ер нь зүгээр ямар ч байсан төсвийн тоо ярихаасаа гадна цаанаа бодлогын чанартай эрэмбэлэх бүтцийн асуудлыг ярихгүй бол бид яг

боловсролыг дэмжээд байгаа юм шиг хэрнээ багш нь цалингүй, сургууль нь мөнгөгүй, бүгд жагссан байдалтай болоод байгаа юм.

Тэгэхээр яг ийм урт хугацааныхаа бодлого болон ялангуяа төсөв... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Найдалаа гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара.

М.Нарантуяа-Нара: “Иргэн баян бол улс баян” гээд байдаг. Гэхдээ яг үнэндээ одоохондоо баян байх бол үнэхээр дүүрсэн асуудал байна.

Яагаад гэвэл Монгол хүний хамгийн анхдагч, ер нь хүний хамгийн анхдагч хэрэгцээ болсон хоол, агаар, ус тийм ээ, байр орон гээд ийм зүйлүүд, амьдрах таатай орчнууд нь бүрэн хангагдаагүй энэ цагт юун баяжих тухай асуудал байна л даа.

Тэгэхээр манай Монгол Улсад наад зах нь хүний анхдагч хэрэгцээ болсон байр, орон сууцаар хангагдсан иргэдийн тоо хэд байгаа юм бэ? Нийт иргэдийн хэдэн хувь нь байр, орон сууцаар хангагдчихсан дараагийн баяжих хүсэл рүүгээ ингээд явж байгаа юм бэ гэдэг асуудлыг хөндмөөр байгаа юм.

Тэгээд энэ тал дээр бид төр, засгийн бодлого оновчтой хэрэгжиж чиглэж чадаж байгаа юу гэдэг асуултуудад иргэдийн өдөр болгон амандаа ярьж байгаа, өдрийн бодол шөнийн зүүд болсон байр, оронтой болох. Тийм ээ. Байр, орон сууцтай болох энэ хүсэл мөрөөдөл үнэхээр их эмзэг асуудал байгаа.

Тэгэхээр манай Монголын залуучууд, иргэдийн асуудал, ялангуяа шинэ залуу гэр бүлүүдийн хувьд бол Монгол Улсдаа хамтын сайхан амьдралыг эхлүүлээд, хамтын сайхан амьдралыг босгоод, байр, орон сууцаар хангагдаад ингээд явах тийм боломж хэрхэн хангагдсан байгаа юм?

Тэгээд бүх хүмүүсийн ярьж байгаа юм нь байрны түрээс маш өндөр болсон. Тэгээд иргэд өөрсдийн гэсэн орох оронтой болох боломжгүй байна. Хөдөлмөр нь үнэлэгдэхгүй байна.

Тийм учраас гадаадад гарч байрны мөнгө хийх хүсэлтэй залуусын цуваа маш их болоод байж байна.

Тэгэхээр нэг зүйл. Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм.

Энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 4 сараас хэрэгжиж эхлээд батлагдаад, мөрдөгдөж байгаа. Тэгээд энэ дээр үнэхээр нэг талархууштай зүйл байна. Бараг бүх л сан юмнууд нь хоосорсон, дампуурсан, хулгайд идэгдсэн байдаг Монгол Улсад энэ Үндэсний баялгийн санд өнөөдрийг

хүртэл, зөвхөн Ирээдүйн өв сан гэхэд 4.7 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний хуримтлал үүссэн байгаа нь үнэхээр бахархалтай.

Гэхдээ нэг зүйлийг гайхаад байгаа юм. Бид дотооддоо наад зах нь монгол хүн бүр, бараг худалч хүнд, ялангуяа залуу гэр бүлүүд бүгдээрээ энэ ипотекийн зээлийн 6 хувийг авах юмсан гээд мөрөөдөөд, ар өврийн хаалга хайгаад явж байгаа энэ цаг үед Монгол Улс өөрөө энэ мөнгөө гадаадын банканд 4.4 хувь, 3 хувь орчим мөнгөөр байршуулаад хүүлээд байдаг нь яг ямар учиртай вэ?

Эхлээд Монгол Улсдаа байгаа асуудлаа шийдэхийн тулд өөрсдийнхөө боломжийн энэ мөнгийг энэ асуудлаа шийдэхэд зарцуулах ёстой юм биш үү? Гэтэл бид ингээд гадаадаас зээл, тусламж бүтээн байгуулалтын гээд л өндөр хүүтэй зээл юм хум, мөнгө төгрөг ингээд л хайгаад л яваад байдаг. Өөрсдөдөө байгаа боломжийг гадаадад ингэж тарамдаж хаяж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Г.Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Нараа гишүүний асуултад хариулъя.

Нараа гишүүн хамгийн чухал асуудал хөндлөө. Өнөөдөр Улаанбаатарын агаарын бохирдол, хөрсний бохирдол ямар хэмжээнд байгааг хүн болгон мэдэж байгаа.

Ийм учраас манай Засгийн газраас Орон сууцжуулалтын банк байгуулах санаачилга гаргаад, манай С.Бямбацогт сайдаар ахлуулсан ажлын хэсэг, манай Э.Бат-Амгалан сайд 80 мянган айлын орон сууцын хөтөлбөр хэрэгжүүлж, яг энэ чиглэлээр ажиллаж байна.

Үндсэндээ 260 гаруй мянган иргэд гэр хороололд амьдарч байгаа XXI зуунд паартай байшинд амьдрахгүй, паалантай жорлонд бие засахгүй. Хөрсний бохирдол ямар түвшинд хүрсэн.

Ийм учраас энэ Орон сууцжуулалтын банкны зорилго бол, энэ Орон сууцжуулалтын хөтөлбөр бол, Э.Бат-Амгалан сайдын санаачилгаар ярьж байгаа бол барилгын салбараа дэмжих нэг талаасаа, нийлүүлэлтийг нь дэмжих, хямд өртөгтэй орон сууц барьж нийлүүлэх. Нөгөө талдаа ипотекийн зээлээр дэмжих, хүлэмжийн хийг ялгаруулах карбон кредитийн зээл. Ийм цогц хөтөлбөр боловсруулаад дуусаж байна. Удахгүй Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Манай Э.Бат-Амгалан сайд дэлгэрэнгүй хариулна. Орон сууцжуулалтын хөтөлбөрийг бас давхар боловсруулж байгаа. Орон сууцжуулалтын хуулийг боловсруулж байгаа. Яг таны хэлж байгаа энэ чухал асуудал байгаа.

Ийм учраас Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэж байгаа.

2015 онд Норвегийн туршлагаар шууд хуулбарлаад Ирээдүйн өв сангийн хуулийг хийсэн. Тэр бол одоогийн асуудлаа үндсэндээ шийдвэрлэсэн улс.

Гэтэл түүгээр бол гадаадад үр дүнтэй хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулна гээд заасан. Одоо 3 орчим хувийн хүүтэй 1.2 тэрбум доллар хадгалуулж байна. Энэ жилийн төсвөөр Ирээдүйн өв сангийн хуулиар 2 тэрбум гаруй доллар хүрч бас энэ хэмжээний буюу бараг 6, 7 их наяд төгрөг, 5 аравны их наяд төгрөг Ирээдүйн өв санд хуримтлагдана.

Энэ маань 3 хувийн хүүтэй хадгалагдаад байгаа мөртлөө манай Хөгжлийн банк, манай Засгийн газар маань 10 орчим хүүтэй мөнгө гаднаас зээлээд байдаг. 3 хувийн хүүтэй мөнгөө гадаа хадгалуулчихаад Хөгжлийн банк 9.5 хувийн хүүтэй гадаадаас зээл аваад байдаг. Нийслэл орон сууцжуулах гээд 8 орчим хувийн хүүтэй бонд гаргаад 500 сая долларын бонд гаргаад Сэлбэ дэд төвийг санхүүжүүлээд байдаг. Энэ хүүгийн зөрүү 5 хувь нь гэхэд, хүүгийн зөрүү нь гэхэд 300 орчим тэрбум төгрөгийн зөрүү гарч байгаа юм.

Ийм учраас орон сууцжуулалтын банк бол орон сууцжуулалтын зээл, ипотекийн зээл бол арилжааны банкнуудын ашгийн 53 хувийг бүрдүүлдэг бөгөөд эргэн төлөлт нь 99.5 хувьтай байдаг. Хамгийн найдвартай зээл. Нөгөө талаасаа орон сууцынхаа үнэ өртгөөр өсөж байдаг. Хүүгээрээ өсөж байдаг.

Ийм учраас энэ 1.2 тэрбум долларыг, цаашдаа энэ 6 их наядийг бид энэ орон сууцжуулалтын хөтөлбөрийн тухайд ард иргэдээ орон сууцжуулахад. Улмаар үүнийгээ үржүүлэгчээр үрлүүлэх юм бол үүнийг 20 хувьд нь санхүүжүүлээд гадаадаас хөнгөлөлттэй зээл, тусламж татаад үндсэндээ XXI зуунд Улаанбаатар хотын “Эсгий гэртэй хот” гэдэг нэрээсээ салах ийм хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж байна.

Ер нь улсын хэмжээнд 137 мянга 841 өрхөд ипотекийн зээл олгосны яг энэ гэр хорооллын иргэдийн орон сууцанд орсон тоо маш бага. Нийт 9.9 их наядын хөнгөлөлттэй зээл олгосон. Ипотекийн зээл. Тэгвэл энэ 6 их наядыг бид ингэж гаргаж ирэх бололцоо байна.

Ийм учраас хуримтлалын сангийн хөрөнгөөс 2024 онд 480.2 тэрбум төгрөгийг арилжааны 9 банкаар дамжуулж орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэр хөрөнгө оруулсан. Энэ эх үүсврийн зээлд 4158 өрх хамрагдсан. Улаанбаатар хотод 2149 өрх, хөдөө орон нутагт 2009 өрх хамрагдсан байна. /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж минут өгье.

Г.Занданшатар: 991 мянган өрх улсын хэмжээнд байгаагаас 700 мянган өрхөд орон сууцгүй, гэр хороололд гэрт. Нийслэлд 232 мянган өрх гэр хороололд амьдарч байгаа юм.

Тэгэхээр 232 мянган өрхийг эхний ээлжид 80 мянгыг нь орон сууцжуулах энэ хөтөлбөр хэрэгжсэнээрээ түлээ түлшинд мөнгө зарцуулаад байдаг биш, 80 мянган өрх орон сууцад хамгийн утаатай хэсэгт хамрагдсанаараа Улаанбаатарын агаарын бохирдол шийдэгдэнэ. Урт хугацааны шийдэл болно. Ийм орон сууцжуулалтын банкны хөтөлбөрийг боловсруулж байгаа. Энэ хүрээнд бас Улсын Их Хурлын тогтоолд энэ утга санаатай заалтыг өргөн барьсан байгаа. Тэднийг дэмжиж өгөхийг хүсье.

Х.Булгантуяа: М.Нарантуяа-Нара гишүүн нэмж тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Баярлалаа. Одоо тэгэхдээ байна шүү дээ. Тийм ээ. Энэ ипотекийн зээлийг Улаанбаатар хотын энэ түгжрэл, энэ юуг саармагжуулахын тулд хөдөө орон нутаг руу ипотекийн зээлийг 3 хувиар Дархан, Эрдэнэт рүү, бусад хөдөө орон нутаг руу барилга байгуулалтыг дэмжих, ипотекийн зээл, тэнд байр авч байгаа залуучуудыг 3 хувиар гээд Улаанбаатар хотдоо тэр 6 хувиа хангалттай гэр хорооллын орчиндоо сайхан олгоод ингээд явах ийм зөв зохицуулалтыг хийхгүй бол дан Улаанбаатарын барилгад энэ ипотекийн зээлд зориулагдаад байх юм бол бас энэ чинь үр дүнгээ өгөхгүй.

Энэ сангийн хөрөнгийг маш олон үр ашигтай, үр өгөөжтэй байдлаар нэмэгдүүлэх боломж нь өөрөө энэ ипотекийн зээлийн хөрөнгөд дэмжлэг болгох замаар оруулах явдал байгаад байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл энэ чинь зөвхөн залуу гэр бүлүүд байр, орон сууцтай болоод зогсохгүй Улаанбаатар хотын... /минут дуусав/

Х.Булгантуяа: Э.Бат-Амгалан сайд хариулъя.

Э.Бат-Амгалан: М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Тантай санал нэг байгаа. Ипотекийн зээлийн асуудал өнгөрсөн 10 орчим жилийн хугацаанд зөвхөн эрэлт талдаа нэлээдгүй ипотекийн зээлийг гаргаад явчихсан юм билээ.

Энэ эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй байдлыг хангаагүйгээс болоод ипотекийн зээл нь урт дараалал очер, мөн сүүлдээ бараг авлигалын асуудал арилжааны банкууд дээр яригддаг, иргэдийн дунд яригддаг асуудлууд нэлээдгүй гарсныг бид нуухын аргагүй.

Түрүүн Ерөнхий сайд хэлсэн. Бид 80 мянган айлын орон сууцын асуудлыг ер нь энэ ажлын хэсгүүд дээрээ нэлээдгүй яриад явж байгаа. Яг тантай санал нэг. Бүсчилсэн байдлаар. Хөдөө орон нутагт энэ ипотекийн зээлээр орон сууц худалдан авч байвал иргэдийг ер нь зүгээр зөвхөн 6 хувь гэж хатуу биш 6-аас 12, 13 хувийн хүүтэй бид бүсчилсэн маягаар орлогод нийцсэн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут.

Э.Бат-Амгалан: Бүсчилсэн маягаар бид төлөвлөлтийг зохион байгуулж байгаа. Жишээ нь, нийслэл Улаанбаатарын хэмжээнд гээд ярихад төвийн дүүргүүд дээр 80 метр квадратаар бид хязгаарлахгүйгээр 80-аас дээш метр квадраттай хотын төвийн өндөр үнэлгээтэй газруудад өндөр хүүтэй 12, 13, 14 хувийн хүүтэй.

Мөн хотын захаар Шархад, Улиастай, Сонгинохайрхан чиглэлд 6 хувийн хүүтэй.

Ер нь цаашлаад улсын хэмжээнд сумууд дээр, аймгууд дээр бид энэ ипотекийн зээлийн асуудлыг 6. 6-аас доош орох боломжийг эрэлхийлж бид ажиллаж байна.

Хамгийн гол нь энэ ипотекийн зээлийг тэр яг эрэлтэд нийцсэн, тэр орлогод нийцсэн, залуу гэр бүлүүд, ахмадууд, төрийн албан хаагч нар, тусгай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэтчилнээр бид зөв зүйтэй зохион байгуулах энэ ажлыг ажлын хэсгүүд дээр хийгээд явж байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Тийм. М.Нарантуяа-Нара гишүүний онцолж асуусан асуулт нь энэ төвлөрлийг сааруулах зорилгоор аймгийн төвүүдэд, нэн ялангуяа Дархан, Эрдэнэт хотуудад шинэ суурьшлын бүсийг бий болгох төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Бид Дарханд ажилласан, Эрдэнэтэд ажилласан. Орон сууцын хорооллуудтай танилцсан. Дархан хотод гэхэд жишээлбэл 50 мянган айлын газар олголтыг шийдэж, нийслэлээс Дархан руу шилжих, Эрдэнэт рүү шилжих, ажлын байр бий болгох, хөдөө аж ахуйн зориулалттай болон аж ахуй хөгжүүлэх газрын асуудалдаа цогц шийдэх, орон сууцын зээл олгох ийм хөтөлбөр энэ хөтөлбөрт сууж байгаа.

Тийм учраас орон сууцын санхүүжилтийг зохистой хийхгүй бол зөвхөн эрэлт талыг нь дэмжээд байхаар үнэ нь өсөөд байгаа. Сүүлийн жилд 15.9 хувиар орон сууцын үнэ өссөн байна.

Ийм учраас нийлүүлэлтийг нь орон сууцжуулалтын хөтөлбөр, орон сууцжуулалтын хуулийг Э.Бат-Амгалан сайдын ажлын хэсэг боловсруулж байгаа. Удахгүй өргөн барина.

Энэ нийлүүлэлт талыг нь дэмжиж байж хямд өртөгтэй, орлогод нийцсэн орон сууцаар иргэдийг хангах. Тэр дотроо Эрдэнэт хотод ч гэсэн баригдаж байгаа тэр Оюут нэртэй ч байна. Олон сайхан шинэ... /минут дуусав/

Х.Булгантуяа: М.Нарантуяа-Нара гишүүн нэмж тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Э.Бат-Амгалан сайд хэлж байна л даа. Ингээд хөдөө орон нутагт 6 хувь гээд тэгж байна.

Улаанбаатар хотод 6 хувиар олгогдож байгаа ипотекийн зээлийг хөдөө орон нутагт мөн яг энэ дүнгээр нь тавих юм бол хүмүүс сонголт нь мэдээж Улаанбаатартаа л 6 хувиа аваад амьдрахыг бодно шүү дээ.

Тэгэхээр хөдөө орон нутагт илүү давуу тал, илүү боломж, илүү хөнгөлөлттэй нөхцөл олгож байж энэ залуучууд чинь тийшээ очиж ажиллаж амьдаръя. Жилийн 3 хувь гэд гэдэг чинь маш том дүн.

Тэгэхээр үүнийг дагаад өөрөө тийшээ хөдөлгөөн саармагжих, тэнд дахиад шинэ хот сүндэрлэх. Хүн ам нь нэмэгдэх юм бол тэр хотын хөгжил цэцэглэл, тэрийгээ дагаад ажлын байр, өчнөөн олон юмнууд цэцэглэх байхгүй юу.

Тэгэхээр хот хөдөө дээр энэ ипотекийн зээлийн дүнгийн ялгавартай байдал зайлшгүй тогтоож байж тийшээ нүүх хүмүүсийн урсгалыг нэмэгдүүлэх юм.

Тэгэхээр энэ дээр маш сайн анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Дээрээс нь ипотекийн зээл гэдгийг ерөөсөө хээл хахуулийн шинжтэй, авлига, хээл хахуулийн, танил талын юм болгодог... /минут дуусав/

Х.Булгантуяа: М.Нарантуяа-Нара гишүүн санал хэллээ.

Хүртээмжийг нэмэгдүүлэх. Дээрээс нь нэмээд энэ бол нийгмийн дунд хамгийн бухимдалтай асуудлуудын нэг. Ипотек гарлаа гэхэд ахиад дээрээс нь нэмээд бараг банкан дээр таньдаг хүн байхгүй бол авч чадахгүй болоод байгаа. Тийм ээ. Нара гишүүн.

Тэгэхээр үүнийг тэгш шударга болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх дээр анхаарах хэрэгтэй байна гээд их чухал асуудлыг хөндлөө.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг.

Х.Ганхуяг: Сая Нара гишүүн, Х.Булгантуяа дарга хоёрын ярьж байгаагаар одоо бид үндсэндээ татаастай холбоотой асуудлыг л яриад байна л даа.

Тэгээд татаас, энэ урсгал шилжүүлэг бол үндсэндээ манай урсгал зардлын 50 гаруй хувь болоод байгаа. Тэгээд миний хүсэх гээд байгаа юм гэхээр Сангийн яамнаас энэ урсгал зардал дээр байгаа энэ татаасуудыг. Бид нэг хууль батлахдаа хонины ноосны, сарлагийн хөөвөрийн гээд урамшуулал, татаас гээд л өгөөд явдаг.

Яах вэ, татаас өгч болно л доо. Тэгэхдээ нэг ийм хугацаатай баймаар байна. Тэгэхгүй бол энэ чинь ингээд мөнхийн үргэлжлээд явахаар чинь нөгөө урсгал зардал дотор тэр чинь эзэлж байгаа байр, хувь нь жилээс жилд нэмэгдээд л яваад байгаа юм.

Тэгээд л дараад нь бид чинь “Цагаан алт” гээд л нэмэгдсэн, “Хүнсний хувьсгал” гээд л нэмэгдэж байна.

Тэгэхээр зарим нэг төслүүд нь нэмэхээр өмнөхүүд нь ингээд хаагаад хаагаад явдаг. Үр дүнгээ тооцдог асуудлыг ярихгүй бол болохгүй байна. Яагаад гэхээр татаас бол ингээд удаан хугацаанд үргэлжлээд явчихаараа ерөөсөө л нөгөө шударга өрсөлдөөнийг боомилдог, үнэ нэмэгдүүлдэг, авлигыг өдөөдөг нэг ийм асуудал болдог. Дандаа ар өврийн хаалгаар явдаг асуудал болдог.

Тийм учраас үүнийг ер нь хийсэн бол 3 жилийн хугацаатай, 5 жилийн хугацаа. Яг энэ хатуу хугацаа тавиад явдаг баймаар байна. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Сая Т.Доржханд сайд ч ярьж байна, П.Наранбаяр сайд ч ярьж байна. Энэ бол асуудлынхаа уг нь цэгийг олж хараад л байх шиг байна.

Ерөөсөө бид энэ хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, эрэмбийг тавих, одоо тэр засаг захиргааны нэгжийг багасгах. Одоо тэгээд хиймээр байна. Ер нь. Одоо ингээд л сонсоод л байхаар мэдээд байх шиг. Тэгээд орж ирж байгаа асуудал ерөөсөө байдаггүй. Тэгээд оновчтой болгох асуудал дээр эцсийн эцэст Сангийн яам яамдуудын хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх асуудал хийдэг. Тэгээд уг нь тэр салбарын яамд нь өөрснөө эрэмбэлээд, тэр төсвийн хязгаарт нь багтаагаад Сангийн яам руу хүргүүлдэг л болмоор байгаа байхгүй юу.

Ингээд процессыг харахад Сангийн яамнаас энэ жилийн хөрөнгө оруулалтын хязгаар 3.2 их наяд байна гээд л тавихад нөгөө яамдаас нь 10, 20 их наядын санал өгдөг.

Тэгэхээр ерөөсөө салбар яамд нь өөрсдөө эрэмбэлэхгүй байна гэсэн үг байхгүй юу. Нөгөө бодлогоо гаргахгүй байна гэсэн үг. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Яг энэ Хөгжил, төлөвлөлтийн хууль, Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хуулиудын уялдаа холбоог нь сайжруулахгүй бол Хөгжил, төлөвлөлтийн хуулиар ингээд 27, 28 их наядын төсөл, хөтөлбөрийг 2026 онд хийнэ гээд баталдаг. Тэгээд тэрийг чинь альныг нь Засгийн газар авч орж ирэх юм. Тэгээд салбарын яамд бөөнд нь багцлаад Сангийн яам руу өгдөг. Тэгээд Сангийн яаман дээр тэрийг эрэмбэлдэг. Нэг ийм асуудал ерөөсөө жилээс жилд давтагдаж явдаг боллоо.

Тэгэхээр чинь одоо гаднын экспертүүд үзэж байгаа. Манай төсвийн хөрөнгө оруулалт 60 хувийн өгөөжтэй байна гэж ярьж байгаа. Яагаад тэгж яриад байгаа вэ гэхээр бид манай салбар яамд маань ажлаа жоохон эрчимтэй хиймээр байна.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд. Ерөнхий сайд эхлээд хариулъя.

Тэгээд Б.Жавхлан сайд.

Г.Занданшатар: Х.Ганхуяг гишүүн маш зөв асуудал хөндлөө. Х.Ганхуяг гишүүн Төсвийн байнгын хорооны даргын хувьд санал нэг байна.

Энэ төсвийн цаглавар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, бусад хуулиудын уялдаа холбоог хангахгүй бол энэ олон хайч чинь Засгийн газрыг ажил хийлгэхэд туйлын хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Тухайлах юм бол С.Ганбаатар гишүүн уншаагүй байх шиг байна лээ. Хууль дээр 10 сарын 31-нд та 5 жилийн үндсэн чиглэлийг бид өргөн барих ёстой. Түүнтэйгээ нийцээгүй. Хуулиараа өргөн барих болоогүй юмтай нийцээгүй гээд бид шаардлага тавиад байдаг. Бид хуулиараа 09 сарын 01-нд өргөн барих болсон.

Хоёрдугаарт нь, одоо төсвийн зарлагаа нэмэгдүүлээд энэ жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлье гэхээр 27 их наяд. Дотоодын нийт бүтээгдэхүүний бараг дөрөвний нэг. Тэгснээ үндэсний нийт бүтээгдэхүүний 24 хувиас, дотоодын нийт бүтээгдэхүүний хувиас улсын төсвийн зардлыг хэтрүүлж болохгүй гээд хуульчилчихсан.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын хуулийн шаардлага, Төсвийн хуулийн цаглавар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиудын чинь уялдаа холбоо ингээд алдагдчихаар салбарын яамд ч гэсэн цэгцтэй бодлогоо төлөвлөх, жилийн төлөвлөгөө, тэгээд хөгжлийн бодлоготойгоо уялдуулах боломжууд алдагдаж байна.

Жилийн төлөвлөгөө маань хэлэлцэх явцдаа баахан төсөвт өртөг нэмэгддэг. 27, 28 их наяд болдог. Үүнийг альныг нь ч суулгахгүй гэдэг маань өөрөө цэгцгүй болдог. Бодлого бол приоритет буюу дэс дараалал байх ёстой.

Ийм учраас Төсвийн байнгын хороон даргатай санал нэг байгаа бөгөөд Төсвийн байнгын хороон дээр энэ талаар ажлын хэсэг байгуулаад, зардал нэмэгдүүлсэн олон хуулийг шинэчлэх талаар Х.Булгантуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан ажиллаж байгаа.

Энэ хуулиудын уялдаа холбоог хангахгүй бол дэгийн хууль, бүх хууль чинь Үндсэн хуулийн зөрчилтэй болох нь байна шүү. Болсон байна шүү. Үүнийгээ янзалж цэгцлэхгүй бол цаглаварын хувьд ч гэсэн, төсвийн тогтвортой байдлын шаардлага зохицуулалтын хувьд ч гэсэн ийм олон хайчин дунд

гүйцэтгэх засаглал хууль хэрэгжүүлэх бололцоо үнэндээ хязгаарлагдмал болж байна.

Х.Булгантуяа: Х.Ганхуяг гишүүн нэмж тодруулъя.

Х.Ганхуяг: Хэлэлцүүлгийн явцад ерөнхийдөө юмнуудаас дахиад тодруулаад явчихъя.

Яах вэ, би гурван асуултаар тодруулга авъя.

Нэгдүгээрт, эрчим хүчний салбар дээр бид 98 тэрбум төгрөг сая тодотголоор нэмж тавьсан байгаа. Тэгээд одоо хүртэл дулаан өгөгдөхгүй байгаад байна.

Тэгэхээр энэ жил өвөл Улаанбаатар маань гайгүй давдаг байгаа. Б.Чойжилсүрэн сайд аа.

Хоёрдугаарт, 575.0 тэрбум төгрөгөөр хавдрын эмнэлэг барина гэсэн байх юм. Тэгээд миний харж байгаагаар хавдрын тийм том эмнэлэг барилаа гээд хавдар буурахгүй болов уу гэж харах юм. Уг нь илүүтэй хүмүүсээ бэлтгэх, нэгдсэн эмнэлгүүд дээр хавдрын тасгуудаа нэмэх асуудал байсан бол арай хурдан шуурхай бид энэ асуудлаа шийдэх байсан юм болов уу?

Хавдрын эх үүсвэр нь яг юу болоод байгаа юм? Тэрийг уг нь Ж.Чинбүрэн сайд маш сайн мэдэж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол бид ингээд асар өндөр хөрөнгө оруулалт хийдэг. Тэгээд дараа нь харахаар ямар ч үр дүнгүй болох гээд байдаг нэг асуудал байгаа шүү дээ.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Х.Ганхуяг Төсвийн байнгын хорооны даргын асуултад нэмж мэдээлэл өгье.

Бид хүрээгээ баталж аваад нийт төсвийн маань зардал тэд шүү, хөрөнгө оруулалт тэд шүү гээд. Дараа нь бид хязгааруудыг нь яаман, яамдаар, салбар хоорондын бодлогын дагуу ингээд тавиад өгчхөж байгаа юм. Түүн дотроо урсгал зардал, хөрөнгө оруулалтаа яаж эрэмбэлж яаж багтаахыг Сангийн яам биш яамд мэддэг шүү. Үүндээ багтаагаад ирүүлсэн.

Ер нь яах вэ, энэ жилийн хувьд сайд нар маань энэ дээр өөрсдөө маш сайн санаачилгатай ажиллалаа. Аль болох хязгаартаа багтааж хөрөнгө оруулалт, бодлогоо багтаахаар. Одоо энэ төсвийн зовлон, энэ орлого буурч байгаа энэ бүх юмыгаа маш сайн харилцан уялдаатай ингэж хийсэн.

Цаашдаа ч тэр. Ер нь яг салбарын хөрөнгө оруулалтууд маань тус тусын салбарын хөгжлийн төлөвлөгөөнүүдтэйгээ уялдуулаад яам бүр ягштал хийгээд явна.

Төлөвлөгөө, төсөв хоёрыг уялдуулах тал дээр таны саналтай 100 хувь нийлж байна. Сая Ерөнхий сайд ч хэллээ. Ингээд цаашдаа хэдүүлээ хамтраад явъя.

Төлөвлөгөө талаасаа 19 их наяд өр... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Төлөвлөгөө талаасаа 19 их наядын ажил хийнэ шүү гээд тавьсан. Одоо улсын төсвийн хөрөнгө оруулалтын орон зай маань ерөөсөө л 3.2.

Төлөвлөгөө талаас нь харах юм бол төсөв маань тээр доор ёроолдоо байж байгаа. Тэгээд төлөвлөгөөтэйгөө нийцэхгүй гээд хэн ч хэлнэ. Төсөв талаасаа харах юм бол төлөвлөгөө маань тэр оройгүй өндөр юм болсон байна шүү дээ.

Тэгэхээр өөрсдийнхөө байгаа энэ боломждоо тааруулж, нийцүүлж тийш нь чиглүүлсэн ийм л төсөв орж ирж байгаа юм.

Тэгэхээр төсөв, төлөвлөгөө хоёр хэрвээ нийцдэг байсан бол тусад нь хийж яах юм. Эсвэл нэг төсөв, эсвэл нэг төлөвлөгөө хийгээд л болоо. Үнэхээр яг төлөвлөгөөтэй байвал төлөвлөгөөгөө яг хүрэх зорилт, яг нөгөө KPI_[key performance indicators] дээрээ тулгуурласан ийм л эрх зүйн бичиг баримт болгомоор байгаа юм.

Татаас зөв өө. Татаас өөрөө хугацаатай. Хамгийн гол нь хүрэх зорилттой байх ёстой. Түүндээ хүрсэн үү, хүрээгүй юу. Өнөөдөр 10 тэрбум төгрөгийн татаас тавиад 100 тэрбум төгрөгийн өгөөж. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэл. Эдийн засгийн аюулгүй байдал... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Х.Ганхуяг даргын асуултад хариулъя.

Энэ жил Улаанбаатар дулааны сүлжээг асуув бололтой гэж би таныг таалаа.

Улаанбаатар дулааны сүлжээ бол ус, дулаанаар хангахад бэлэн байна. Харьяалагдах орон сууцын компанидаа хандах хэрэгтэй. Төлбөрийн үлдэгдэлгүй аж ахуйн нэгж, хувь хүмүүст дулаан тавихад бэлэн байгаа. Тавиад эхэлсэн.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлаас 2025 оны 01 сарын 23-нд байгуулагдсан ажлын хэсэг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлагдах бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг ажиллаад, тайлангаа Төсвийн байнгын хороонд танилцуулаад, тэнд холбогдох яамдын хүмүүс байлцаад, манай ажлын хэсэг сая дэгийн хуульд өөрчлөлт оруулж, 9 сарын 01-нд нэгэнт улсын төсөв өргөн баригдаж байгаа бол 10 сарын 01 хүртэл бид зүгээр нэг сошиал дээр тавигдаад өнгөрөх биш, хэлэлцүүлэг хийх.

Хэлэлцүүлэг хийхээсээ өмнө өөрсдөө төсөвтэй нарийвчлан танилцаж, асуулт асууж мэдээлэлтэй болох хуулийн дэгийг Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.

Эндээс гарсан нэг зүйл нь холбогдох хуулиудыг авч үзэх ёстой гэдэг дээр Сангийн яаманд хүртэл чиглэл өгсөн.

- 2020-2025 оны хооронд
- ▶ Төсвийн тухай хуульд **71** удаа,
- ▶ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд **21** удаа

нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Эдгээр хуулиудын хоорондын уялдаа холбоо. Сая бас Ерөнхий сайдын хэлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг ч гэсэн уялдуулах асуудлууд байгаа.

Үүнийг холбогдох асуудлыг хариуцсан яамд яаралтай оруулж ирэх асуудлуудыг Та бүхэн өөрсдөө хариуцаад хийх нь зүйтэй.

Энэ том хуулиудад нэг бодлын хувь гишүүд өөрсдөө ганцаараа төсвийн тухай хууль байдаг юм уу, том хуулиудад өөрчлөлт оруулах бол хэцүү. Бид нарт тийм ажиллах том баг, нарийн мэргэжлийн хүмүүс ч байхгүй.

Тэгэхээр үүн дээр холбогдох яаманд өөрсдөө энэ өөрчлөлтийг нь яаралтай оруулж ирэх нь зүйтэй. Тэгээд шаардлагатай үед Та бүхэн яаралтай горимоор гээд л олон хуулиудыг оруулж ирдэг шүү дээ. Тэгэхээр үүнтэй уялдуулаад явах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүн. Хавдрын эмнэлэгтэй холбоотой. Тийм.

Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн.

Ж.Чинбүрэн: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тийм. Ер нь төвлөрлийг сааруулах бодлого маань өөрөө их оновчтой зөв байх ёстой. Төсөв дээр тавигдаж байгаа “Хавдар-2” төсөв маань өөрөө 526.0 тэрбум буюу 95 мянган метр квадрат бүхий орчин цагийн бүх технологийг суурилуулсан ийм оношилгоо, эмчилгээний том төв байх юм.

Өнөөдөр гадагшаа урсаж байгаа урсгал нь зөвхөн хавдрын тусламж авахаар жилд 90.0 сая доллар энэ технологиуд, энэ шинэ технологиуд байхгүйгээс болоод урсаад байгаа юм.

Тэгэхээр энэ урсгалыг зогсоож нь буцаагаад эдийн засагтаа сайн гэдгийг Та төсөөлж ойлгож байгаа гэдэгт итгэлтэй байна.

Хоёр дахь асуудал. Тийм ээ. Одоо богино хугацаандаа юу хийх юм бэ. Энэ чинь 4, 5 жил үргэлжилнэ шүү дээ. Энэ хугацаанд сая Засгийн газрын 100 хоногийн дотор хийж амжсан ажил бол хойд бүсийн хавдрын төвөө бид нээж чадлаа. Тийм ээ. Эрдэнэт эмнэлгийн харьяанд байсан эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяа болгоод, түүнийг нь хойд бүсийн Хавдар судлалын төв болгоод энд 500 мянган хойд бүс, Дархан, Сэлэнгийн иргэд эмчлүүлэх... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Юуны өмнө сая Ерөнхий сайд орон сууцын бодлого дээр эрэлтийг дэмжих бус зэрэгцүүлээд нийлүүлэлтийг дэмжинэ гэж байгааг мэргэжлийн хүний хувьд дэмжиж байна. Үүн дээр зөвлөгөө, хамтарч ажиллах зүйлүүд байвал дэмжээд явъя гэж бодож байна.

Эхний асуулт. Ерөнхий сайдаас асууя.

Та бүхэнд ийм 1 хуудас 2 график тараасан байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ангилсан байгаа.

Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын

- ▶ 35 хувь нь зам,
- ▶ 18 хувь нь боловсрол,
- ▶ 14 хувь нь эрчим хүч.
- ▶ 8-хан хувийг эрүүл мэндийн салбарт хуваарилж.

Гадаадын зээл, тусламжаа оруулах юм бол

- 20 хувь нь зам,
- 17 хувь боловсрол,
- 14 хувь эрчим хүч,
- 21 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулахаар байна.

Айлаар жишээ авах юм бол аав нь цалингаараа 570 худалдаж авчхаад эм тан, хүүхдийнхээ сургуулийн форм, ном, дэвтрээ авах мөнгөө өөр айлаас гуйгаад сууж байгаа, зээлээд сууж байгаа ийм нөхцөл байдалтай байна.

Зам дагаж хөгжил ирэхгүй. Хүнээ хөгжүүлж байж л хөгжил ирнэ.

Татвар төлөгчдийн мөнгийг эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд гэсэн энэ 3 салбарт хэзээнээс зарцуулдаг болох юм бэ гэсэн Монгол Улсын хөгжлийн бодлогын чиглэлийн талаар асуулт асууя.

Хоёр дахь нь, Б.Жавхлан сайдаас асууя.

Ирэх оны төсөвт улсын жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй 18 төсөл, арга хэмжээний 77 тэрбум төгрөг зураг төсөл, ТЭЗҮ-гүй 5 төсөл, арга хэмжээний 196.0 тэрбум төгрөг. Санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулаагүй буюу буруу төлөвлөсөн 75 төсөл, арга хэмжээний 409.0 тэрбум төгрөг буюу нийт 682.0 тэрбум төгрөгийг тусгасан байна.

Нөгөө талдаа насаараа төр түмнийхээ төлөө зүтгээд, ажлын карьераа нийгэмдээ зориулж байгаа багш, эмч, сувилагч, цэрэг, цагдаагийн албан хаагчдын тэтгэвэртээ гарахдаа авдаг 36 сар хүртэлх нэг удаагийн тэтгэмжийг талыг нь 2027 он хүртэл хойшлуулна гэж байна.

Төсвийн санал асуулга дээр иргэд, төр, нийтийн албан хаагчид ийм зүйл хүссэн юм уу? Эрэмбээ яаж тогтоосон юм бэ гэдэг хоёрдугаар асуулт.

Гурав дахь асуулт. Н.Учрал сайд болон Б.Жавхлан сайдаас асууя.

Жилийн төлөвлөгөөний 3 дугаар хавсралтад туссан KPI буюу шалгуур үзүүлэлт төсвийн 1 дүгээр хавсралтын KPI-тай нийцсэн байдал нь 60 хувь хүрэхгүй байна.

Төсөв боловсруулахдаа үүн дээр хэрхэн анхаарч ажилласан бэ?

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд үр дүнд суурилсан засаглалыг бэхжүүлэх ёстой гээд ярьж хэлээд, зарчмын зөрүүтэй саналыг 30, 40-өөр нь гаргаад, албан бичиг хүртэл ажлын хэсгээсээ явуулж байхад ийм нөхцөл байдалтай орж ирж байгааг юу гэж бодож байна вэ? Энэ нийцлийг хэзээ хангадаг болох вэ?

Х.Булгантуяа: Эхлээд Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Энэ чухал асуудал. Ер нь яг төсөв ерөнхий том агуулгаараа эрүүл мэндийн салбарт зарцуулж байгаа хөрөнгө оруулалт 5.5 дахин нэмэгдсэн. Энэ хавдрын эмнэлэг, зүрх судасны төв.

Хоёрдугаарт нь, боловсролын салбар байгаа. Хоёр дахин нэмэгдсэн. 1.2 их наяд төгрөг зарцуулах байсан бол 2.4 их наяд төгрөгөөр сургууль, цэцэрлэг барьж байгуулах, 2028 онд гэхэд гурван ээлжийг бүрэн халж, хоёр ээлжид бүрэн шилжих зорилт дэвшүүлсэн ийм цогц өөрчлөлтүүд хийгдэж байгаа.

Энэ санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд яагаад замаас ялгаатай байна вэ гэхээр зам бол үндсэндээ шинэ зам байхгүй. Ноднин жил эхлүүлсэн замуудыг үргэлжлүүлэхгүй бол болохгүй.

Ийм учраас зам маань тасралтгүй үргэлжилж явж байхгүй бол капитал удах тусмаа зардал илүү их шаардагддаг, эвдэрдэг, хэмхэрдэг ийм онцлогтой салбар.

Ийм учраас нөгөө бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд маш их замууд тавигдсан. Өнгөрсөн жилүүдэд. Энэ ажлуудыг үргэлжлүүлэх. Бүрэн хэмжээгээр тавьж чадахгүй байгаа. Ийм учраас замын хөрөнгө оруулалт бол тэгж сууж байгаа.

Зээл, тусламжийн хувьд бол яах вэ аав, ээжээсээ илүү доноруудын хөнгөлөлттэй зээл буюу Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр сургууль, цэцэрлэг дээр өөрсдөө ассессмент судалгаагаа хийгээд энэ чиглэл рүү илүү их хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэж хүний хөгжлийн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн учраас энэ чиглэл 5.5, хоёр дахин нэмэгдэж бид илүү их шаардлага тавьсан.

Ийм учраас энэ бол бүгд хоорондоо уялдаатай. Зам дагаж хөгжил. Ер нь эрэмбээрээ бол нэгдүгээрт эрүүл мэндийн салбар 5.5 дахин өссөн.

Хоёрдугаарт, боловсролын салбар хоёр дахин өссөн. Ингээд нийт багцаар нь үзнэ үү гэхээс биш төсвийн бодлого хаанаас юугаараа санхүүжих нь эцсийн дүндээ хоёрдугаар өндөр ач холбогдолтой асуудал биш.

Энэ талаар Б.Жавхлан сайд тодруулж хариулна.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Бид нарын ажилд нэлээн нэмэр болоод бүр гишүүд бүрт ийм хөрөнгө оруулалтын ийм диаграмм явуулсан байна лээ. Баярлалаа. Танд.

Тэгээд зарим нэг тоо нь жоохон зөрүүтэй байна шүү. Эргээд харна биз.

Одоо хөрөнгө оруулалтын бүтцийг харах юм бол эрчим хүч, зам хоёр нэгдүгээрт байгаа нь энэ бол хамгийн зөв. Бүрэн итгэлтэй байна. Энэ хоёрыгоо хийхгүйгээр бид нэг ч эмнэлэг барьж чадахгүй, нэг ч сургууль барьж чадахгүй. Ийм байдалд ирсэн байгаа.

Тийм учраас хөгжлийн яг түүчээлэгч нь локоматив нь яах аргагүй эдгээр дэд бүтэц гэдэг дээр хамгийн зөв онош тавигдаад, сүүлийн 5 жил энэ хоёр салбар луу түлхүү явж байгаа.

Ойрын 5-аас 10 жил ч ер нь энэ бүтэц нэг их өөрчлөгдөхгүй болов уу.

Эрчим хүч ашиглалтад орохын хэрээр, эх үүсвэрүүд нэмэгдэхийн хэрээр, зам харгуй нэмэгдэхийн хэрээр тэрний үзүүр дээр нь баялаг бүтээгч нар хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалтууд тэнд бий болно. Ингээд эдийн засгийн маань төвлөрөл саарна гэдгийг хэн хүнгүй бүгдээрээ ойлгож байгаа байх гэж найдаж байна. /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Энэ жил “Боловсролын жил”, “Эрүүл мэндийн жил”. Эрүүл мэндэд анхаарах ёстой гээд олон нийт ийм санал өгсөн. Үүний дагуу бид эдгээр салбарууд дээр хөрөнгө оруулалтуудыг хэд дахин нэмсэн байгаа.

Сая Ерөнхий сайд маш тодорхой хэллээ. Хэрвээ тэгээгүй бол энэ ингээд 3 4-д биш бүр 10-аас хойш ангилагдах, эрэмбэлэгдэх ийм хэмжээнд байсан шүү гэдгийг онцолж хэл хэлье.

Улсын жилийн төлөвлөгөөтэй уялдуулж Та асуулаа. Ер нь энэ дээр 2 хууль байгаа юм шүү.

Төсвийн хууль, Төлөвлөгөөний тухай хууль гээд. Төсөв талаасаа ингээд төлөвлөгөөнд суурилсан байна гэж байгаа юм. Хөгжлийн төлөвлөгөө талаасаа энэ рүү чиглэсэн байна гэж ийм шаардлагууд байдаг.

Түүнээс биш 100 хувь нийцнэ гэдэг зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл Засгийн газар ч тэр, Улсын Их Хурал ч тэр, ер нь бол ийм бодлогын орон зайнууд үлдэж байна гэсэн үг.

Тэгэхдээ тэр нь мэдээж төлөвлөгөөгөө биелүүлэхэд чиглэсэн ийм байдалтай байна.

Хэрвээ энэ хоёр 100 хувь нийцэх юм бол тусдаа ингэж хууль байж яах вэ дээ. Ингэж Их Хурлаа ч зовоогоод, Засгийн газраа ч зовоогоод. Зүгээр нэг л байж байх хэрэгтэй.

Тэгэхээр энэ хөгжлийн бодлого, төлөвлөгөө, төсөв хоёрыг цаашид... /минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайд. Ажлын хэсгээс 4 номерын микрофон дээрээс.

И.Батхүү: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

2026 оны төсвийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хянаж зөвшөөрөл өгөхдөө урт хугацааны болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, тухайлбал “Алсын хараа-2050”, Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэлтэй эсэх, 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тавигдсан бодлогын тэргүүлэх чиглэлтэй нийцтэй эсэх дээр голлон анхаарч ажилласан байгаа.

Яг энэ шалгуур үзүүлэлтийн хувьд таны хэлж байгааг маш их анхаарч ажиллаж байгаа. Манай яамны хувьд. Энэ улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд байгаа зорилтуудын шалгуур үзүүлэлтийг 4 түвшнээр авч үзэж байгаа.

■ Тухайлбал,

- Үндэсний үр дүн,
- Салбарын үр дүн,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн гаргах үр дүн,
- Хөтөлбөрийн үр дүн гээд.

Улсын төсвийн хавсралтад туссан гол асуудлууд нь “хөтөлбөрийн үр дүн” дээр суурилж дүгнэлт, тоонууд нь гарсан байгаа.

Х.Булгантуяа: Г.Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Хөгжлийн төлөвлөгөө, төсөв хоёрыгоо 100 хувь нийцүүл гэж би хэлээгүй ээ. Шалгуур үзүүлэлт буюу энэ KPI 100 хувь нийцүүлэх ёстой.

- Төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй.
- Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй.

Ер нь энэ бусад яамдынхаа төлөвлөгөө, төсвийг хэмжих юм уу, удирдах юм уу, үгүй юм уу? Тэрийг л асуусан юм.

Сая хэлсэн. Нэг удаагийн тэтгэмжийг талыг нь хагас, бүтэн жилээр хойшлуулаад 2027 онд олгоно гэж байгаа юм. Үүнийг эрэмбэлэхдээ ямар шалгуур үзүүлэлт ашигласан юм бол оо?

Ирэх 5 жилдээ дахиад зам дээрээ анхаарна гэж байна. Тэгж болохгүй ээ. 330 сумыг замаар холбох гээд байгаа юм уу? Ямар ч хэрэггүй шүү дээ. Бүсчлэлийн хөгжил биш шүү дээ. Тэр чинь. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулж байгаа гэдэг зүйл болно.

Тэгэхээр ирэх 5 жилийн чиглэл дээр Н.Учрал сайдтай хамтраад би зам дээр орох хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаад, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбар луу тавих тал дээр нь хамтарч ажиллах хүсэлтэй байна. Тодруулгаа авъя.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд эхлээд хариулъя. Тэгээд Б.Дэлгэрсайхан сайд.

Н.Учрал: Монгол Улсыг аймаг, нийслэл хотыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлалыг сайдын тушаалаар баталсан. Энэ аргачлалын дагуу одоо бид энэ 5 жилийн үндсэн чиглэлийг анх удаа боловсруулж байгаа юм.

Тэгэхээр Г.Лувсанжамц гишүүний хэлж байгаа тоон болон чанарын үзүүлэлтүүдийг яг хэмжиж болохуйц байдлаар үзүүлэлтүүдээ тавина. Тэгж байж эргэж хянаж явахгүй бол одоо ерөөсөө энэ 100, 100 гэсэн чанарын үзүүлэлтүүд байна шүү дээ. 100, 100 хувь хангагдсан гээд. Тэр нь зүгээр нэг уулзалт хийсэн, форум хийсэн гээд нэг баахан зураг тавиад илгээгээд. Тэр нь хийсэн хийсэн гээд бичсэн. Юугаар хэмжих нь ойлгомжгүй. Үзүүлэлт нь ойлгомжгүй учраас хэмжиж чадаагүй.

Тэгэхээр шинэ аргачлалын дагуу 1, 2, 3 дугаар түвшнийхээ дагуу “салбарын үр дүн”, тэр “төсвийн ерөнхийлөн захирагч”, “хөтөлбөр”, “үндэсний үр дүн” гээд үзүүлэлтүүд, индикаторуудаа маш ойлгомжтой болгохоор энэ удаагийн 5 жилийн чиглэлийг боловсруулж байгаа.

Энэ дээр гишүүнтэй хамтраад ажиллана.

Х.Булгантуяа: Б.Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Ер нь монголчууд бид өөрсдөө ярьдаг. Зам дагаж хөгжил гэж. Замгүйгээр Монгол Улсыг төсөөлөхийн аргагүй.

Мэдээж энэ жилийн хувьд бид төсөв, санхүү, энэ нөхцөл байдлаа харгалзаад өнгөрсөн жил тавигдсан бүх замуудаа дуусгахаар шийдсэн байгаа.

Шинээр хэдхэн зам орж ирсэн. Тэгэхдээ энэ бол стратегийн ач холбогдолтой. Улс орон цаашдаа хэрэгтэй ийм замуудыг тавигдсан байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, ер нь салбарын яамны зүгээс замуудаа эрэмбэлж байгаа. Яг “**эдийн засгийн үр өгөөжтэй зам**” гэж яг юуг хэлэх юм бэ гэдгээ эрэмбэлж байгаа.

Жишээлбэл, Замын-Үүд, Улаанбаатарын хоорондох зам Монгол Улсын хувьд эдийн засгийн хамгийн үр өгөөжтэй зам.

Нийт импортын 78 хувь нь яг энэ замаар явж байгаа. Экспортын 30 гаруй хувь нь энэ... /минут дуусав/

Х.Булгантуяа: Г.Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Н.Учрал сайд, Б.Дэлгэрсайхан сайдад баярлалаа.

Яг зөв зүйлийг хэлж байна. Тийм ээ. Өгөх үр дүнгээ бид эрэмбэлж байгаад ямар замаа өргөтгөх юм, ямар зам нь хэрэггүй байх юм. Үүнийгээ ирэх 5 жилийн чиглэл дээрээ Та бүхэн маань тусгаж өгөөсэй гэж хүсэж байна.

Эцэст нь саар зүйлийн хажуугаар сайн зүйл байгаа гэдгийг дурдах ёстой. Төсөв өргөн барихаар зарим туршлагатай гишүүд нь болсон болоогүй хууль зөрчсөн, Үндсэн хууль зөрчсөн гэж попорч болохгүй.

Төсөв дээр 3 сайн зүйл гарсан.

➤ Нэгдүгээрт нь, иргэд, олон нийтээс санал асуулга авсан.

➤ Хоёрдугаарт нь, төсвийн 6 дугаар бүлэг буюу төсвийн эрсдэлийн шинжилгээ гэдэг зүйл анх удаагаа орж ирж байна. Үүнийгээ уншаарай, Та бүхэн маань.

➤ Гуравдугаарт нь, **PMS**¹ /project management system/ буюу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем хөгжүүлнэ гэсэн. Энэ олон нийтэд нээлттэй болсон. Харагдаж болохоор байгаа. Та бүхэн ороод хараасай гэж бодож байна.

Энэ дээр сүүлийн асуулт Б.Жавхлан сайдаас асууя. Энэ цахим системдээ бид төсвийн урсгал зардлаа оруулж өгөх үү? Ийм ажлыг төлөвлөж байгаа болов уу гэсэн асуулт байна.

¹ <https://pms.mof.gov.mn>

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баярлалаа. Г.Лувсанжамц гишүүн ээ.

Энэ PMS систем ашиглалтад ороод бараг 2 жил болж байгаа шүү. Манай гишүүд үүнийг нэг л ашиглаж өгөхгүй байгаад байгаа юм. Тэгээд үүнийг сайн ашигладаг болоорой.

Хэрвээ үүнийг гишүүд маань үзэх юм бол энд ер нь асуулт ер нь хоёроос гурав дахин багасна шүү. Энд тавих асуулт. Эндээс ер нь нэлээн олон хариулт олоод авна.

Энэ яах вэ, хөрөнгө оруулалтуудыг ер нь төлөвлөдөг, гүйцэтгэлийг нь хянадаг. Ялангуяа яг хэрэгжилтийнх нь явцад хүртэл гүйцэтгэлээ тийшээ явуулсан. Мөнгөө авмаар байна. Тэнд гацчихлаа, энд гацчихлаа гээд л хоёр яамны хооронд дунд ингээд л хөөрхий ёстой гүйдэг. Тэгээд л эцэстээ Сангийн яаман дээр гацсан байна. Тэнд очоод мөнгө нь гацсан байна гэдэг.

Гэтэл яг энэ системээр ороод харах юм бол одоо зам байлаа гэхэд Зам, тээврийн яаман дээр ямар мэргэжилтэн дээр гацсан байгаа нь хүртэл харагдана. Хэдэн хоног тэнд хэвтэж байгаа нь хүртэл харагддаг ийм систем байгаа шүү.

Тэгээд Г.Лувсанжамц гишүүний асуусанчлан энд бид урсгал зардлаа тооцдог болсон байгаа явж байгаа. /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир.

Д.Бум-Очир: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

2026 оныг боловсролын жил болгон зарласан. Мань мэт шиг багш байсан гишүүд, тэгээд Монголын 47 мянган багш нар маань их баярласан байгаа юм. Их хүлээлт өндөр байсан.

Би өнгөрсөн хаврын чуулганы үеийн Байнгын хорооны хурал дээр хэлж байсан. Маш их хүлээлт байгаа шүү гэж.

Мэдээж “Боловсролын жил” болгоод тодорхой асуудлуудыг шийдвэрлэх гээд зорьж байгаад баяртай байна. Тэр 108 сургууль, 95 цэцэрлэг.

Тэгээд би нэг зүйлийг ойлгохгүй байсаар их удлаа. Урьд нь ч асууж байсан. Энэ 108 сургууль, 95 цэцэрлэгт хэдэн багш хэрэгтэй болох юм бэ? Энэ багш нараа хаанаас олж ирэх юм бэ? Мэдээж Монголд сургууль, цэцэрлэг хэрэгтэй байгаа. Сургуулиа барих гэж байгаа. Энэ “Боловсролын жил” болгосондоо энэ асуудлыг нь шийдвэрлэж байгаад баяртай байна. Шийдвэрлэх гэж зорьж байгаад.

Гэтэл нэг асуудлыг нь яаж шийдвэрлэх нь одоо болтол ойлголт ойлгомжгүй байдалтай байгаа юм. Тэр нь багшлах хүний нөөцийн хомсдол гэж яриад байгаа энэ асуудал.

Өнгөрсөн намрын чуулганаар яг энэ асуудал ингээд яригдсан. Тэгээд 45 хоногоор багш бэлдэнэ энэ тэр гээд хүн амьтан төөрүүлээд. Одоо ийм балай юмаа болих хэрэгтэй шүү дээ.

Бид багш дутагдаад байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тэгээд яах юм бэ? Үүнийг бодож байгаа хүн байна уу? Багшийн хомсдолоосоо бид хэзээ гарах юм бэ? Үүнийг бодож байгаа хүн байна уу? Боловсролын сайд эрх биш бодох ёстой. Чиг үүргийнх нь гол хүн нэг юм хэлэх байх.

Одоо тэгээд дахиад бичээд 45 хоног гэдэг ийм юм битгий яриарай. Өөр юм яримаар байх юм. Би одоо яг магадгүй өнгөрсөн жил хэлж байсан багшийн ерөөсөө л гол асуудал нь цалин бага, ачаалал их шүү дээ.

Тэгээд “Боловсролын жил” болгож зарлачхаад багш нарын хамгийн их хүлээж байсан нөгөө цалин нэмэгдэх болов уу гэж горьдож байсан тэр горьдлого нь, хүлээлт нь байхгүй.

Мэдээж төсөв мөнгө байхгүй гээд л бид ярьдаг. Байхгүй гээд л яриад л байвал жил болгон л байхгүй гээд л яриад байх байх. Нөгөө 3 яамны хамтарсан ажлын хэсэг энэ тэр гэсэн. Одоо тэрний үр дүн нь, дүгнэлт нь ямар юм байгаа юм.

Одоо тэгээд цалин нэмж чадахгүй л гэж хэлэх байлгүй. Энэ хүний нөөцийн асуудлаа яах юм бэ гэдэг асуудал. Үүнийгээ урт хугацаандаа яаж шийдэх юм, богино хугацаандаа яаж шийдэх юм.

Дараагийн нэг зүйл. Зарим талаар багш нараа урамшуулах биш цөөхөн хэдэн байгаа багш нараа урмыг нь хугалах бодлого явуулаад байх шиг байх юм. 75 хувь бэлдсэн багш гүйцэтгэлийн үнэлгээндээ орж чадахгүй байгаад байна шүү дээ. Ямар их ачаалал үүрүүлэх гээд байгаа юм бэ? Энэ багш нарыгаа тамлаж ханадаггүй юм бэ? Багш болж чадахгүй нь байна шүү дээ.

1 минутаа авчихъя.

Х.Булгантуяа: Эхлээд П.Наранбаяр сайд хариулаад. Тэгээд Д.Бум-Очир гишүүн тодруулчихъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өнөөдөр багшаар бэлтгэгдэж байгаа оюутны тоо 4 мянга 800 гараад явж байгаа. Эдгээр бэлтгэгдэж байгаа оюутнуудыг багшийн зах зээл рүү,

багшлах хөдөлмөрлөх нөөц рүү оруулж ирэх нь туйлын чухал байна. Өнөөдөр нийт төгсөж байгаа хүүхдүүдийн, уучлаарай 30 орчим хувь нь л багш руу орж ирж байгаа.

Тэгэхээр энэ дээр үндсэн цалинг нэмэх асуудал туйлын чухал байгааг хүлээн зөвшөөрч байгаа. Энэ дээр бид судалгаа юмнуудаа хийгээд явсан.

Багшийн хомсдолыг урт хугацаанд нь, мөн богино хугацаанд хэрхэн шийдвэрлэх вэ гээд.

Бид 6 багц арга хэмжээг хэрэгжүүлж байгаа.

Нэгдүгээрт нь, өнөөдрийн сургалтын цагийн норм нь 19 цагт хүрэхгүй байгаа багшийг шилжүүлэн ажиллуулах. Тэтгэвэртээ суусан багшийг дахин ажиллуулах. Дөрөвдүгээр курстээ багшаар суралцаж байгаа оюутнуудыг оруулж ажиллуулах. Багшийн тасралтгүй хөгжлийг хангах, түүний зэрэгцээ бид багшийг богино хугацаанд бэлдэж. Энэ чинь богино хугацааны л арга хэмжээ. Богино хугацаанд тухайн бакалаврын зэргээр нь төгссөн чиглэлээр нь бэлдэж оруулж ирж байгаа. Энэ дээр ойролцоогоор 150 орчим багш бэлтгэгдээд өнөөдөр багшлах цагийн багш нар ажиллаж байх жишээтэй.

Бидэнд байгалийн ухаан, математик, англи хэлний багш нар дутагдаж байгаа. Энэ жилийн тооцооноос харахад 3500 багш дутаж байна гэсэн тооцоо гарсан. Энэ тэгэхдээ сургуулийн өмнөх боловсролын тоо нь ороогүй.

Эндээс ингээд цаашаа явахаар 11 сард бид бас нэг тоогоо авдаг. Энэ дээр багшийн дутагдлыг тодорхой хэмжээнд арилгасан гэсэн байдалтай орж ирдэг. Багшийн дутагдлыг арилгах ажил цаашдаа ч үргэлжилнэ. Бид багшийн ажлыг хамаагүй залуу хүмүүс орж ирэхэд илүү таатай болгох боломжийг л үүсэх, ийм боломжийг бий болгохын тулд л ажиллаж байна гэж ойлгох хэрэгтэй.

Ер нь өнөөдрийн багшийн хангалт 93.7 хувьтай. Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт нь 97.1 хувьтай байгаа ч гэсэн багшийн дуталгүй байгаа сургуулийн эзлэгчийн 20 хувь л байна.

Тэгэхээр энэ бодитой байдлаа бид харж багшийг бэлдэж гаргах шаардлага байсаар байгаа.

Ийм учраас багшийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад тэтгэлэг олгож эхэлсэн. 100 хувийн тэтгэлэг. Гэхдээ энэ бол гэрээтэй. Төгссөн хойноо 5 жил багшаар ажиллах ийм үүргийг хүлээж байгаа ийм учиртай.

Мөн бид бас энэ багшийн ажлын ачааллыг бууруулах чиглэлээр 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт багшийн туслах ажиллуулах ийм шийдвэрийг гаргаж ажиллаж байна. Энэ 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт ажиллах багшийн туслахыг Монгол Улсын Боловсролын их сургуулийг түшиглэн сургаж байна.

Мөн алслагдсан бүс нутгийн сургуулийн багшийн дутагдлыг нөхөх чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж, энэ хичээлийн жилд ахлах ангийн 36 мянга 941 хүүхэд алслагдсан байдлаас үл шалтгаалан цахимаар амжилттай суралцах боломжийг бий болгож байна.

Тэгэхээр багшийн мэргэжлийн нэр хүндийг өсгөх, багш нарынхаа урмыг тэтгэх ийм ажлуудыг үе шаттай, дэс дараатай бид хийх ёстой гэж үзэж байгаа.

Гүйцэтгэлийн үнэлгээний тухайд энэ чинь ойролцоогоор нийт багш нарын 52 хувь нь гүйцэтгэлийнхээ үнэлгээнд хамрагдаад ороод үнэлгээнийхээ юмыг аваад явж байгаа юм.

Энэ шалгалтыг бид оновчтой зохион байгуулах. Мөн гүйцэтгэлийн үнэлгээнд төлөвлөгдсөн мөнгөн хөрөнгийн тодорхой хувийг үндсэн цалинд нь шингээж өгөх гэсэн ийм бодлогуудыг хэрэгжүүлэхээр саналуудаа хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Д.Бум-Очир гишүүн нэмж тодруулъя.

Д.Бум-Очир: Баярлалаа. П.Наранбаяр сайд аа.

Яах вэ, жижиг сажиг косметик гэж нэрлэдэг ийм юмнууд хийгээд Монголын багш нарын дутагдлыг, хомсдол гэж яриад байгаа энэ зүйлийг арилгаж чадахгүй л дээ.

Бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тэр сая 494 мянга ч билүү гээд яриад байдаг. Гар дээрээ сая нэг зуун наян хэдэн мянган төгрөг л очдог юм шүү дээ.

Та нар өөрсдөө сая нэг зуун наян хэдэн мянган төгрөгөөр амьдраад үз л дээ. Бүгдээрээ л бид хүүхдүүдтэй шүү дээ. 18, 20 хүрч байгаа хүүхдүүдээ багш бол. Багш болохоор чинь чамд сард сая 480 мянган төгрөг өгнө. Сая 480 ч биш шүү дээ. Сая 180 орчим мянган төгрөг өгнө. Тэр цалин дээр очоод тийм ажил хий гээд хэлээд үз л дээ. Бид нарын нэг ч хүүхэд очихгүй шүү дээ.

Ийм байдлаар хэр удах юм.

Дараагийн нэг зүйл. Уг нь ачаалал нь ихсэх тусмаа хувьсах зардал нь нэмэгдмээр байгаа байхгүй юу. Би хэрвээ багш байлаа гэхэд ачаалалтай байгаа бол би тэр ачааллынхаа мөнгийг авмаар байна шүү дээ. Тэгэхэд яамнаас барьж байгаа бодлого бол хувьсах зардал нь олон сурагчтай байх тусмаа буурдаг ийм тогтолцоо хийсэн. Үүнийгээ тайлбарлаж өгөөч. П.Наранбаяр сайд аа.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Цалингийн бүтцийн тухайд бид бол ачаалалд нь суурилсан, ачаалалд нь тохирсон үндсэн цалинг нэмэх ийм л саналыг боловсруулаад явуулаад байгаа юм.

Бид 25 хувийн үндсэн цалинг нэмж чадах юм бол нийтдээ төсөвт 560 тэрбум төгрөг шинээр нэмэгдэх хэрэгтэй байна гэсэн тооцоолол гаргасан. Энэ дээр төсвийн зарлага, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ гэсэн макро тоонууд хэрхэн хөдлөхийг манай мэргэжлийн байгууллагууд ярих байх.

Ямар ч байсан цалингийн асуудал бол зөвхөн нэг яамны асуудал ерөөсөө биш. Энэ бол Сангийн яам, мөн Гэр бүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газраас өргөн барьж Улсын Их Хурал бид өөрсдөө шийдэх ёстой ажил байгаа гэдгийг хэлье.

Харин олон хүүхэдтэй сургууль дээр яг ингээд тэр чигээр нь өгөөд байвал тэгвэл цөөхөн хүүхэдтэй сургууль яах юм, сумын сургуулиуд яах юм. Цөөхөн хүүхэдтэй сургуулийг илүү дэмжиж, тэнд чинь хөдөөд боловсролыг хүргэх хувьсах зардлын бодлого явж байгаа гэдгийг Та ойлгох хэрэгтэй байх.

Бид ийм бодлого барьж ингэж явах... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя. 1, 1 минутаар байхаар нэмээд 2 минут болгочихъё. Д.Бум-Очир гишүүн нэмээд эхлээд тодруулчихъя. Тэгээд хариулт.

Д.Бум-Очир: Тэр сумын сургуулийг ойлгож байна. Наадхаа өөр аргаар шийд л дээ. Битгий ачаалал ихтэй байгаа сургуулиудын мөнгөнөөс сумын сургууль дээр аваачиж өгөх байдлаар ингэж шийд л дээ.

Наадах чинь миний бодлоор оновчтой шийдэл гэж бодохгүй байна.

Дараагийн нэг зүйл. Ерөнхий сайд болоод бусад сайд нар байгаа дээр би нэг зүйлийг хэлчихмээр байх юм.

“Боловсролын жил” болгоод бид боловсролынхоо нэг тулгуур асуудлыг шийдэх чиглэлд олигтой ажил хийж чадсангүй шүү гэдгийг би сануулаад хэлмээр байна. Тэр нь багшийн цалингийн тухай асуудал.

Багшийн цалинг нь нэмэх гээд байгаа нь ерөөсөө хэдэн, 47 мянган багшийг мөнгөтэй болгох гээд байгаа тухай асуудал ерөөсөө биш ээ. Татвар төлөгчдийн хүүхдүүдийг л аятайхан боловсролтой болгох гээд, Монголын ирээдүй гэрэл гэгээтэй болгох гээд байгаа асуудал шүү дээ.

Энэ ерөөсөө багшийн асуудал биш, бидний хүүхдийн тухай асуудал. Энэ татвар төлөгчдийн хүүхдүүдийн тухай асуудал. Ингэснээр бид

- ядууралыг бууруулна;
- ажилгүйдлийг бууруулна,
- гэмт хэрэг, зөрчил буурна,
- өвчлөл буурна.

Энэ жинхэнэ хөгжил шүү дээ. Миний ойлгож байгаагаар бол.

Гэтэл үүндээ бид хөрөнгө оруулалт хийхгүй хойш татаад суугаад, зөвхөн байшин, барилга барих гээд яриад суугаад байгаа нь тоогүй байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Д.Бум-Очир гишүүний энэ боловсролыг дэмжих, хүний хөгжлийн гол суурь болсон боловсролыг дэмжих үндсэн зарчим, санаачилгыг дэмжиж байгаа.

П.Наранбаяр сайд яг өдөр тутмынхаа ажлыг хариуцаж байгаа учраас нөгөө гол стратегийн чиглэл болох багшийн хөгжлийг дэмжих 3 жилийн төсөл, хөтөлбөр боловсруулах үүрэг даалгавар авсан. Тэр талаараа дэлгэрэнгүй танилцуулах хэрэгтэй.

Энэ 3 жилийн хугацаанд багш нарын цалинг нэмэгдүүлэх. Одоо тэнд бичсэн байгаа шиг төгрөгөөр нь илэрхийлсэн хэмжээнд хүргэх. Үүний тулд цахимжилт, цахим боловсрол, хиймэл оюун ухаан ашигласан технологийн шинэ дэвшилд нэвтрүүлэх, багшийн ачааллыг хөнгөлөх, хөдөөд 40 хувийн нэмэгдэлтэй. Хотод байгаа багш нарын хувьд тулгамдаад ачаалал болоод байгаа асуудал хувьсах зардал энэ тэрийг цогцоор нь шийдэх ийм боловсролын жилийн хүрээнд шийдвэрлэх цогц төлөвлөгөө боловсруулах даалгавар аваад ажиллаж байгаа.

Энэ хүрээнд одоо жишээлбэл Ш.Урангоо гээд охин Стэнфордын их сургуульд өөрөө бие даагаад сураад ковидын үед. Одоо хоёрдугаар курст суралцаж байна.

Ковидын үед хичээл хаалттай байхад, хичээл орохгүй байхад интернэтгүй малчин айлын охин уулын оройд гарч интернэттэй газар бие дааж хичээллээд энэ сургалтын платформ ашиглаад одоо тэтгэлгээр Стэнфордын их сургуульд дэлхийн боловсрол эзэмшээд суралцаж байна.

Тэр хүүхдүүдтэй хүртэл ярилцаад яаж энэ хиймэл оюун ухааныг ашигласан боловсролын илүү дэвшилттэй технологийг нэвтрүүлэх үү. Энэ үндсэн дээр багшийн ачааллыг яаж нэмэгдэх вэ гэдэг цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

Өнөөдөр манайд тулгараад байгаа асуудал нь энэ алтан гахай 82 мянган хүүхэд энэ жил төгсөж байна. Үүнээс хойш сая орчим хүүхэдтэй байсан бол сая 347 мянган хүүхэдтэй болоод байна. Үүнийг дагаад сургууль, цэцэрлэгүүд баригдаж байна. Насжилт уртасгаж ийм сайн үр дүн гарч байна. Тэтгэврийн авагчдын тоо нэмэгдэж байна. Энэ бүхэн маань нийгмийн ачаалал, социал зардлыг төсөвт маш их нэмэгдүүлж байгаа.

Ийм учраас нэг амьсгаагаар шийдэх... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут өгье.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын тогтоолд энэ талаар ер нь нэмэлт орлого олох боломжоо гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл баялаг бүтээгчдээ дэмжиж, баялгийн хулгайтай тэмцэж, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг нэмэгдүүлснээр төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

Түүнээс биш өнөөдөр яг энэ мөчлөгийн эдийн засаг маань нүүрсний үнэ хоёр дахин буурснаас шалтгаалаад төсвийн орлого 3.3 их наядаар тасраад явж байна.

Бусад зардлууд цалин хөлсөө тэлсэн ийм мөчлөгийн эгзэгтэй үе таарч байгаа үед бид боловсрол, эрүүл мэндийн салбараа тэргүүн ээлжид дэмжиж, иргэдийн оролцоотой, иргэдийн хяналттай төсвийн зарцуулалтыг хэмнэх зарчмыг баримталж энэ төслийг боловсруулсан.

Өнөөдөр эдийн засгийн байдал үнэхээр хүнд байгааг дээр дооргүй ойлгож байгаа гэж итгэж байна. Тэгэхдээ бид багш нарын орон сууцжуулалтыг дэмжих, тодорхой тооны багш нарын энэ орон сууцын зээл, ипотекийн зээлийн асуудлыг шийдэх хөтөлбөр, багш нарын үйлдвэрчний эвлэлтэй тодорхой асуудлаар тохиролцон ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен.

Б.Бейсен: Энэ төсвийн төсөлтэй танилцаж байна л даа.

Сангийн сайдаас асууя. Эмч, багш нарын цалинг 2026 онд хэчнээн хувиар нэмэхээр тусгаж байна? Нэмэгдэх үү? Үнэхээр цалин нь бага, амьдралын хүрэлцээ муу байна.

Дараагийн асуудал. Энэ Эрүүл мэндийн даатгалын сан дампуураад өр зээл ихэслээ. Аймгуудын нэгдсэн эмнэлгүүд хоёр аравны хэдэн тэрбумын өртэй мөртлөө 3 тэрбумын авлагатай байна. Хотын клиникийн эмнэлгүүд мөн адилхан их хэмжээний өртэй бөгөөд авлагатай байж байна. Сан нь хоосорсон.

Бид өнгөрсөн жил жилийн эцсээр эрсдэлийн сангийн 54 тэрбум, чөлөөт төлөвлөлтийн 60 хэдэн тэрбум. Дээр нь 350 тэрбум шийдэж өгсөн. Үүнийг юунд зарцуулсан бол?

Нөгөө талаар эрүүл мэндийн даатгалын шалгуур үзүүлэлт барууны орнууд буюу өндөр хөгжилтэй орнуудын системийг нэвтрүүлсэн. Монгол орны эрүүл мэндийн салбарын хөрсөнд тохирсон эрүүл мэндийн даатгалын систем байхгүй. Үүнийг шинэчлэх тал дээр Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам бүтэц, орон тоог шинэчилж батлахгүй бол, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн нийгмийн эрүүл мэнд, зохион байгуулалтад хандаж байгаа бүтцээ шинэчлэхгүй бол энэ илүү орон тоонд нэлээн юу явж байна.

Энэ тал дээр Эрүүл мэндийн сайд бодлого баримталж байгаа юу?

Дараагийн асуудал. Цомхотголын асуудал байна. Одоо яам, Тамгын газарт хүний нөөцийн газар, хүний нөөцийн тасаг гээд байж байна. Даргын туслахууд, одоо ганц хүний нөөц, хуучин боловсон хүчин хариуцдаг ийм том газрууд. Үүнийг сонгогдож болдоггүй юм уу?

Аймгуудын тэр хот тохижуулах газрынх нь. Тэгээд олон нийтийн цагдаа, нийгмийн ажилтан эд нарыг цомхотгож яах юм. Үүнийг зохицуулж болохгүй юм уу? Нэгдүгээрт.

Дараагийн асуудал. Баруун аймгууд дээр өвөлжилт хүндрэх нь ер нь. Увс, Ховд, Баян-Өлгий аймаг дээр. Өвс тэжээл дээр 2026 онд төсөв дээр тавьж байгаа юм байна уу? Ер нь. Хэчнээн хэмжээний юу тавьж байна?

Ан, амьтан бас ихээр хорогдох төлөвтэй байна. Одоо энэ Ховд гол дагаад буга хүртэл голын эргээр ороод ирсэн байна. Аргал, угалз их хэмжээгээр үрэгдэх хандлагатай байна.

Байгаль орчны сайд энэ тал дээр нэмж ан, амьтан буудуулах тал дээр ямар арга хэмжээ авах юм? Төсөвт төвлөрүүлэх тал дээр. Тэртээ тэргүй зуд болоод энэ чинь үрэгдэнэ шүү дээ. Үхнэ. Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

Х.Булгантуяа: Эхлээд Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн хариулъя.

Ж.Чинбүрэн: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Цалин нэмэгдэх үү гэлээ. Тэгэхээр багш, эмч нарын цалин бүгдийг нь л ярьж байгаа байх. Тийм ээ.

Тэгэхээр эмч нарын цалин, эмнэлгийн ажилчдын цалин, сувилагч, бага эмч гээд бүгд л хамаарч байгаа.

Тэгэхээр бид Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл 2021 оноос хэрэгжиж эхлэхдээ “чанартай гүйцэтгэл дээр тулгуурласан санхүүжилтийн тогтолцоо” гэдэг нь сайн ажиллаж, олон хүн эмчилсэн тэр байгууллага, тэр байгууллагын эмч, ажилчид цалин өндөр авна гэсэн ийм том хуулийн реформ бид хийсэн.

Ковид цар тахлын үед эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин өндөр байсны учир бид ковидыг даван туулахад бас том чухал нөлөө үзүүлсэн. Харамсалтай нь ковидоос цааших хугацаанд эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин нэмэгдэж чадаагүй.

Тэгээд нэлэнхүйдээ төрийн албан хаагч, төрийн ажилтнуудын цалин нэмэгдээд, Эрүүл мэндийн даатгалын сангийн төлбөрийг нэмэгдүүлээд байсан.

Гэтэл үүнийгээ бид цалиндаа оруулж чадалгүй өр шир, баахан авлага, нэг ёсондоо нэхэмжлэлийг хянаж чаддаг олон нийтийн хяналтын тогтолцоо байхгүй болсонтой холбоотой баахан өр шир гарсан.

Дараагийн асуулт шууд үүнтэй уялдаж байгаа. 316 тэрбум төгрөг тавьж өгөөд байхад юу нь дутуу гээд. Түрүүн миний хэлдэг мөнгө дутаагүй ээ. Сэтгэл дутсан гэж хэлээд байгаа нь энэ. Тэр дотор 54 тэрбум төгрөгийг нь бид эрүүл мэндийн хувийн хэвшлийнхний өрийг дарж өгсөн.

Саяын гүйцэтгэлээр 2025 онд нийтдээ хувийн хэвшлийнхэн 165 тэрбум төгрөгийн санхүүжилт өгөхөөр төлөвлөлттэй байсан. Энэ төлөвлөлт нь 8 сард дуусчихсан. Тэгээд дахиад 9, 10 сард 40, 40 тэрбум буюу дахиад нөгөө 140 тэрбум төгрөгийн өрөн дээрээ ахиад 220 тэрбум төгрөгийн өр болгох ийм бодлого явж байсныг би зогсоогоод Сангийн яамтай яриад гүйцэтгэлийг нь зогсоочхоод байж байгаа.

Тэгэхээр би түрүүн хэлсэн. Төсөвтөө дагуулаад Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, сайжруулах 3 жилийн хөтөлбөр өгсөн байгаа. 2026 онд хэрэгжих 13 төсөл, арга хэмжээ байгаа.

Үүгээр дамжуулан жинхэнэ даатгал шиг даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг даадаг тогтолцоо болох, даатгалын санг өөрийг нь институцчилэх ийм тогтолцооны том шинэчлэл хийнэ.

Энэ шинэчлэлтэй дагалдаад санхүүгийн асуудлуудын илүү актуар тооцоолд оруулдаг, илүү төлөвлөдөг, илүү зөв төлөвлөдөг, иргэддээ санхүүгийн дарамт очдоггүй байх энэ тогтолцоог хэрэгжүүлэх үндсэн зорилго орно.

Дээрээс нь олон нийтийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээнүүдийг яаралтай авна.

Ингээд авчихвал бид 2028 он гэхэд Эрүүл мэндийн даатгалын сан өөрөө биеэ даачихсан, ямар нэгэн гаднын нөлөөгүй жинхэнэ даатгуулагчдын эрх

ашгаа хамгаалдаг ийм тогтолцоо руу шилжих 3 жилийн хугацааны том хөтөлбөр өргөн бариад байгаа. Энэ хөтөлбөрийг би бас танд тусгайлан гардуулаад өгчихье.

Х.Булгантуяа: Б.Батбаатар сайд Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Б.Батбаатар: Ан, амьтны тэжээлийн доройтол асуудалтай газруудад яах вэ гээд.

Байгаль орчны салбарт тавигдаж байгаа төсөв бол их бага байгаа. Мазаалай хөтөлбөр Говийн их дархан газарт зарим зүйлийн хамгаалалтыг авч тодорхой хэмжээнд ажиллаж байгаа.

2026 оны төсөв дээр яг зэрлэг ан, амьтдын тэжээл дээр хөтөлбөрийн зардал дээр байгаа дүндээ зориулаад, дээрээс нь гаднын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа дүн дээр зориулаад зохион байгуулалтыг нь хийгээд ажиллаж байна.

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Ерөнхий сайд, Байгаль орчны сайд хоёроос. Энэ зудтай аймгуудаар том том угалз, аргал, буга энэ тэр зудад нэрвэгдээд эндэх нь их байна.

Тийм учраас энэ намрын 9, 10, 11 сард багтааж квотыг нь дахиж Засгийн газар хэлэлцээд төсөвт мөнгө оруулах боломж байна уу гэдэг асуудлыг тавьж байна л даа. Нэгдүгээрт.

Хоёр дахь асуудал. Энэ сайжруулсан түлшний асуудал байж байна. 228 тэрбумд түлш оруулж ирнэ гэсэн. Хэчнээн тонн нь орж ирчхээд байна. 2026 оны.

Одоо өвөлжилтийн бэлтгэл ажил хэр хангаж байна. Шахмал түлш. Одоо айлууд түлш түлээд эхэлсэн байгаа. Энэ талаар тодруулж асууя.

Х.Булгантуяа: Эхлээд Б.Батбаатар сайд хариулах уу? Ерөнхий сайд хариулах уу? Уул уурхайн сайд байхгүй байна.

Г.Занданшатар: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр 7 сарын 20-нд ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж эхэлсэн. Нэн ялангуяа баруун аймгуудад гангийн байдалтай, өвөлжилт хүндрэх нь тодорхой болсон. Энэ бол муу амлаж байгаа юм биш. Орон нутгийн иргэдээс ийм санал санаачилга маш их ирж байгаа.

Хоёрдугаарт нь, Оросын Холбооны Улсын шатахууны дотоод нөхцөл байдлаас шалтгаалаад баруун аймагт бензин, шатахууны хомсдол үүсэж болзошгүй нөхцөл байдал үүссэнийг бид нийлүүлэгч талтай ярилцаж шийдвэрлэсэн. Одоо цаашдаа тогтворжуулах чиглэлээр энэ сарын 23-нд яриа хэлэлцээ үргэлжлүүлж баруун аймгийн түлш шатахууны асуудлыг шийдвэрлэнэ.

Харин мал, мах бэлтгэлийн ажил нэлээн эрчимжиж байна. Энэ чиглэлээр мал, мах гаргах ажлаар ирэх Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлэх малын эрүүл мэнд, хорио цээрийн дэглэм, холбогдох зохион... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Байгалийн нөөц, ан амьтны тоо толгой, нөхцөл байдлыг судлаад квотыг нь тогтоогоод, зохистой ашиглалтаар хэдэн ан, агнуурыг агнаж болох вэ, аль бүс нутаг, аль аймагт хэдийг агнаж болох вэ гэдэг тоог гаргадаг.

2025 оны хувьд энэ тоо батлагдаад өнгөрсөн өмнөх хагас жилд сайдын тушаалаар тоо нь гарсан байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө Засгийн газрын тогтоол болон бусад журам, дүрмийнхээ хүрээнд гардаг учраас одоо нэмэлтээр зуд турхан болох нь гээд ан, амьтныг агнана гэдэг ийм байдлаар тоо гаргах боломжгүй.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгээд зарим сайдуудынхаа хэлж байгаа зүйлийг сонсохоор нүднээс бараг нулимс гоожих гээд байгаа юм. Нээрээ л бид хэд зөв чиг рүү яваад байгаа ч юм шиг.

Тэгээд түрүүн Хассуурийн Ганхуяг гишүүний хэлж байгаа бодит үйлдэл байхгүй. Тэгээд ерөөсөө бараг төсвийнхөө хэлэлцүүлгийн дундуур зүгээр сууж чадахгүй гараад хэвлэлийн хурал хийгээд зогсож байгаа сайд нар ч байна. Тэгээд одоо иймэрхүү байдлаар төсөв хэлэлцүүлэх юм бол энэ чинь өөрөө хандлагын асуудал харагдаж байгаа байхгүй юу.

Тэгээд зарим хүмүүс маань ярих юм. Нэг салбарын төсвийг танайд нөгөө салбарт өгмөөр байна гээд байгаа байхгүй юу. Бид эсрэгээрээ яримаар байгаа юм. Хэрэгцээгүй зардлаа танаад, яаж энэ төсвийн орлогыг илүү их бүрдүүлдэг болох тухай яримаар байна. Бидэнд зам хэрэгтэй, боловсрол хүний хөгжүүлэх асуудал дээр бүгд хэрэгтэй байхгүй юу. Бүгд хуримтлагдсан. Энэ асуудлууд чинь.

Тэгэхээр ерөөсөө уялдаагүй асуудал байхгүй.

Тэгэхээр бид хэд яаж эдийн засгийг тэлэх, орлогыг тогтвортой олж ирдэг болох вэ гэдэг зүйлээ бид хэд ярьж байж бусад салбар яана уу гэхээс биш яг байгаа энэ хэмжээндээ бид сэтгээд байвал ерөөсөө юу ч өөрчлөгдөхгүй.

Нэг талдаа бол үнэн. Бид нарын энэ 5 литрийн сав цоорчихсон байхгүй юу. Энэ 5 литрийн саванд тонн ус хийсэн ч энэ дүүрэхгүй. Яагаад гэхээр энэ цоорхой.

Тэгээд түрүүн Т.Доржханд гишүүн, бас зарим хүмүүс хэлээд байна л даа. Тэр нэгжийг өөрчлөх асуудал. Б.Найдалаа гишүүн. Тэр зөв шүү дээ.

330 сумыг 110 болгох судалгаа аль хэзээ хийгдсэн юм. Тэгэхдээ бодит үйлдэл, бодлого болж чадахгүй байгаа.

Тэгээд манай сайдууд ер нь жоохон вакумжихдаг юм шиг байна. Ер нь ямар ч хүн болсон. Тэгээд буудуулахгүй байж байгаад улс төрийн амьдралаа нэг жоохон урт болгочихъё доо гээд ерөөсөө юм хийдэггүй. Тэгээд яах вэ, яг цаг хугацааны цагалбартаа хэдэн юман дээр орж ирж гүрийж сууж байгаад л юмаа хийж аваад л. Төсөв батлагдана. Цаг хугацаатай хэдэн юмаа батлуулж аваад тэгээд л буруу хараад суудаг. Ерөөсөө л энэ.

Тэгээд ээлжилж хэдэн хүмүүс сайд болж тоглоод л. Тэгээд ийм зүйлтэй. Ерөөсөө юм хийдэггүй, өөрчилдөггүй. Тэр судалгаа тоосонд дарагдаад бараг хэрэггүй болтол байж байгаа байхгүй юу. Тэгээд өөрчлөлтүүд байхгүй.

Бид асуудлаа мэдээд байдаг. Юу ч өөрчлөхийг хүсдэггүй.

Тэгэхээр ийм байх юм. Ерөнхийд нь хэлэхэд.

Тэгээд төлбөрийн тэнцэл дээр нэг үүсээд байгаа асуудал бол энэ тээврийн асуудал. 800 сая долларыг шууд алддаг болсон байна.

Уул уурхайн биржийн хуулиас болоод байна уу, яг юунаас болоод байна? Үүнийг засах ямар бодлогын арга хэмжээ төсвийн бодлоготойгоо уялдуулж орж ирж байгаа юм бэ?

Хоёрдугаарт, АМНАТ-ын бодлогыг Засгийн газрын тогтоолоор баталдаг бол сүүлдээ ашиг сонирхол орж байгаа юмнууд ил далд болсон. Улсын Дээд шүүхийн шийдвэрийн оролцоотойгоор хийдэг боллоо. Үүнийгээ хуульчилъя. АМНАТ-ын асуудлыг бие даасан хуулиар явъя. Тодорхой орлогыг нь орон нутагт нь үлдээе. АМНАТ-аас орж ирж байгаа тодорхой орлогыг нь буцаагаад байгаль орчинд зарцуулдаг байя.

Ингэж байж энэ чинь өөрөө олон эрх ашгууд чинь ойлголцож байж дундын ойлголтдоо хүрч байж энэ чинь явна. Уул уурхай чинь. Өнөөдөр байгаль орчны салбарт тэр ус цөөрөм дээр ерөөсөө 3-хан тэрбум төгрөг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хэн хариулах вэ? Н.Учрал сайд.

Н.Учрал: Тийм. П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ер нь түрүүн ч гэсэн тэр хөгжлийн бодлогыг үнэлэх, тэр индикаторуудын талаар ч ярилаа. Тэгээд ер нь ингээд нэг ажил төлөвлөхөөд, хийсэн нэр зүүгээд, тэрийгээ 100 хувь гэж үнэлээд. Индикатор шалгуурууд нь ч тодорхой биш. Ингэж явсаар байгаад нэг тайлан тавьдаг. Байнгын хороон дээр ороод хөгжлийн бодлогоо тайлагнадаг бол ерөөсөө нэг формалный л болсон юм байна л даа.

Тийм учраас хөгжлийн бодлогын баримт бичиг, 5 жилийн чиглэл бол шинэ аргачлалаар явснаараа П.Сайнзориг гишүүний яриад байгаа салбар болгон дээр хийгдэх ажлуудын яг индикаторт суурилсан хэмжилт хийнэ.

Тэгээд тэр үр дүнд хүрээгүй бол үнэлгээ доошилдог л ийм байдал руу шилжих ёстой байхгүй юу. Тухайн салбарт ямар үржил гарсан бэ гэдгийгээ бодит тоогоор хэмжихгүй бол одоо нэг ийм байдалтай байна.

Тэгээд энэ удаагийн төсвийн гол онцлог байгаа нөхцөл байдалтай бид нийцсэн үнэн бодит байдлаас зугтаагүйгээр төсвөө боловсруулсан.

Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд барьсан нь энэ удаагийн төсвийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлсэн төсөв болсон гэж үзэж байгаа.

Тийм учраас ирэх он жилүүдэд яг энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиа бариад яг зөв цагтаа мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлээд явбал эдийн засаг эрүүлжинэ. Орлого зарлага аль аль нь буурсан. Гол нь тэр тэнцэлжүүлсэн орлогоосоо суурь зарлагаа хасаад тэр суурь тэнцэл чинь өөрөө эерэг гарч байна гэдэг бол сайн үзүүлэлт.

Гэтэл өнөөдөр зүгээр багш нарын ч юм уу, эмч нарын ч юм уу цалин хөлс, халамжийн олон салбарт 200 гаруй хуулиар халамжлаад ирсэн. Тэгээд хуулиа хэрэгжүүлэхээс өөр гарцгүй ийм байгаа үед энд цалинг нь нэмье гээд явахаар нөгөө урсгалынхаа 24 хувийг барихгүйгээр, жилийн төлөвлөгөөнд туссан тэр 24 хувиа барахгүйгээр тэрийг давуулаад явах юм бол цаашаа дахиад л нөгөө инфляцыг хөөрөгдөөд л, нөгөө төгрөгийн ханш нь сулраад л. Цалин өссөн нэртэй хэдий ч өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ нь дагаад хөөрөгдөөд байхаар ямар ч ялгаагүй л юм болоод байгаа байхгүй юу.

Тийм учраас цалин хөлс нэмсэн нэртэй. Төсвийн сахилга бат байхгүй. Тэгээд л нөгөө инфляц улам өдөөгдөөд явсаар байгаад л тэгээд л ийм л байдалд оччихоод байгаа юм байна лээ л дээ.

Тийм учраас ерөөсөө л энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиа энд анх барья л гэдэг зорилгоор л энэ удаагийн төсөв хийгдсэн.

Тийм учраас тэр дотоодын нийт бүтээгдэхүүн, орлого хоёрын харьцааг 2028 хувь он хүртэл 28 хувь бууруулж чадвал энэ Засгийн газрын татварын багц хууль хэрэгжинэ. Тэр хувийн хэвшлийн ачаалал буурна. Тэр хөрөнгө оруулалтын хуулиа баталчихвал хөрөнгө оруулагч нар, тэгээд хандлага өөрчлөгдөнө өө л гэж ингэж зориод байгаа юм.

Тийм учраас энэ удаагийн төсвийн мөчлөг сөрсөн бодлого бол геологийн салбарт эрэл хайгуулыг нэмэгдүүлэх чиглэлээр төсвийг жишээ нь хоёр дахин нэмэгдүүлсэн. Ингээд тэр, хувийн хэвшлийн түншлэлээ дэмжсэн.

Дээрээс нь шинжлэх ухаан дээр. Шинжлэх ухаанд үнэхээр оюуны өмчийг эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт татаж оруулж ирэх юм бол тэр, хувийн хэвшлийн түншлэлийн дагуу ирэх жилд тэр R&D /research and development/ буюу тэр судалгаа хөгжүүлэлтдээ өөрөө тэр оруулж ирсэн мөнгөнөөсөө тодорхой хувийг нь зардаг.

Тэгээд Монгол Елс бүхэлдээ ийм нэг дижитал дататай болох чиглэл рүү хандсан нйм л төсөв болсон гэж ойлгоод байгаа.

Тэгэхээр сахилга баттай, хариуцлагатай, ямар ч байсан урагшаа харсан. Гэхдээ мэдээж энэ чинь нөгөө хөнжлийнхөө хэрээр хүлээж хийж байгаа учраас буцаад зөв голдиролдоо орцгооё.

Тийм ч учраас 10 сарын 30-наас өмнө. Түрүүн Ардчилсан намын гишүүдийн С.Ганбаатар гишүүний яриад байгаагаар ч гэсэн 5 жилийн чиглэл дээрээ ч гэсэн зөв хэмждэг тодорхой болгоё л гэдэг зорилготой байгаа.

Х.Булгантуяа: Г.Дамдинням сайд. Тэгээд дараа нь Б.Жавхлан сайд хариулъя.

Г.Дамдинням: Тийм. П.Сайнзориг гишүүн аягүй чухал юм хэлээд байгаа юм.

Энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль маань хэд хэдэн асуудалтай болчихоод байгаа юм.

▷ **Нэгдүгээр асуудал нь,** бид ганцхан хил дээр аваачиж өгнө гэдэг үүрэг хүлээсэн зохицуулалт руу оруулсан. Уурхайн аман дээрээсээ зарж болдоггүй нэг ийм асуудалтай.

Тэгэхээр үүнийг жоохон чөлөөлж өгөх өөрчлөлтийг манай яамнаас хууль эрх зүйн орчны өөрчлөлтийг бэлдэж байна.

▷ **Хоёрдугаар асуудал нь**, Уул уурхайн бараа, бүтээгдэхүүний хууль дээр байгаа дараагийн маш төвөгтэй асуудал юу вэ гэхээр дотоодын борлуулалтыг хориглоод хаячихсан.

Тэгээд дотоодын борлуулалтыг хориглохоор зэрэг 47 аж ахуйн нэгжүүд үндсэндээ бүтээгдэхүүн байхгүй. Дархан төмөрлөгөөс бүтээгдэхүүн авч чаддаггүй. Эрдэнэс Тавантолгойгоос бүтээгдэхүүн авч чаддаггүй.

Тэгээд аваад боловсруулаад гаргаж чаддаггүй ийм нөхцөл рүү ороод байгаа юм. Үүнийг засах ёстой байгаа.

Тэр АМНАТ-тай холбоотой асуудал бол шүүх, хуулийн байгууллага оролцоод их зовлонтой юм байна лээ. Шийдэх ёстой. Хуулийг нь янзлах гээд л оролдоод бичиж байгаа бид. Танилцуулаад явна. Ойрын үед оруулж ирье л гэж байгаа юм. Тийм.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Хуульч хүн. Тэгээд төлбөрийн тэнцэл дээр айхтар нарийн тоо асуулаа. Яах аргагүй яг тийм байгаа юм. Ачаа тээвэр дээр бид алдаад байгаа. Төлбөрийн тэнцэл дээр харах юм яг нөгөө тээврийн гарах урсгал данс 788.0 сая, бараг 800.0 сая долларын ийм хасахтай байгаа. Үүнээс яг ачаа тээвэртэй нь холбоотой 581.0 сая доллар.

Өөрөөр хэлбэл Монгол Улс бараа татахдаа, эсвэл экспорт хийхдээ тээвэр дээрээ алдаад байна. Дандаа гаднаас үйлчилгээ аваад байна гэсэн үг.

Тэгэхээр үүнийг багасгахын тулд нөгөө л дэд бүтэц ярина. Бид машин үйлдвэрлэдэггүйгээс хойш бид суурилагдсан дэд бүтэц буюу төмөр зам, замаа л бариад байх хэрэгтэй. Ингэж байж бид өртгөө бууруулна.

Гэхдээ энэ дотор нэг нюанс байгаа. Хэрвээ бид хэрвээ бид Биржийн хууль хийгээд яг хил дээр хүргэгдсэн үнээр гээгүй байсан бол энэ 581.0 сая доллар маань манай дансаар орж гарахгүй. Хаагуур ч юм. Бүгд цаад талдаа төлбөр тооцоо нь явна. Хилийн цаана.

Ингээд биржийн үнээр буюу яг хилийн үнээр бид бирж дээрээ зардаг болсон учраас ямар ч байсан энэ мөнгө манай дансаар дамжиж байгаа. Татвар

дээр харагдана. Тодорхой хэмжээнд Монгол Улсад үлддэг болсон байгаа гэдгийг хэлье.

Сая Г.Дамдинням гишүүн АМНАТ дээр асуулаа. АМНАТ дээр би бас нэг хоёр зүйл хэлье.

АМНАТ гэдэг бол Үндсэн хуулийн 6.2-ыг гүйцэлдүүлэх цорын ганц бидний платформ. Өөрөөр хэлбэл ашигтай ч бай, ашиггүй ч бай Монголын ард түмэн эндээс энэ АМНАТ-аа бид авч байх л ёстой байгаа юм. Роялтигаа авч байх ёстой ийм зүйл.

Тийм учраас бид роялтигийн хувь хэмжээг Засгийн газар өөрчлөх тэнд ямар ч эрх мэдэл байхгүй. Энэ бол Их Хурлын эрх мэдэл.

Харин Засгийн газрын бодлогын орон зай хаана байдаг вэ гэхээр тэр АМНАТ-ыг ногдуулах суурь үнэ, эх үүсвэрийг Засгийн газар үүнийг тогтоодог. Үүнийг дээш нь доош нь болгох. Энэ нь мэдээж АМНАТ төлж байгаа хэсэг улсуудад таалагдахгүй. Үүнийг шүүхэд өгдөг. Шүүх харамсалтай нь эсрэг талд ийм шийдвэр гаргаад байгаа. Сүүлийн үеүдэд.

Тэгэхээр үүнийг олон нийт харах ёстой. Энэ дээр шаардлага тавих ёстой, хяналт тавих ёстой.

Засгийн газар өөрийнхөө тэр бодлогын орон зайндаа харин тултал сууриа тэлэх л арга хэмжээ авах боломжтой. Хувь, хэмжээг өөрчилж чадахгүй юм чинь. Сууриа тэлэхдээ харин салбараа унагааж ч болохгүй. Салбараа дэмжээд, сууриа ч тэлээд, биржээ ч дэмжээд явах ийм л оновчтой арга хэмжээнүүдийг Засгийн газар эрэлхийлж ажиллах ёстой. Энэ дээрээ бид хичээж ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: П.Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: АМНАТ-ыг бол бие даасан хуулиар оруулж ирээрэй гэж би хүсэж байгаа юм.

Өөр нэг зүйл байна. Энэ төрийн өмчит компаниудыг олон нийтэд болгох бодлого ирэх жил хэрэгжих үү? Үүнийг хэлээдхээч.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой зүйлийг хэлье. Энэ бол бодит кэйс шүү. Ерөөсөө архины хамааралтай нөхөр жилд 6 удаа Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээ хийлгээд 20 сая төгрөг авч байна.

Тэгэхээр ямар эмчилгээ, үйлчилгээг нь 100 хувь Эрүүл мэндийн сангаас гаргах юм? Ямрыг нь өөрөөс нь тэдэн хувь, 50 хувь, 80 хувь гаргуулах юм? Энэ зүйлийг өөрөө хэрэглэгчдэдээ хяналтыг нь бий болгох асуудал байхгүй бол багц

багцаар нь хүний регистрийн дугаар яваад, хэвтэн эмчлүүлж мөнгө хусдаг ийм сүлжээ битүү байна. Үүнийгээ бид засах ёстой.

Тэгээд тэр архины хамааралтай нөхөр 20 сая төгрөгөөр, бусад хүний мөнгөөр архиа уугаад жилд 6 удаа эмнэлэгт хэвтээд байж байна шүү дээ. Ингэж болох юм уу? Энэ сан чинь.

Тэгэхээр үүнийг өөрчлөөч ээ. Ингэхээр чинь яаж нөгөө хүрэх ёстой эрүүл мэндийн салбар болох вэ.

Сая Эрүүл мэндийн сайд нэг ноцтой зүйл хэллээ. Би энэ үйлчилгээг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: П.Сайнзориг гишүүн ээ, та зөв хэлж байна.

Ер нь бид өөрийн буруугаас болж өвчин тусчхаад тэгээд бусдын даатгуулсан мөнгөнөөс тусламж, үйлчилгээ авна гэдэг бол энэ шударга биш. Харин манай даатгалын тогтолцооны гол зарчим бол солидарность буюу залуучууд нь хөгшчүүлдээ, эрүүл нь өвдсөндөө туслах болохоос өөрийн хариуцлагагүйгээс болж байгаа улсуудыг санхүүжүүлнэ гэдэг нь буруу.

Тийм учраас энэ дээр бид онцгой анхаарал хандуулах ёстой.

Тийм учраас донтолттой холбоотой эмчилгээ бол нийгмийн эрүүл мэндийн тусламжийн санхүүжилтээр Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам хамтдаа энэ асуудлыг шийдэх ёстой гэдэг дээр санал нэг байна.

Тэр гүйлгээ зогсоосон гэдэг бол энэ буруу гүйлгээг хэлж байгаа юм шүү. Түүнээс хүнд эмчилж байгаа гүйлгээг зогсоосон биш шүү. Та зөв анхаараарай. Алагчлаад. Та зүгээр төсөөлөөд үз дээ. 10 хүн эмчлүүлэх гээд ирэхэд 8 нь улсын эмнэлэг дээр очно. Ар гэр нь бүх эм, тариаг нь гаднаас оруулж ирж байгаа шүү дээ. Хувийн эмнэлэг дээр очсон 2 хүн нь бүх эмчилгээ нь бүрэн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Төрийн өмчит компаниудын асуудал. Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл хариулъя.

П.Сайнзориг гишүүний хэлж байгаа энэ төлбөрийн тэнцэл дээр Та бүхэн анхаараарай.

Энэ оны эхний 7 сарын байдлаар 284.1 сая ам.долларын алдагдалтай байгаа. Өны эцэс гэхэд 600.0 сая ам.долларын төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахаар байна.

2026 онд 1.5 тэрбум долларын алдагдалтай гарахаар байна.

Монголбанкны дэд Ерөнхийлөгч хийж байсан 2 хүн Улсын Их Хурлын чуулганы танхимд сууж байна. Энэ бол ерөөсөө инфляц өдөөгдөөд л монгол төгрөгийн ханшийг унагах л эрсдэл үүснэ шүү дээ.

Инфляц гэдэг чинь өөрөө яг л хүн болгоны карманаас авч байгаа татвартай яг адилхан. Цалингаас, тэтгэврээс. Бидний худалдаж авч байгаа бараа, бүтээгдэхүүнээс авч байгаа татвартай яг адилхан.

Тэгэхээр бид нөгөө талдаа татвараа бууруулъя гэж ярихаас бараг илүүтэйгээр магадгүй инфляцаа бууруулъя гэж ярих ёстой юм биш үү? Үүнийг бол манай Б.Чойжилсүрэн сайд өөрөө маш их ярьдаг хүн. Үүн дээр Та бүхэн анхаараарай.

Мөнгөний бодлого тун удахгүй Улсын Их Хуралд өргөн барихаар байгаа.

Б.Цэнгэл: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Үндсэн чиглэлийг Засгийн газар хурлаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Энэ удаагийн үндсэн чиглэлээр бид 9 хуулийн этгээдийг оруулахаар төлөвлөж ажиллаж байгаа.

Энэ дээр Эрдэнэс Тавантолгой, Дулааны 3 дугаар цахилгаан станц, Эрдэнэтийн дулааны станц, Төрийн банк, МИАТ, Монголын цахилгаан холбоо, Монголын хөрөнгийн бирж, Хөдөө аж ахуйн бирж, Үндэсний давхар даатгал гэсэн 9 хуулийн этгээд үндсэн чиглэлд орохоор байгаа.

Ингээд Засгийн хурлаар хэлэлцүүлээд улмаар Их Хуралд өргөн барина.

Х.Булгантуяа: П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд Ж.Чинбүрэн сайд аа, яг энэ асуудлыг ойлгож байгаа бол яг хийчхээрэй. Байгаа нөөцөө битгий хулгайд алдаад байгаарай. Байгаа нөөцөөр өөр өөрийнхөө эрүүл мэндийг хайхардаггүй архичдыг битгий эмчлээд байгаарай.

Тэнд ахмадууд, тэнд хүүхдүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй байна. Үүнийг анхаарна биз.

Тэгээд хоёрдугаарт Шадар сайдаас асууя гэж бодсон юм. Энэ нэг тендерийн хууль байна. 6 сарын 30-ны дотор тендерээ зарлаж чадахгүйгээс болоод хөрөнгө оруулалтын талаасаа төсвийн хууль чинь ерөөсөө 6 сарын настай болсон. 6 сарын настай хууль баталж байгаа. Бид одоо ч батална.

Тэгээд энэ төсөв дээр тавьж өгч байгаа хөрөнгө оруулалтуудыг энэ тендер худалдан авалт талаасаа асуудалгүй явчихдаг энэ юмыг хиймээр байна. Нөгөө талдаа бид төсвийг төлөвлөхдөө маш сайтар бэлтгэл ажлыг хангах ёстой гэдэг ийм хоёр зүйл ерөөсөө харагдаад байгаа. Тэгээд энэ реформ ерөөсөө орж ирдэггүй. Ер нь л сайхан л ярьдаг л даа. Тэгээд буудуулчихна гээд ерөөсөө байхгүй.

Ийм холын бодолтой ч гэдэг юм уу, улс төрд олон жил явна гээд ерөөсөө биеэ цэнээд нэг ийм яст мэлхийний хуяг дотор ороод... /минут дуусав/

Х.Булгантуяа: П.Сайнзориг гишүүн үг хэллээ дээ. Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Өмнөх Засгийн газарт би Хэрэг эрхлэхийн даргаар ажиллаж байхдаа тэр тендерийн хуулийг над руу шилжүүлсэн.

Тэгээд тэр тендерийн хуулийг бүх л салбарын яамдыг оролцуулаад боловсруулаад дууссан. Үүн дээр П.Сайнзориг гишүүн өөрөө хууль санаачлаад, тэгээд тэр хуулийн концепцтой нь нэгтгээд хуулийг боловсруулаад дууссан.

Одоо тендерийн хуулийг аваад ороод ирье. Гол нь орж ирэхээрээ камерын өмнө амьдрал дээр өөр байхад нэг камер харахаараа бас нэг баларсан юм болдог шүү. Тийм.

Тэгэхээр яах вэ, тендерийн хуулиа оруулаад ирье. Улс орны хөгжлийн төлөө тэр төлбөрийн тэнцэл чинь уг нь экспорт, хөрөнгө оруулалт л хоёр шүү дээ.

Тэгэхээр тэр хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөө, тендерийн хууль 10 дугаар сард өргөн мэдүүлье. Тэгээд Их Хурлын гишүүд дэмжихийг хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе Та бүхэнд.

Энэ төсөвтэй холбоотойгоор хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Тэгэхээр голчлоод Сангийн яамныхнаасаа асууя.

► **Нэгдүгээрт нь,** 2026 оны төсөв маань 1.3 их наядын алдагдалтай орж ирж байгаа. Бид 2025 оны энэ жилийн төсвийг батлахдаа алдагдалтай орж ирээд тэгээд алдагдалгүй болго гээд, хориг орж ирээд, тэрийг нь хүлээж аваад явсан.

Тэгэхээр энэ эрсдэлээ тооцож байгаа юу? 1.3 их наяд. Хэрвээ хориг ороод ирвэл бас яах вэ гэдэг эрсдэлийг ер нь тооцож байгаа юу гэдэг нэг асуулт байна.

► **Хоёрдугаарт нь**, гадаад зээлийн ашиглалтаа бид сайжруулъя гээд байгаа. 12-оос 13 их наядын зээлийн хэлэлцээр хийгдсэн. Ингээд хүлээгдэж байгаа, ашиглаж чадахгүй гээд байгаа гадаад зээлийн боломжууд байгаад байна.

Гэтэл нэмэгдээд одоо нөгөө зээлийн хэлэлцээрүүд орж ирээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг нөгөө зээлдүүлэгч тал нь адилхан байх юм бол энэ зээлийн зориулалтыг өөрчлөх талаар юм уу, эс үгүй бол ашиглаж чадахгүй байгаа тэр зээлээ ашиглах тал дээр ажиллаж болох уу, болохгүй юу? Ер нь энэ жил хэдий хэмжээний гадаад зээлийн санхүүжилт орж ирж байгаа вэ гэдэг.

► **Гуравдугаарт нь**, Татварын багц хуулийн шинэчлэлт хийх ажлын хэсэг бараг түрүү намрын чуулганаас эхлээд ажилласан.

Тэгэхээр бид ард түмнийхээ нуруун дээрээс татвараа хөнгөлөөд татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд Сангийн яам бас үүнийг мэдэж байгаа.

Тэгэхээр мэдээж энэ намар бол одоо ер нь татварын багц хуулийн өөрчлөлт орж ирэх болов уу гэж бодож байна. Зүгээр. Хэрэгжих хугацаа нь ямар байх юм гэдгээсээ болоод татварын орлого дээр мэдээж ачаалал ирнэ. Үүнийг ирэх жилийнхээ төсөв дээр тооцоолж үзэж байгаа болов уу гэж асууя.

► **Дөрөвдүгээрт нь**, үнийн зөрүү, ханшийн зөрүү гээд. Эсвэл магадлангаар орсон гээд баахан хэрэгжиж байгаа төслүүд дээр хөрөнгө оруулалт нэмэгддэг.

Тэгэхээр энэ жил тийм нэмэгдэл нь аль зэрэг байгаа вэ гэдэг нэг асуудал байна. Хэчнээн хэмжээний нэмэгдэл орж ирээд байна гэдэг.

Тэгээд энэ асуулттай холбоотойгоор Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байгаа юм. Бид одоо энэ төсөв ороод ирэхээр нэг бол цалингаа нэмье, тэтгэврээ нэмье л гээд байдаг. Тийм ээ.

Тэгэхээр үнийн өсөлтөө ер нь хязгаарлах, бууруулах тал дээр ямар бодлого авч хэрэгжүүлж явах юм бэ?

Тэгээд дараагийнх нь, Гэр бүл, хөгжлийн яамнаас уг нь асуучихмаар байгаа юм. Төрийн албан хаагчдын нөгөө 36 сарын тэтгэмжтэй л холбоотой юм асуух гээд байгаа юм.

Бид уг нь 3 жилийн өмнө. 1 минутаа нэмээд шууд авчихъя. 3 жилийн өмнө энэ чинь 20-иод их наядын л төсөв баталж байсан юм билээ. Одоо бид гуравхан жилийн дараа 10 их наядаар нэмэгдүүлсэн төсөв яриад байгаа. /минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулъя. Г.Занданшатар Ерөнхий сайд хариулчхаад. Тэр чинь уг нь тодруулгаар нэмж байх ёстой шүү дээ. Хэдүүлээ ядаж төсөв дээрээ дэгээ нэг сайн сахиад явчихъя. Бүх хүмүүс тэгж явсан. Р.Батболд гишүүн ээ.

Г.Занданшатар: Ер нь Засгийн газар байгуулагдсанахаа дараа шуурхайлаад үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор төсвийн тодотгол хийсэн.

Ер нь яагаад алдагдалгүй төсөв батлах шаардлага тавьж хориг тавьсан бэ гэхээр орлогыг хэт өөдрөгөөр төсөөлсөн, зарлагыг тэр хэмжээгээр тэлсэн байсан учраас.

Тэгэхдээ дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал төсөв өргөн барьснаас хойш өөрчлөгдөөд, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болоод, тарифын дайн үүсэх нөхцөл бүрдээд. Ийм бодит эрсдэл нь үүнийг тэнцвэржүүлэх зорилгоор төсвийг алдагдалгүй тавих шаардлага тавьсан.

Өнгөрсөн 30 жил дандаа алдагдалтай төсөв баталж ирсэн. Хэрвээ ингэж алдагдалгүй төсөв батлах шаардлага тавиагүй байсан болбол тэр 2.8 их наядын алдагдал дээр саяын 3.3 их наядын орлогын тасалдал нэмэгдээд 6.1 их наядад төсвийн алдагдалд хүрэх юм бол инфляц 2 оронтой тооноосоо дээш давж үсэрч, дээр нь валютын ханшийг 4 мянга хүртэл алдах тооцоотой. Ихээхэн эрсдэл үүсэх нөхцөл байдал байсан.

Тийм учраас төсвийн тодотгол хийж, 2.2 их наядаар хязгаарласнаараа валютын ханшийг тогтворжуулж, инфляцыг тогтвортой байлгаж чадсан. Их өсөлтөөс урьдчилан сэргийлж чадсан.

Одоо өнөөдөр валютын нөөц түүхэнд байгаагүй дээд хэмжээндээ буюу 5.7 тэрбум долларт хүрээд байна.

Энэ бол валютын ханшийн интервенц хийвэл тогтворжуулах төдийгүй бидний боломжийг нээсэн.

Төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн хүрээнд ч гэсэн Тавантолгой компани дээр бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөл томилж ажиллуулснаараа үр ашиг 3 дахин сайжирсан. Экспорт тэр хэмжээгээр нэмэгдсэн. 7, 8 сарын экспорт 1.6 дахин нэмэгдсэн. Өмнөх хагас жилийнхээс.

Биржийн арилжаа 40-өөс 60 хувь нь бүтэлгүй болдог. Бараг зогссон байсан бол биржийн арилжаа сэргэсэн. Үнийг 13-аас 17 хувиар нэмэгдүүлж чадсан. Ийм бодит үр дүнгүүд гарсан учраас эдийн засаг дахь өсөлт тогтворжиж, 5.7 хувьд эдийн засгийн өсөлт хүрээд байна. Энэ хэмжээгээр төсвийн орлого, борлуулалтын орлогоо бид тэнцвэржүүлж чадаж байна.

Энэ бол бодит байдал юм. Тоо худлаа ярьдаггүй. Эдийн засгийн энэ өсөлтүүдийн хүрээнд төрийн өмчийн компаниудад хийж байгаа шинэчлэлүүд гэхэд “Эрдэнэс Эм Жи Эл” дээр бид 2-хон их наядын ашигтай ажиллах тооцоотой байсныг ирэх жил 3 их наяд болгож шахсан. 1 их наядаар нэмж.

Төсөвт орох орлого 540 тэрбумаар нэмэгдүүлж байна.

Энэ бол сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, төрийн өмчийн компаниуд дээр хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн бодит үр дүн. Тоо худлаа ярьдаггүй. Бодит тоонууд ийм байгаа.

Зөвхөн 7 сард бараг 3 сая тонн, 8 дугаар сард 3.8 сая тонн нүүрс арилжаалсан нь сүүлийн нэг жилийн хамгийн өндөр үзүүлэлтүүд байгаа. 6 сар хүртэл үндсэндээ зогсчихсон, гацсан байсан.

Тавантолгой дээр байсан хулгай зэлгийнүүдийг зогсоож шалгах ажлыг эхлүүлсэн. Тэр ТНАЛТ /Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв/, тэр 1 их наядаар барьсан нүүрс баяжуулах үйлдвэрүүд үндсэндээ ажиллагаагүй болсон байсан.

Энэ бодит ажлуудын чинь үр дүнд өнөөдөр эдийн засгийн сэргэлт бий болж, цаашдаа бид ирэх жилд эдийн засгаа тогтворжуулаад, бодитой өсгөх, 2027, 2028 онд GDP-г үндсэндээ даблдах зэсийн, гангийн үйлдвэрүүд ажлаа энэ жил. Одоо тендерээ зарлаж эхэлж байна.

Оюутны шинэ ордыг нээлээ. Эрдэнэтийн зэсийн орд, Эрдэнэтийн үйлдвэр маань ахиад 100 жил ажиллах бололцоотой боллоо. Энэ хэмжээгээр тэнд шинэ суурьшлын бүс, шинэ төлөвлөлтийг эхлүүлж байна.

Газын хоолой Монгол Улсаар дамжихад нэлээн их орлого олно. Одоо тодорхойдоо хэлээд яах вэ. 2031 оны 01 сарын 01-нээс эхлээд борлуулалт, манай төсвийн орлого ахин тэлнэ.

Ийм бодит эдийн засгийн суурь өөрчлөлтийг 2-хон сарын хугацаанд тавьж чадлаа бид.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд 36 сарын асуудал асуусан. Дээрээс нь Н.Учрал сайд.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төрийн албан хаагч нарын нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой асуудлыг олон гишүүд асуулаа. Тийм. Р.Батболд гишүүн дахиж асуулаа. Тийм ээ. Яагаад хуваав гээд.

Тэгэхээр энэ ерөөсөө л нөгөө жилийн төлөвлөгөөнд орсон урсгал зардлаа 24 хувьд багтаах ёстой шүү. Тэгээд энэ хязгаараас л болж байгаа юм.

178 тэрбум төгрөгийн асуудал л даа.

Тэгэхдээ энд ямар нэг эрсдэл гарахгүй. Яагаад гэхээр төрийн албаны хууль дээр ямар нэг өөрчлөлт ороогүй. Бид өмнө нь ч гэсэн 2015, 2016, 2017, 2018 онуудад бүр 3, 4 жил дараалаад ийм арга хэмжээнд авч л байсан юм байна лээ.

Тэгэхээр одоо юу гэдэг юм, 3, 4 дүгээр улиралд тэтгэвэрт гарах гэж байгаа төрийн албан хаагч нар маань таллаад авч болно, эсвэл бүтнээр нь аваад, зарим нэг нь тэтгэвэрт гарах хугацаагаа 27 хоног руугаа шилжүүлж болно, эсвэл төсвийн эрхлэн захирагч нар өөрийнхөө урсгал дансан дээр хэмнэлтүүд гардаг. Үүнийгээ энэ рүүгээ шилжүүлж болно... /минут дуусав/

Х.Булгантуяа: Р.Батболд гишүүн нэмж тодруулъя.

Р.Батболд: Яах вэ, зүгээр би түрүүн асуулт гүйцээгдэж асуугдаж чадсангүй.

Бид гуравхан жилийн өмнө 10 их наядаар бага төсөв ярьж байсан юм байна. Тэгээд 3 жилийн дараа энэ чинь 32 их наядын орлого, 33 их наядын зарлага гээд яриад яваад байгаа юм. Тэгээд тэр дотор нь 178 тэрбум төгрөг байдаг юм уу, энэ төрийн албан хаагчид руугаа, энэ тэтгэмж рүү нь халдахгүй байж болдоггүй юм уу л гэдэг асуулт асуусан юм.

Хоёрдугаарт гэх юм бол Ерөнхий сайдаас уг нь бас асуух гэж байсан юм. Танай Засгийн газрыг нь сайн ажиллалаа, муу ажиллалаа гээд байх юм. Тэгээд энэ 2 сарын хугацаанд тоо баримттай юм байвал хэлчхээрэй гээд гол нь яг асуух гэж байсан. Өөрөө түрүүлээд ярьчихлаа.

Тэгээд яах вэ, нэмээд хэлэх юм байвал хэлээд өгөөрэй. Сая валютын нөөц, экспорттой холбоотой л юм ярьж байх шиг боллоо л доо. Тэгээд яасан яг сайн ажиллаад байна уу, муу ажиллаад байна уу гэдэг юм.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Сайн, муу ажилласныг бид өөрсдөө дүгнэхгүй. Гэхдээ энэ тоо баримтууд бидний 2 сарын ажлын үр дүнг яруу тод харуулж байгаа.

- ▶ Төрийн өмчийн компаниуд дээр шинэчлэл хийгдэж байна.
- ▶ Төрийн албаны шинэчлэл хийгдэж байна.
- ▶ Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн шинэчлэл хийгдэж байна.

Бид үндсэндээ реформын чиг баримжаатай Засгийн газар байхыг зорьж, цогц реформ хэрэгжүүлж байгаа.

Одоо бидний өргөн барихаар төлөвлөж байгаа 5 жилийн үндсэн чиглэл бол иргэдийнхээ шинэ итгэлийг шинэтгэл болгож, шинэтгэлийн үр дүнд Монгол Улсын үсрэнгүй хөгжил, дэвшлийг хангах, хүнд наалдацтай хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүний хөгжил, чанартай өсөлт гэсэн зорилтын доор эдийн засгийн өсөлт чанартай хүндээ наалдацтай бодлогот хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх ажил эхэлсэн.

- Би сая хэллээ.

➤ **Зэсийн үйлдвэрийн** ТЭЗҮ-г үндсэндээ сая бид баталгаажуулж дууслаа.

Одоо ажлын даалгавар нь гараад тендер нь зарлагдана. Энэ ондоо бид зэсийн үйлдвэр барьж эхэлнэ.

Энэ бол хөгжлийн тулгуур гүүр болно. Үсрэнгүй хөгжлийн үндэс болно.

➤ **Гангийн үйлдвэрийн** ажил, тохиргоо үндсэндээ хийгдэж байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж 1 минут өгье.

Г.Занданшатар: Бид төрийн данхар бүтцийг өөрчилж, төрийн өмчийн компаниудын шинэчлэл хэрэгжүүлснээрээ чиг үүргийн давхардлыг арилгаж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, төрийн өмчийн нэгдмэл удирдлага, зохион байгуулалтын систем шилжүүлж байна.

Эрчим хүчний салбар дээр гэхэд Баруун бүсийн эрчим хүчний компани, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээнүүдийг нэгтгээд Богдын гол, Тосонцэнгэл, Тайшир, Гуулингийн усан цахилгаан станц ХХК-нуудыг нэгтгээд дандаа үр ашигтай байх, чиг үүргийн давхардлыг арилгасан ийм цогц өөрчлөлтүүд хийж байгаа.

Одоо МИАТ компанийн 10 хувийг хувьцаалж IPO гаргахаас өгсүүлээд удахгүй төрийн өмчийн үр ашгийг сайжруулах цогц хөтөлбөр Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа гэдгээ сая манай Б.Цэнгэл дарга танилцууллаа.

Ийм учраас үндсэндээ эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, томоохон төсөл, хөтөлбөрүүд бодитой хэрэгжсэн ийм бодит ажлууд явж байгаа.

Бид 2 сарын хугацаанд борви бохисхийлгүй ажилласны үр дүнд эдийн засгийн өсөлтийн суурийг тавиад... /минут дуусав/

Х.Булгантуяа: Р.Батболд гишүүн нэмж тодруулъя.

Р.Батболд: Ж.Энхбаяр сайд аа, уучлаарай, би асуултаа гүйцээе.

Хөдөө аж ахуйн сайдаасаа нэг асуулт асууя.

Энэ нөгөө зээлийн хүүгийн хөнгөлөлтөөр одоо бид ирэх жил хэдэн төгрөг тавьсан байгаа вэ? Энэ жилийнхээсээ багасаж байгаа юу, багасахгүй байгаа гэдэг асуулт Хөдөө аж ахуйн яамнаас асууя.

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн салбарт “Шинэ хоршоо”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Атар-IV” гэсэн 4 цогц хөтөлбөр хэрэгжиж байгаа.

▷ “Хүнсний хувьсгал” хөтөлбөр хэрэгжээд үндсэндээ дууссан. Бүх зээл олгогдоод дууссан. 2026 онд төлөх зээлийн хүүгийн татаас төсөвлөгдсөн.

▷ “Шинэ хоршоо” хөтөлбөрийг өргөжүүлнэ.

Одоо 800 гаруй тэрбум төгрөгийн зээл олгогдсон бол 500.0 тэрбумыг 2026 онд нэмж олгох эх үүсвэр, түүнд шаардлагатай татаасууд явагдаж байгаа.

▷ “Атар-IV” дүгээр хөтөлбөр энэ жилийн тухайд 800.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл байснаас одоо 500 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл аж ахуйн нэгжүүд дээр очоод байна.

Үүний ашиглалт 2026 он руугаа шилжинэ. Ингээд цаашдаа үргэлжлүүлж авна.

▷ “Цагаан алт” хөтөлбөр маань өөрөө 2... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут өгье.

Ж.Энхбаяр: “Цагаан алт” хөтөлбөр нийтдээ 2.6 орчим их наядын санхүүжилттэй хөтөлбөр.

2025 онд мөн 800.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод явж байгаа. Энд ашиглалт их сайн яваа.

Ингээд энэ 4 хөтөлбөрийн үргэлжилсэн бодлого цаашдаа явна.

Салбарын гол бодлого байгаа эх үүсвэрийг хувийн хэвшилд хөнгөлөлттэй эх үүсвэр, зээл болгох хэлбэрээр л манай нийт төсөв хөрөнгийн 99 хувь нь зарцуулагдаж байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт гээд сая танилцуулгад хөдөө аж ахуйн салбарын төсвийн хөрөнгө оруулалтууд үндсэндээ байхгүй байгаа.

Цэвэр хувийн хэвшлээ дэмжих бодлогоо л дахин үргэлжлүүлнэ. Энэ ч их үр дүнтэй болж байгаа нь сүүлийн үед гараад байгаа судалгаа, эдийн засгийн мэдээллээр их өндөр гараад байна. Зөвхөн 2024 оны үр дүн гэхэд л 48 мянган ажлын байр энэ салбарт шинээр бий болсон ийм үр дүн гараад байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд ээ, одоо нэг цаг цайны завсарлага. Ингээд 2 цаг 20 минутаас үдээс хойших чуулганы хуралдаан үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганаа эхлүүлье.

Гишүүд, Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд оруулъя. Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлье. Асуулт хариулт явж байгаа.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Төсвийн хэлэлцүүлгээр уул уурхайн тухай, олборлолтыг нэмэгдүүлэх талаар, багш нарын цалинг нэмэгдүүлэх, багш нарын ажлын байрны хүртээмж, тэтгэврийн зээл гээд л олон сайхан юм ярьж байна. Ярих ёстой.

Гэхдээ энэ бүхэн чинь усгүй бол явахгүй л л дээ. Би одоо эрхэм Засгийн газрын гишүүд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхнийг ус уухгүй байгаач гэж уриалахдаа хүрээд байна.

Яагаад гэхээр манай говийн усны төсөл энэ төсөвт ерөөсөө алга. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багц дандаа хасагдсан байх юм. Одоо ерөөсөө байгаль орчин, цөлжилт, газар нутгийн доройтол, усны хомсдол, шар шороон шуурга ярьж байгаа хүн алга.

Энд байгаа мөнгийг дандаа хасдаг. Жишээ нь, 2024 онд Байгаль орчны яаман дээр 308.0 тэрбум төгрөг байсан бол тодотголоор 110 болгож бууруулсан. Одоо 213 байна.

Нэг хурал зөвлөгөөний ажилчдын зардал 1.5 тэрбум байхад усны газрын жилийн урсгал зардал 1.9 тэрбум байх жишээтэй.

Тэгэхээр яахаараа уснаас мөнгөө хасаад байдаг юм бэ? Ерөнхий сайд аа. Эсвэл манай энэ усны төслийг мартчихдаг юм уу? Бид усгүй бол хэзээ ч амьдарч чадахгүй шүү дээ. Уул уурхайгаасаа хэчнээн их мөнгө олоод тэр мөнгөөрөө арал худалдаж аваад улсаараа нүүх ёстой юу. Хэрвээ усны төслийг мартаад байдаг бол би та бүхэнд сануулга болгох гээд энэ цэнхэр дээлээ өмсөөд хүрээд ирлээ. Ядаж энэ дээлний өнгийг хараад усны төслөө тавьж баймаар байна.

2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. Дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хүртэлх хувийг байгаль орчны салбарт зарцуулж байх ёстой гэж. Гэтэл өнөөдөр 0.20 хувьтай л байна.

Тэгэхээр эрхэм Ерөнхий сайд та усны төсөл, усны мөнгийг хас гээд үүрэгдээд, сайд нараа загнаад байдаг уу? Эсвэл сайд нар нь огт ус уудаггүй хүмүүс байдаг юм уу?

Байгаль орчиндоо, уур амьсгалын өөрчлөлттэй, цөлжилттэй мөнгө ерөөсөө тавихгүй мөртлөө бид өнөөдөр хөгжил яриад, том том юм яриад байх шаардлагагүй л гэж бодож байна.

Тэгээд яагаад усны төслийг хасаад байдаг юм бэ? Энэ тал дээрээ тайлбар өгөөч. Яагаад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг мөнгө тавьдаггүй юм бэ? Зөвхөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын “COP17” /Conference of the Parties/ хуралд л зориулж мөнгө тавьсан. Бусад бүх төсвийг хассан. Хөв, цөөрмүүд хасагдсан. Хилийн усны хэлэлцээрийн төсөв хасагдсан. Усны хайгуул байхгүй. Усны хайгуул өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 17 хувьтай байдаг. Уул уурхайн хайгуул 87 хувьтай байдаг. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Ямар ч ядарсан үедээ, ямар ч хэцүү үедээ бид байгаль орчиндоо зориулсан мөнгөө, усны мөнгөө л хасмааргүй байх юм. Хэрвээ хасна. Ингэж байх ёстой гэвэл ус уухаа болих хэрэгтэй. Хариултаа аваад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Л.Мөнхбаясгалан гишүүн Засгийн газар бүрдэж байх үед гэсэн “Хөх морь” төслийн талаар тодруулж ярьж байсан.

“Хөх морь” төслийн хүрээнд 33 байршилд 52 метр куб ус хуримтлуулах боломжтой судалгаа хийгдэж, урьдчилсан байдлаар энэ төсөлд 1 тэрбум доллар төсөвт өртөгтэй байхаар урьдчилсан тооцоо гарсан.

Энэ төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох Хэрлэн-Тооно гадаргын ус хуримтлуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэс Оюу Толгой” компанийн 3 сая долларын санхүүжилтээр 2024 онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. 2026 оны 3 дугаар сард дуусах хуваарийн дагуу боловсруулж байна.

Техник, эдийн засгийн үндэслэл боловсрогдож бэлэн болж байж түүний төсөв, санхүүжилтийн асуудал ярьдаг.

2026 оны төсөлд Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Өмнөговь аймгийн Баяндалай сумдад хөв, цөөрөм байгуулахад 5.2 тэрбум төгрөгийн төсөлд тусгасан байгаа.

Тэгэхдээ энэ дээр онцлон зориулж тодруулж хэлэхэд Б.Батбаатар сайдад бас үүрэг өгөөд ирэх жилийн COP-ийг үндсэн гол төсөл “Бэлчээрийн шүхэр” гэж яригдаж байсныг “Говийн ус” төсөлд хөрөнгө мөнгө босгож чиглүүлж, үндсэндээ 150 тэрбум төгрөг ирэх жил төсөвт суусан байгаа.

Энэ ажлын гол төслөө говийн усны төсөл, говь ус, усны төсөлд, энэ цөлжилтийн эсрэг COP Нэгдсэн Үндэстний Байгууллагын форумууд зарцуулж. Бусад өмнөх улсуудын туршлагаар түүн дээр олон тэрбум доллар босгосон туршлага бий.

Тэгэхээр энэ төслүүддээ мөнгө зарцуулахаар техник, эдийн засгийн үндэслэлээ бэлэн болгож энэ хүрээнд боловсруулж хэрэгжүүлэх үүрэг өгөгдөөд COP-ын бэлтгэл ажил хангагдаж ажиллаж байна.

Тэгэхээр “COP17” буюу энэ цөлжилтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конференц, форум бол зүгээр баахан мөнгө зарцуулаад үр дүнгүй үлдэх биш энэ бүс нутгийн хэмжээнд болон дэлхийн дулааралд нөлөөлж байгаа цөлжилтийг даван туулахын тулд говийг усжуулах төсөлтэй нягт уялдуулах. Энэ хүрээндээ манай Засгийн газраас зүгээс танилцуулах төсөл бол энэ “Хөх морь” төсөл байхаар чиглэл өгөөд ийм бодлого чиглэлтэй ажиллаж байгаа. Энэ чиглэлээр харин манай сайд нар, манай гишүүд бас энэ чиглэлээр хамтарч, нэн ялангуяа говиос сонгогдсон гишүүд уулзсан. Одоо тодорхой асуудлууд чинь шийдэгдсэн. Тэр чиглэлээр хамтарч ажиллахыг хүсье.

■ Байгаль орчны төсөв буураагүй.

- 2024 онд 224.0 тэрбум,
- 2025 онд 260.0 тэрбум,
- 2026 онд 442.0 тэрбум төгрөг болж өссөн байгаа.

Харин 2026 онд Улсын Их Хурлаас батлагдсан урсгал зардлын хэмжээ 24 хувьд барих ёстой гэдгээр хязгаарлагдаж байгаа. Бүх төсөв хязгаарлагдаад байна. Өглөө ч гэсэн бид зөндөө ярьсан.

Хөрөнгө оруулалтын төслүүд нь заасан журам, зааврын дагуу техник, эдийн засгийн үндэслэл, шаардлага хангасан төслүүд нь төсөвт ордог. Тэр журмаараа явж байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье.

Одоо бид их олон жил ярьсан. Энэ говийн бүс нутгаа усжуулна гээд. Мөн өөр бусад аймгууд дээр ч хөв, цөөрмийн жижиг жижиг төслүүд даах хэмжээндээ явуулаад байгаа.

Дорвитой яг говийн бүсийг усжуулах энэ төсөл дээр яг үнэнийг хэлэхэд Л.Мөнхбаясгалан гишүүн ээ, бэлэн хөрөнгө мөнгө тавих хэмжээний шаардлага хангахаар зураг, төсөв, нарийвчилсан магадлан гарсан, яг хөрөнгө оруулалт хийхэд бэлэн болсон тийм төсөл одоо хүртэл байхгүй байгаа байхгүй юу.

Одоо энэ дээр Б.Батбаатар сайд бас үүнийгээ үнэнээр нь л хэлэх хэрэгтэй.

Тийм учраас хойтон “COP17” юуны тулд бид маш том олон улсын ийм арга хэмжээг зориглоод хийх гэж байгаа билээ. Тэнд бас их том боломж гарах ёстой. Үүнийг бид аялал жуулчлалын салбар, ногоон хөгжил, байгаль орчин, энэ усны төслүүд дээрээ маш том боломж гэж харах ёстой.

Тийм учраас бүгдээрээ “COP17”-д маш олон чиглэлээр бэлдэх хэрэгтэй. Түүний нэг хэсэг нь... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Тийм. Тийм учраас “COP17”-г онилоод, тэр болтол бэлтгэл ажлуудаа хангах хэрэгтэй. Төсөл, хөтөлбөрүүдээ бэлэн болгох хэрэгтэй. Зураг, төсвүүд дээрээ суух хэрэгтэй. Тэр болтол гадаад яв. Гаднын хүмүүсийг авчир. Үүнийгээ танилцуул. Ийм бэлтгэл ажлыг хангаж, энэ дээрээ харин бид хөрөнгө мөнгө зарцуулах ёстой гэж бодож байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар сайд хариулт өгье.

Б.Батбаатар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбар дээр 400 хэдэн тэрбум байгаа. Үүнээс COP-ийн багцад нь 229.0 тэрбум төгрөг байгаа.

Үлдсэн нь байгаль орчны, энэ салбарын яамны төсөв дээр байж байгаа.

Энэ дээр усанд нийтдээ 16.2 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс хөрөнгө оруулалт 3 төсөл, арга хэмжээнд 3.9 тэрбум төгрөг байж байгаа. 3.9 тэрбум. үүний 1.9 тэрбум нь Эгийн голын цахилгаан станц, Эгийн голын судалгааны ажилд зарцуулагдахаар байгаа.

Тэгэхээр ирэх жилийн СОР-ийн тухайд би бас Их Хурлын гишүүддээ нэгэнт төсөв хэлэлцэж байгаа учраас, одоо жишээ нь энэ долоо хоногт гадаад томилолт байсан. Явж чадаагүй. Төсөв хэлэлцэж байгаа сайдууд сууж байх нь... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: 2021 оны 58 дугаар зарлиг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн.

Дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг, хөрөнгө оруулалтыг байгаль орчны салбарт зарцуулж байх ёстой гэсэн энэ зарлиг яагаад хэрэгждэггүй юм бол оо?

Өнөөдрийг хүртэл сая хэлж байгаагаар Хэрлэн-Тооно, Орхон-Онги, Онги-Цагаанбургастан төсөл байхгүй юм байна шүү дээ. Одоо ТЭЗҮ нь. Мөнгө хуваарилагдаад авах бэлэн юм байхгүй гэж байна шүү дээ.

Тэгээд үүнийг хэзээ бэлэн болгох ёстой юм бэ? Хоёр асуулт.

Гурав дахь асуулт нь, 333 гэсэн хөв, цөөрмийн төсөл байсан. Одоо ерөөсөө 3, 4-хөн хөв, цөөрөм л орж байгаа байхгүй юу. Бороо ороод л байдаг. Тэр ус урсаад л алга болдог. Тэрийг л тогтоож хэрэглэх гэж тэр хөв, цөөрөм гэдэг төсөл чинь яваад байгаа шүү дээ. Энэ дээр яагаад илүү анхаарч болдоггүй юм бэ?

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Хэрлэн-Тооно, Онгийн ТЭЗҮ эцэслэн боловсрогдож дуусаагүй байгаа.

Хөв, цөөрмийн тухайд төсвөөс үнэхээр 3-хан хөв, цөөрөм дээр л тавигдаж байгаа.

Сая манай усны газрынхан Тайланд руу хуралд яваад Азийн хөгжлийн банкн дээр 58.0 сая долларын хүсэлт тавьсан. Тэгэхдээ зээл авах боломжгүй.

Буцалтгүй тусламжаар гээд эхний ээлжид энэ ажлыг эхлүүлье гэдэг анхан шатын тохироонд хүрсэн байгаа.

СОР болон энэ усны асуудлуудтай холбогдуулаад байгаль орчны салбарынхан нэг бол хөдөө, нэг бол гадаад явж байж олон зүйлийн ард шийдэх юм байна. Улсын нэгдсэн төсөв, нөхцөл байдал ийм байгаа нөхцөлд.

Тийм болохоор энэ зүйл дээрээ одоо өнөөдөр бас Их Хурлын гишүүд жаахан харж үзээрэй гэж л хүсэлт тавимаар байна даа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ жилийн төсөвт Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар “Хүний хөгжил” манай Засгийн газрын хамгийн том мега төсөл байх болно гэж хэлсэн.

Төрийн албан хаагчдыг цомхотгоно гэдгээ мөн хэлсэн.

- Дундговь аймагт 48 хүн,
- Өмнөговь аймагт 52 хүн,
- Говьсүмбэр аймагт 21 хүн,
- Дорноговь аймагт 110

төрийн албан хаагчдыг цомхотгохоор болсон байна.

Хөдөө, орон нутагт төрийн албан хаагчдыг яаж ажиллуулах вэ гэж байхад ингээд цомхотголд оруулаад байвал энэ байгаа оносон зөв шийдвэр болж чадах уу? Ерөнхий сайд аа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд өгөх үү? Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Улсын Их Хурлаас төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгохоор, тоог нь бууруулахаар тухайн үеийн Эдийн засаг, хөгжлийн яамны санаачилгаар төлөвлөгөө, бодлого батлагдсан.

Бидний баримталж байгаа ч шаардлага бол чиг үүргийн давхардал. Иргэдэд, бизнес эрхлэгчдэд хүндрэл, чирэгдэл учруулж байдаг чиг үүргийн давхардалтай, нэн ялангуяа дарга нарын тоо төсвийг илүү бууруулах чиглэл баримталсан. Яам яаманд нь энэ эрх, үүргийг нь өгсөн. Яам бол төсөв дотроо зохицуулалт хийгээд аль болох ард иргэддээ хүрч үйлчилдэг ажилтнуудад биш илүүдэл, давхардлыг цомхотгох шаардлага тавьж байгаа.

Энэ чиглэлээр манай ажлын хэсгийг С.Бямбацогт сайд ахалж ажиллаж байгаа. Төрийн албаны шинэчлэлийн ажлын хэсгийг. Төрийн албаны аттестатчилал. Төрийн албанд бусдын зовлонг өөрийн биед эргэцүүлж, ард иргэддээ үйлчилж чаддаг тийм шаардлага тавигдаж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Ер нь ард иргэддээ хүрч үйлчилдэг ажил хэрэгч, шударга төрийн албыг цогцлоож бий болгох тийм зорилготой төрийн албаны 4 цогц хууль орж ирнэ. Одоо бас. Багц хууль. Төрийн албаны ёс зүйн хуулиа ч шинэчилнэ.

Энэ чиглэлээр манай ажлын хэсгийг С.Бямбацогт сайд ахалж ажиллаж байгаа. Дэлгэрүүлж хариулна.

Орон тоо цомхотгож байгаа асуудал ч гэсэн давхардсан чиг үүргүүдийг цомхотгож байгаа. Яамдын хэмжээнд гэхэд, одоо Эдийн засаг, хөгжлийн яам 28 газар хэлтсийн даргатай байсан бол 11 болж цөөрүүлсэн. 168 орон тоог цомхотгосон гээд илүү төв аппарат дээр дийлэнх ачааллыг авч байгаа. Төв дээр.

Харин аймаг ч гэсэн хяналтын хоёр, гурван чиг үүрэг давхардуулсан тийм Тамгын газар, бүтцүүд байгаа. Эднийг бас цэгцлэх шаардлагатай байгаа.

С.Бямбацогт сайд гүйцээгээд хариулчих.

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Сая ер нь Ерөнхий сайд хариуллаа.

Улсын Их Хурал 2026 оны жилийн төлөвлөгөө батлахдаа төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар цөөрүүл гэсэн улсын төлөвлөгөө баталсан. Бид ч гэсэн 2025 оны төсвийн тодотголыг 7 дугаар сард хийхдээ энэ төлөвлөгөөгөө Улсын Их Хурлаас баталсан төсвийн тодотголын дагуу төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар цөөрүүлэх хуулийг баталсан. Энэ хуулийг хэрэгжүүлж байгаа.

Хэрэгжүүлэхдээ аль болох дээрээсээ, дарга нараасаа эхэлье гэдэг үүднээс яамдын газар, хэлтсийн дарга нарын тоог 30 орчим хувиар цөөрүүлсэн. Агентлагуудын газар хэлтсийн дарга нарын тоог бас нэлээд өндөр хувиар цөөрүүлсэн.

Төрийн албан хаагчдыг цөөлөхдөө ажлаас халагдсан, тэтгэвэртээ гарсан, жирэмсний амралтаа авсан, өөр ажилд шилжсэн энэ хүмүүсийн оронд аль болох нөхөж хүн авахгүй байдлаар зохицуул. Шууд цомхотголд эхний ээлжинд оруулахгүй байх... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа.

Тэгээд төсвийн хүрээ хэлэлцээд явж байхад манай санал хэлсэн гишүүдийн ихэнх алдагдалтай төсөв оруулж ирсэн гэж нэлээн шүүмжлэнгүй хандаж байгаа.

Зүгээр миний хувьд тэгж харахгүй байна. Гадаад ертөнцийн мэдээллийг хараад байхад Засгийн газар чинь улс орноо хөгжүүлэх бодлого, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ямар төсөв оруулж ирэх вэ гэдгээ сонгож шийддэг эрхтэй байх ёстой.

Тэр ч утгаараа 1.3 их наядын алдагдалтай төсвийг сонгож оруулж ирж байгаа нь хөгжлийн бодлоготойгоо холбоотой болов уу гэж бодож.

Өчигдөр нэлээн үндэслэлтэй тайлбарууд Засгийн газраас хийж байсан юм.

2026 оныхоо төсвийг төсвийн хүрээтэйгээ холиод хэлэлцээд явчихаар нэг л тийм таагүй мэдрэмж төрж байгаагаа хэлье.

Үүнтэй холбогдуулаад төсвөөс 3 асуулт л асууя даа.

Нэгдүгээр асуудал бол энэ Төсвийн хуулийг тодорхой агентлагууд дээр очоод зүгээр зөрчихдөг. Төслүүд батлагдсан хуулийн заалтыг өөрчилдөг ийм явдал гараад байх юм.

Одоо жишээлбэл энэ жилийн төсөв дээр одоо асуулт.

➤ Энэ жилийн төсөв дээр зураг, төсөв нь магадлан хийгдээгүй хэчнээн объект орж ирсэн бэ?

➤ Энэ дээр нийтдээ хэчнээн төгрөгийн төсөв тавигдсан бэ?

➤ 2026 онд хэдийг нь санхүүжүүлэх юм бэ?

Гурван тоо надад хэлж өгөөч ээ. Яагаад би үүнийг асуугаад байна вэ гэхээр энэ чинь ерөөсөө “магадлан хийж байна” гэж хэлээд л баталсан төсвийг хоёр, гурав дахин нэмдэг. Зарим объект дээр, миний нэг сайн мэдэх объект дээр 7 дахин нэмэгдээд л объект нь ашиглалтад ороогүй яваад байгаа юм. Тэгэхээр энэ гурван тоог.

Хоёрдугаарт, олон барилга бариад байх юм. Энэ дотор бид барьсан барилгуудын ашиглалтыг нэлээн сайн үзмээр байгаа юм. Төсөв дээр чинь “соёлын төв” гээд сумдад 24 объект орж иржээ. Энэ яаж ашиглагддаг юм бол? Улирлын чанартай юмнууд л байгаад байдаг.

Тэгэхээр энэ ашиглалтыг яаж сайжруулах, ямар бодлого Засгийн газар төлөвлөж байна вэ гэсэн нэг асуудал байна.

Энэ асуудал дотор бид шинэ объектыг барихдаа судалгаа хиймээр байгаа юм. “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв барина” гээд 10-аад мэдээллийн төвийг сумдад барих нь. Энэ чинь зарим улс, Засгийн газрынхаа гишүүнийг цахим сайд томилоод ажиллуулж байхад сумын төв дээр үндсэндээ 900 метр квадрат талбайтай 2 байшин бариад байх юм уу? Энэ 330 сумандаа бас нэг ийм юм барих гээд байгаа юм биш биз дээ. Энэ ямар судалгаан дээр үндэслээд үүнийг оруулж ирж байгаа юм болоо гэсэн нэг ийм асуулт байгаа юм.

Гурав дахь нь, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой юм.

Тэгэхээр тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг бид чинь индексжүүлээд... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Д.Рэгдэл: Индексжүүлээд, одоо дахиж индексжүүлэхгүй гээд орхисон нэг асуудал байгаа.

Гэтэл Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар 2013 оны 9 дүгээр сарын 01-нээс өмнө тогтоолгосон улсын тэтгэвэр тогтоолгох цалингийн дээд хэмжээг 1 сая 400 мянгаар тооцоод тогтоочоод, энэ 2013 оныхоо 9 дүгээр сарын 01-нээс хойш тогтоолгосон улсуудынхаа тэр тэтгэвэр тогтоох доод хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдсэн буюу 4.2 саяас тогтоосон байгаа.

Ингээд тэтгэврийн 3 дахин том зөрүү гараад. Энэ дээр зарим улсуудын судалгаагаар 150-иад мянган ахмадын эрх ашиг зөрчигдлөө. Тэтгэврийн зөрүү нь 3 дахин боллоо.

Дээр нь нэмээд л дахиж тэтгэврийн шинэчлэл хийхгүй шүү. Зөвхөн ханшийн уналтаар тооцоод явна гэсэн чинь бүр хүчтэй цохилт болсон. Үүнийг засах талаар Т.Аубакир сайд... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Иргэдэд үйлчлэх төвийн барилга гээд. Үүнийг манай иргэд янз янзаар ойлгодог юм шиг байгаа юм. Нутгийн удирдлагын ордон. Хуучнаар сумын Засаг даргын Тамгын газрын барилга.

Монгол Улс 330 сумтай. 330 суманд төрийн үйлчилгээг ард иргэддээ сумын Тамгын газрын барилга буюу Иргэдэд үйлчлэх төвийн барилгаар дамжуулж үйлчилгээг хүргэдэг.

Энэ барилгууд нь хуучирч муудсан гээд шинэчлэх ажил хийгдэж явж байсан. Одоо энэ төсөв дээр суусан 8 объект бол хуучны сумын Засаг даргын Тамгын газрын барилга байгаа. Гэхдээ 2021-2024 онд төсөвт суусан. 2025 онд, 2026 онд нэг ч конторын барилга төсөвт суулгаагүй.

Конторын барилгыг тэвчиж болох зардал, заавал барих шаардлагагүй гэж иргэд үздэг. Энэ хүрээндээ үндсэндээ 2026 оны төсөв дээр нэг ч шинэ барилга суугаагүй байгаа.

Ер нь цаашдаа таны хэлж байгаа тэр мянга орчим метр квадрат талбайтай, дотор нь сумын Тамгын газрын 20 орчим хүн ажилладаг барилга, байшин хэрэгтэй юу, хэрэггүй юу? Үүнийг илүү оновчтой цэгцтэй, зардал багатай, дээрээс нь хүртээмжтэй, бүтээмжтэй болгох талд анхаарах ёстой юм билээ.

Тэр мянга орчим метр квадрат талбайг ажиллаж байгаа 20 хүнд нь хуваагаад үзэхээр нэг хүнд 50 орчим метр квадрат. Яг ашигтай талбайгаар нь хуваагаад үзэхээр нэг ажилтанд 20 гаруй метр квадрат талбай ноогдож байгаа.

Тэгвэл Төрийн ордонд үйл ажиллагаа явуулж байгаа Их Хурлын гишүүдийн туслах, зөвлөх, Тамгын газрын ажилтнуудын нэг хүнд ногдож байгаа талбайг үзэх юм бол 5 метр квадрат хүрэхгүй шахуу.

Ингээд үзэхээр бид цаашдаа барилга, байшин барихдаа ямархуу зураг, төсөвтэй, ямархуу бүтэц, зохион байгуулалттай байх вэ гэдэг тал дээр анхаарахгүй бол зураг, төсөв зохиодог байгууллагууд нь төсвөөс зураг төсвийн үнэ авахын тулд маш үр ашиггүй, маш том талбайтай, ашиггүй талбай ихтэй, маш өндөр зардлаар баригдах барилгууд барьдаг.

Өөрөөр хэлэх юм бол Төрийн ордонд амьдарч, ажиллаж байгаагаар бодох юм бол нэг хүнд 5 метр квадратаар бодвол, 20-иор бодох юм бол 100 метр квадрат талбайтай барилга. Нийт талбайгаар бол 200 метр квадрат талбайтай барилгад ажил хийж болох бололцоотой байхад мянган метр квадрат талбайтай болгодог. 2 давхар байшингийн багана, дам нурууг хийхдээ 20 давхар байшингийн тийм зузаан багана дам нуруутай, арматуртай хийдэг. Ингээд төсвийн зардал нэмэгддэг ийм нэг асуудал байна.

Дээрээс нь, тэр барилга, байшинг дагуулаад урсгал зардлууд, халаалт дулаан, цахилгаан, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул манаач гээд маш их зардлууд нэмэгддэг. Иймэрхүү юм үндсэндээ улсын төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлж байгаа гол шалтгаан болж байгаа юм билээ.

Тэгэхээр цаашдаа бид энэ конторын барилга барихдаа тодорхой нэг шалгуур шаардлага тавьдаг байхгүй бол аль болох том контор барих гээд, аль болох бие даасан контортой болох гээд уралддаг болсон.

Аймгууд ч гэсэн ялгаа байхгүй. Нэг аймгийн 4 давхар Тамгын газрын барилгад бүгд багтдаг байсан бол одоо сүүлийн 10, 20 жилийн дотор үндсэндээ нэг байшинд багтдаг байсан барилгууд 20-иод барилгатай болсон. Тэр 20-иод барилгыг дагаад 20-иод харуул, манаач, цэвэрлэгээ үйлчилгээ, тог цахилгаан. Тэрийг дагасан урсгал зардал гээд ийм л болсон юм билээ.

Тийм болохоор энэ дээр нэлээн томоохон бодлогын өөрчлөлт хийж байж энэ асуудлыг шийдэх байх. Энэ асуудлыг шийдэх ёстой гэж харж байгаа.

Тийм учраас энэ жил Иргэдэд үйлчлэх төвийн барилга буюу конторын барилга нэг ч тавигдаагүй байгаа. 2026 онд.

Д.Амарбаясгалан: Ч.Ундрэм сайд нэмж хариулт өгье.

Ч.Ундрэм: Соёлын төвөө бид цаашид COMMUNITY CENTER буюу олон улсын жишигт нь нийцүүлж “Хүний хөгжлийн төв” болгож хөгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Ер нь манай Соёлын төв бол анхных нь 1921 онд сумдад байгуулагдаж эхэлсэн байдаг. Түүхэн үүргээ гүйцэтгээд, өнөөдөр угаасаа олон нийтийн маш олон арга хэмжээг зохион байгуулаад ажиллаж байгаа.

Энэ жилийн төсөвт бид шинэ соёлын төвийн төсөл огт оруулж ирээгүй. Баригдаад эхэлсэн байгаа барилга, байшингуудаа аль болохоор дуусгах чиглэлд Улсын Их Хуралд төсвийн саналдаа оруулж ирсэн байгаа.

Гэхдээ сая олон нийт, иргэдээс авсан санал асуулгад 240 мянган хүн оролцсоноос 140 мянган хүн нь хотын иргэд байсан. Хотын иргэдэд соёл, урлагийн хэрэгцээгээ Соёлын төв ордон... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ч.Ундрэм: Драм, дуурь гээд олон байгууллагуудаас авдаг бол суманд бүх хэрэгцээгээ соёлын төвөөсөө авдаг.

Тэгээд энэ COMMUNITY CENTER-ийн хувьд бид соёл, урлагийн хэрэгцээг нь хангахаас гадна сургалт, хөгжлийн хэрэгцээ, NETWORK-ийн хэрэгцээ гээд

олон талын сайжруулж, шинэчлэлийг менежментийн хувьд, арга хэмжээ хэмжээний хувьд хийе гэж бодож байгаа.

Үүнээс гадна соёлын төвүүд нэлээн хуучирсан. Ер нь 70 хувь нь цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй учраас бид ахуйн соёлын хувьд ч гэсэн ариун цэврийн байгууламжтай болгох, дотоод зохион байгуулалтыг нь шинэчлэх, тавилга болон ном, тоног төхөөрөмжүүдээр хангах гээд олон шинэчлэлийн ажлуудыг төлөвлөөд явж байгаа.

Тэгэхээр энэ чиглэлд гишүүдийгээ дэмжиж, хамтарч ажиллана гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Э.Бат-Амгалан сайд хариулт өгье.

Э.Бат-Амгалан: Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Ер нь барилгын салбартай холбоотой магадлалын зөрүүг л асуугаад байх шиг байна л даа.

2025 оны 9 сарын 15-ны байдлаар сүүлийн 2 жилээр бид яаман дээр судалгаа гаргаж үзсэн. 122 төсөл, арга хэмжээний нийтдээ 99.5 тэрбум төгрөгийн зөрүү магадлалын дүнгээр баталгаажиж ажиллаж байгаа юм.

Энэ ингээд жил болгон яагаад ингээд магадлал хийлгээд, ахиулаад, асуудал үүсгээд, энэ хардалт сэртэлт хаана хаанаа яваад байдаг юм бэ гэхээр нэлээд хэд хэдэн асуудлууд дээр төсөв зохиохдоо бид ажиллах ёстой юм билээ.

Тэр нь юу вэ гэвэл хамгийн нэгдүгээрт жишээ нь барилгын ажилтны цалингийн тарифын жишгийг бас өөрчлөх асуудал дээр төсөв зохиохдоо хийхгүй бол зах зээлийнхээ одоо яг өнөөдрийн үнэлгээтэй уялдуулж энэ төсвөө гаргахдаа жишгийг нь нэмж өгч явахгүй бол асуудлууд гараад яваад байдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Тилеуханы Аубакир сайд хариулт өгье.

Т.Аубакир: Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газраас 1997 оноос хойш тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 9 удаа шинэчлэн тогтоох арга хэмжээг авсан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай 238 дугаар тогтоолоор 9 жилийн дараа итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, 2011 оны 4 сарын 05-ны өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 1 сая 80 мянган төгрөг байсныг 1 сая 404 мянган төгрөг болгож, бүх тэтгэвэр хаагчдын тэтгэврийг дахин бодсоны үр дүнд нийт 160

мянган тэтгэвэр хаагчдын тэтгэврийн хэмжээ дунджаар 181.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байдаг. 181.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байдаг.

Даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох сарын цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2019 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 2 сая 400 мянган төгрөг болгоход шаардлагатай 333 аравны... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 2019 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 2 сая 400 мянган төгрөг болгоход шаардлагатай 333.8 тэрбум төгрөгийг 2026 оны нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсвийн төслийн саналд тусган хүргүүлсэн боловч 2026 оны төсөвт бас суух боломжгүйгээр үлдсэн байж байгаа гэж хариулъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Д.Рэгдэл гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Үндэсний аудитын газраас 2026 оны төсвийн төсөлд хийсэн аудитаар тэнд яг 4 төсөл дээр огт магадлал байхгүй байна шүү гэж ийм зөвлөмж өгсөн байгаа.

Тэр 4 нь ийм юм байгаа юм.

Манай Б.Батбаатар сайд байна уу? “COP17” дээр бэлтгэл ажил хангах гээд 150.0 тэрбум төгрөгийн объектууд бэлдэх байгаа юм.

Энэ объектууд шавар зуураад л нөгөө барилга, байшин бол ерөөсөө биш байгаа юм. Энэ дандаа угсрах тийм мобайл зөөврийн томоохон байгууламжууд байгаа юм.

Тэгэхдээ үүнийг хамгийн гол нь цаашаагаа бид дахиад ашиглах ёстой. Цаашаагаа яг зориулалтынх нь дагуу ашиглахын тулд одоогоос дараа нь хүлээж авах сайд нар, байгууллагуудтай нь холбож өгч байгаа. Онцгой байдалтай. Хархорин руу. Мөн бусад олон чиглэлээр ашиглаж болохоор зүйлүүд байгаа.

Түүнд нь хэрэглэх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, унаа автобус гээд бүгдийг нь... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас шууд магадлан шаардахгүй гэж байгаа.

Хоёрдугаарт, хавдрын эмнэлэг байгаа. Хавдрын эмнэлэг дээр манай зураг, төсвийн компаниуд үнэхээр туршлага, дадлага дутаж байна. Эмнэлгийн байгууллага ч гэсэн.

Тэгээд яг магадлан хийх явцад процесст дээр нь стандартын асуудал гарч ирж байна. Ингээд ер нь нэг эхлүүлж болохоор 5 объектынх нь 2 объектыг нь ирэх жил эхлүүлье гэж байгаа. Тэр нь магадлал нь хагаслаад бэлэн болсон байгаа.

Дөрөвдүгээрт, байгаль хамгаалагч нарын харуулын байр гээд 388.0 саяын 8 газар. Энэ нь 35-аас 50 сая төгрөгийн зөөврийн байгууламж байгаа. Түүн дээр магадлан шаардлагагүй гэж үзэж байгаа.

Эцэст нь 2 дугаар эмнэлгийн их засварын асуудал байгаа. 4.3 тэрбум төгрөгийн. Энэ бол 2024 онд магадлал нь хийгдсэн. Ингээд 2025, 2026 онуудад үргэлжилж байгаа их засвар байгаа шүү. Энэ мөн бас “COP17”-гийн урьдчилсан бэлтгэл ажилтай холбоотой эрүүл мэндийн салбарын ажил байгаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би хэд хэдэн юмнуудыг асуух гэсэн юм.

Төсвийн ном дээр 123 дугаар хуудсан дээр нийтдээ төрийн өмчит компаниудыг ер нь орлогыг төвлөрүүлээд нийтдээ 548.3 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна. Үүнээс 372.9 тэрбум төгрөгийг хуримтлалын санд, 95.4-ийг орон нутгийнх, 80.0 тэрбумыг. 123 дугаар хуудсан дээр 372.9 тэрбумыг төвлөрүүлнэ гэж байгаа юм байна.

Гэтэл 2024 оны аудитын дүгнэлт дээр нийтдээ 100.0 тэрбумыг төвлөрүүлэх байснаас дөнгөж 40.0 тэрбумыг төвлөрүүлж чадсан.

Энэ чинь бүр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс 548.3 тэрбум төгрөгийг нийтдээ төвлөрүүлнэ гэж бичсэн байна.

Тэгэхээр яаж ингэж 12 дахин нэмэгдүүлэх гэж байгаа юм бол оо? Ямар бодлогоор. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бас ингэсэн байна. Энэ чинь одоо гүйцэтгэл нь дөнгөж 40 хувьтай, 60 хувиар муу байхад 13.7 дахин нэмэгдүүлсэн байна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд санал болгож, бүтцийн өөрчлөлт хийснээр 120.0 тэрбумын эх үүсвэрийг төсөвт төвлөрүүлнэ гэсэн байна. 71 дүгээр хуудас дээр.

Тэгвэл энэ яг хавсралт 3 дээр Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлтийн алдагдал санхүүжүүлэх эх үүсвэр дээр хамгийн сүүлд нь өмч хувьчлалын орлого гэж 2026 онд бичигдэх ёстой. Тэр нь тэг байна.

Тэгэхээр энэ тооцооллууд чинь та нар энэ юун дээрээ алдаатай гаргасан юм биш үү? Ядаж байхад энэ одоо бараг 7 шрифтээр бичсэн. Хүн харахад ч их хэцүү юм.

Дээрээс нь, Засгийн газрын өрийн эрсдэлийг Та бүхэн мэдэж байгаа. 96.3 хувийг гадаад өр. Нийт гадаад өрийн 25 хувь нь “хөвөгч хүүтэй зээл” байна. Одоо төсвийн хүрээнд ярихад хамгийн их ярьсан зүйл нь ер нь дэлхий даяар санхүү, эдийн засаг хүнд байна гэж байгаа цаг үед хөвөгч хүүтэй зээллэг дээрээ Та бүхэн анхаарч байгаа юу? 2026 онд гэхэд жишээлбэл нийслэл 159.7 тэрбум төгрөг. Хүүгийн төлбөрт 246.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байгаа.

Дээрээс нь, орон тооны тэлэлтийг хязгаарлаж байгаа гэж байгаа мөртлөө төрийн захиргааны албан хаагчдыг ирэх жил 500-гаар, ажлын албаны албан хаагчдыг 300-гаар нэмэгдүүлэхээр байгаа.

Энэ би дандаа төсвийн номоос хэлж байгаа шүү. Ингэж байгаа юм. 2026 онд орон тооны тэлэлтийг хязгаарлаж, 2025 оны түвшинд хадгална гэж төсвийн номын 125 дээр байгаа.

Тэгсэн мөртлөө ялангуяа төрийн захиргаа, ажлын албаны албан хаагчид ийм олноор нэмэгдэх хэрэгцээ шаардлага байгаа юм уу? Тэгсэн доор багш нэмэгдлээ, эмч нэмэгдлээ гэвэл бид бүгдээрээ ойлгоно. Түүнийг ойлгож хүлээж авна.

Дээрээс нь, аж ахуйн нэгжүүдээс Сангийн Яамны 2026 онд өмнөх аж ахуйн нэгжүүдээс олгосон зээллэгүүдээ 440, 13.1 тэрбум төгрөгийг төвлөрүүл... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Төрийн өмчийн компаниудтай холбоотой гүйцэтгэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хариулна.

Тэр зээлтэй холбоотой тоонуудыг задлаад 4 дүгээр микрофон дээрээс манай Санхүүгийн газрын дарга С.Тулга хариулчих. Тоонуудыг нь тайлбарлаадхаарай.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрийг өгье.

С.Тулга: С.Тулга Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя.

Гадаад зээлийн үлдэгдэл энэ оны хагас жилийн байдлаар GDP-гийн 39.5 хувь буюу 35.5 их наяд байгаа.

Тэгээд гадаад зээлийн хувьд таны хэлсэн үнэн. Манайх 25 хувь нь “хөвөгч хүүтэй зээл” байгаа. Бид 2011 онд бага орлоготой орноос дунд орлоготой орнууд шилжсэн. 2024 онд дунджаас дээгүүр орлоготой оронд шилжсэн.

Тэгэхээр Монгол Улсын хувьд өмнө нь авч байсан нэн хөнгөлөлттэй зээлийг авах боломж маань дуусгавар болсон байгаа. Одоо шинээр авч байгаа зээлүүд дандаа “хөвөгч хүүтэй зээл” байгаа.

Тэгэхдээ “хөвөгч хүүтэй зээл” маань бас одоо энэ зах зээлээс босгож байгаа хувийн хэвшлийн зээлээс хамаагүй хөнгөлөлттэй байгаа. Тухайлбал, Азийн хөгжлийн банкнаас бид SOFR² /Secured Overnight Financing Rate/ дээр нэмэх нь 0.5 хувь. Одоогоор хүү нь 5 хувьтай байгаа. Хугацаа нь 25 жилийн хугацаатай. Эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ерөнхийдөө хөнгөлөлттэй хүүтэй байгаа.

Хөвөгч хүү гэдэг гэдэг ерөнхийдөө ийм нөхцөлтэй зээл байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индэрийг өгье.

Б.Цэнгэл: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Ер нь төрийн өмчит компаниудын өр төлбөрийн асуудал нэлээн өндөр дүнтэй байгаа. 22.8 их наядын өр төлбөр байж байгаа.

Ногдол ашгийн тухайд Та асууж байна. Ногдол ашгийг бид 2024 онд нийт 594 тэрбум төлөвлөсөн. 2025 оны хувьд 608. Үүнээс Ирээдүйн өв санд 507. Ногдол ашиг хэлбэрээр 101 тэрбум гэж явж байгаа.

Гүйцэтгэлийн байдал бас тийм хангалттай бус байгаа нь үнэн. Өнөөдрийн байдлаар улсын төсөвт 101-ээс 51.3 гэдэг нь 50.4 хувьтай. Баялгийн сангийн хэрэгжилт... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Цэнгэл: 507-гоос 111.7 гэхэд 22.0 хувьтай явж байна.

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайд нэмж хариулт өгье.

² Баталгаажсан нэг шөнийн санхүүжилтийн хүү гэсэн утгатай. SOFR нь LIBOR-ийг (London Interbank Offered Rate) орлуулах шинэ суурь хүү. Хүүг АНУ-ын New York Federal Reserve (Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк) өдөр бүр шинэчилдэг.

С.Бямбацогт: Төрийн өмчит компаниуд уг нь орлоготой, ашигтай ажилладаг. Олсон ашиг, орлогоосоо төсөвт тодорхой хувиар төвлөрүүлэх. Мөн иргэдийн хуримтлалын сан төвлөрүүлэх ёстой.

Тэгээд энэ талдаа жоохон учир дутагдалтай ажиллаад байгаа. Их наяд, их наяд төгрөг ашигтай ажиллаж байна гэж ярьдаг. Гэтэл нөгөө хуримтлалын сан руу орж байгаа нь маш бага. Төсөв рүү төвлөрүүлж байгаа нь бага байгаа юм.

Тийм болохоор ирэх жилээс энд бодлогын томоохон өөрчлөлт хийе. Төрийн өмчит компаниудын 34 хувийн, ялангуяа стратегийн ордуудын 34 хувийг төр эзэмшиж байгаа. Үүнтэй холбоотой ногдол ашгийг бид хуримтлалын сан төвлөрүүлэх ёстой. Энэ нь хангалттай биш. Ялангуяа “Эрдэнэс Тавантолгой” компани.

Тэгэхээр энэ дээр томоохон бодлогын өөрчлөлт хийж, иргэддээ Баялгийн сангаасаа байгалийн баялгийн өгөөжөөс хүртэх бололцоог нэмэгдүүлье. Нөгөө талдаа төсөв, эдийн засаг хүнд үед төрийн өмчит компаниуд тэвчиж болох зардлуудаа тэвчих. Шаардлагатай бус хөрөнгө оруулалтуудаа хойшлуулах байдлаар... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Тийм. Төрийн өмчит компаниудын үр ашгийг сайжруулах цогц шинэчлэлийн төсөл хэрэгжиж байгаа.

Тэгэхдээ энэ үр ашгийг нэмэгдүүлэх ажил зүгээр цээжнээс аваад тавьчихсан тоо биш. Жишээлбэл, “Эрдэнэс Монгол” компани дээр бид очиж ажиллаад бүх захирлуудын илтгэл, тайланг сонсоод жилийн төлөвлөгөөг нь батлаад, энэ түвшинд хүрвэл цалин, урамшууллын тогтолцоог нь, хариуцлагыг нь тодорхой болгож, хариуцлагын гэрээтэй нийлүүлээд. Ингээд нийт энэ 548.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллуулах зарчмын шийдлүүдийг гаргаад. Ингээд энэ төрийн өмчит компаниудын үр ашгийг сайжруулах, бүтцийг нь өөрчлөх, зарчмын хувьд бүгд ашигтай ажиллах ийм цогц шинэчлэл, өөрчлөлтийн үр дүнд зах зээлд нээлттэй хувьцаат компани болох гэсэн цогц өөрчлөлт, шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж, бүгдээр нь гарын үсэг зуруулж авсан ийм төлөвлөгөө байгаа.

Энэ түвшиндээ хүрвэл цалин урамшуулал нь шийдэгдэнэ. Өндөр цалингуудыг нь хүртэл хязгаарласан байгаа.

Д.Амарбаясгалан: Б.Цэнгэл дарга. 3 дугаар индэр.

Б.Цэнгэл: Тэр 120 тэрбумын тухайд. Бид ер нь 2026 онд 200.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ гэсэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс. 80 тэрбумыг нь ногдол ашиг хэлбэрээр. 120 тэрбумыг нь үндсэн

чиглэлийг бид одоо Их Хуралд Засгийн газар өргөн барих гэж байгаа нь энэ дээр 9 аж ахуйн нэгж явж байгаа. Үүний нэг аж ахуйн нэгжээс нь буюу Төрийн банкны тодорхой хувийг бид IPO гаргаж олон нийтэд биржээр нээлттэй явуулна. Эндээс 120 тэрбумыг төвлөрүүлэхээр тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан: Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Дарга аа, юуг нь асуулгачихъя. Тэгэх үү? Нөгөө тоо нэмэгдсэн талаар.

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Төрийн албан хаагчдын тоо өнөөдөр 226 мянган төрийн албан хаагч байгаа.

Хамгийн олон нь буюу төрийн үйлчилгээний албан хаагч нар. Энд багш, эмч нар, сувилагч, бусад хүмүүс ордог. Энэ нь нийтдээ 67.0 хувь буюу 152 мянга.

Дараагийнх нь, 21.6 хувь буюу 49 мянга, 50 мянга орчим нь төрийн тусгай албан хаагч нар.

Дараагийн жин эдэлж байгаа нь 9.4 хувь буюу 20 мянга орчим нь төрийн захиргааны албан хаагч байгаа.

Үлдсэн 1.7 хувь буюу 3800 орчим албан хаагч нь төрийн улс төрийн албан тушаалтан. Яг ийм харьцаатай байгаа.

Өсөлтийг аваад үзэх юм бол хамгийн өндөр өссөн нь сүүлийн 10 жилийн хугацаанд төрийн тусгай албаныхан 27 хувиар нэмэгдсэн. 2015 онд 35 мянган албан хаагчтай байсан бол одоо үндсэндээ 50 мянга хүрч байгаа. 27 хувиар нэмэгдсэн.

Дараагийн хамгийн өндөр өсөлттэй нь төрийн үйлчилгээний албан хаагч нар. Энэ бол нөгөө хүн амын өсөлттэй холбоотойгоор эмч, багш нарын тоо нэмэгдэж байгаа. Үүнтэй холбоотой... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: 2026 онд төрийн захиргааны албан хаагч дээр 500.

Бид чинь төрийн захиргааны албан хаагчдаа бууруулъя. Цахимжилт явагдахаар би уг нь төрийн захиргааны албан хаагчдын тоо буурна гэж ойлгоод байгаа шүү дээ.

Төрийн захиргааны албан хаагчид 500-гаар. Ажлын албаны албан хаагчид. Одоо нөгөө Үндэсний хороо чинь уг нь татан буугдахаар энэ уг нь бас буурмаар юм. Гэтэл 300-гаар.

Шүүгч, прокурор. Энэ бүр 100-гаар нэмэгдсэн байна.

Тэгэхээр энэ юунаас болов оо? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 120.0 тэрбумаар төрийн өмчит компаниудынхаа хувьчлалыг хийх гэж байгаа юм бол яагаад Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт дээр орлого талд нь Та бүхэн бичээгүй юм бэ? Хоёрхон жилийн дотор 13.7 дахин төрийн өмчит компаниудынхаа ногдол ашгийг нэмж чадах юм уу? 13.7 дахин шүү дээ. Хувиар яриагүй.

Тэгэхээр энэ бол их л өндөртэй харагдаж байна даа.

Дээрээс нь, экспортын биет хэмжээ. Түрүүн нэлээдгүй ярилаа. Нүүрс. Б.Дэлгэрсайхан сайд аа, би ингэж ойлгосон. /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Ингэсэн байдаг юм. Сая 8 сард 8.5 сая тонн нүүрс хилээр гарсан. Манай нэвтрэн өнгөрүүлэх чадвар ийм хэмжээнд хүрчээ. Өмнө нь нэг удаа 8.9 сая гарч байсан юм. 8.5 саяыг та 12 сараар үржүүлээд үзээрэй. Энэ чинь бараг 100 сая гараад явчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр төмөр замаар гараагүй, зөвхөн зам тээврээр гарч байгаа тохиолдолд ийм хүчин чадалтай байгаа юм. Төмөр замаар гараад эхэлбэл бүр баллахаар байгаа.

Тийм учраас бидэнд нэвтрэн өнгөрүүлэх чадвар нь байна. Нүүрс нь байна. Ер нь урд эрэлт нь ч байж байна. Эд нарыгаа нэг холбох юм тэгээд энэ хэмжээний нүүрс гарахаар байгаа. Бүр үүнээс ч илүү гарахаар. Биет хэмжээгээр болбол.

Үнэд найдаад хэрэггүй. Биет хэмжээн дээрээ л хэдүүлээ зөөх ёстой тоогоо л зөөе. Ажлаа хийе.

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Зам холболт бол сая 6 сарын 15-нд ажил эхэлсэн. Нэлээн шуурхай явж байгаа. 2027 оны 3-аас 4 сар гэхэд ашиглалтад орно. Энэ бол ямар ч асуудал байхгүй. Ямар нэгэн саатал байхгүй.

Энэ ашиглалтад орсноороо сая Сангийн сайдын хэлдгээр авто тээвэр дээр нэмэх нь 40-өөс 50 сая тонн нүүрс нэвтрүүлэх боломж бололцоо бүрдэнэ.

Өнөөдрийн байдлаар бид хэдий холбоогүй байгаа ч гэсэн “Монголын төмөр зам” Цогтцэций, Гашуунсухайтын хооронд өдөрт 8-аас 9 цуваа нүүрс ачигдаж байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Х.Булгантуяа гишүүн ээ.

Одоо бидний явж байгаа “GFS86”³ /Government Finance Statistics/ системээр өмч хувьчлалын орлого чинь төсвийн орлого болж орж ирэхгүй шүү дээ. Энэ чинь урьд нь хөрөнгө болоод нэг удаа бичигдсэн, орлого болоод бичигдсэн юмыг зарж борлуулбал мөнгөн хөрөнгө л болно.

Өөрөөр хэлбэл тэр нь манай төрийн сангийн мөнгөн урсгал дээр л нэмэгдэж орж ирнэ. Түүнээс ямар нэг ашиг орлого гэж төсөв дээр тусгагдахгүй.

Тэгээд одоо хувьцаат компани болсон байгаа компаниуд шинэ IPO гаргасан тохиолдолд тухайн компанийн эргэлтийн хөрөнгө нэмэгдэнэ, хөрөнгө нэмэгдэнэ. Түүнээс төсвийн орлого дээр ямар ч хамаа байхгүй.

Д.Амарбаясгалан: Х.Булгантуяа гишүүн дахин тодруулж асууя.

Х.Булгантуяа: Би бас тойргоосоо нэг зүйлийг асуух гэсэн юм.

Одоо манай Баянзүрх дүүрэг хүн ам хамгийн ихтэй дүүрэг. 2025 онд нэг ч шинэ сургууль, цэцэрлэг баригдсангүй.

Эргээд л харахад манай нэг хороонд шинээр нэг сургууль юм уу, цэцэрлэг барихын хэмжээний хүн ам нэмэгдэж байгаа.

Тэгээд би Боловсролын сайдтай болсон. “Боловсролын жил” зарлагдаж байгаа юм чинь манай дүүргийн боловсролын асуудал хамгийн сайн шийдэгдэх ёстой гэж тийм хүлээлттэй манай дүүрэг тэр чигээрээ байгаа.

Тэгээд одоо гурван ээлж рүү сургуулиуд шилжсэн. Хүүхдүүдээ ийш тийшээ автобусаар зөөж байна. Ахиад дээрээс нь нэмээд цэцэрлэггүй хороо

³ Олон Улсын Валютын Сан (IMF)-аас боловсруулсан Government Finance Statistics Manual (GFSM) буюу төрийн санхүүгийн тайлангийн гарын авлагын 1986 оны хувилбар.

зөндөө байна. Ийм байгаа цаг үед манай Баянзүрх дүүргийн сургууль, цэцэрлэгийн асуудлыг яаж шийдэх вэ? П.Наранбаяр сайд аа.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Баянзүрх дүүрэг бас миний ч сонгогдсон тойрог. Маш хүнд.

Тэгээд яах вэ, энэ жил. Мэдэж байгаа. Та бүхэн тэр Олимп хотхонд нэг шинэ сургууль ашиглалтад орсон.

Ер нь өөрийнх нь онцлог бол газар нь олдохгүй. Одоо хөл гишгэх газаргүй бүгдийг нь өмчлөөд хаячихсан. Ийм одоо хүнд нөхцөл байдалд байдаг. Бид энэ жил 30, 31, 24 дүгээр хороо сургууль байхгүй байгаа.

Сургууль байхгүй байгаа 37, 13, 8 болон 22 дугаар хороонд шинээр сургууль, цэцэрлэгийн барилгыг төлөвлөж оруулсан байгаа.

Энэ нь бас тэр Азийн хөгжлийн банкны зээлэнд эдгээр нь орсон. Мөн дуусах барилгууд дээр энэ ороод явж байгаа.

Манай Баянзүрх дээр нийслэлийн зүгээс бас их анхаарч шинээр барилга бариулах дээр бид нийслэлийнхээ төлөөлөгчидтэй ярилцаж, өөрсдийнхөө энэ өгсөн мэдээллийг өгч, бүр төлөвлөгдөөгүй, энэ улсын төсвөөр оруулж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: 2026 оны төсөв дээр хөрөнгө оруулалтыг оруулахдаа иргэдээс санал авсан нь маш зөв зүйтэй ажил болсон.

Тухайлбал, олон жил яригдсан Даланзадгадын 50 мегаваттын дулааны цахилгаан станцын асуудал бондын хөрөнгөөр шийдэгдэхээр болж байна. Гурвантэс, Шивээхүрэнгийн боомт хүрэх зам улсын төсөвт сууж байна.

Мөн Улаанбаатар, Мандалговь, Даланзадгад чиглэлийн нүүрс зөөж байгаад эвдэрсэн замын их засвар энэ жил, ирэх жил их засвар хийхээр орж байна. Ханбогд, Манлай, Өлзийт, Мандалговь гэсэн шинээр Гашуунсухайтын боомт руу чиглэсэн замын зураг, төсөв хийхээр болж байна.

Манай говийн бүсийн 4 аймагт царцсан арван хэдэн барилга байдаг. Голдуу нийгмийн салбарын. Эдгээрийг дуусгах төсөв хөрөнгийг нь тавьж өгсөн гэх мэтчилэн иргэдийн хүсэн хүлээсэн хөрөнгө оруулалтуудыг тавьж өгсөн байгаа юм.

Бид цалин, тэтгэврийг нэм л гээд байдаг. Тэгсэн мөртлөө нөгөө талаасаа урсгал зардлыг хас гээд ингээд хоёр шал өөр юм ярьж байгаа.

Ер нь бид яаж төсвөө нэмэгдүүлэх вэ, эдийн засгаа яаж солонгоруулах вэ. Ганцхан нүүрснээс биш өөр ямар эх үүсвэртэй болох вэ гэдгээ л маш сайн ярих ёстой байгаа юм. Валютынхаа нөөцийг яаж нэмэгдүүлэх вэ.

Гол нь юмны үнийн өсөлтөө яаж барих вэ гэдэг. Цалин нэмээд л, тэтгэвэр нэмээд л байдаг. Юмны үнийн өсөлтөө гүйцэхгүй нэмээд яваад байвал хэзээ ч энэ чинь шийдэгдэхгүй асуудал.

Тийм учраас бид нөгөө талдаа нэлээн сайн анхаарахгүй бол болохгүй юм байна гэж.

Энэ Малчны тухай хууль гээд 2 жил шахуугийн өмнө Г.Тэмүүлэн гишүүн ахлаад, Т.Аубакир гишүүн, Ж.Батжаргал гишүүн бид хэд санаачилсан. Өнөөдрийг хүртэл энэ хууль нь хэрэгжээд байхад хэрэгжихгүй нэг заалт байгаа. Малчны нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлье гэсэн.

Тэгээд энэ нь яригдаад хаанаа очоод гацдаг юм. Сангийн сайд, Т.Аубакир сайд хоёр энэ дээр хариулт хэлээч. Одоо тойргоор явахаар малчид их асууж байгаа шүү дээ. Өнөө нэг хүүхдийг нь үнэгүй хөдөө аж ахуйн чиглэлээр сургана гэсэн. Хэр хэрэгжилттэй байгаа юм бол? П.Наранбаяр сайд аа.

Хоёрт гэвэл энэ бирийн хуулиа эргэж харахгүй бол энэ болохгүй байна. Манай Даланзадгадын дулааны станц өвөлжилтийн бэлтгэлээ хангах гээд “Эрдэнэс Тавантолгой” компаниас нүүрс авах гэсэн. Тэгсэн та одоо нөгөө биржийн хуулийн дагуу экспортод гаргаж байгаа үнээр ав гээд тэгдэг. Тэгээд угаасаа алдагдалтай ажиллаж байгаа Даланзадгадын дулааны станц яаж тэр тендерт нь ороод, тэгээд тэр гадаадынхантай өрсөлдөөд экспортын үнээр авах вэ дээ. Ийм амьдралгүй хуулиа түргэхэн өөрчлөхгүй бол өвөлжилтийн байдал их хүндрэхээр байгаа.

Дараа нь ипотекийн зээлийг орон нутагт 80 хувийг нь энэ жил олгоно гэсэн. Тэр ямар хэрэгжилттэй явж байгаа юм. Ирэх жил орон нутагт хэдэн хувийг нь, Улаанбаатарт хэдэн хувийг нь олгох юм. Улаанбаатар чинь цементэн шугуй бариад ерөөсөө барилга, байшин барих ч... /минут дуусав/

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ? Харин тийм. Малчны хуулийн хэрэгжилтийг асуусан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд эхлээд хариулъя. Тэгээд Боловсролын сайд.

Т.Аубакир: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Малчны эрх зүйн байдлын тухай хууль, мөн малчин иргэний нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой хуулийг өнгөрсөн парламентын үед

Г.Тэмүүлэн гишүүн, Ж.Батжаргал нарын бидний гишүүд өргөн барьсан л хууль л даа.

Тэгээд яах вэ, мэдээжийн хэрэг Нийгмийн даатгалын санд ачаалал болж орж ирэх юм. Хөдөө орон нутгаар явахад малчдын тавьдаг гол хүсэлт үүнтэй холбоотой байдаг. Мөн манай тойрог дээр ч энэ асуудлыг ярьдаг.

Би өөрөө энэ салбарын сайд нь болоод хүрээд ирсэн. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг миний өмнө тулгарч байгаа. Өмнөх Засгийн газрын үед буюу Л.Энх-Амгалан сайдаас, мөн бусад яамдаас санал авдаг журам батлахын тулд энэ хүрээнд яамд руу явж санал авсан. Зарим яамд татгалзсан.

Хоёр долоо хоногийн өмнөөс эхлээд мөн энэ хуультай холбоотой журмыг нь батлаад малчдын тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг асуудлыг шийдье гээд төсөвтэй холбоотой бид санал авах хүрээнд саналаа аваад явж байгаа. Мөн зарим яамд татгалзах байх. Яг тойргоос сонгогдсон гишүүд, хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд тулгамдаж л байгаа л асуудал. Малчдаа бид эргээд өндөр насны тэтгэвэр авах боломжийг нь бүрдүүлж өгөх ёстой ийм хууль байсан.

Тэгээд нийт төсөв дээр ирэх ачаалал нь 30 гаруй тэрбум төгрөгийн асуудал байдаг. Миний хувьд үргэлж оролдлого хийнэ. Одоо энэ журмыг батлахын тулд.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд. Тэгээд Э.Бат-Амгалан сайд.

П.Наранбаяр: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Малчны тухай хуулийн 4.2.5 дээр малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах гэсэн заалт байдаг. Энэ заалт энэ жилээс хэрэгжиж эхэлсэн.

Өнөөдрийн бидний авсан мэдээгээр Хөдөө аж ахуйн их сургуульд 70 хүүхэд үнэ төлбөргүй суралцаж байна. Тодруулж хэлэх юм энэ намар мал аж ахуйн чиглэлээр, 27 тэжээл бэлчээрээр 20 орчим, мал зүйчээр 20 орчим оюутан шинээр элсэн суралцаж эхэлсэн.

Мөн эчнээ хэлбэрээр элсэлт авч суралцуулна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Э.Бат-Амгалан сайд.

Э.Бат-Амгалан: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Хөдөө орон нутагт ипотекийн зээлийг эхний 3 жилийн хугацаанд 3 хувь байхаар ипотекийн зээлийг ялгамжтай тогтоож байгаа. 2025 оны байдлаар гэхэд

500 зээлдэгчид 53 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээлийг олгосон байгаа юм байна.

Манай яамнаас эрэлт, нийлүүлэлт тал дээр нь л анхаарч байгаа болохоос Монголбанкнаас гаргасан журмаар хөдөө орон нутагт хэдэн хувь байх юм, нийслэлд хэдэн хувь байх юм гэдэг дээр Монголбанкны юу болж байгаа.

Нэмээд хэлэхэд орон нутагт урьдчилгаа төлбөрийн асуудлыг 12 хувь хүртэл бууруулж, Зээлийн батлан даалтын сангаар дамжуулж олгож байгаа. Жишээ нь, ипотекийн зээлд хамрагдахад 30 хувийн урьдчилгаа шаарддаг бол хөдөө орон нутагт 12 хувь болгож бууруулж байгаа. Нийт 2025 онд 193 зээлдэгчийн 4.1 тэрбум төгрөгийг батлан даалтын сангаар гаргасан байна.

Х.Булгантуяа: Биржийн тухай хууль. Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тэр тийм ээ. Биржийн хуульд дотоодын худалдан авалтыг хориглосон нэг ийм заалт байгаа. Энэ нь манай дотоодын дулааны станцууд болон дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд бэрхшээл үүсгээд байгаа.

Тэгээд Ашигт малтмалын хуулийг дагуулаад Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн өөрчлөлтийг удахгүй оруулж ирэхээр бид бэлтгэж байна. Тэгээд өөрчилнө. Одоо ганц гарц нь юу вэ гэхээр Ашигт малтмалын хуулийн дагуу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд хийх ёстой гэдэг, шууд гэрээгээр олгох ёстой гэдэг заалт дээр үндэслээд л явж байгаа. Хууль зүйн хувьд энэ нь бас жоохон маргаан дагуулаад байдаг

Тэгэхээр үүнийг нэг мөр хуулийн өөрчлөлтийг оруулж ирж шийднэ.

Д.Амарбаясгалан: Н.Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Б.Цэнгэл дарга аа, төрийн өмчит компаниудын хэмнэлтийг яаж хийх гэж байна? Бид чинь хэмнэнэ гээд сумын арван хэдхэн албан хаагчтай Тамгын газрын төрийн албан хаагчаас хэмнээд л цомхотгоод байдаг. Жишээ нь, “Эрдэнэс Тавантолгой” компани 1600 ажилтантай. Бүгдээрээ шахуу Улаанбаатар хотоос явдаг. Ингээд 35 автобус шаардлагатай. 2 удаа явахаар 70 автобус энэ хооронд чинь явж байгаа байхгүй юу.

Тэгээд орон нутгаас хүн аваад ажиллуулахад нэг хүний орон тоон дээр ажиллах юман дээр 14, 14. 2 хүн ажиллуулаад. Ийм л үрэлгэн. Тэр төмөр зам ч ялгаа байхгүй.

Тэгээд үүнийг яаж цэгцлэх юм? Орон нутгаас ерөөсөө хүн авахгүй. Дандаа Улаанбаатар, бусад аймгуудаас хүн авдаг. Орон нутагтаа харилцах газар ч байхгүй. Нэг ийм байдалтай юмыг яаж ер нь цаашаа цэгцлэх юм?

Дараа нь Т.Аубакир гишүүнээс түрүүний асуулт дээр тодруулга авъя.

Дараа нь, энэ АМНАТ-ын ийн орон нутагт үлдэх өгөөжийг нэмэгдүүлэх, хувь хэмжээг нэмэгдүүлэхдээ ер нь Засгийн газар ямар хуулийн төсөл... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд хариулъя. Тэгээд Т.Аубакир сайд.

Б.Дэлгэрсайхан: Н.Наранбаатар гишүүний асууж байгаа төрийн өмчит компаниудаас ажилчид нь ээлжээр яваад үрэлгэн зардал их гарч байна гээд.

Тэгээд төмөр замтай холбоотой өнгөрсөн хугацаанд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу 2 төмөр замыг нэгтгэсэн. “Тавантолгой төмөр зам”, “Монголын төмөр зам” хоёрыг. Тэгээд Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төрийн өмчтэй компанийн бүтэц, орон тоог цомхотгох. Энэ хэмнэлтийн асуудлаар шийдвэр гаргаад өнөөдөр ТУЗ хуралдаад, тэгээд ямар ч байсан удирдлагын 40 хувийг нь орон нутагт шилжүүлэхээр болж байгаа.

Дээр нь ажилчдыг нь ээлжгүй болгохоор хүмүүсийг нь орон нутагт төмөр замын чиглэлээр сургаад ажиллаж байгаа.

Тийм учраас цаашдаа ирэх жил төмөр зам нэг ээлжид орно гэж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Т.Аубакир сайд. Тэгээд Б.Цэнгэл дарга.

Т.Аубакир: Н.Наранбаатар гишүүний асуултад дахиад нэмээд хариулахад Малчны тухай хуулийн 4.3.4 дэх хэсэгт заасан хуулийн 4.29-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна гэж заасны дагуу санал авахаар явуулсан. Зарим яамд дэмжээгүй гэдгээ хэллээ.

Үүнээс гадна малчдад зориулж дараах арга хэмжээнүүдийг авч байгаа.

Нэгдүгээрт, малчны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцаж байгаа. Яг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаагаар.

Малчид тэтгэвэрт гарах ердийн наснаас 5 жилийн өмнө тэтгэвэрт гарч байгаа буюу эрэгтэй малчин 55, эмэгтэй 50 насандаа тэтгэвэрт гарах эрхтэй байгаа. Тэтгэврийн даатгалын сангаас 2024 онд 32.3 мянган малчны өндөр настны тэтгэвэрт 237 тэрбум төгрөг зарцуулаад байгаа зэрэг арга хэмжээнүүдийг аваад явж байгаа.

Энэ мэдээж хэрэг санхүү, эдийн засагтай холбоотой зарим тооцооллууд явдаг.

Д.Амарбаясгалан: 3 номер. Ажлын хэсгийн микрофон. Б.Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Гишүүний асуултад хариулья.

2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлж, зардлыг 15 хувиар бууруулахаар тусгасан байж байгаа. Энэ хүрээндээ бид төрийн бус компаниуд дээр энэ шийдвэрийг хэрэгжүүлээд явж байгаа.

Нөгөө нэг асуудал гэх юм бол төсвийн хэмнэлттэй холбогдуулаад төрийн өмчит компаниуд өнөөдөр 59 мянга орчим хүмүүс ажиллаж байна. Орон тоог 10 хүртэлх хувиар бууруулах чиглэлтэй ажиллаж байгаа.

Зардлыг бид бууруулах асуудлыг яаж авч үзэж байгаа вэ гэхээр ер нь нийт төрийн бус компаниудын зардалд 18.2 их наяд төгрөгийн зардал гаргадаг. Энд үйлдвэрлэлийн зардал 12.9 их наяд.

Үйл ажиллагааны бус зардал гэж байдаг. Үйл ажиллагааны бус зардал ойролцоогоор 686.0 тэрбум төгрөг байгаа.

Тэгэхээр бид үндсэн үйл ажиллагааны зардал руу орохгүйгээр үйл ажиллагааны... /минут дуусав/

Х.Булгантуяа: 3 номерын микрофон нэмж өгье.

Б.Цэнгэл: Үндсэн үйл ажиллагааны зардлыг хөндөхгүйгээр гэхдээ үйл ажиллагааны бус зардал буюу 685.9 тэрбум төгрөгөөс энэ 15 хувийн хэмнэлтийг хийх бололцоотой гэж үзэж байгаа юм.

Ингэснээрээ бид 264-өөс 700 орчим тэрбум төгрөгийн ерөнхийдөө зардлыг бууруулах боломж байна гэсэн тооцоололыг хийсэн. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Н.Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Одоо бидний ерөөсөө мөнгө олж байгаа ганц салбар уул уурхай л байгаа юм л даа.

Тэгээд эрэл хайгуулаа нэмэгдүүлье, олборлолтоо нэмэгдүүлье л гээд яриад байдаг. Тэгээд энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийнхөө эргэн хуваарилалтад эргэж харахгүй бол энэ уул уурхайг чинь дэмждэг сум, баг, орон нутаг гэж байхгүй боллоо шүү дээ. Тухайлбал, Өмнөговь аймаг 3.4 их наяд төгрөгийн АМНАТ улсын төсөвт өгчхөөд 42 тэрбум төгрөгийг эргүүлж авч байгаа байхгүй юу. Энэ чинь 1 л хувь нь байгаа байхгүй юу. 42 тэрбумаа 15 сумдаа хуваахаар нэг нэг тэрбум төгрөг л уул уурхайгаас очиж байгаа байхгүй юу.

Тэгээд ийм нөхцөлд эргээд тэр орон нутагт нь, тэнд байгаа иргэдэд нь, суманд нь, багт нь ямар ч өгөөжгүй нөхцөлд хэн үүнийг дэмжих юм бэ?

Тэгэхээр үүнийг өөрчлөх юм уу? Баялгийн тухай хуулиар өөрчлөх юм уу? Ашигт малтмал юм уу, татварын хуулиар өөрчлөх юм уу? Энэ дээр ер нь ямар бодлого барих юм бэ?

Цаашдаа уул уурхайгаа дэмжье л гэж бодож байгаа бол орон нутгийн өгөөж, тэр ажлын байр, ханган нийлүүлэлт энэ тэрийг нь орон нутгаас нь авахгүй бол одоогийнх шиг явахгүй болоод байна шүү дээ. Уул уурхай чинь, цаашдаа.

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, бид уул уурхайн эдийн засагтай улс болсон. 2000 оноос хойш гэхээр чинь бараг 20 гаруй жил ер нь эргэлт буцалтгүй ийм боллоо. 2020-оод оны эхэн үеэр АМНАТ ялгарал ийм том байгаагүй юм. Зарим нэг аймаг нь ийм том АМНАТ төлдөг.

Одоо энэ ялгаа их өндөр болж ирж байгаа учраас бид энэ АМНАТ-ын хуваарилалтыг эргэж харах цаг нь болжээ.

Үнэхээр Өмнөговь аймаг, Өмнөговь аймгийн ард түмэнд Монголын ард түмэн талархах хэрэгтэй. Уул уурхайг хамгийн их дэмждэг, хамгийн их эргэлтэд оруулдаг. Тэр хэмжээгээрээ бусад аймаг, хотуудад маш их ийм ээлтэй явж ирж байгаа. Жишээ нь, Хөвсгөл аймаг фосфоритынхоо ордыг хааснаас хойш манайх ногоон аймаг болно. Нэг ч уул уурхай хөндөхгүй гээд зарласан.

Тийм учраас АМНАТ-ын хуваарилалт энд хамгийн бага очдог байх жишээтэй. Би зүгээр нэг аймаг жишээ авлаа шүү.

Ингээд Өмнөговь аймгийн АМНАТ... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас одоо ямар төсөл явж байгаа вэ гэхээр АМНАТ-ыг одоо бид 10 хувийг нь орон нутгийн хөгжлийн сангийн нийт том санд нь хуваарилж байгаа. Тэндээсээ аймгуудаа коэффициентлоод хуваарилдаг.

Одоо үүнийг хоёр дахин нэмье гэж байгаа. Төсөл ингэж явж байгаа. 20 хувь болгоно. Түүн дотроо дахиад уул уурхайг илүү их дэмжиж байгаа, илүү их эргэлтэд оруулж байгаа, илүү их АМНАТ төлж байгаа бол тэнд индексийг нь дахиад өндөр тавьж байгаа.

Үүнийг харин хэзээнээс хэрэгжүүлэх вэ, хэзээ үүнийгээ Их Хурал дээр ярилцах вэ гэдэг бол дараагийн асуудал. Үүнийг удахгүй Их Хуралд өргөн барина. Тийм.

Өмнө нь би танд танилцуулж байсан. Тийм ээ. Төсөл яг хэвээрээ байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: 2016 оноос хойш улсын төсвийн орлого, зарлагыг хараад байхад бид мөнгөгүйн зовлон биш мөнгөтэйн зовлонг эдэлсэн байна.

Гол нь бид мөнгөө зарцуулж сураагүйн санхүүгийн менежментгүй байна. Амсуулж тавьсаар байгаад аль ч үгүй болсон. Асуудал нь шийдэгдсэн салбар өнөөдөр Монголд нэг ч байхгүй.

➤ 2006 онд улсын төсөв **784-хөн тэрбум** байсан.

➤ 2016 онд улсын төсөв **9 их наяд** байсан.

▶ Өнөөдөр **44 их наяд**.

Сүүлийн 20 жилийн хугацаанд 44 дахин ихэссэн. Өнөөдөр асуудал нь шийдэгдсэн нэг салбар алга.

Ахиад хэлье. “Иргэн баян бол улс баян” гэж Ерөнхий сайд илтгэл дээрээ дурдаж байсан. Өнөөдөр “улс нь баян, иргэн ядуу болсон”. Эсрэгээрээ болсон.

Сугалаанд их хэмжээний мөнгө хожоод юм үзээгүй юм шиг бүгдээрээ үрэн таран хийж байгаад дампуурсан хүн шиг л улсын төсвийг гарын салаагаар урсгаж байна.

Б.Жавхлан Сангийн сайд болсноос хойш 130 их наяд төгрөг зарцуулагдлаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүний 74.0 хувь чинь төр үйлдвэрлэж байна гээд өөрсдөө бичсэн. Тэгсэн мөртлөө 2026 оны улсын төсөв дээр хувьчлалын орлого гэж нэг ч төгрөг байхгүй буюу эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах хүсэлгүй байна, бодолгүй байна гэсэн үг.

С.Бямбацогт сайдын хэлсэн тэр төр хоолны газар ажиллуулах шаардлагагүй, амралтын газар ажиллуулах шаардлагагүй. Эд нарыг хувьчлах хэрэтэй. Яаралтай.

Мөн 2016 оноос улсын төсвийн зарлага, орлого дээр бас нэлээн суулаа. 2026 оныг “Боловсролын жил” гээд зарласан юм бол. Улсын Их Хурлын дарга ч

үгэндээ дурдаж байсан. 108 сургууль, 108 цэцэрлэг барихад энэ асуудал шийдэгдэнэ гээд.

Тэгвэл “Боловсролын жил” юм бол 1 их наяд төгрөг гаргаад 2026 онд энэ асуудлаа шийд. Бүр болохгүй бол асуудлаа нэг нэгээр нь шийдээд явъя.

2027 онд эрүүл мэндийн салбараа гэдэг ч юм уу. Алтан гахай жил төрсөн хүүхдүүдээ 6 жилийн дараа сургуульд орохыг нь төр нь мартсан. Засгийн газар мартсан. Сургуулийг нь бариагүй, цэцэрлэг нь бариагүй.

Сүүлийн 10 жилийн хугацаанд 1062 ширхэг сургууль, цэцэрлэг, дотуур байр хүртэл баригдсан юм байна лээ. Анхны төсөвт өртөг нь 2.8 их наяд байсан. Гэхдээ 3.4 болсон. 600.0 тэрбум төгрөг нэмэгдсэн.

Нэг сургуулийг барилгажилтын дундаж хугацааг нь 3.3 жил барьж байна. Жил бүр төсвийг нь нэмж хойшлуулдаг. Энэ бол авлига. Төсөв нэмдэг авлига. 500.0 тэрбумаар.

Сүүлийн 10 жилд орсон 1062 төсөл, хөтөлбөрт нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл нэг ч байхгүй. Дундаж хугацаа нь 3.3 жил шүү.

Сургуулийн барилга ганцхан жил барьж чадахгүй бол бид хүүхдүүдийн асуудлыг яаж шийдэх юм. Хүн төвтэй төсөв чинь тэгээд энэ юм уу? Хүн төвтэй төсөв ийм байдаг юм уу? Үндэсний номын сангийн төсөв тодотголоосоо буураад 3 гаруйхан тэрбум төгрөг болсон. Номын санд ном авах төсөв хэдэн төгрөг байгаа юм.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Г.Занданшатар. Ерөнхий сайдын микрофоныг өгөөрэй.

Г.Занданшатар: Ер нь Ө.Шижир гишүүний хэлдэг шиг нөхцөл байдал үүссэн учраас энэ жилийн төсөв харьцангуй цомхон, төсвийн тэлэлтийг хязгаарласан, иргэдийн оролцоотой, иргэдээр хяналт тавиулах, цаашдаа иргэдээр үнэлүүлэх ийм төсвийн шинэчлэлийн бодлогыг баримталж боловсруулсан юм.

Яагаад гэвэл баялгийн хараалын шинж тэмдэг буюу нүүрс, зэсийн үнэ өсөхөөр дагаад урсгал зардлаа тэлдэг. Эргээд агшихаар нь энэ мөчлөг сөрсөн бодлого байдаггүй.

Тийм учраас энэ бол мөчлөг сөрсөн төсөв.

Дэлхийн бүх улсууд ихэнх нь, Европын улсууд ч гэсэн 3 хүртэл хувийн алдагдалтай байдаг. Манайх 3 хувь хүргээгүй. Дотоодын нийт бүтээгдэхүүн, төсвийн алдагдал байдаг норм нь ийм.

Харин нэг талдаа бодит байдлыг ойлгох хэрэгтэй. Таны хэлээд байгаа 1 их наяд биш 1.2 их наядаар ирэх жил боловсролын салбарын төсвийг нэмэгдүүлсэн байгаа. 105 сургууль барьж ашиглалтад оруулна.

Гэтэл энэ төсвийн тэлэлт, бодлого ямар учиртай вэ гэхээр сая гаруй хүүхэдтэй байсан одоо сая 347 мянган хүүхэдтэй болсон. Хүн амын насжилт уртасаад дундаж нас өссөн. Тэтгэвэр авагчдын тоо нэмэгдсэн. Одоо 447 мянгад хүрлээ. 200 гаруйхан мянга байсан юм. Намайг банканд тэтгэврийн асуудал хуваарилдаг байхад.

Энэ бүхэн нийгмийн ачааллыг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангийн зардал ч өсөж байна. Шинээр сургууль, цэцэрлэг барих шаардлагыг ч нэмэгдүүлж байна.

Яг энэ хүн амын цонх нээгдэж байгаа энэ үед чинь өөрөө төсвийн нийгмийн зардлыг нэмэгдүүлдэг ийм үед таарч байгаа. Ийм учраас боловсролын салбарын багш нарын тоо, эмч нарын тоо байнга тасралтгүй өсөж байгаа.

Гэтэл нөгөө уурхайгаас олж байгаа орлогоо зөв зарцуулж чадаагүй учраас өнөөдөр энэ асуудлаа шийдэх, эдийн засгаа төрөлжүүлэх бодлого хаягдсан. Ийм учраас төсвийн шинэчлэл, одоо бид зэсийн үйлдвэр, гангийн үйлдвэр, том өөрчлөлтүүд хийж байгаа. Зохицуулалтыг энэ дээр эхэлж байна.

Ард түмэнд АМНАТ-аас олж байгаа орлогоосоо илүү орлогыг, татварыг НӨАТ-аар авч байгаа учраас бид НӨАТ-ын буцаан олголтыг эхлүүлж байгаа. Энд 4 ам бүлтэй айл жилдээ 2 сая орчим төгрөг буцааж авдаг болж байгаа. Үүгээрээ далд эдийн засгийг ил болгож, уул уурхайгаас улбаатай эдийн засгийн далд байгаа орлогын ялгаатай байдлыг засварлах, татварын реформ хийх суурийг нь тавьж байгаа юм.

Ингэж татварын бааз сууриа өргөтгөж, бүртгэлийг чангатгаж, ил тод байдлыг нь нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэх замаар. Үүний үндсэн дээр татварын дарамтыг 3-аас 4 их наядтайгаар бууруулж, хувийн хэвшлийг дэмжсэн бодлогоор хэрэгжүүлж байгаа.

Төрийн өмчит компаниудын хувьчлал, шинэчлэлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Энэ талаар манай Б.Цэнгэл дарга тодорхой танилцуулсан.

Гагцхүү энэ төсвийн цаглавар өөрчлөгдөөд 9 сарын 01-нд төсөв өргөн барьдаг болсон учраас энэ бодлогын баримт бичгүүд 10 сарын 01-нд өргөн баригдах болоод байна. Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, шинэтгэл, шинэ итгэл дээр тулгуурласан шинэтгэлийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЧАНАРТАЙ ӨСӨЛТ” гэсэн бодлогын баримт бичиг маань, 5 жилийн төлөвлөгөө маань 10 сарын 31-нд өргөн баригдах ийм хуультай.

Энэ зохицуулалтуудаа бид Улсын Их Хурал ч гэсэн анхаарч засаж байж, хамтарч ажиллаж байж энэ том реформыг хийж чадна.

Ингэж байж бид энэ эдийн засгийн төрөлжилтөө нэмэгдүүлж, уул уурхайгаас, нэг улсаас хамааралтай болсон эдийн засгаа бид өөрчилж чадна. Нэгхэн өдрийн дотор өргөс авсан юм шиг үүнийг ч шийдэж чадахгүй.

- Экспортын 95 хувь нь уул уурхайгаас хамааралтай.
- Гадаад худалдааны 70 хувь нь нэг улсаас хамааралтай.

► Өр 160 хувьд хүрсэн ийм эдийн засаг бий болгосон нь бодит үнэн байна.

Энэ бүхнийг чинь л өөрчлөх гэж манай Засгийн газар 10 реформтой шинэтгэл, хүний хөгжил, чанартай өсөлтийн 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулаад бэлэн болгож байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яам хэлэлцүүлж байна. Татварын реформоо бэлэн болгосон байгаа. Хэлэлцүүлж байна.

Гагцхүү нэмэгдсэн өртгийн албан татварын төсөвтэй хамт оруулж ирдэг нь нэмэгдсэн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж минут өгөөрэй.

Г.Занданшатар: Төсөвтэй хамт зөвхөн татварын реформын нэмэгдсэн өртгийн албан татварын хуультай холбоотой хэсэг орж ирж байгаа.

Нэмэгдсэн өртгийн албан татвар бол орлого төвлөрүүлэхээсээ гадна бүртгэлийн чиг үүрэгтэй анх үүссэн татварын төрөл. Ингэж нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлснээрээ бид 2 сая татварын байцаагчтай болж байна гэсэн үг болно. Ингэж бүртгэл e-barimt-ын нэхэлт нэмэгдсэнээрээ эдийн засаг ил тод байдал нэмэгдэнэ. Далд эдийн засаг ил болно.

Ирэх долоо хоногоос бид e-barimt-ыг цахимжуулах ажлыг тууштай хэрэгжүүлж эхэлнэ. Цаасаар биш цахимаар хэрэгжүүлдэг DIGITAL POST буюу цахим инновацын шинэ технологио нэвтрүүлж байна. Энэ долоо хоногт туршилтыг нь эхлүүлсэн.

Энэ бүхэн эдийн засгийн ил далд хулгай, луйврыг цэгцэлж, уул уурхайн үр ашгаа нэмэгдүүлж, төрийн өмчит компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх гэж байгаа ийм цогц 10 реформын бодлогыг бид нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн дараагийн үндсэн чиглэлдээ 2025-2026 онд боловсруулах үндсэн чиглэлтэйгээ боловсруулаад... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Ө.Шижир гишүүний асуултад зарим мэдээллүүд нэмж өгье. Хувьчлалын орлого төсвийн орлого болдоггүй. Тийм. Өмнө нь хөрөнгө болоод орсон орлого мөнгөн хөрөнгөд л болдог ийм бүртгэл дээр тусгана.

Тийм учраас ирэх жилийн орлого гэж тусгагдахгүй. Цаашдаа ч бас тусгагдахгүй байх.

Амсуулдаг хөрөнгө оруулалт гэж байхгүй. Байхгүй болсон. Магадгүй 5, 10 жилийн өмнө ийм тохиолдлууд их олон байсан байна лээ. Одоо бол тийм зүйл байхгүй.

Ирэх жилүүдэд “Боловсролын жил” болж байна. Мөн олон нийтийн санал асуултаар эрүүл мэндийн салбартаа илүү түлхүү анхаараарай гээд захисан байгаа.

Тэгэхээр ирэх жил эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын хөрөнгө оруулалт 2-оос 5 дахин нэмэгдэнэ. Энэ талаар маш дэлгэрэнгүй маш олон хуудас материал таны өмнө байгаа.

Эдгээр арга хэмжээнүүд ингээд ирэх оны төсөвт тусгагдсан байна.

Х.Булгантуяа: Ө.Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: 2016 оны 579 ширхэг төсөл, хөтөлбөрийн чинь 140 нь шилжиж байгаа. 237 нь төсөв нь хасагдаж байгаа буюу 2037 он руу хойшилж байгаа.

Тэгээд энэ чинь жил ирэх зун төсөв нь нэмэгдээд яваад байгаа. Энэ чинь амсаж тавьж байгаа биш юм уу? Нэг сургуулийг 320-хон хүүхдийн сургуулийг 7 жил барьдаг улс байгаад байна шүү дээ. Ганцхан жил барьж чаддаггүй юм уу? Энэ Б.Чойжилсүрэн сайд чинь 2000 айлын орон сууцыг нэг жилд бариад байна шүү дээ. Ядаж энэ Б.Чойжилсүрэн сайдаас үлгэр жишээ аваач.

Би П.Наранбаяр сайдаас нэг юм асууя. Энэ хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн гэдэг дээр нэг ээлжээр хичээллэх боломжтой төрийн сургуулиудыг 51-ээс 61 болгоно гэсэн байгаа юм. Эхлээд бид 3 ээлжтэй 2 сургуулиа, 2 ээлжтэй байгаа нэг сургуульд 55-аас 70 хүүхэд сурч байгаа сургуулиудаа нэг ангид 25-аас 30 хүүхэд сургадаг болгох зорилт тавихгүй юм уу?

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ө.Шижир гишүүн ээ. Наад төсөл, арга хэмжээтэй чинь холбоотой хэдхэн л тоо байгаа даа. Та нэг сайн тогтоод хараадхаач. Ингээд л нэг сөрөх гээд л яараад байх юм.

Наадах чинь 549 төсөл. 149 нь шинэ, 430 нь үргэлжлэх байгаа.

Одоо ингээд “Боловсролын жил” гээд зарлаж байгаа шиг 2017 онд тэгж зарлаад явж байсан юм билээ. Тэр үедээ нэг маягийн зураг гээд аягүй олон сургуулиудыг эхлүүлсэн. Тэндээс 2026, 2027 онд сүүлийнх нь ашиглалтад орж байгаа.

Түүнээс биш сүүлийн 2, 3 жил явна. Хугацаа нь. Сүүлийн 4 жилийн хугацаанд эхэлсэн төслүүдээс ийм сунжирч байгаа төсөл нэг ч ширхэг ч байхгүй гэдгийг би танд хэлье.

Та наадхаа нэг сайхан тогтоод хараарай. Харин энэ удаа ийм төсөл, арга хэмжээнүүд нэг ч байхгүй байгаа шүү. Амсуулж байгаагүй. Харин энд төсөл хэлэлцэх, төсвийн ажлын хэсэг энэ тэр дээр ингээд янз бүрийн төсөв, арга хэмжээнүүд нэмэгддэг. Түүн дээр нэг маягийн хэв зургаар гэдэг тийм л төсөл битгий... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ө.Шижир гишүүн нэмж тодруулна. П.Наранбаяр сайдаас. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр мэдээж бид ач холбогдлоор нь жагсааж асуудлыг эрэмбэлж шийдэж явна. Өнөөдөр яг нийслэлд 3 сургууль 3 ээлж рүү ороод байгаа. Ноднин яг энэ 9 сард 8 сургууль байсан. Энэ жил 3 сургуультай байгаа.

Гэхдээ бид эндээс нэг сургуулийг нь гаргаж байгаа. 3 ээлжээс нь. Үлдсэнийг нь ойр орчимд нь сургууль, барилга түрээслэх аргаар гаргана.

Ер нь сургуулийн нэг бүлэгт улсын дундаж нь 30.4 хувьтай, төрийн өмчийн сургууль 31.6 хувь хүүхэдтэйгээр ингэж хичээллэж байгаа.

Цаашдаа бид сургууль, цэцэрлэгийнхээ хүртээмжийг нэмээд, сайн бүтээн байгуулалтаа хийх юм бол энэ ээлжийн коэффициентийг 1.3 руу бүр оруулж ирэх юм.

Нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн тоог 35 руу оруулж ирэх юм. Ийм л зүйлийг зорьж бид “Боловсролыг дэмжих жил” гэж зарлаж энэ ажлуудыг хийж байгаа. Сургууль барих ажил бол зураг, төсөв сайн бол яг хугацаандаа... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ө.Шижир гишүүн нэмж тодруулна.

Ө.Шижир: Төсөвт өртөг нь нэмэгдсэн 140 барилга, байгууламж чинь. Би танд 2 жишээ уншаад өгье. Б.Жавхлан сайд аа. Та дахиад л худлаа ярилаа.

Говь-Алтай аймгийн Халиун суманд 100 хүүхдийн ортой дотуур байрыг 2027 онд дуусгана гэсэн байна. 2022 онд эхлүүлээд, 100 хүүхдийн ортой дотуур байрыг 5 дахь жилдээ барина гэсэн үг. Зургаа дахь жилдээ. Өгсөн ном дээр чинь 2027 онд дуусна гэсэн байна. Ийм жишээ 140 байна.

Тэгээд хамгийн их гал түймэр гардаг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт сүүлийн 10 жил онцгой байдлын төсөв гэж хөрөнгө оруулалтад 800-хан сая төгрөг өгсөн байна лээ. Хэнтий аймагт нэг юм барьсан. Байдаг нисдэг тэргийг нь сайд нар, дарга нар нь хурал руугаа аваад явдаг. Хамгийн их гал түймэр гардаг тэр бүсэд онцгой байдалд урсгал зардлаас өөр юм шийдэж өгөөгүй.

Ийм юмнуудыг л яриад байгаа юм. Сүүлийн 10 жилд боловсролын салбарын 1062 төсөл чинь анхны төсвөөсөө 500.0 тэрбумаар өссөн байна гэж байгаа юм. Үүнийг чинь авлига гээд байгаа юм.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг 4 номерын микрофон дээрээс хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Ө.Шижир гишүүн асуултад хариулъя.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Ж.Дэлгэржаргал.

Таны асуусан Говь-Алтай аймагт баригдаж байгаа дотуур байрны хувьд 2022 онд яг нэг маягийн зургаар эхлээд, дунд нь санхүүжилтүүд нь зогсоод, ажил нь дуусахгүй. Сүүлд энэ 2026 онд тавигдаж байгаа өртөг нэмэлт энэ ажлыг дуусахад хийсэн магадлалын ерөнхий дүгнэлтэд Үндэсний аудитын газраас хийсэн дүгнэлтийн дагуу үлдэгдэл санхүүжилтийг тусгаад явж байгаа.

Нийтдээ аудитын дүгнэлт дээр яг Сангийн яамнаас хүргүүлсэн тоо 644 тэрбумын нэмэгдэл байгаа. Үүнээс 194 тэрбум нь өргөн барихаас өмнө ирээд бид төсвийн төсөлд тусгасан.

194 тэрбумын өртөг бол яг төсөвт өртөг дээрээ тавигдаад, төсвийн хязгаартайгаа бид багтаагаад, одоогийн явж байгаа ажлын гүйцэтгэлд нь уялдуулаад, санхүүжих дүн талдаа хуваарилаад тавьсан байгаа.

Өөрөөр хэлбэл зарим нь 2026 он дээр, зарим ачаалал нь 2027 он дээр. Энэ бол яг хуулиараа шилжиж байгаа санхүүжилт биш, нэмэлтээр үүсэж байгаа нэмэлт санхүүжилт учраас... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Ө.Шижир гишүүн ээ, би танд захъя.

Их Хурал дээр төсөл, арга хэмжээнүүд нэлээн нэмэгддэг юм шүү. Түүн дотор харин залхуураад, амарчлаад нэг хэв маягийн зураг гээд ийм төсөл, арга хэмжээ нэмбэвээ. Та түүн дотор нь өөрөө цохиж явах вий. Энэ саяын яригдаж байгаа энэ төслүүд чинь ер нь дандаа л иймэрхүү төслүүд байгаа шүү.

Тэгэхээр та өөрөө их сайн үлгэр жишээ, манлайлал үзүүлж ажиллах хэрэгтэй шүү.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Өчигдрийн асуултынхаа хариултыг буюу Төрийн албаны зөвлөл Баянхонгор аймагт хийсэн хууль бус томилгоотой холбоотой хариулт авагдаагүй байгаа.

2024 оны санхүүгийн тайланд 15 их наяд төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч нарынх нь хариуцлагын асуудал ерөнхий аудитаар хариулаагүй байгаа. Энэ дээр хариултыг өгүүлэх талаар Улсын Их Хурлын Тамгын газрынх нь дарга мэдэгдэж өгөөрэй.

Тэгээд өчигдөр уг нь Авлигатай тэмцэх газар Монгол Ардын намын цагаан байр луу орохдоо дутуу орсон юм. Өшөө цаашаа орсон бид одоо энэ төсөв гэж яриад байгаа тоогоо хэд дахин нугалаад авах боломжийн хэмжээний дарга нар тэр цагаан байранд маш их байгаа.

Одоо энэ төрд шахаа хийдэг, баяждаг, томилгоо хийдэг, аалзны тор угсардаг, сүлждэг хүмүүс тэнд сууж байгаа. Энэ бол зарчим. Авлигатай тэмцэх газар уг нь ажлаа хийгээд нэг ийм хоёр, гурван том даргыг бариад яг шударга хариуцлагыг нь хүлээлгэж чадах юм бол энэ төсөв хэд дахин нэмэгдэх боломжтой ийм л төсөв бид тойрч суугаад хэрүүл хийгээд сууж байна.

Л.Оюун-Эрдэнэ гэдэг хүн бол бандийнхаа эхнэрийн, найз охиных нь тэр нэг сошиалд тавьсан зургаас нь болоод явсан. Монгол Ардын намд ийм бэртэй дарга маш олон байгаа гэдгийг нийгэм мэдэж байгаа. Авлигатай тэмцэх газарт л үүнийг хандаж хэлээд байгаа юм.

Тэгээд Хархорин хотын зөвлөлийн дарга Н.Энхбаяр дарга бол Монголын энэ төрийн өндөр албан тушаалуудыг бүгдийг нь хашсан. Энэ хүний яриа нийгэмд нэлээн хор уршигтай байж мэдэхээр байгаа.

Энэ хил холболтын асуудлыг явуулдаггүй ч гэдэг нэг хүн. Бас өмнө нь байсан.

Г.Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газрын үед энэ төслөө явуулах сонирхол байгаа юу? Эсвэл энэ Н.Энхбаяр гэдэг хүнийг нохойд барьдаг мод шиг ингээд ашиглаад яваад байх уу?

Энэ ах намын даргын төлөөх суудлын зодоон нь эх орныхоо эдийн засгаар тоглох хэрэгтэй юу, үгүй юу?

Өнгөрсөн жил хамтарсан Засгийн газар байгуулаад улс орныхоо хөгжлийн төлөө хамтраад дорвитой төсөл, хөтөлбөр хөдөлгөө гээд хэд хэдэн том төсөл хөдөлгөсөн.

Тэгээд үүнийг эсэргүүцэх Монгол хүн лав байхгүй байх. Үүний цаана ямар нэгэн эсвэл тийм нэг далдын хүч үйлчлээд байгаа юм. Энэ далдын хүчийг Тагнуулын ерөнхий газар, хуулийнхан болдог бол эднийг тодруулаад Улсын Их Хуралд хаалттай мэдээлэл өгдөг ч юм уу, шаардлагатай бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд уг нь мэдээлэл өгөөд бид нэг эв найрамдалтай явбал зүгээр гэж үзэж байгаа.

Тэгээд энэ төсөв хүнд байна гэж яриад төрийн албанд насаараа ажилласан төрийн албан хаагч нарынхаа тэтгэмжийг 36 сараар авах гэж байсан тэтгэмжийнх нь тал хувийг алга болгочхож байгаа юм. Энэ төрд насаараа зүтгэсэн энэ хүмүүст энэ төсөв хүнд байх чинь ер нь ямар хамаатай юм бэ?

Яг энэ тэтгэмжээ авах гэж л хүлээж сууж байгаа төрийн албан хаагч зөндөө байгаа шүү дээ. Энэ урсгал зардал нь өсөөд байгаа дарга нарынх нь, ерөнхийлөн захирагч нарынх нь зарцуулаад байгаа урсгал зардал ихдээд байгааг. Энэ дээр нь уг нь танаж хасаад, ядахдаа төрийн албан хаагч нарынхаа тэтгэмжийн асуудлыг шийдэж болдоггүй юм уу л гэдгийг сайд, дарга нарт хандаж хэлэх гээд байгаа юм.

3 сая төгрөгийн цалинтай болбол хулгай хийнэ гээд байгаа юм. Тэгтэл гудамжинд жагсаад байгаа тэтгэвэр авч байгаа улсууд чинь зайлуул 600 мянган төгрөгийн л татвартай байгаа шүү дээ.

Тэгээд үүнийгээ шийдвэл уг нь дундаж тэтгэвэр... /минут дуусав/

Х.Булгантуяа: Тодруулчих. Хамгийн эхлээд хэн хариулах вэ? Ерөнхий сайд хариулах уу? Нөгөө хил холболтыг. Аан.

Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Төрийн албан хаагч нарын нэг удаагийн тэтгэмж 36 сар хүртэлх энэ хөрөнгөд санаа зовох зүйлгүй. Энэ чинь суурь хууль нь хэвээрээ байж байгаа.

Хөндөгдөхгүй. Төсвийн хязгаартай холбоотойгоор иймэрхүү зохицуулалт өмнө нь ч гэсэн практикт байдаг.

Тийм учраас ирэх жил тэтгэвэрт гарах улсууд оныхоо сүүл рүүгээ шахаад ч юм уу, яг тэтгэвэрт гарлаа гэхэд хагаслаад үргэлжлээд авч болно. Наана нь тэтгэвэртээ гараад он гараад бүтнээр нь ч авсан болно. Төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө төсөв дотроо мөн шаардлагатай зохицуулалтууд хийж болно.

Ер нь өнөөдрийг хүртэл яаж ирсэн бэ гэхээр яг манай төрийн албан хаагч нар. Би яг хойтон тэтгэвэрт гарна гээд бүр нэрээ өгч байгаад захиалдаг. Тэдэн сарынхаа тэтгэмжийг авна гээд. Яг хойтон нь юу болдог вэ гэхээр ер нь нэг 10-аас 20 хувийн хэмнэлттэй гардаг. Нөгөө улсууд би дахиад нэг жил ажилламаар байна, арай болоогүй байна гээд хэмнэлттэй гараад байдаг юм.

Тэгэхээр нь 10-аас 20 хувийн хэмнэлттэй гарна. Түүн дээр шахаад явж болно.

Тийм учраас хууль нь хэвээрээ байгаа учраас энэ дээр ерөөсөө огт санаа зовох зүйлгүй гэдгийг анхааруулж хэлье.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд. Ерөнхий сайд нэмж хариулъя. 1 минутыг нийлүүлээд 2 минутаар.

Г.Занданшатар: Даваагийн Ганболд гишүүний уншсан асуултуудад хариулъя.

Нэгдүгээрт нь, хил холболтын асуудал Улсын Их Хурлаар шийдэгдсэн. Улсын Их Хурлын тогтоолтой асуудал.

Энэ хил холбох нь зарчмын хувьд зөв. Хоёр улсын гэрээгээр шийдэгдэж байгаа асуудал. Энэ бол эрх зүйн шинж чанартай баримт бичиг. Улсын Их Хурлаар батлагдсан. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн шинж чанартай ийм бичиг баримт бичиг.

Харин аж ахуйн нэгж хоорондын гэрээ хэлэлцээрээр үнэ хэлэлцээрт тохирсон тэр асуудал тусдаа асуудал.

Тэгээд юмыг ялгаж салгаж үзэж харахгүй бол нэг нийтэд нь бүгдийг нь харлуулдаг. Нэг бол нийтэд нь цайруулж цагаан болгодог юм бол энэ асуудал дээр зохицохгүй. Энэ үр ашигтай. Улсын Их Хурлаас өргөн барьсан тогтоол дээр олон улсын стандартын дагуу олон улсын аудитаар бүх асуудал хянагдаж цэнэглэгдэж явах ёстой гэсэн ийм агуулгатай байгаа.

Хоёрдугаарт нь, ер нь авлигатай тэмцэх асуудал энэ авлигатай тэмцэхгүй бол улс орон сүйрнэ.

Тийм учраас өнөөдөр бид энэ нүүрсэн дээр байгаа асуудлууд. Тавантолгой дээр онцгой дэглэм тогтоогоод ажиллаж байхад тэнд баригдсан нүүрс баяжуулах үйлдвэр 1 их наяд төгрөгөөр. 13 километр замын зайд барьсан. Тэр хооронд сая 500 мянган төгрөгөөр тээвэр хийдэг байсан. Онцгой дэглэм тогтоох сургаар сая төгрөг болсон байсан. Очоод бид газар дээр нь ажиллахад 300 мянган төгрөг болсон байсан. Одоо 3 өдөр машинаар зөөгөөд нэг өдөр ажилладаг. 1 их наядаар барьсан үйлдвэр.

Тэгтэл хувийн хэвшлийн барьсан үйлдвэр ямар хямдхан ямар өртөгтэй байна. Ямар үр ашигтай ажиллаж байна. ТНАЛТ гээд нүүрс ачилтын ложистик төв байна. Одоо тэр баяжуулах үйлдвэрийн уурхайтай холбогдох конвейер гэж ахиж тавиад 280 тэрбум төгрөгөөр барьж байна.

Ингэж улсын мөнгө уйлдаггүй гэдэг шиг нүүрсний асуудлууд чинь хэрээс хэтэрсэн. Улс оронд хохиролтой олон асуудлууд байна. Энэ бүхнийг цэгцлэх шаардлагатай байгаа. Энэ шинэчлэлийн ажлуудыг эхэлсэн. Ингэхгүй бол ер нь... /минут дуусав/

Х.Булгантуяа: Да.Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн Сангийн сайд болон Ерөнхий сайдад баярлалаа.

3 сая төгрөгийн цалинтай дарга хулгай хийнэ л гээд зарлаад байгаа. Тэгтэл энэ талбай дээр чинь 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй улсууд тэтгэвэр нэмээд өгөөч л гэж байгаа юм.

1.2 саяас 1.5 сая байхад эд нар хуримтлал үүсгэхгүй юм гэхэд нэг өрөнд орчихгүйхэн шиг амьдрах боломж байгаа. Төрийн албан хаагч нарын цалин бас яг адилхан. Багш, эмч болон бусад төрийн албан хаагчид.

Тэгэхээр урсгал зардал дээрээсээ шаардлагагүй зардлуудаа танаад эдгээр улсуудынхаа цалин тэтгэврийг нэмэхэд анхаарч өгөөч ээ л гэж та нараас хүсээд байгаа юм.

Тэгээд ордны гадна талд нэг эмэгтэй 807 хоног ирж жагсаж байгаа. Энэ Хөдөө аж ахуйн сайд нь солигдоод явдаг. Төрийн нарийн нь үлдээд байдаг. Энэ дээр Хөдөө аж ахуйн сайдаас нэг тодруулга авмаар байна.

Тэгээд дараад нь дахиад тодруулъя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд эхлээд хариулна.

Г.Занданшатар: Даваагийн Ганболд гишүүн ингэж мушгиж болохгүй.

Төрийн өмчит компаниудын үр ашгийг сайжруулахын тулд. Да.Цогтбаатар гишүүн. Уучлаарай. Даваагийн Цогтбаатар гишүүн.

Одоо энэ компанийн захирлуудын цалинг бууруулж 3 сая төгрөг болгосон. 7 сая, 10 сая төгрөгийн цалин аваад байгаа учраас. Үр ашгаар нь цалинжуулна. Ашигтай ажиллуулаад. Саяын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлээд, үр ашгаа багасгаад, авлига, хээл хахуультай тэмцээд байвал үр дүнгийн урамшуулал цалин тооцно гэж. Компанийн захирлуудын мөнгөний асуудал ярьж байгаа шүү.

Энэ дээр санал нэгдэхгүй янз бүрийн юм ярьсан улсуудад хариуцлага тооцсон. Ингэж энэ төрийн өмчит компаниудын үр ашгийг сайжруулах бодлогыг, өндөр цалинтай зүгээр сул суугаад байдаг биш. Ингэж байж энэ төсөвт чинь орж ирж байгаа тэр 548 тэрбум төгрөгийн ногдол ашгийг нэмэгдүүлж байгаа. Ингэж байж бид компаниудын үр ашиг, ашигт ажиллагааг сайжруулж байгаа. Ингэж байж бид эдийн засгийн уналтын үед төсвийн орлогоо нэмэгдүүлж, зардлаа хязгаарлаж, ирэх жилээс эдийн засгийн том өсөлтийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж микрофон өгье.

Г.Занданшатар: Ийм учраас Үндэсний баялгийн санг арвижуулах зорилгоор ч гэсэн бид 1763 лицензийн тооллого хийж, хэний ямар хамааралтайг шалгаж байгаа.

Ухаахудаг, “Энержи Ресурс”-ээс авхуулаад бүх орд газруудад шаардлага өгөөд үндэсний баялгийн санг арвижуулах цогц хөтөлбөр хэрэгжүүлж байгаа.

Энэ хүрээндээ шаардлагын дагуу “Энержи Ресурс” компани гэхэд шаардлага хүлээж аваад яриа хэлэлцээ эхлүүлсэн байгаа. Ингэж бид үндэсний баялгийн сангаа арвижуулж, ингэж байж иргэдийн тэтгэвэр, тэтгэмж боловсрол, эдийн засгаа дээшлүүлэх, шинэ хөрөнгө оруулалтын шинэ орчныг бүрдүүлсэн, орон сууцжуулалтыг дэмжсэн цогц хөтөлбөрийг хийхээр Улсын Их Хурлын тогтоолд дагаад өргөн барьсан байгаа.

Ингэж байж зөвхөн ганц, хоёр орд газар биш. 1763 лицензийн тооллого хийгдэж байна. Шалгалт явагдаж байна. Стратегийн бүх орд газруудтай шаардлага тавиад хэлцэл хийгдэж байна. Энэ дотроо Эрдэнэтийн үүсмэл 3 орд, мөн “Энержи Ресурс”, “Ухаахудаг”... /минут дуусав/

Х.Булгантуяа: Хөдөө аж ахуйн сайд нэмж хариулъя. Да.Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. 2019 онд та Үндэсний баялгийн санг анх санаачилж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулсан. Таны санаачилга бодит ажил болгохын төлөө юу хийж байна аа?

Тэгээд Төгрөг нуур, Цайртын ордуудыг авлаа гээд байгаа. Бусад ордуудаа яах талаар. Одоо энэ Ухаахудаг ч гэдэг юм уу энэ дээр та нэмэлт тодруулга хэлээч.

Сая та баахан ордууд ярилаа. Үндэсний баялгийн санг ярьчихлаа. Энэ дээр.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Үндэсний баялгийн сангийн үзэл санааг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бид өөрсдөө боловсруулж яг бичсэн хүмүүс. Тэр үед зөвлөлдөх ардчиллаар, зөвлөлдөх санал асуулгаар ард иргэдтэйгээ зөвлөлдөхөд дандаа дарга нарын эрх мэдэл, сандал, ширээ хуваарилсан асуудал яригдаад байна. Ард түмэнд ямар өгөөжтэй байх юм бэ. Энэ орлогын ялгаа, тэгш бус байдал чинь галзуурлаа. Энэ уул уурхайн баялгаасаа ард түмэнд өгөөжтэй байх ямар үзэл санаа байна гэдэг асуудал ард иргэдийн зүгээс тавиад зөвлөлдөх ардчиллаар.

Ингээд энэ Үндэсний баялгийн сангийн үзэл санааг анх боловсруулж, энэ н.Сүндэрьяа, энэ О.Батнайрамдал гишүүн боловсруулсан төсөл дээр нэмж ажилласан.

Ингээд бид 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ санааг оруулсан юм. Үндсэн хуулийн 6.2-т нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. Үүний дагуу Үндэсний баялгийн сангийн хуулийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж 2019 онд хуульчилсан юм.

Харамсалтай нь, 4, 5 жил энэ хууль хэрэгжээгүй. Бид хууль болгон дээр, чуулган болгон дээр нэхэж шаарддаг байсан. Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилт... /минут дуусав/

Х.Булгантуяа: Тэгье. Ерөнхий сайдын микрофоныг.

Г.Занданшатар: Ингээд 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлаад. Энэ дотроо үүсмэл орд энэ тэр байхгүй байхад оруулаад. Ингээд энэ 34 хувь стратегийн орд газрууд, төрийн өмчийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн бол 34 хувийг авна гэдэг үзэл санааг чинь Улсын Их Хурлаас нэмж оруулж ирсэн юм.

Ингээд үүнийгээ тууштай хэрэгжүүлэх ажил эхлүүлсэн. 6 дугаар сарын 20-ны өдөр ажил аваад л Засгийн газар анхны хуралдаанаараа С.Бямбацогт сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан.

Хууль хяналтын байгууллагууд дээр шалгуулах асуудлыг Л.Мөнхбаатар сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан.

Ингээд энэ Үндэсний баялгийн санг арвижуулах хөтөлбөр төлөвлөгөөтэй бүх газартай яриа хэлэлцээ эхлүүлсэн. Одоо яриа хэлэлцээ явж байгаа. Түрүүчээсээ Төгрөг нуурын ордыг авсан. Цайртын минералын ордыг авсан. Ингээд дэс дараатай хэрэгжинэ.

Ингэж бид 34 хувь уу, тусгай АМНАТ уу, баялгийн татвартай болох уу гэдэг ийм асуудал ярьж байгаа.

Энэ 34 хувь Оюу Толгойн жишээн дээр харахад зээлийн хүүгээр ч юм уу, дундаас нь хүүлээд, зардлаа нэмэгдүүлээд, ашиггүй ажиллаад 34 хувиасаа ашиг оролддаггүй болдог ийм буруу туршлага байгаа учраас баялгийн татварт шинээр тогтоох асуудлыг бид бас Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэж байна.

Эцсийн дүндээ энэ асуудлыг нээлттэй Их Хурлын гишүүдээр шийдүүлнэ. Бид энэ бүх асуудал хэлцлийг хийгээд Улсын Их Хуралд оруулж ирж энэ 126 гишүүн “Баялагтаа эзэн Монгол” байх энэ хөтөлбөр үзэл санаа, Үндэсний баялгийн сангийн асуудлыг шийдвэрлэнэ.

Яагаад гэвэл энэ стратегийн ордын асуудлууд учраас. Бид чанга ярьж биш, харин бидний хийсэн ажлын үр дүн чанга дуугараасай гэж бид бага ярьж, их хийх зарчмаар ажиллаж байгаа.

Энэ хоёр сарын хугацаанд Оюутын шинэ ордыг нээсэн. Гангийн, зэсийн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах бүх бэлтгэлийг, одоо тендер зарлах бүх бэлтгэлүүдийг хангалаа. Ажлууд урагштай сайн явж байгаа.

Ийм учраас уул уурхайн баялаг төдийгүй 2028 оноос 2032 онд Монголын эдийн засаг даблдах, хүнд наалдацтай өсөлт хийх, “Чанартай өсөлт, хүний хөгжил” гэдэг энэ зарчмыг бид боловсруулаад Улсын Их Хуралд 5 жилийн үндсэн чиглэл болгож оруулж ирэхээр бүх юм бэлтгэл ханган ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд хариулах юм уу? Төрийн албаны зөвлөл, Ерөнхий аудитор хоёр. 4 номерын микрофон. Ажлын хэсгийн.

Л.Цэдэвсүрэн: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөл. Л.Цэдэвсүрэн. Төрийн албаны зөвлөлөөс 2024 онд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг болон 2025 оны нийт гүйцэтгэлийн дүнгээр бид 1100 гаруй байгууллагад 15 мянган төрийн албан хаагчийг хамруулаад шалгалт хийсэн.

2024 онд энэ шалгалтын дүн 639 зөрчил, дутагдал илэрснээс өнөөдрийн байдлаар 98 хувийн гүйцэтгэлтэй байгаа.

Яг таны асуугаад байгаа Баянхонгор аймаг дээр тухайлсан 7 зөрчил өнгөрсөн долоо хоногт арилсан байгаа.

Ер нь нийт 16 яам, 7 аймаг, нэр бүхий агентлагууд дээр нэлээн их зөрчлүүд гарсан. Бүгд 98 хувийн гүйцэтгэлтэй харилцсан байна.

2025 онд манай байгууллагаас хийсэн хяналт шалгалт дээр 166 зөрчил илэрсэн. Үүний биелэлтийн хугацаатай өгсөн үүрэг даалгавар 10 сарын 01-нд гүйцэтгэлийн тайлан гарна. Үүний дараа асуудлууд үүснэ. 2025 оны гол зөрчил дутагдал аймаг... /минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж өгье.

Л.Цэдэвсүрэн: Аймаг гэдгээсээ илүүтэй улсын хэмжээний нийт сум, зарим агентлаг, яамд дээр хийсэн шалгалтын дүн учраас бидний биелэлтийн хугацаа жоохон хожуу байгаа гэдгийг гишүүн ойлгох байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: 4 номерын ажлын хэсгийн микрофон. Аудитаас гэсэн. Тийм ээ. Да.Цогтбаатар гишүүн ээ. Аудит. Үндэсний аудитын газрынхан чинь байхгүй байгаа юм уу? Аан?

Харин тийм. Та хэд төсөвтэй холбоотой яг энэ танилцуулгын хэсэг дээр гишүүд онцгой ач холбогдол өгч асууж байхад ажлын хэсгийнхэн гуравхан хоног тогтвор суурьшилтай суугаад, сайн бичиж аваад нэг ажил хэрэгчээр хариулчхаач.

Яах вэ, энэ хүмүүс ойлгохгүй байгаадаа биш шүү дээ. Олон нийт үүнийг асуугаад өгөөч гээд зарим асуултуудыг тавьдаг байхгүй юу. Гишүүдэд. Тойргоос нь, салбараас нь.

2024 оны төсвийн гүйцэтгэлийг сая хаврын чуулганаар оруулж хэлэлцүүлсэн. Үүнтэй холбоотой зөрчил дутагдлуудтай авсан арга хэмжээний тухай асуусан. Да.Цогтбаатар гишүүн. 3 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Ц.Наранчимэг.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн. Бүх төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргасан алдаа зөрчлийн талаарх мэдээллийг Да.Цогтбаатар гишүүнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын гарын үсэгтэй албан тоотоор хүргүүлсэн байгаа. Зөвлөх рүү чинь мөн цахим шуудан хаягаар хүргүүлсэн.

Төрийн аудитын тухай хуулиар бид 9 дүгээр сарын 30-ны дотор бүх төсвийн ерөнхийлөн захирагч буюу Монгол Улсын Засгийн газар өмнөх

аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр тайланд тусгасан.

Манай байгууллага 9 сарын 01-нээс завсрын аудитыг хийж байгаа. Санхүүгийн тайлангийн аудитаар завсрын аудитыг бүх шатны төсөв захирагч нарт эхлүүлсэн байгаа.

Энэ аудитаар бид өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгасан энэ зөвлөмжийнхөө хэрэгжилтийн давтан аудитыг хийгээд дүнгийн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Засгийн газарт нэг хүсэлт, шаардлага байна. Ерөнхий сайд аа.

Сая 7 сарын 07-ны өдөр Ерөнхий сайд аа, аягүй чухал хууль баталсан юм. Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулаад, мянган өрх тутамд баригдаж байгаа хотхон, хороолол заавал улсын сургуультай байна гэсэн ийм заалт батлагдсан байхгүй юу.

Гэтэл энэ хууль хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа. Одоо энэ Яармагийн дэнж, Нисэхийн дэнжээр дүүрэн том том 2, 3 мянган айлын хотхонууд огт сургуульгүй баригдаж байгаа. Тиймээс таныг Ерөнхий сайдын албан даалгавар гаргаж энэ хуулийн хэрэгжилтийг хангаач гэж хүсэж байгаа юм. Одоо энэ Барилга, хот байгуулалтын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартайгаа мониторинг хийж энэ хуулийн хэрэгжилт дээрээс онцгой анхаарч өгөхийг хүсэж байгаа юм.

Яагаад гэх юм бол одоо ерөөсөө баригдаж байгаа байшингууд бүгдээрээ сургуульгүй. Тэгээд хаана орох нь бүү мэд. Хүүхдүүд. Одоо тэнд сонгодог жишээ нь Солонго-1, 2 гэж хороолол байгаа шүү дээ. Засгийн газраас санхүүжүүлж байгаа. Ганцхан сургуультай. 5 мянган айлтай.

Тэгээд энэ жил тэнд нэг сургууль тавихаар Ж.Батсуурь сайд бид хоёр уг нь хөөцөлдөж байсан. Тэр тавигдсан уу, яасан. Үүнийг нэгд асууя гэж байгаа юм.

Хоёрдугаарт, яамдын тоног төхөөрөмж гээд 500 орчим тэрбум төгрөг байна. Боловсролын яам, эрүүл мэндийн салбарыг ойлгож байна. Бусад төрийн яамд чинь яасан тоноглогдож дуусдаггүй юм бэ? Энэ зардал дээр хэмнэлт хийх бололцоо байсан уу, байгаагүй юу.

Одоо Гадаад хэргийн сайд байна. Уучлаарай. Ганц зүйл асуучихъя. Танай яаманд чинь 20 тэрбум төгрөгөөр тоног төхөөрөмж авна гэсэн. Энэ юу юм бэ? Ямар их үнэтэй тоног төхөөрөмж танайх авах гэж байгаа юм бэ? Үүнийгээ зүгээр би сонирхож асууж байгаа шүү. Хариулаад өгөөч ээ гэж хүсэж байна.

Гуравдугаарт, Ерөнхий сайд аа, таны дэвшүүлж байгаа орон сууцын банктai би зарчмын өөр саналтай байна. Би хуучин орон сууцын салбарт ажиллаж байсан хүний хувьд. Одоо байгаа Төрийн банкаа орон сууцын банк болгооч. Дахиж Төрийн банк байгуулж яах юм бэ? Төр ер нь хажуудаа арилжааны банктai байж яах юм бэ?

Тийм учраас дахиад нэг төрийн өмчийн банк байгуулагдах юм бол ахиад нэг тийм дарга, цэргийн асуудал үүснэ. Тэгээд төрийн нөлөө орно.

Тийм учраас одоо байгаа Төрийн банкаа болж өгвөл бүтцийн өөрчлөлт хийгээд орон сууцны банк болгож болохгүй юу? Тэгвэл маш том хэмнэлт болоод бусад зүйл үүсэх юм байна гэж би харж байгаа юм. Ийм зүйлүүдийг асуух гэсэн юм.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд түрүүлээд хариулна.

Г.Занданшатар: Ж.Алдаржавхлан гишүүн их чухал асуудал хөндлөө.

Ер нь анхнаасаа Улаанбаатар хотын төлөвлөлтгүй газар олголт өнөөдрийн энэ түгжрэлийн нэг шалтгаан. Бас сургууль, цэцэрлэг газаргүй. Одоо Хан-Уул дүүрэгт гэхэд сургуульгүй олон хороод байж байна. Улаанбаатарт ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ хүнд байгаа. Нийтдээ 53 хороонд ямар ч сургууль байхгүй байгаа. 73 хороонд төрийн өмчийн сургууль байхгүй байгаа.

Үүнээс болоод ээлжийн коэффициент Улаанбаатар хотод 16.1 хувь болсон.

Тэгэхээр таны санаачилсан нөгөө хот болох санаачилгыг би хотын даргад тавиад байгаа. Дүүргүүдийг хотод хуваарилах. Дүүргүүд нь тэр газар олголтоо төлөвлөгөөтэйгөөр баригдаж байгаа хороолол болгондоо зайлшгүй шаардлага тавьж, сургуультай байх, сургуулийн газрыг нь шийдэж байх зарчмуудыг.

Одоо манай Г.Лувсанжамц гишүүний тэр “Дулаанбаатар” санаачилга байна. Энэ чиглэлээр та хэд хамтарч ажилламаар байна. Ер нь орон сууцжуулалтын банк бол Төрийн банк 100 хувь байхгүй байх юм. Арилжааны банкуудын оролцоотой. 50 хувь нь арилжааны банк нь. Олон улсын байгууллагуудын оролцоотой TRILATERAL буюу гурван талт хяналттай механизм байхгүй бол Төрийн банкны яг менежмент, зохион байгуулалтад нийцэхгүй байгаа.

Бид Төрийн банкныг болгоё гэж үзсэн. Судаллаа. Одоо байгаа зээл олголт, хөдөө орон нутагт олгож байгаа зээл, “Хоршооны зээл”, “Малчны зээл”-ээс авхуулаад энэ бүтэц нь өөр болоод явсан учраас RESTRUCTURING буюу өөрчлөлт хийхэд илүү их зардалтай хүнд болсон юм билээ.

Тэгэхээр энэ бол бөөний банк буюу арилжааны банкуудаараа дамжуулан зээл олгодог, мөнгө босгодог CARBON CREDIT гээд хямдхан хүүтэй, ногоон зээл босгодог. Яагаад гэвэл гэр хорооллын яндан бууруулж, хүлэмжийн хийтэй болж байгаа. Ийм системийн банкны ерөнхий төсөл гараад бид боловсруулаад явж байна. Саяын үржүүлэгчийн коэффициентээр. Одоо МИК гэхэд жишээлбэл хувийн банк, байгууллага зээл аваад ипотекийн зээл санхүүжүүлээд болж байхад Засгийн газрын баталгаатай бол энэ илүү их бололцоотой болно.

Энэ бол олон улсын судалгаа, олон улсын байгууллагуудтай, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, олон талт судалгааны үр дүн дээр, Солонгосын талтай ч гэсэн судалгааны үр дүн дээр энэ бол ийм шинэ систем, механизм бүрдүүлж зөвхөн ипотекийн зээл биш, энэ маань нийлүүлэлт талаа санхүүжүүлэхгүй бол одоо орон сууцын үнэ 15.9 хувиар өсөөд дандаа эрэлт талаа санхүүжилт, ипотекийн зээл талаа санхүүжүүлэхээр орлогод нийцсэн орон сууц баригдаж байгаа ямар ч чиглэл байхгүй. Ингэж байж Улаанбаатарын гэр хорооллоо орлогод нийцсэн хямд өртөгтэй, хүмүүсийн худалдан авах чадварт нийцсэн гэр хорооллын ийм орон сууцжуулах хөтөлбөрийг тусдаа боловсруулах талаар ажиллаж байгаа. Энэ талаар Э.Бат-Амгалан сайд ажиллаж байгаа. Та хоёр бас хамтарч ажиллаад, нийслэлээс сонгогдсон гишүүд энэ дээр орон сууцжуулалтын хөтөлбөр, орон сууцжуулалтын банкн дээр хамтран ажиллахыг хүсэж уриалж байна. Манай Э.Бат-Амгалан сайд энэ талаар тодорхой нэмж хөтөлбөр, санхүүжилт, системийн талаар танилцуулах байх.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд. Тэгээд Э.Бат-Амгалан сайд.

Б.Жавхлан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Тоног төхөөрөмж ер нь дуусахгүй юм билээ. Шаардлага нь ч байгаа. Харин зохистой хэмжээг нь л барих ёстой.

Тухайлбал, 2026 оны төсөв дээр төсвийн ерөнхийлөн захирагч нараас нийтдээ 3.4 их наяд төгрөгийн тоног төхөөрөмжийн санал ирсэн юм. Эндээс 482.0 тэрбум төгрөг нь төсөвт багтаж орсон байгаа.

Хамгийн өндөр нь “COP17”-д зориулагдсан тоног төхөөрөмж. 67 тэрбум төгрөгийнх. Гэхдээ энд нэг онцлог байгаа. COP дуусна. Маргаашаас нь энэ тоног төхөөрөмжид ингээд яг салбар салбаруудынхаа хэрэгцээ хэрэгцээгээ дагаад шингээгээд явах юм. Жишээ нь, хамгаалалтад нь зориулагдаж байгаа шинэ тоног төхөөрөмжүүд бүгд энэ хуулийн байгууллагууд, цагдаагийн байгууллага руу очно. Автобуснууд явж байгаа. Тэр объект болгон тэр угсардаг мобайл зөөврийн том асрууд мөн яг өөр өөрсдийнхөө чиглэлээр. Ялангуяа онцгой байдлын... /минут дуусав/

Х.Булгантуяа: Э.Бат-Амгалан сайд. Тэгээд Б.Батцэцэг сайд.

Э.Бат-Амгалан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд Солонго гээд нэртэй төсөл хэрэгжиж байгаа. Нийт 66 блок, 5002 айлын орон сууцын төсөл явж байгаа. Анх төсөл эхлэхдээ сургууль, цэцэрлэггүй эхэлсэн.

Таны хэлсэн сая энэ хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлж байгаа.

Тэгээд энэ хүртэл хугацаанд энэ мянга орчим айлд нэг сургууль, 250 айл буюу 250 өрхөд нэг цэцэрлэг гээд ингээд хууль мөрдөөд явж байгаа. 2 сарын хугацаа л өнгөрч байна.

Үүний өмнө хийгдсэн маш олон алдаатай, төвлөрөл ихтэй, өнөөдрийн түгжрэлийн асуудал болсон энэ хотхон, байрууд өмнө нь маш олон баригдсан байгаа.

Би 1 минут нэмээд авчихъя.

Х.Булгантуяа: 1 минут нэмж өгье. Дэгээрээ ингэж байгаа шүү дээ. Хамгийн эхний хариулт нь. Тэгээд нэмээд нэг, нэг минут л байгаа.

Э.Бат-Амгалан: Солонго 5002 айлын төсөл дээр улсын төсвөөр гадна инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн барилга байгууламж, шугам хоолой бүгдийг нь барьсан байгаа.

Нийслэлд хандаж нийслэлийн төсвөөр 960 хүүхдийн 1 сургууль, 240 хүүхдийн 2 сургууль, хөгжлийн төв, сэргээн засах төв тус бүр бүр 1, төрийн үйлчилгээг анхан шатанд хүргэх нэгж буюу хорооны барилга нэгийг барихаар төлөвлөөд ажиллаж байгаа.

Сая Ерөнхий сайд хэлсэн. Энэ Орон сууцжуулалтын тухай хуулийг Засгийн газраас, тэр дундаа Барилга, хот байгуулалтын яамнаас энэ намрын чуулганд өргөн барихаар ажиллаж байна.

Мэдээж Ж.Алдаржавхлан гишүүн бид хоёр Нийслэлийн иргэдийн хуралд цуг сууж байсан. Энэ Улсын Их Хуралд цуг сууж байна. Энэ хотын зовлон жаргалыг маш сайн мэднэ.

Тийм учраас энэ ажлын хэсгүүдэд орж энэ Орон сууцжуулалтын тухай хууль дээр хамтарч ажиллана байх гэж итгэж байна.

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Гадаад харилцааны яам хилийн чанадад 50 дипломат төлөөлөгчийн газартай. Тэгээд автомашины парк шинэчлэлийн зардал байгаа юм.

Хилийн чанадад дипломат төлөөлөгчийн газруудад 17 автомашин тоног төхөөрөмжүүд худалдаж авахад 9.6 тэрбум төгрөг тусгасан. Бид өнгөрсөн 3 жилд үүнийг шинэчилж чадахгүй тэвчээд энэ жил тавьж оруулж байгаа.

Тэгээд гишүүдийгээ энэ төвд болон хилийн чанадад автомашин шинэчлэлд дэмжиж өгөхийг хүсэж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 7 сарын 04-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор хилийн чанад дахь авто машинуудыг актлах шийдвэр гараад акталсан байгаа. Энэ нь тухайн орныхоо хууль дүрэмд нийцэхгүй, хуучирсан, ашиглах боломжгүй 17 автомашиныг зайлшгүй шинэчлэх шаардлага байгаа.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан сайд гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Э.Бат-Амгалан сайд аа, С.Бямбацогт сайд аа, хэдүүлээ нэг ийм ажил хиймээр байна. Ерөнхий сайд гараад явсан юм чинь. С.Бямбацогт сайд аа, тэр хууль хэрэгжээд эхэлсэн шүү дээ. Тийм ээ. Тэрийг хэрэгжүүлэхийн тулд тийм бүр мониторингийн ажил хиймээр байна.

Ялангуяа нийслэл хотод баригдаж байгаа, одоо эхэлж байгаа хотхон, хорооллуудыг сургуультай юу, үгүй юу гэдгийг очиж үзмээр байна.

Яг үнэндээ Яармагт маш том том 2, 3 мянган айлтай ямар ч сургуульгүй хотхон зөндөө эхэлж байна. Хуулиа хэдүүлээ хэрэгжүүлмээр байна.

Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нийслэлдээ үүрэг өгөөд, Барилгын яам хамтраад бүгдийг нь газар дээр нь очиж үзмээр байна. Тэгэхгүй бол сэмээрхэн бариад дуусна. Тэгээд сургууль байхгүй. Хүүхдүүд хаачих вэ. Ийм асуудал үүсээд байна.

Тийм учраас хуультай болсон юм чинь энэ дээр Засгийн газар маань нэг хүчтэйхэн хөдлөөд өгөөч ээ гэж би хүсэж байна.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн үг хэллээ. Тийм ээ. С.Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Ж.Алдаржавхлан гишүүний хэлж байгаа асуудал маш чухал, маш зөв асуудал. Олон жил бид үүнийг ярьдаг. Үр дүн гардаггүй. Яаж ийгээд л сургууль, цэцэрлэггүй хотхон, хороолол барьдаг байсан. Үүнийг өөрчлөөд хуулийг Ж.Алдаржавхлан гишүүн тэргүүтэй гишүүд санаачлаад өнөөдөр батлагдсан байгаа.

Тэгээд хуулийг хэрэгжүүлэх үүрэг Засгийн газарт ногддог. Засгийн газар энэ үүргээ биелүүлнэ. Энэ тал дээр хотын захиргаатай, Улаанбаатар хотын даргатай хамтарч ажиллана. Энд барилга эхлэх зөвшөөрөл, “А” даалгавар өгөхөөс авхуулаад барилгын барьж байх явцад нь хяналт тавих, хүлээж авах гээд энэ бүх процесс Барилга, хот байгуулалтын яам хяналт тавьж байгаа.

Хуучин мэргэжлийн хяналтын тодорхой чиг, барилга угсралттай холбоотой чиг үүрэг Барилга, хот байгуулалтын яаманд ирсэн. Энэ тал дээр тэгээд Барилга, хот байгуулалтын яам, Улаанбаатар хотын захиргаатай хамтраад бид бүхэн яг таны хэлсэн саналын дагуу хамтарч ажиллая.

Тэгээд тодорхой үр дүн гаргана. Энэ гарах ёстой ажил.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайхан.

Т.Мөнхсайхан: Ирэх оны төсөв хүний хөгжлийг дэмжих, боловсрол, эрүүл мэндийг дэмжиж байгаа гээд байгаа.

Эрүүл мэндийг дэмжиж байгаа төсөв харагдахгүй л байгаа. 2026 онд ер нь эрүүл мэндийн салбар энэ төсвөөр ер нь дэмжих биш дампуурах тийм маягтай л харагдаад байгаа.

Тийм учраас 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгож эртхэн засгийн хурлаар орж томоохон шаардлагатай тооцоо, судалгаануудыг хийх ийм байдлыг бий болгож болох уу гэдэг зүйлийг Ерөнхий сайдаас асуумаар байна.

Одоо энэ оны хувьд төсөв эрүүл мэндийн салбарт хүндэрсэн. Тодотголоор 47.0 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалынсанд төвлөрөх төсвөөс хасагдсан.

Ингээд бид өнгөрсөн жилүүдэд үүссэн байсан 300 гаруй тэрбумын өр, авлагыг барагдуулсан боловч өнөөдрийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөс хуваарилаад хувийн хэвшлүүдэд хуваарилдаг төсвийг өнгөрсөн оныхоос 40 орчим хувиар багасгаж, 163 тэрбум болгосон. Тэгсэн боловч өнөөдрийн байдлаар энэ төсвийг 9 сарын байдлаар хувийн хэвшлүүдэд олгоод дууссан. Дахиад хувийн хэвшлүүдэд төсөв хуваарилах асуудал яригдаад.

Ингээд улсын эмнэлгүүд нь хүндрэх энэ нөхцөл байдал үүсээд байна. Одоо 11 сар гэхэд эрүүл мэндийн салбарын санхүүжилт хүнд байдалд орж, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнүүд иргэдэд төлбөртэй хүргэх үү, үгүй юу гэдэг асуудал яригдана.

Тэгээд энэ нөхцөл байдлаараа он давахад 300 орчим тэрбум төгрөгийн өглөгтэйгөөр Эрүүл мэндийн даатгалынсан он давахаар байна.

Тэгээд ирэх оны төсвөөс энэ өглөгөө мэдээж барагдуулж таараа. Ингээд үзэхээр ирэх оны төсөв энэ оныхоос 20 тэрбумаар хасагдсан гэдэг чинь өөрөө яагаад ч хүрэлцэхгүй ийм хэмжээний төсөв болоод байна.

Хөрөнгө оруулалтыг 3.5 дахин нэмэгдүүлсэн гэж байгаа юм. Одоо манай салбарт үүсэж байгаа нөхцөл байдал чинь энэ барилга, байшинг барих, энэ авах, тоног төхөөрөмж дээр ажиллах, энэ хүмүүсийн цалин мөнгө, энэ тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх мөнгө нь дутагдаад байгаа болохоос биш яг барилга, байгууламж барьж, тоног төхөөрөмж авснаараа өнөөдрийн эрүүл мэндийн салбарт үүсээд байгаа нөхцөл сайжрахгүй.

Тийм учраас ирэх оны төсвийг, эрүүл мэндийн салбарт тавигдаж байгаа төсвийг нэмэгдүүлмээр байна.

Өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбарын төсөв нэмэгдсэн л гэж байгаа юм. 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь байсан. 3.1 хувь байсан. Өнөөдөр 2026 оны төсөв дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 3 хувиас доош орохоор байгаа.

Олон улсдаа энэ чинь батлагдсан тоо баримт шүү дээ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 6 хувиас дээш байж эрүүл мэндийн салбарынх нь асуудал шийдэгддэг гэж.

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд хариулах уу?

Ж.Чинбүрэн: Ерөнхий сайдад хүсэлт тавьж байна 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгоё гэж. Үүнийг Ерөнхий сайд өөрөө хариулах байх.

Ер нь Засгийн газраас, Эрүүл мэндийн яамнаас мэдээж тухайн салбарын жил болгох хүсэл байлгүй яах вэ. Энэ том ажил болно.

Та тэгж байна. Өр барагдуулсан боловч гээд. Ер нь даатгалын тогтолцоо, реформ бид хийгээд 2021 оноос хойш нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд бид том реформоо хийхдээ хяналттай, алдаа мадаггүй, зөв явах тогтолцоогоо хийж чадалгүй баахан нэхэмжлэлийг хянах боломжгүйгээр баахан гүйцэтгэлээр гаргаад, эмнэлгүүдийг гүйцэтгэлийн уралдаанд уриалсан нь өөрөө энэ тогтолцооны том алдаа болсон.

Чанарт суурилсан үр дүнгийн санхүүжилтийг нэхэмжлэлийг нь хянах ийм тогтолцоог хийж чадсансан бол өнөөдөр ийм байдал үүсээд та 2025 оны зарцуулах ёстой байсан даатгалын сангийн 316.0 тэрбум төгрөгийг 2024 оны урьд өгөхгүй байх байсан. Ийм боломж байсан.

Тэгэхээр бид энэ тогтолцоогоо илүү хяналттай, зөв байлгах тал дээр ажиллах хөтөлбөрийг 2026 оны төсөвтэй хамт Сангийн яамтай бид баг гаргаад

энэ хөтөлбөрөө 2026 онд 2025-2028 онд Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо жинхэнэ институт шиг биеэ даасан корпоратив байдлаар ажиллах боломжтой. Хэн нэгэн сайдаас хамаардаг биш. Хэн нэг улс төрчөөс хамаараад сан дампуурдаг биш ийм тогтолцоо руу орох хөтөлбөр 3 жилийн хугацаатай хийгээд тавьсан байгаа.

Би бас таныг энэ дээр санал бодлоо өгөөсэй гэж бодож байна. 3 жилийн хөтөлбөр байна. Би танд өгье. Төсөвтэй хамт өгсөн.

Ингээд бид 2028 онд Эрүүл мэндийн даатгалын сан жинхэнэ утгаараа даадаг.

- Өвчтөн,
- эмнэлэг,
- даатгал

гэсэн гурван хэлхээс жинхэнэ утгаараа ажилладаг ийм тогтолцоо руу орохыг зорьж байгаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэх хүсэлтэй байна. Улс төр, геополитик хөнжлийн хэрээрээ хөлөө жийх энэ бодлого чухал. Би бол харин эсрэгээр өнөөдөр бид хөрөнгө оруулалтыг 5.5 дахин нэмсэн бол том амжилт гэж харж байгаа.

Өнөөдөр бидний 2024 онд нийтдээ 18 мянга 200 хүн Монгол Улсад нас барсан. 70 хувь нь эмнэлэг дотор биш гадуур нас барсан. Эрдэмтэн, судлаачид 6 мянгыг нь аврах боломжтой байсан гэсэн дүгнэлт гаргасан байна.

Тэгвэл өнөөдөр бид 2026 оны төсөвтөө хөрөнгө оруулалтаа аймаг болгон дээр, Монгол Улсынхаа өнцөг булан бүр дээр харвасан, шигдээс болсон, гэмтэл осолд орсон бүх улсуудыг авардаг яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тогтолцоо хийхээ зорьж байгаа. Би үүнийг буруу гэж бодохгүй байна. Энэ зөв гэж бодож байна. Хүндээ хүрнэ гэж бодож байгаа.

Дээрээс нь, бид тулгамдаж байгаа том асуудал бол бид нэгэнт хөрөнгө оруулалтаар буюу гүйцэтгэлээр нь санхүүжилт өгөөд, тухайн эмнэлгүүд тоног төхөөрөмжөө шинэчилж чадахгүйгээс хойш бид тоног төхөөрөмжийг нь шинэчлэх, хүний нөөцийг бэлдэх, дутуу барилга, байшин, шинэ технологиудыг суурилуулахад зорих ёстой.

Өнөөдөр бид хамгийн сүүлд гарсан шинэ утсуудыг Та гартаа бариад, бид бүгдээрээ бариад сууж чадаж байгаа. Тэгсэн хэрнээ эрүүл мэндийн салбарт байгаа шинэ технологиуд гараад ирэхэд монгол хүн хамгийн сүүлд тэр технологийг хүртдэг байх нь өөрөө гутамшиг. Үүнийг арилгахын төлөө хөрөнгө оруулалтууд явна.

Тийм учраас та энэ дээр эргэлзэхгүй байж болно.

Х.Булгантуяа: Т.Мөнхсайхан гишүүн нэмж тодруулъя.

Т.Мөнхсайхан: Би энэ хөрөнгө оруулалтуудыг буруу гээгүй шүү. Ж.Чинбүрэн сайд аа. Энэ маш зөв.

Хамгийн гол нь өнөөдөр манай салбарын тулгамдаж байгаа асуудал энэ хөрөнгө оруулалт дээр чинь ажиллах хүний нөөц, тусламж, үйлчилгээгээ үзүүлэх санхүүжилт чинь асуудалд ороод байна шүү дээ.

Одоо 11 сард тусламж, үйлчилгээний санхүүжилт хүрэхгүй болохоор иргэдийн нуруун дээр, даатгуулагчдын нуруун дээр ачаалал ирэх гээд байна. Үүнийг та яаж шийдэх гэж байна аа?

Ирэх онд энэ жилийнхээ өр төлбөрийг барагдуулахаар ирэх жил үүнээс илүү хүнд нөхцөл байдалд орох гээд байна. Энэ асуудлыг яаж шийдэх гэж байна? Үүнийгээ шийдсэн төсөв оруулж ирэхгүй юм уу? Бид үүнийг ирэх жил шийдэхгүй бол 2027 онд энэ бүгдийг цогцоор нь шийдээд “Эрүүл мэндийн жил” болговол яадаг юм бэ гэдэг би энэ салбарынхаа хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх асуудлыг ярьж байгаа.

Түүнээс биш хөрөнгө оруулалтыг буруу гэж огтхон ч хэлээгүй. Гэхдээ яаралтай тусламж бол эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийг сайжруулах ёстой шүү. Тэр нь 80 хувийн эрсдэлийг дагаад байгаа юм. Түүн дээр та санал бодлоо хэл.

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Чухал сэдэв л дээ. Т.Мөнхсайхан гишүүн ээ.

Одоо үндсэндээ улсын эмнэлгүүд ар гэрт нь эм тариа захиад эхэлсэн. Өнөөдөр улсын эмнэлэгт очоод хүн эмнэлэгт хэвтэхэд бүх эм тариагаа гэрээсээ зөөж байгаа шүү дээ.

Буцаад бидний нөгөө сайжруулсан тогтолцоо байхгүй болчихоод өнөөдөр ийм байдалтай.

Тэгээд хувийн эмнэлгүүд нь болохоор санхүүжилтээ 100 хувь авчихсан. Тэгээд очоод эмчлүүлсэн хүмүүс нь нэмэгдэл мөнгөө төлөөд, тэгээд ямар нэгэн эм тариа гэртээ захихгүйгээр эмчлүүлээд болоод байгаа. Энэ ялгавартай байдал нь өөрөө энэ даатгалын сангийн нөхцөл байдлыг хүндрүүлж байгаа юм.

Тэгэхээр одоо бид яаж байна вэ гэхээр хамтын төлбөрийн асуудлыг шийдэх гэж байна. Мөн төлбөртэй тусламж, үйлчилгээний инфляцтай уялдуулж

үнийн дүнг өсгөх асуудлыг ярьж байна. Үүнийг Засгийн газрын хуралд удахгүй оруулна.

Тэгээд Сангийн яамтай нийлээд хамтарсан сайдын тушаалаар энэ шийдвэр гарна.

Дээрээс нь бид шаардлагатай санхүүжилтийг юу юу байх вэ гэдгээ зөв зохицуулах ажлаар дөнгөж сая Даатгалын ерөнхий газрын даргыг сольж, арай санхүү мэдлэгтэй... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулна.

Г.Занданшатар: 2027 оныг Эрүүл мэндийг дэмжих жил болгохтой холбоотойгоор товчхон хариулт хэлье гэж бодож байна.

Тэгээд ер нь яах вэ, Монголын хоёр том эмч, хоёр сайд байхад би дундуур нь ороод юу гэх вэ гэж бодоод.

Тэгээд тэгээд хоёр сайд маань, хоёр Монголын бас нэртэй мэс заслын эмч нар хамтраад эрүүл мэндийн салбараа өөд нь татах талаар. Зөвхөн 2027 оныг биш энэ хүний хөгжлийн гол асуудал монгол хүний насжилтыг уртасгах, энэ эмчилгээ, оношилгооны хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой хөтөлбөр гаргаж ажиллахыг даалгавар болгосон байгаа.

Нэгдүгээрт, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо, хөтөлбөр, менежментийг сайжруулах шаардлагатай. Энэ бол засгийн ч мөнгө биш, төсвийн ч мөнгө биш, даатгуулагчийн мөнгө.

Тийм учраас гурван талт механизмтай.

Тэгэхээр энэ гурван талт механизмдаа зөвхөн эмнэлгүүдийн талд юм уу, аль эсвэл төсвийн талд байгаад биш нийт өвчтөнүүд иргэдийн эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулахад чиглүүлсэн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж минут өгье.

Г.Занданшатар: Нийт иргэдийг хамгаалах зорилттой нийгмийн халдварт өвчинтэй тэмцэх, монгол хүний насжилтыг богиносгож байгаа гол гол өвчнүүдтэй тэмцэхэд чиглэсэн тодорхой бодлого хөтөлбөр Эрүүл мэндийн яам боловсруулж хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Энэ дээр Улсын Их Хурал зүгээс ажлын хэсэг байгуулаад хамтарч ажиллавал. Нэн ялангуяа Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай асуудлаар хамтарч ажиллахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Алдагдалтай төсөв орж ирсэн.

Би угаасаа л алдагдалтай төсөв манай улс орны хувьд байхаас өөр гарцгүй. Алдагдалгүй төсөв манайх шиг дөнгөж хөгжиж байгаа ядуу улсад дэндүү их тансаглал юм гэдгийг хэлж байсан.

33 их наядын зарлагатай, 1.4 их наядын алдагдалтай.

Тэгээд яг энэ дотроо 178.0 тэрбум төгрөгийг багтаах орон зай үнэхээрийн байсангүй гэж үү гэдэгт л гайхаад байгаа юм. Тэтгэвэртээ гарч байгаа төрийн албан хаагчдын нэг удаагийн тэтгэмжийн асуудал. 36 сарын тэтгэмжийг 2026 онд 50 хувийг нь, 2027 онд 50 хувийг нь өгнө гэдэг асуудлыг оруулж ирснийг олон ч гишүүн асууж байна, олон ч төрийн албан хаагч санаа зовж байгаа.

Сангийн сайд үүн дээр санаа зоволтгүй ээ. Тэгж байгаад л ер нь болно шүү дээ. Өмнө нь ч гэсэн ингэж олгож байсан. 2027 онд өгнө байна шүү дээ гэдэг асуудлыг ярьж гэж байна.

Санаа зовохоос өөр арга байхгүй. Сүүлийн 3 сарын хугацаанд төрийн албан хаагчдын нийгмийн хамгаалалтай холбоотой 3 дахь удаагийн оролдлого орж ирж байна. Төсвийн тодотгол дээр төрийн албан хаагчдын яг энэ нийгмийн хамгаалалыг хуульчилсан асуудлыг буюу “9.2-ыг хүчингүй болгох” ийм санаархал орж ирж байсан. Үүнийг зогсоосон.

Дагасан тогтоол дээр нь яг энэ

- тэтгэмжтэй холбоотой,
- урамшуулалтай холбоотой,
- нэмэгдэл хөлстэй холбоотой

асуудлыг бас тэгшитгэх асуудал орж ирж байсан. Үүнийг ч гэсэн больсон.

Одоо ч гэсэн дахиад л энэ тэтгэмжтэй холбоотой асуудлыг 50 хувийг нь өгье, 50 хувийг нь дараа өгье гэдэг асуудлыг оруулж ирж байна.

Цэц дээр ч гэсэн энэ асуудал орсон байгаа. Хууль одоогоор яг ийм байгаа ч гэсэн дахиад өөрчлөх санаархлууд болон цэц дээр ямар асуудал яригдах вэ гэдэг нь асуултын тэмдэг үлдэж байна.

178.0 тэрбум төгрөгийг оруулсан бол энэ 24 хувьдаа багтаана гэдэг өөрчлөлт нь хэд байсан юм бэ? Миний тооцооллоор бараг зууны хэдэн хувь л байгаад байх юм.

Хоёр хууль зөрчиж байгаа. Ямар хууль зөрчиж байна вэ гэдгийг би Та бүхэнд хэлье. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд 6.4.8 төсвийг зохистой

удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй гэсэн ийм заалт байгаа буюу өглөг үүсгэх гээд байгаа биз дээ. Тийм ээ. Өр төлбөр дараа он руугаа шилжүүлэх гээд байна.

Төрийн албаны тухай хуулийн 9.2-т төрийн албаны зардлыг бууруулах нь өөрөө яг энэ төрийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөрийн хэмжээг бууруулах, түр буюу бүрмөсөн зохих үндэслэл болохгүй гээд заагаад өгсөн байгаа. Түр зогсоож байгаа хэлбэр мөнөөсөө мөн.

Өмнөх онтой харьцуулахад 111 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна гэж байгаа. Аргагүй шүү дээ. Төр өөрөө ийм дохио өгөөд байхаар хэзээ мөд өөрчлөгдөж магадгүй. Бушуухан шиг энэ төрөөс явах минь гэсэн ийм бодолтой л байгаа шүү дээ. Төрийн албан хаагчид. Өмнө яах вэ дахиад нэг жил ажиллая, за яах вэ гэдэг байсан бол ийм орчинтой, ийм дохио өгч байхад бушуухан гарч энэ 36 сарын тэтгэмжээ байгаа дээр нь авъя л гэсэн бодолтой байна шүү дээ.

Хүний амьдрал баялаг. Манай дундаж наслалт ямар байгаа билээ. Бүтэн жилийн хугацаанд үхэх эрхгүй гэсэн ийм л юм зааж байна шүү дээ. Хэцүү биз дээ. Хүний амьдрал баялаг. 36 сараар нь... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулах уу? Эхлээд. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Дахиад л хэлье дээ. Та санаа зоволтгүй. 2026 онд тэтгэвэрт гарах төрийн албан хаагч нарын нэг удаагийн тэтгэмжийг бүрэн тавина. Бүрэн тавина. Төр өөрөө ийм үүрэгтэй.

Тийм учраас санаа зовох зүйл байхгүй. Тэр 24 хувьд ганц энэ 178 биш байгаа юм. Нийлэхээрээ энэ чинь бараг 1 их наяд гаруй төгрөгийн хэмнэлт. Хэмнэлт юу байх вэ. Энд багтахгүй байгаа. Ганц энэ тоо биш шүү. Биш байхгүй юу. Та өөрөө ч сайн мэдэж байгаа. Үүнийг.

Дээрээс нь зөрөөд энд чинь 951.0 тэрбум төгрөгийн зайлшгүй статистик өсөлтөөр шууд автомат нэмэгдэж байгаа бас урсгал зардал байгаа юм. Тэрийг энэ 24 хувьдаа багтаах хэрэгтэй. Та маш сайн мэдэж байгаа. Жил болгон тэтгэврийн энэ татаасны дүн хэдээр нэмэгддэг билээ. Тэтгэвэр авагчдын тоо хэдээр нэмэгддэг билээ.

Дээрээс нь, тэтгэврийн 6 хувийн нэмэгдэл. Зөвхөн 6 хувийн нэмэгдэл нь 378.0 тэрбум байх жишээтэй. 951-ээр нэмэгдээд зөрөөд энэ 24 хувьдаа багтаана гэдэг чинь аягүй том тоо байхгүй юу. Аягүй том тоо. 24 их наяддаа биш. Буцаагаад хэмнэж байгаа тоон дотроо хэдэн хувь нь вэ гэж асуувал одоо энэ их чухал ач холбогдолтой харьцуулалт гарч ирнэ. Энэ чинь 1.5 их наядын зардал бид бууруулж байж, ноднингоос хойш бууруулж байж энэ 24 хувьдаа багтаагаад зөрүүлээд тэр нөгөө статистик өсөлтөөр автомат нэмэгдэж байгаа 950-ийгаа багтааж байж нөгөө 24 хувь чинь орж ирж байгаа байхгүй юу.

Тэгээд доороос нь бид маш их зардлаар шахаад байдаг. Дээрээс нь 24 хувьдаа багтаах ёстой шүү гээд. Ингээд дунд чинь ерөөсөө ийм бодлогын орон зай гэж ерөөсөө байхгүй болж ирж байгаа юм.

Бид ямар нэг байдлаар энэ өөрчлөлт хийхгүй бол цаашдаа энэ улам хязгаарлагдана. Ингээд л ерөөсөө 24 хувьдаа баригдаад л жил болгон автомат өсөлтөө яаж шингээх вэ гэдэг л нэг ийм л төсөв болж ирнэ. Юун төсвийн бодлого. Ийм харьцаа байгааг Та өөрөө сайд байсан хүн маш сайн мэдэж байгаа.

Тэгээд таны зовж байгаа асуудлыг ойлгож байна.

Тэгэхдээ ямар ч байсан санаа зоволтгүй. Хойтон хэдүүлээ болгоно.

Х.Булгантуяа: А.Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Хэдүүлээ Сангийн сайдынхаа санаа зоволтгүй гэдэг үгэнд цадаад яах вэ дээ.

Улсын Их Хурлын гишүүдээ би уриалж байна. Хэдүүлээ яг энэ 178.0 тэрбум төгрөгийг буцааж бүтнээр нь хуулийнхаа дагуу суулгаж тусгаж өгөх ёстой шүү. Энэ бол 24 хувийн хязгаарыг давахгүй. 24.01 хувь болж өгч байгаа учраас энэ дээр асуудалгүй хэдүүлээ төрийн албан хаагчдынхаа нэг амар санаа тайван тэтгэвэртээ гарах зохицуулалтыг нь хийж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Энэ дээр гишүүд бүгдээрээ дэмжих байх.

Нөгөө талдаа яг энэ хуулийн хоёр заалтыг зөрчсөн эсэхийг хэдүүлээ ярьж байгаад энэ төсөв дээр анхаарахгүй бол хууль зөрчсөн байгаа нь угаасаа тодорхой гарч ирэх юм бол үүнийг яаж шийдвэрлэх ёстой юм. Эргээд ийм зөрчилтэй төсвийг оруулж ирсэн Засгийн газар уу, эсвэл үүнийг хэлэлцэж батлах Улсын Их Хурал хариуцлага хүлээх үү гэдэг нь нэг асуудал болно.

Үүн дээр дахиад тэтгэвэртэй холбоотой. Би 1 минутаа нэмэлтээр авъя. Тэгэх үү? Сая Сангийн сайд тэтгэвэртэй холбоотой асуудал ярьсан учраас... /минут дуусав/

Х.Булгантуяа: А.Ариунзаяа гишүүний микрофон. 1 минут.

А.Ариунзаяа: Сая Сангийн сайд тэтгэвэртэй холбоотой асуудлыг ярьсан.

Бид нийгмийн даатгалын тэтгэврийг тусдаа шүү дээ. Энэ чинь шал өөр тусдаа ойлголт байхгүй юу. Тэтгэмжтэй огт хольж болохгүй. 36 сарын тэтгэмжтэй.

Тэтгэвэртэй холбоотой 6 хувийн нэмэгдлийг оруулж ирж байгаа. Яах вэ, салбар яамнаас 10 хувь гэж санал болгосон юм билээ. Сангийн яам яалт ч үгүй 6 хувьдаа барьж байгаа байх.

Цаашлаад энэ 6 хувийг бүгдийг нь адилтгаад 6 хувиар нэмэгдүүлнэ гэсэн хууль байхгүй шүү. Тэтгэврийн тухай хуулийн 27.1 дээр өмнөх оны инфляцийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ. 27.2 дээр энэхүү нэмэгдүүлэх аргачлалыг Засгийн газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналаар аргачлалыг батлах байгаа юм шүү.

Тэгэхээр яг энэ 6 хувьдаа багтаагаад хоорондын зохистой харьцааг нь хадгалаад, бага тэтгэврийг нь нэмэгдүүлэх, илүү өндөр тэтгэврийг нь бага зэргээр нэмэгдүүлэх зохистой харьцааг нь хадгалах аргачлалыг батлах эрх нь Засгийн газарт байгаа шүү. Үүнийгээ зөв оруулж Сангийн яам болоод одоо... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: А.Ариунзаяа гишүүний бүр саяын хэлж байгаа саналтай би огт санал нийлэхгүй байна.

Өчигдөр Ж.Баясгалан гишүүн бас асууж байсан. Өөр хэд хэдэн гишүүд асуугаад байгаа юм.

Энэ тэтгэврийг нэмэгдүүлэхдээ бага тэтгэвэр дээр өндөр хувиар, өндөр тэтгэвэр дээр нь бага хувиар гэдэг маш буруу. Маш буруу шүү. Өндөр тэтгэвэр авч байгаа улсууд чинь бүх насаараа өндөр шимтгэл төлсөн юм. Нийгмийнхээ хариуцлагын дагуу өөр өөрийнхөө төлөө. Тэгчхээд тэтгэвэрт гарсан хойноо дахиад торгуулж болохгүй шүү дээ. Өндөр шимтгэл төлснийхөө төлөө.

Тийм учраас энэ жигд 1 хувиар хувилж нэмэгдүүлэх нь хамгийн шударга байгаа юм.

Тэгэхээр ийм тогтолцоо руу л бид хэзээ ч явахгүй ээ. Энэ болохгүй.

Х.Булгантуяа: Яах вэ, тэгэхдээ Б.Жавхлан сайдын ярьж байгаа бас үнэн шүү. Тэтгэврийн зөрүү гэдэг чинь. Хэрвээ хүн болгоны тэтгэвэр адилхан байх юм бол хүн болгоноос авч байгаа нийгмийн даатгалын шимтгэл адилхан байх ёстой. 5 саяас ч 100 мянган төгрөг, саяас 100 мянган төгрөг, 2 саяас 100 мянган төгрөг авбал бүгдэд нь ижил тэтгэвэр өгөх нь зүй ёсны хэрэг. Энэ тогтолцоо нь угаасаа тийм. Дэлхий даяараа л тийм байдаг.

Тэтгэвэр халамж биш. Энэ бол би тэтгэвэрт гарах нь тодорхой. Амьдралын жамаар ахмад настан болох нь тодорхой. Тэр үедээ би авч хэрэглэх мөнгөө төрд уг нь хадгалуулж байгаа юм. Хамгийн гол нь хийх ёстой зүйл нь

Б.Жавхлан сайд аа. Энэ нэмэгдэж байгаа хувь хэмжээ дээрээ л байгаад байгаа юм.

Түүнээс биш ирэх жил одоо инфляц 8.8 хувьтай байна шүү дээ. Одоо 8.8 хувь. Ирэх жил 10 хувь болох юм бол наад 6 хувь чинь ахиад инфляцдаа идэгдээд эсрэгээрээ өөрсдийнх нь өсөлт нь бараг хасах руу орох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүн дээрээ л санаа зовоод байгаа юм.

Тэгээд манай Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс ч гэсэндээ би түрүүн хэлж байсан юм. Та бүхэн инфляц дээрээ ажиллаач ээ.

Энэ бол яг хүн болгоноос авч байгаа татвар. Цалингаас ч, тэтгэврээс ч, халамжаас ч, бараа бүтээгдэхүүнээс гэсэн бүгд дээр нь нэмж авч байгаа татвартай агаар нэг байхгүй юу.

Тэгэхээр үүн дээрээ л манай ахмадууд бухимдаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, зүгээр явж байсан тэтгэврийн зээлийг барьж аваад 30 хэдэн их наядын зээлийг гаргаж байгаад. Нийт тэтгэврийн зээл 1.2 их наяд байсан уу, 4 их наяд байсан уу. Түүнд аягүй санаа зовоод л ерөөсөө тэтгэврийн зээлийг бид өөрчлөх ёстой гээд Монголбанк, Засгийн газрын хоёрын хийсэн алдаанаас үүдээд тэтгэвэр авагчид бухимдаад байгаа байхгүй юу. Та нар албан журмаар, албан хүчээр бидний цалин дээрээс авах үедээ аягүй сайн тооцоотой авчхаад буцаад өгөх болохоор тооцоогоо хийж ном журмын дагуу өгөхгүй байна гэдэгт л иргэд бухимдаад байгаа юм.

Тэгээд энэ дээр хэдүүлээ бие биедээ ухаантай сайхан үг шидэлцээд, аргална, болно гэсэн ч гэсэн ард түмэн бас үүнийг өөрсдөө тооцдог болсон шүү. Манай тэтгэвэр авагчид бүр наадахыг чинь өөрсдөө маш сайн мэддэг. Ажилласан жил, энэ бүх тооцооллуудаа сайн мэддэг болсон.

Тэгэхээр энд бид хэдэн ухаантай үг хэлэлцээд нэмэргүй л дээ. 500 мянган тэтгэвэр авагчид байна. Одоо.

Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Ер нь жоохон тэгш байдал алдагдаад та хоёр нийлээд А.Ариунзаяа гишүүнийг буруутгаад байгаа юм шиг байгаа болохоор би бас тэнцвэржүүлъя гэж бодож байна. Нэгдүгээрт.

Ер нь зарчмын хувьд Нийгмийн даатгалын сангийн хууль хэлэлцэхэд энэ параметр үзүүлэлтүүдийг, шалгуур үзүүлэлтүүдийг тооцохдоо асуудал нь тэнд байгаа болохоос үүнийг тэгж харахгүй бол яг энэ тэтгэврийн зөрүүг нэмэгдүүлж

байгаа чинь тэгш нэмэгдүүлж байгаа асуудал байгаа юу гэвэл байгаа. Энэ хоёр талтай асуудал.

Яагаад гэхээр төрийн тусгай тэтгэвэрт гарч байгаа улс ч байна уу, 4.5 сая төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүн 6 хувиар нэмэгдэхэд үндсэндээ 260-аад мянган төгрөгөөр тэтгэвэр нэмэгдэж байгаа юм. Тэгтэл тэтгэврийн доод хэмжээгээр авч байгаа хүнийх 41 мянгаар нэмэгдэж байгаа. Тэгтэл тэр өндөр тэтгэвэр авч байгаа хэсэг нөгөө сүүлийн 5, 6 жилээр бодогддог тэтгэвэр, инфляцын ханшийн зөрүү энэ тэрээс яг адилхан ажил хийж байсан хүмүүсийн тэтгэврийн зөрүү гараад байгаа юм.

Тийм учраас дундаж тэтгэвэр 901 мянган төгрөг болж байгаа ч гэсэн цаашдаа нийгмийн даатгалын багц хууль, реформоороо нийгмийн даатгалын сангаа... /минут дуусав/

Х.Булгантуяа: Тэгээд аргачлалыг Засгийн газраар баталдаг шүү дээ. Засгийн газрын тогтоолоор баталдаг. Энд бид зүгээр бүтэн дүнгийн л төсөв дээр нийтдээ тавьж өгч байгаа юм.

Тэгээд мэдээж аргачлалаа ерөнхийдөө бодоод оруулж ирж байгаа байх. Сангийн яам төсөв дотроо үүнийг бодоод оруулж ирж байгаа байх.

Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Өдөржин 2026 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэж байна.

Тэгээд хэдэн тодорхой асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухай мэдээж маш том чухал асуудлуудын нэг. Тэгээд энэ 2025 оны эхний 8 сарын байдлаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэл маш удаашралтай буюу дөнгөж 31 хувьтай байна. Үүн дотроо шинээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 19-хөн хувьтай байна.

Тэгэхээр энэ хурдаараа бид энэ ондоо багтаагаад хөрөнгө оруулалтынхаа ажлуудыг хийж амжих уу? Гүйцэтгэлийг яаж хурдасгах гэж байна вэ?

Дараагийн нэг асуулт. Бусад гишүүд ч гэсэн бас хөндөж байна лээ. Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор өгч байгаа, олгож байгаа хөнгөлөлттэй зээл, зээлийн үеийн дэмжлэгийг харуулж байгаа бодит үр дүнг харуулсан мэдээлэл энэ төсвийн төсөлд ховор байна. Хөдөө аж ахуйн салбар маш их дэмжлэгийг авдаг салбар. Зээлдэгчийн тоо, хүү, хувь хэмжээ энэ тэр ороод байхаас биш үр дүнг харуулсан мэдээлэл алга.

Өөрөөр хэлэх юм бол үр ашиг, үр өгөөж байхгүй байнгын татаастай яваад байна гэж боломгүй.

Тэгэхээр үр дүн. Ер нь цаашдаа яаж сайжруул гэж бодож байна.

Түүнээс биш хөдөө аж ахуйн салбар бол маш чухал салбар. Дэмжих ёстой гэдгийг ойлгож байгаа. Тийм ээ. Юм асуухаар үгүйсгэхгүй шүү. Яаж сайжруулах вэ гэдэг талаар дандаа гишүүд санаа зовж асууж байгаа гэдгийг үндэс болгоод ойлгосон нь дээр байх.

Дараагийн нэг асуулт. Олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. Олон нийтийн санал асуулгаар хамгийн өндөр хувь буюу 17 хувь нь нийгмийн халамжийн бодлого дээр анхааръя. Энд зарцуулж байгаа төсвийг багасгаад, бууруулаад, илүү ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх энэ тал руугаа бодлогоо зангидъя гээд санал гаргасан байна шүү дээ.

Гэтэл энэ яг 2025 оныхоо төсөвтэй адилхан 2026 онд 4.6 их наяд. Өмнө нь 4.5 их наяд байсан.

Тэгэхээр энэ дээр ямар дорвитой бодлого хийх ёстой вэ. Яг халамж шаардлагатай эсэхдээ. Тэгсэн мөртлөө өгөөж муутай дүнтэй оччихоод байгаа шүү дээ. Тийм ээ. Дараагийн асуудал бол гадаад зээл, тусламж, төслүүдийн ашиглалт бага байгаа. Сангийн яам үүнийг түрүү жил ч гэсэн хэлсэн шүү дээ.

Тэгээд энэ ашиглалтыг хэрхэн сайжруулах вэ буюу одоо дөнгөж 68 хувьтай, 15.9 их наяд төгрөг ашиглагдаагүй хүлээгдэж байгаа. Гэтэл 617.9 сая долларын нэмэлт зээл оруулж ирж байна. Энэ дотроо Зүрх судасны тэр үндэсний төв гээд байгаагаа EBRD-аас SOFR нэмэх нь 1.6 хувьтай авах гэж байна. Энэ зөв үү? Энгийн зээл 25 жилийн хугацаатай байдаг. Энэ чинь 18 жилийн хугацаатай юм шиг байгаа юм.

Тэгээд бусад үед SOFR нэмэх 0.75 хувь байдаг. Энэ өндөр хувьтай байна. Яагаад энэ вэ? Энэ ер нь зээлийн ашиглалт. Байгаагаа ашиглах. Нэмж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Мөнхсоёл гишүүний асуултад Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Б.Мөнхзул гишүүний асуултад хариулъя.

Энэ жилийн гүйцэтгэл одоогоор 37.7 байна. Өмнөх онуудтай харьцуулахад бас нэг их тийм муу тоо биш шүү. Яагаад вэ гэхээр энэ жил сая 6 сарын 01 гэдэг нөгөө хэмнэлтийн хууль хэрэгжээд эхлэхээр энэ жил ер нь удаашралтай байгаа хөрөнгө оруулалтууд, төслүүд ихэнх нь хасагдсан. Эрсдэлтэй байх төслүүд маань.

Тэгэхээр энэ төслүүд үргэлжилж байгаа. Шинээр эхэлсэн цөөхөн төслүүд явж байгаа учраас оны төгсгөл рүү ер нь их өндөр хувьтай гарна. 90-ээс дээш хувьтай бараг гарах болов уу? Тэгээд тэр үед нь та надаас асуугаарай.

Зүрх, судсан дээр 26 сая долларын буцалтгүй тусламж байгаа. Энэ төсөл нь өөрөө энэ чинь аягүй BLENDED_[холимог] санхүүжилттэй байхгүй юу?

Тэгэхээр blended дотроо хамгийн өндөр хувьтай буцдаггүй тусламжтай төсөл байгаа юм. Энэ чинь бараг сүүлийн бараг 7 жил хэлэлцээрийг нь хийв үү дээ. Люксембург талтай. Тэгээд EBRD оролцоод явах байгаа юм.

Тэгэхээр энэ бол маш сайн санхүүжилт бид олж авч чадсан. Маш сайн санхүүжилт шүү.

Яах вэ, хүүгийн хувьд одоо бүгдээрээ бид ийм хөвөгч хүүтэй болсон. SOFR дээр нэмэх нь 1 гэдэг. Маш олон.

Тэгээд Б.Мөнхсоёл гишүүн ээ, цаашдаа бидний энэхүү буурна гэсэн ойлголт байхгүй. Манай зээлжих зэрэглэл ахих тусмаа Дэлхийн банкны ангилал маань одоо нөгөө буурай орноосоо гараад явсан шүү дээ. Дунджаас дээгүүр хөгжиж байгаа орныхоо ангилалд орсон. Тэгэхээр цаашдаа бидэнд хуучин шиг 30, 40 жилийн хугацаатай, бараг хүүгүй шахуу 1, 2 хувийн хүүтэй тэр зээл дахиж олдохгүй. Тэр өнгөрсөн.

Тэгээд SOFR дээр нэмэх нь ийм хүү олдвол бид аваад байх л хэрэгтэй болж байгаа юм.

Тэгэхээр ийм том. Одоо энэ чинь өөрөө төгрөгөөр бол энэ чинь төгрөгөөр бараг 70 гаруй тэрбум төгрөгийн төсөл байгаа юм. Үүнийг бид шууд төсвөөс санхүүжүүлж чадахгүй.

Тийм учраас барууны ийм мундаг том стандарт орж ирж байхад тосож аваад л энэ төслөө маш амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ чинь барилгыг нь барина, тоног төхөөрөмж нь орж байгаа юм, эмч, эмнэлгийн ажилтнуудын сургалт нь орсон. Энэ аягүй сайн ийм бүр төгс төсөл байгаа юм шүү. Тэгээд энэ төслийг Та маш сайн дэмжиж өгөөрэй.

Ач холбогдлыг нь манай сайд илүү сайн ярих байх. Санхүүжилт талаасаа маш өгөөжтэй, одоо бидэнд олдох хамгийн л сайн зээл шүү гэдгийг баталж хэлэх байна. Тийм.

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Салбарын өнгө их сайн байгаа.

Сая статистикийн хагас жилийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн дүнг танилцуулсан. Хөдөө аж ахуйн салбар дангаараа 35.6 хувийн өсөлтийг хангасан. Хагас жилээр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 5.6 бүхлээр өссөн. Үүний 3.6-г хөдөө аж ахуй бүрдүүлсэн.

Олон жил дандаа хасах үзүүлэлттэй байсан салбар яагаад өсөв. Энэ Улсын Их Хурлын баталсан ноос, ноолуур, арьс шир боловсруулах “Цагаан алт” хөтөлбөр, малчдаа дэмжсэн “Хоршоо” хөтөлбөр, тариаланчид, ногоочид, фермерүүдээ дэмжсэн “Атрын-IV” хөтөлбөр, “Хүнсний хувьсгал” гэсэн 4 хөтөлбөр харилцан хамааралтай, шүтэлцээтэй ажиллаад үр дүн гарч эхэлж байна гэсэн үг.

Энэ салбарт Монголын ажиллах хүчний 2 хүний нэг нь ажиллаж байгаа юм. /минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд нэмж хариулья.

Ж.Энхбаяр: Сая үзүүлж байгаа эдийн засгийн ач холбогдлоос гадна нийгэм, улс төрийн ач холбогдол их байна. 2 хүний нэгийг ажлын байраар хангаж байна буюу нийгмийн тогтвортой байдлыг хангаж байгаа гол салбар. Нийгмийн баялгийг хамгийн жигд хуваарилж чадаж байгаа салбар. Хамгийн олон оролцогчтой.

Хэт уул уурхайгаас ангид байгаа эдийн засгийнхаа алдааг бид сая нүүрсний шок дээр харлаа шүү дээ. Нүүрс унаад бүгд дагасан. Тээвэр, худалдаа, үл хөдлөх унахад хөдөө аж ахуй ганцаараа босож ирж байгаа юм. Энэ чинь бидний хөгжүүлэх гол бодлого, энэ Их Хурлын баталсан хөтөлбөрүүд, Засгийн газрын хөтөлбөрүүд, Ерөнхийлөгчийн санаачилсан хөтөлбөрүүд зөв болж байна гэдэг нь харагдаад байна шүү дээ.

Гол нь биднийг үүнийгээ бид дунд хугацаандаа тогтвортой 2028 он хүртэл хамтраад хэрэгжүүлье. Тэгэхэд хэлэх үгтэй, хийх ажилтай. Тоон үзүүлэлтүүд олон зүйл дээр гарч байна. “Цагаан алт” дээр гарч байна, “Атар” дээр гарч байна, “Хүнсний хувьсгал” дээр, “Хоршоо” дээр гарч байгаа. Ингээд яривал цаг багтахгүй.

Саяхан л тансаг хэрэглээ байсан өндгийг Монгол Улс 100 хувь дотроосоо хангадаг болоод ирлээ шүү дээ. Ингээд жишээ яривал олон зүйл байна.

Х.Булгантуяа: Т.Аубакир сайд нэмж хариулья.

Т.Аубакир: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулья.

Манай яамнаас нийгмийн халамжийг зорилтот хэсэгт илүү чиглүүлэхээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг

боловсруулаад Улсын Их Хуралд намрын чуулганд өргөн барихад бэлэн болсон байж байгаа.

Нийгмийн халамжийн санд 2025 онд 2 их наяд 513.0 тэрбум төгрөг төсөвлөсөн бол 2026 онд 2 их наяд 583.4 тэрбум төгрөг болж 2.7 хувиар нэмэгдэж тусгаж байгаа.

Халамжийн сан 2 их наяд гаруй төгрөг гээд тэгэхээр бид бас эндээс хүүхдийн мөнгөө салгаж ойлгох ёстой. Хүүхдийн мөнгө, одонгийн мөнгө гэдэг ч юм уу бусад тэтгэмжүүд энэ санд хамт явж байдаг учраас их том дүнгээр харагдаад байгаа.

Өмнөх оны төсвөөс 44.5 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 6 хувиар нэмэгдүүлэхэд, үлдсэн 25.5 тэрбум төгрөг нь хүн амын насны бүтцийн өөрчлөлттэй уялдсан зардлын өсөлт болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, хөнгөлөлтийн зардлын нэмэгдэлд... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Мөнхсоёл гишүүн нэмж тодруулна.

Б.Мөнхсоёл: Хариулт өгсөн сайд нарт баярлалаа.

Ер нь төсвийн цаглавар болон Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд Х.Булгантуяа дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан юм.

Түүн дээр дэмжлэг, татаасыг хамгийн их авсан салбар хөдөө аж ахуйн салбар байсан. Хамгийн олон ажиллах хүчнийг бий болгодог салбар гэдгийг эдийн засгийн онолын хувьд мэднэ. 5.6 хувийн эдийн засгийн өсөлтийн 3.6-г эзэлж байгааг мэдэж байгаа.

Гол нь хөтөлбөр болгон дээр үр өгөөжийг тооцохгүй байгаа дээр тухайн ажлын хэсэгт орсон бүх гишүүд санал нэгтгэйгээр шүүмжлэлтэй хандсан.

DTL information. Нарийвчилсан тооцоог дараа нь авъя.

Хоёрдугаарт нь, бид ер нь ингэж хандаад байгаа юм шиг санагдаад байгаа юм. Төсвийнхөө бодлого дээр. Шинж тэмдэг дээр ажиллаад байгаа. Реформын шинжтэй юмнуудаа хийж чадахгүй байгааг аргагүй шийдэхгүй бол байнга цалин пүнлүү, тэтгэврийн өсөлт яригдана шүү. Одоо нийгмийн даатгалын шимтгэл, Эрүүл мэндийн даатгалын сан байнга яригдана шүү. Байнгын Б.Жавхлан сайдын толгойны өвчин байна гэдгийг сануулж хэлээд, гадаад... /минут дуусав/

Х.Булгантуяа: Хоёр тодруулсан. Дэгийн тухай хуулийн дагуу нэг л тодруулахаар байгаа.

Хөдөө аж ахуйн салбар чухал салбар. Сая төсвийн тухай ном дээр ч гэсэн 45 мянга 200 орчим хамгийн их ажлын байр, ажиллагсад хөдөө аж ахуйн салбарт байдаг. Шинээр бий болсон нь энэ юм уу? Тийм ээ.

Тэгвэл 45 мянга 200 ажлын байр шинээр бий болсон гэж үзэж байгаа юм байна.

Т.Аубакир сайд аа, та ялангуяа шинээр ажлын байр үүсэж байгаа гэдэг тооцооллийг ер нь их сайн хараарай. Тэгэхгүй бол ингээд л нэг салбараас нөгөө салбар луу шилжээд байгааг шинээр ажлын байр бий болж байгаа гэж тооцоход их хэцүү. Нийт нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдөө Та бүхэн аваад үзэх юм бол онцгой өндөр нэмэгдсэн нь бага байгаа байхгүй юу.

■ 3.4 сая хүн амаас

- 1.3 сая орчим нь хүүхэд,
- 500 мянга нь тэтгэвэр авагчид,
- 110 мянга орчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд,
- 150 мянга орчим нь оюутнууд,
- 200 мянга орчим нь гадаадад байгаа иргэд.

Ингээд хасаад үзэхээр жилд 60, 70 мянга орчим хүн шинээр төрөөд, 100 мянга орчим хүн байнгын асаргаа үзүүлж байгаа.

Тэгээд тооцоод үзэхээр цаана нь үлдсэн хэсэг нь бараг ажиллаж болохоор хэсэг бол ихэнх нь ажиллаад байгаа юм шиг.

Харин бидний анхаарах ёстой зүйл нь ажил хийж байгаа иргэдийнхээ бүтээмжийг сайжруулах, цалинг сайжруулах, үнэлгээг сайжруулах, хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах дээр илүү их анхаарахгүй бол зүгээр ганцхан манай салбарт ажлын байр нэмэгдсэн гэдэг бол хангалттай биш. Үнэнийг хэлэхэд арай гайгүй салбарт ажлын байр бий болох л юм бол яваад өгөх гээд байдаг.

Тэгээд үүний нэг том жишээ бол уул уурхайн салбар луу бүхий л салбараас орж байгаа. Тэгэхээр үүн дээр анхаарч ажиллаарай гэж хүсэж байна.

Тэгээд манай Г.Очирбат гишүүн ажлын хэсэг дээр хөдөө аж ахуйн салбарт үзүүлж байгаа зээл, тусламжуудын үр дүнгийн талаар үнэлгээ хийсэн. Мэдээж бид хөдөө аж ахуйн салбараа дэмжих ёстой. Гэхдээ тасралтгүй дэмжлэгээр явна гэдэг бол бас болохгүй. Яагаад гэвэл Монголын бүхий л салбарт дэмжлэг хэрэгтэй байгаа. Нэг хэсгийг нь хэсэг хугацаанд дэмжээд хөл дээр нь босгоод дараагийн салбар луу орохгүй бол одоо энэ бол халамжийн салбар болж ерөөсөө болохгүй шүү гэдэг тийм дүгнэлт гарч байсан.

Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг.

М.Ганхүлэг: Гишүүддээ оройн мэндийг хүргэе.

Өнгөрсөн жилийн төсвүүдтэй харьцуулахад нэлээн реформын шинжтэй өөрчлөлтүүдийг эрэлхийлсэн ийм төсвүүд нэлээн орж ирж байсан. Энэ удаад байгаа боломж, бололцоондоо тулгуурлаад төсвийг оруулж ирж байх шиг байна.

Салбартай холбогдолтой асуудлуудыг Байнгын хороо дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр нэлээн детальчлаад саналаа хэлээд явна.

Хэд хэдэн зарчмын асуултуудыг би төсвийн хэлэлцүүлэг эхэлж байгаатай холбогдолтой асууя гэж бодож байгаа.

Төрийн албан хаагчидтай холбогдолтой, тэтгэвэртэй холбогдолтой асуудлууд дээр гишүүдтэйгээ санал нэг байгаа. Орон нутагт уулзалтууд хийгээд явахад хамгийн их яригдаж байгаа асуудал байгаа.

Өнгөрсөн хугацаанд бид аль нэг салбарыг гэхээсээ илүүтэй нийт төрийн албан хаагчдын цалингийн түвшинг нэмэгдүүлэх чиглэл дээр томоохон үр дүн гаргаж чадсан.

Хоёрт, их сайн хийсэн зүйл нь зүйл нь орон нутгийн нэмэгдэлтэй холбогдолтой асуудлыг бий болгож гаргаж ирж чадсан. Энэ бүсчилсэн хөгжил болон орон нутагт ажиллах бололцоог хангахад нэлээн том үүрэг роль болоод явж байгаа.

Тэгэхээр энэ бодлого, хөтөлбөрүүд 2026 онд ямар байдалтай тусаж байгаа вэ гэдэг тал дээр илүү тодорхой асуултууд иргэдээс ирээд байгаа юм. Ер нь бидэнд аль нэгэн салбарыг бусад салбартай нь харьцуулж байдаг юм уу, өөрчлөхгүйгээр жигд төрийн албан хаагчдынхаа цалинг өсгөөд явах энэ бодлого цаашдаа үргэлжлэх ёстой.

Үүний хүрээнд бидний удаа дараа амлаж байгаа нэг зүйл бол инфляцын түвшинтэй уялдуулж төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх боломж цаашдаа ер нь ямар байх вэ? Энэ жилийн хувьд яаж орж ирж байна вэ гэдгийг би илүү тодотгоод асууя.

Хоёр дахь нь, орон нутгийн нэмэгдлүүд аймаг дээр 20 хувь, сум дээр 40 хувь явж байгаа энэ байдлууд дээр тодорхой өөрчлөлт юмнууд байх уу? 36 сартай холбогдолтой асуудал дээр А.Ариунзаяа сайдтай би ижил саналтай байгаа гэдгээ илэрхийлье.

Ерөнхий сайд хариулах уу, эсвэл Н.Учрал сайд хариулах уу? Жилийн өмнө хамгийн их яригдсан сэдэв бүсчилсэн хөгжлийн асуудал байсан.

Тэгээд одоо ер нь бүсчилж хөгжих хэвээрээ байгаа юу? Бид. Тэгээд бүсчилсэн хөгжлийн хүрээнд бид 6, 7 бүс болоод төсвөө жүжиглэхгүйгээр илүү үр бүтээлтэй, илүү эдийн засгийн үр өгөөжтэй төслүүд рүү оруулъя гэдэг ийм агуулгуудыг ярьж хэлж байсан. Нөгөө 14 мега төслийн 5 нь хэрэгжээд явж байна гээд тэгсэн. Одоо 14 мега төслөө болиод зөвхөн хүний хөгжлийн мега төслөө дагнахаар болж байна уу? Энэ мега төслүүдийг яг 14 төрлөөр нь үндсэндээ детальчлаад 2026 оны төсөв дээр суусан зүйлүүд ямар байгаа вэ гээд жоохон детальчлаад асууя.

Нэмэлтээр дараа нь асууя.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн бодлого, зорилтууд туссан.

Тэгэхээр Их Хурлаас баталсан баримт бичиг учраас хэрэгжүүлээд л явна. Энэ ч хүрээндээ Засгийн газрын 14 төсөл, хөгжлийн төслүүдийг эрэмбэлсэн. Энэ эрэмбэлэх гол шалгуур үзүүлэлтүүд 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ л чиглэгдэж байгаа.

Гэхдээ би түрүүн хэлсэн. 10 дугаар сарын 30-наас өмнө барих 5 жилийн үндсэн чиглэл бол бид яг үзүүлэлтүүдээ тавиад хэмждэг болох зорилго руугаа явах ёстой.

➤ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 149 төсөл байгаа.

- Энэ дотор бүсчилсэн хөгжлийн 45 төсөл байгаа. 45 төслүүдэд:
 - эдийн засгийн бүтцийн шинэчлэлтэй холбоотой 52 төсөл,
 - эрчим хүчний шинэчлэлтэй холбоотой 36 төсөл,
 - ногоон хөгжлийн чиглэлийн 10 төсөл,
 - хүний хөгжлийн 6 төсөл байгаа.

Тэгэхээр нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг шиг энэ удаагийн төсөв бол сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлсэн. Ирэх он жилүүд ч эдийн засгаа зөв голдирол руу нь чиглүүлэх зорилгоор л энэ удаагийн төсвийг авч орж ирсэн.

Тэгэхээр бид өнөөдрийн хэлэлцүүлгийн явцад нэг талаас нь цалингаа нэм гээд байдаг.

Тэгээд Их Хурлаас баталсан урсгал зардлын 24 хувиа давах гээд байдаг. Нөгөө талаасаа хөгжлийн төслүүдээ явуул гээд байдаг. Гэтэл гаднын хөнгөлөлттэй зээлээ ашиглаж чаддаггүй. Ашиглая гээд статистик алдагдал

үүсгээд байна. Эх үүсвэр нь гадаадын хөнгөлөлттэй зээл юм гээд 1.3 хувийн алдагдал бичихээр зээл чинь хэрэгжихгүй байна гээд байдаг.

Өмнө нь хэрэгжиж байсан төслүүдээ урагшлуулаад явуулъя гэдэг зорилго л байгаа болохоос биш одоо улсын хэмжээнд авсан бүх гадаад зээлээ ирэх жил хэрэгжүүлбэ гэж огт зориогүй.

Тэгэхээр энэ чинь өөрөө ирэх жил 1.9 их наядын л зээлийн ашиглалт шүү дээ.

Тэгэхээр бид зарчмын хувьд яах ёстойг мэддэг хүн бүгдээрээ байна. Гэтэл яаж хүрэх вэ гэдгээ мэдэхийн тулд нөхцөл байдал дээрээ, амьдрал дээрээ нийцэж ажиллахаас өөр сонголт байхгүй.

Тэгэхээр хуулийнхаа хүрээнд төсвийн тогтвортой байдлын хуулиа бариад л төслүүдээ эрэмбэлээд явъя. Юутай ч Засгийн газар эхний 100 хоног дээрээ энэ олон төслүүдээ бүгдийг нь эрэмбэлээд дууссан.

Тийм ч учраас техник, эдийн засгийн үндэслэлтэй, үндэслэлгүй зураг, төсөвтөө үгүйгээр нь ялгаад ирэх онд зураг, төсөв ТЭЗҮ-үүд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр төвлөрөөд шаардлагатай ТЭЗҮ-үүдээ бэлтгэх ажлуудыг шат дараалалтай хийнэ.

Энэ эдийн засгийн өсөлтийн 5.7 хувьд ч тэр, инфляцын тоондоо ч тэр бид яаж хүрэх вэ гэвэл мэдээж салбарууд үүрэг оролцоотой байгаа энэ төслүүд ч нэмэр болно.

Дээрээс нь, түрүүн хөдөө аж ахуйн салбар ч их яригдаж байна. Татаас Их Хурлаас баталсан баримт бичиг. Гол нь бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр болоод ирэх 5 жилийн чиглэл дээр EXIT STRATEGY гээд байгаа. Ер нь татаас өгсөн бол хэзээ дуусах вэ гэдэг энэ гарах тэр EXIT PLAN-ыг маш тодорхой тусгаж өгөх ёстой юм байна.

Тэгээд хэзээ дуусах нь мэдэгдэхгүй татаас яваад байдаг. Хэмжиж чадахгүйгээр дуусдаг. Тэгээд сүүлдээ бүх салбар халамж руу чиглэх юм бол явахгүй нь.

Тийм учраас цаашдаа халамжийн шинж чанартай үйл ажиллагаануудыг заавал EXIT PLAN-тай нь хамт оруулж ирж баталж явдаг байхыг 5 жилийн чиглэл дээр хатуу шаардана.

Тэгээд салбаруудаа бид шахаад явна гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулах уу? 20 хувийн нэмэгдэл, 40 хувийн нэмэгдэл, Төрийн албан хаагчдын 36 сар, бүсчилсэн хөгжил. Бүсчилсэн хөгжлийг ярьсан. Сая Н.Учрал сайд. Б.Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: М.Ганхүлэг нэг гишүүний асуултад хариулъя.

Эдгээр зохицуулалт тэр орон нутгийн нэмэгдлүүд дээр ямар ч өөрчлөлт гарахгүй ээ, М.Ганхүлэг гишүүн ээ. Одоо энэ чинь дандаа өөрөө хуультай байхгүй юу. Нөгөө олон хуулиар аль хэдийн нөгөө төсвөө хуваарилсан том нөлөө бүхий заалтуудын нэг энэ өөрөө зохицуулалт нь. Тийм. Одоогоор энд өөрчлөлт оруулах ямар нэг тийм хуулийн санаачилга байхгүй.

Тэгэхээр санаа зоволтгүй. Энэ үргэлжлээд явна. Тийм.

Х.Булгантуяа: М.Ганхүлэг гишүүн нэмж тодруулъя.

М.Ганхүлэг: Тийм. Нэлээн тодорхой тодорхой зорилтууд тавиад явж байсан асуудлууд яригдахгүй болоод эхлэхээр санаа зовох юм.

Н.Учрал сайд аа, ялангуяа зүүн бүс нутаг түүхэн аялал жуулчлал, мал аж ахуй, хөдөө аж ахуйн гол бүс болно гээд зөвхөн уриа төдий байгаад байж болохгүй байна. Энэ чиглэлийн тодорхой ажил, үйл ажиллагаанууд дээр бид төлөвлөлтийнхөө дагуу ажлуудаа хийгээд явах учиртай.

Бүтэн жилийн хугацаанд бид бүс, орон нутгийн хөгжлийн тэр ТЭЗҮ байгуулах тэр ажлаа хийж чадахгүй бол тодотголоор хасуулах хасуулахгүй тухай яриад л байж байсан.

Тэгэхээр яг иймэрхүү ажлууд дээрээ шахаад цаашдаа явах нь зөв юм гэсэн байр суурьтай байгаа юм. Бүсчилсэн хөгжлийн гол концепцууд ер нь цаашдаа Монголын хөгжлийн чухал загвар байна гэдэг бодолтой байгаа.

Дахиад нэмэлтээр 1 минутаа авч болох уу?

Х.Булгантуяа: М.Ганхүлэг гишүүнд нэмж 1 минут.

М.Ганхүлэг: Бүстэй холбогдолтой бас дахиад нэг асуудал байгаа юм. Сая яриад байгаа Засаг даргын Тамгын газрын байр, Мэдээллийн төв гэдэг бүтээн байгуулалтын ажлууд зүүн бүс нутагт хийгдэж байгаа.

Гэхдээ аудитын байгууллагын дүгнэлт гараагүй гэдэг нэрийдлээр үндсэндээ барилгын ажил юмнууд нь нэлээн дууссан. 300, 400 сая, 200 сая төгрөгийн ийм зөрүү дүгнэлтүүд үндсэндээ гарсан. Тэгээд байрандаа орох хэцүү, байх хэцүү жил, хоёр жилийн нүүр үзэж байгаа төслүүд байна. Яалт ч үгүй орон нутагт царцаад байгаа байдлууд байна.

Тэгэхээр энэ дээр дахиад жил хүлээхгүйгээр тодорхой дүгнэлтүүдийг нь үндэслээд явах, гарах гарц гаргалгаа юу байна вэ гэдгийг аудит болон Б.Жавхлан сайдаас тодруулъя.

3 барилга байгаа юм.

Х.Булгантуяа: 4 номер. Ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Хэнтий аймгийн 3 сумд хэрэгжиж байгаа Тамгын газрын барилга байгаа.

Яг төсвийн төсөл дээр тавигдахад гэрээний үлдэгдэл байхгүй. Одоо яг тавигдах хэрэгцээ шаардлага нь нэмэлт санхүүжилттэй холбоотой. Нэмэлт санхүүжилт дээр магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Магадлалын ерөнхий дүгнэлтийг хянах процесс аудит дээр хийгдэж байгаа. Одоогоор Сангийн яаманд ирээгүй байна.

Х.Булгантуяа: Сархадын Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн энэ оройн амгаланг айлтгая.

Боловсролын салбарт зохих түвшний хөрөнгө оруулалтууд хийх анхаарал хандуулж байгаад талархалтай байна.

198 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр байна. Түүнээс гадна төсвийн нийт хөрөнгө оруулалтын 18 хувь, гадаадын зээл, тусламжийн 17 хувь боловсролын салбарт хуваарилагдсан байгаа нь сайшаалтай юм. Бас нэг зүйлийг онцгойлон тодруулмаар байна. П.Наранбаяр сайдаас, Үндэсний аудитын газраас бас асуумаар байна.

Өнгөрсөн жилүүдээс ажил нь дуусаагүй царцсан барилга, байгууламжид байгаа юм. Сургууль болон цэцэрлэгүүд. Үндэсний аудитын газраас дүгнэлт гараад үүнийг төсөв рүү оруулах арга хэмжээг зохион байгуулах ёстой. 16 сургууль, цэцэрлэгийн аудитын дүгнэлт гараагүй гэсэн байдлаар ороогүй байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яагаад Үндэсний аудитын газраас дүгнэлт гараагүй вэ? Сайд яагаад энэ дээр гаргуулаад үүнийгээ оруулж чадаагүй вэ гэдэг нэг ийм асуулт байгаа юм. Нэгэнтээ боловсролын хөгжлийг нь дэмжих жил нь байгаа учраас энэ жилийн хүрээнд оруулсан бол бид багаар бодоход 9980 хүүхдийн асуудлыг шийдэж байгаа л ийм л нөхцөл байдал байна л даа. Энэ дээр тодорхой хариулт авъя.

Хоёр дахь зүйл. Энэ мэргэжлийн боловсрол дээр сайд яг ямар хөрөнгө оруулалт хийсэн бэ? Нэн ялангуяа бид чинь дадлагын баазыг сайжруулах чиглэлээр, сургалтын орчныг сайжруулах чиглэлээр онцгой анхаарна гээд зорилт тавьсан шүү дээ. Яагаад гэхээр зэрэг эрэлтэд нийцсэн ажиллах хүчнийг

бэлдэх гол үндсэн сургалтын байгууллага чинь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, политехникийн коллежууд.

Тэгэхээр энд үндсэндээ өнгөрсөн жилүүд олигтой хөрөнгө оруулалт хийгдээгүй. Тэгээд бид нэг тийм ажиллах хүчний хомсдолд орсон ийм улс орон болсон байж байдаг. Энэ дээр та нэг тодорхой хариулаач гэж байгаа юм.

С.Бямбацогт сайдаас би нэг ийм зүгээр тодруулах гэж байгаа юм. Энэ төсөвтэй холбоотой учраас зориуд.

Аймгууд төсвийн тодотгол хийж байна. Хурал нь хуралдаад. Тэгсэн түүн дээр жишээ нь зарим төрийн захиргааны албан хаагчдыг шууд хоморголоод гэдэг юм уу, бөөнөөр нь чөлөөлөх, цомхотгох зохион байгуулалт хийгээд явж байна гэж байгаа юм. Тэрийгээ яаж үндэслэж байна гэхээр зэрэг ерөөсөө төсөв байхгүйтэй холбоотой гэсэн шалтаг, эсвэл шалтгаан, нөхцөлийг тавиад байна л даа. Гэтэл тэрийг нь үзэхээр зэрэг баг, хорооны “нийгмийн ажилтан” гэдэг албан тушаалтан байгаад байдаг. Төрийн албаны зөвлөлөөр ажлын байр нь тогтоолоор батлагдсан. Ажлын байрных нь дүгнэлт нь.

Тэгээд одоо энэ чинь бүхэлдээ ажлын байрыг бий болгосон ийм нөхцөл байдал байгаад байдаг. Энэ дээр Та бүхэн явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийхгүй бол энэ чинь нэг ийм нугалаа үүсэх вий. Энэ дээр та ямар байдлаар ажиллах вэ гэж асууж байгаа юм. Би үлдсэнийг нь дараа нь тодруулъя.

Х.Булгантуяа: С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Улсын Их Хурал хууль баталдаг хууль тогтоох дээд байгууллага. Засгийн газар хуулийг хэрэгжүүлдэг гүйцэтгэх дээд байгууллага. Үндсэн хуульд тэгж заасан байгаа.

Тэгээд Улсын Их Хурлаас баталсан хуулиараа 2026 оны жилийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар цомхотго гээд баталсан. Өнгөрсөн 6 сард төсвийн тодотгол батлах үедээ нааш нь татаад төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын орон тоо 9 хувиар цомхотгох төсвийн тухай хууль батлагдсан. Одоо хэрэгжээд явж байгаа.

Тэгээд Засгийн газар хууль хэрэгжүүлэх хүрээндээ аль болох төсвийн хэмнэлтийг дээрээсээ эхэлье гэдэг үүднээс яамдын газар, хэлтсийн дарга нарын тоог цөөлсөн.

Агентлагуудын газар, хэлтсийн дарга нарын тоог цөөлсөн. Ингэхдээ 30 орчим хувиар. Нийтдээ төрийн захиргаад, яам, агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын тоог 9 хувиар цөөлөх ажлыг хийж, бүтэц, чиг үүргээ оновчтой болгох ийм ажлыг хийж хэрэгжүүлж байгаа.

Үүнийг орон нутагт засаг захиргааны анхан шатны нэгжүүд дээр хийж хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн иргэдийн Хурал, Засаг даргын Тамгын газар зохион байгуулах ёстой.

Тэгээд энэ ажлаа зохион байгуулахдаа Засгийн газраас өгч байгаа чиглэл бол аль болох сул орон тоон дээр хүн авахгүй байх, ажлаас халагдсан хүний оронд хүн авахгүй байх, гадаад, дотоод шилжсэн явсан хүмүүсийн оронд хүн авахгүй байх, өвчтэй, жирэмсний амралттай, өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийн оронд хүн авахгүй байх ийм байдлаар 9 хувь руугаа шилжих, энэ 9 хувьдаа хүргэх бодлого баримтал гэсэн чиглэлийг өгсөн. Ийм чиглэлийг. Гэтэл хууль газар дээрээ хэрэгжихдээ таны ярьж байгаатай адилхан тухайн аймаг, сумын баг, хорооны нийгмийн ажилтныг бүгдийг нь албан тушаал, энэ орон тоог цомхотгож байгаа байдлыг би буруу гэж үзэж байна.

Төрийн үйлчилгээг ард иргэдэд хамгийн түрүүлж хүргэдэг, хамгийн доод анхан шатны нэгж яг иргэдтэй нүүр тулж аж ажилладаг нийгмийн ажилтнууд ажлаа хийх ёстой. Түүний оронд илүүдэлтэй, давхардалтай орон тоонууддаа анхаарах ёстой. Чиг үүрэг. Тийм үү. Ажил хийдэггүй, ажил хийдүүлдэг нөхдүүдээ анхаарах ёстой. Ийм байдлаар анхаар гэдэг асуудлаар бид төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгож байгаа.

Дарга нар нь үнэлэхээрээ даргадаа тал засаж байгаад сайн үнэлэгддэг. Иргэд үнэлэхээрээ хүнд сурталтай, авлига авдаг, ажлаа хийдэггүй, цагаа бүртгүүлээд цалингаа авдаг ийм албан хаагч нар хэцүү байна. Хүнд сурталтай нь яриад байдаг. Ийм ялгавартай үнэлгээ байж болохгүй. Энэ үнэлгээ нь ил тод болгоё. Иргэд нь ч үнэлдэг байя. Дарга нь зөв үнэлж үү, буруу үнэлж үү гэдгийг иргэд нь ч хараг. Иргэд нь ч бодитой үнэлээд миний үнэлгээг зөв байна уу, буруу байна уу гэдгээс дарга нар нь хардаг байг.

Ийм хоёр талаас нь үнэлэх үнэлгээний системийг бий болгож байгаа. Ингэж байж тэр төрд ажиллаж байгаа хүмүүсийг чадвартай улсууд нь ажлаа сайн хийгээд үнэлэгдээд, урамшуулал аваад ажлаа сайн хийдэг. Чадваргүй, залхуу, ажлаа хийдэггүй, арга заль хэрэглэдэг улсууд нь тэр үнэлгээ нь ил тод болсноороо ажлаасаа халагдах, чөлөөлөгдөх ийм байдлаар төрийн албыг илүү хүнд сурталгүй, илүү чадвартай, сэтгэлтэй улсууд нь урамшууллаа аваад сайн ажилладаг, албан тушаал ахиж дэвшдэг, тогтвортой ажилладаг. Чадалгүй, сэтгэлгүй улсууд нь ажлаасаа зайлуулагддаг чөлөөлөгддөг ийм байлгах бодлогыг бид төрийн албаны хуулиар хийж байгаа. Төрийн албаны хуулиас наана ч гэсэн энэ асуудлыг хийнэ.

Тийм болохоор ялгаварлаж, улс төржиж хоморголж халах асуултууд байх ёсгүй. Энэ дээр шалгалт хийнэ. Энэ дээр тодорхой хариуцлага асуудал ярина гэдгийг гишүүнд хэлье.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын хүрээнд нийт төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт магадлал хийлгэх, аудитын дүгнэлт гаргуулахаар 109 төсөл, арга хэмжээг явуулсан.

Үүнээс 59 дээр нь дүгнэлт нь хугацаандаа ирээд амжсан гэсэн үг. Бусад нь 9 сарын 01-нээс өмнө амжаагүй. 50 төслийн дүгнэлтийг аудитаар үргэлжлүүлэн дүгнэлтийг гаргаж байна. Үе шаттайгаар.

Энэ нь нийтдээ 190.9 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнүүд байсан.

Мэргэжлийн боловсролын салбарт Азийн хөгжлийн банкны 20 сая долларын хөнгөлөлттэй зээлийг оруулахаар яригдаж байна. Үүнээс бид мэргэжлийн боловсрол дээр нэгдсэн дадлагын бааз хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлдэхээр төсөвт оруулсан байгаа. Улсын төсөв дээр мэргэжлийн боловсролын 4 төсөл, арга хэмжээг бид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх... /минут дуусав/

Х.Булгантуяа: Үндэсний аудитын газраас. 3 номерын ажлын хэсгийн микрофон дээрээс.

Д.Энхболд: Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд. С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өнгөрсөн оны аудитын дүгнэлтээр Засгийн газарт олон жил үргэлжилсэн төсөл, арга хэмжээг дуусгах тал дээр тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг өгсөн байгаа.

Энэ зөвлөмжийн дагуу 2026 оны төсвийн төсөл дээр шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг харьцангуй бага төлөвлөж, үргэлжилж байгаа болон шилжих арга хэмжээнүүдийг дуусгах бодлого барьсан байсан.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 05 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор төсөвт өртөгт өөрчлөлт гарч байгаа магадлалыг хянах аудитыг хийх чиглэлийг гаргасан байгаа. Улсын Их Хурлаас.

Үүний хүрээнд нийтдээ захиалагчдаас... /минут дуусав/

Х.Булгантуяа: 3 номерын микрофоныг нэмж өгье.

Д.Энхболд: 192 төсөл, арга хэмжээг Үндэсний аудитын газарт ирүүлсэн. Энэ аудитын зорилго нь төсвийн төслөөс өмнө аудитын дүгнэлтийг гаргах зорилго агуулаагүй. Магадлалд өөрчлөлт орж, зураг төсөвт өөрчлөлт орсон дээр хөндлөнгийн хяналтыг хийж 8 сарын 15-наас 11 сарын 15-ны хооронд хийж ирүүлэх хугацаатай байгаа.

Тэгэхээр бид аль болох төсвийн төслөөс өмнө арга хэмжээнүүдийг тодорхой хэмжээнд шуурхайлах бодлого барьж, зуныхаа амралтыг авалгүйгээр ажиллаад 100 арга хэмжээний дүгнэлтийг гаргаад хүргүүлсэн.

Одоо дараагийн арга хэмжээнүүд үе шаттайгаар хийгдээд явж байгаа.

Х.Булгантуяа: С.Зулпхар гишүүн нэмж тодруулъя.

С.Зулпхар: Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн ирсэн байгаа дээр би нэг зүйл тодруулъя.

Төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий субъект тодорхой албан тушаалтныг төрийн албаны тухайн албан тушаалын ерөнхий болон тусгай шалгуурыг хангахгүй байхад нь томилсон тохиолдол байгаа юм.

Тэгээд үүнтэй холбоотой гомдол танай дээр очсон. Танайх хяналт шалгалт хийгээд Төрийн албаны зөвлөлөөс санал, дүгнэлт нь гараад тогтоолоо хүргүүлсэн. Тухайн эрх бүхий субъектэд. Юу гэсэн гэхээр зэрэг тухайн албан тушаалд томилогдсон хүн албан тушаалын 5-аас 6 шалгуурыг хангахгүй байна. Ийм учраас энэ хүнийг чөлөөл гээд Та бүхэн зөрчил арилгуулах тухай ийм хугацаатай даалгавар хүргүүлсэн байгаа юм.

Энэ даалгаврыг тухайн албан тушаалтан эхлээд биелүүлсэн. Биелүүлсэн гэдэг нь тэр хүнийг чөлөөлсөн. Угаасаа тэр хүн үүрэг гүйцэтгэгч байхгүй юу. Тэгсэн чинь дараа нь яасан гэхээр чөлөөлснийхөө маргааш нөгөөдөр нь ахиад томилчихсон. Одоо үүнийг... /минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан хянан шалгалтын үр дүнгийн талаар товч мэдээлэл өгсөн учраас товчхон хариулъя.

Иймэрхүү кэйсүүд хоёр, гурван яам болон хэд хэдэн аймаг дээр гарсан. Өнгөрсөн долоо хоногт бид хуралдаад ерөнхийдөө хянан шалгалтын үр дүнгийн талаар асуудлуудаа хэлэлцээд холбогдох байгууллагуудаас гарсан шийдвэрүүдийг татаж авсан.

Яг манай хурал гурав дахь өдөр болоход тав дахь өдөр нь буцаан томилгоонууд маш их хийгдсэн байсан. Одоо 10 сарын 01-нд бид эцсийн тайлангуудаа хүлээж авна. Хэрвээ 10 сарын 01-нд дахин энэ асуудал давтагдах юм бол манай байгууллага өөрөө шууд шийдвэрийг хүчингүй болгоно.

Хэрвээ тэр шийдвэрийн дагуу тодорхой арга хэмжээ авагдахгүй бол бид шийдвэр гаргасан хүнээс төрд учирсан хохирол буюу тодорхой мөнгөн дүнг өөрөөс нь, хувиас нь төлөх арга хэмжээг авна байна.

Х.Булгантуяа: С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Ц.Цэдэвсүрэн дарга аа, маш их баярлалаа.

Би зориуд энэ яах ёстойг угаасаа мэдэж байгаа. Та бүхэн ямар шийдвэр гарахыг ч мэдэж байгаа.

Энд сууж байгаа бид төрийн албан хаагч нар, төрийн улс төрийн албан хаагч нар шүү дээ. Бид сайд байна уу, Улсын Их Хурлын гишүүн байна уу хуулиа хэрэгжүүлнэ гэдгээ хэдүүлээ ягштал ойлгосон гэдэгт эргэлзэхгүй байна.

Яг энэ эргэлзэхгүй байгаа энэ ойлголт дээрээ Та бүхэн хуулиа хэрэгжүүлээч ээ л гэж байгаа юм. Ийм нөхцөл байдлыг битгий дахиж гаргаач ээ. Үүнээс чинь болоод жирийн иргэд, жирийн төрийн албан хаагчдын итгэл алдаж байна. Алдарч байна. Төрд итгэхгүй. Одоо төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалд нь итгэхгүй гэдэг ийм байдал үүсэж байна.

Тийм учраас би энд ямар нэгэн нэр дурдаагүй. Тэр хүн үүнийг сонсож байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: С.Зулпхар гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Төсөв дээр нийгмийн аудит гэдэг зүйлийг ер нь хэн хийх ёстой юм бэ? Би ийм аудит хийх шаардлагатай байна гэж харж байгаа. 9 хувиар төрийн албан хаагчдыг цомхотгоно, тэтгэмжийг хоёр хуваана гээд нүдэнд харагдахгүй, мөнгөөр хэмжигдэхгүй мөртлөө цаанаа асар их эдийн засаг болон нийгмийн үр дагавартай зүйл гараад байгаа юм.

Түрүүн тэр тэтгэмжийн асуудлыг олон дахин оролдсоноос болоод маш олон төрийн албан хаагч нар ер нь энэ төрд удаан үнэнчээр ажиллах итгэл алдрах вий дээ.

Тэгэхээр ийм мессежийг бид маш их бодолтой өгдөг байх хэрэгтэй.

Тийм учраас төрийн албан хаагчийн залуу зандан насанд нь тогтвортой ажиллах юм бол тэтгэвэрт гарахад чинь 3 жилийн цалин өгнө гэж амлаж ажиллуулчхаад гарах гээд ирэхээр нь хасна, танана, хуваана гэдэг мессежийг олон дахин яримааргүй байгаа юм.

Тийм учраас Б.Жавхлан сайд хоёр, гурвантаа санаа зовох зүйлгүй гэж хэлж байна. Би Засгийн газрын тэргүүн бас үүнтэй санал нэг байгаа байх. Би амнаас нь сонсмоор байна. Цаашдаа Их Хурал ч гэсэн өөрсдөө энэ тал дээрээ.

Хоёрдугаарт, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувийг урсгал зардал дээшээ гаргахгүй гэдэг байдлаар бид түрүү жил ийм хуулийг оруулж ирээд баталсан. Гэтэл дотоодын нийт бүтээгдэхүүнээ нэгдүгээрт бодит тооцож чадаж байна уу, үгүй байна уу?

Хоёрдугаарт, урсгал зардал дотор Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгүүдийг оруулаад урсгал зардал гэж тооцоод яваад байгаа юм. Энэ чинь өөрөө биеэ даасан сан. Харин урсгал зардал дотроо татаас өгч байгаа, төсвөөс өгч байгаа тэр төр даадаг гэдэг юмаа оруулаад явах нь зөв байх.

Түүнээс биш орлогоороо, зарлагаараа нөхөөд явж байгаа, яг ингээд авч үзэх юм бол нийгмийн даатгалын сан уг нь тэнцвэртэй сан байсан.

Тэгээд энэ талаас нь харахгүй бол. Энэ олон өргөдөл, гомдлууд их ирж байна л даа. Багш нар ажил хаялт, тэмцэл хийнэ гээд л өнөөдөр дахиад л нэлээн асуудал болоод л эхэлж байна. Эмч нар араас нь, ахмадууд тэтгэврийн зээл нэмэгдсэн.

Тэгэхээр бид асуудлыг нь шийдэх ёстой юм. Энэ тал дээр төсвийнхөө хуулийн хайчин юунаас гаргахад Засгийн газар өөрөө энэ хуулиа санаачлаад ороод ирэх боломж байна уу? Өөрчлөх.

Хоёрдугаарт, хэрвээ болохгүй гэж байгаа бол гишүүд санаачилъя. Тэгж байж энэ боломж, асуудлуудаа шийдэхгүй 6 хувь яриад суудаг. Ирэх жил цалин нэмэхгүй гээд сууж байдаг гэх юм бол энэ бол нэлээн хүнд сонсогдож байна.

Тэтгэвэр, цалин нэмэхэд ирэх жил 6 хувь гэж тооцож байгаа учраас 6 хувь болж нэмнэ гээд байгаа юм. Уг нь энэ жил чинь 8 хувь. Одоо бараг оны сүүл рүү 9 хувь руу дөхөөд ирэхээр тэр худалдан авах чадварыг нь нөхөх зорилгоор ирэх жил нэмээд, дээр нь боломж байвал бодитоор нэмж байж энэ чинь нэмэлт болно. Тэгж тооцохгүйгээр буруу байдлаар тайлбарлаад байна.

Нэмэлт 1 минутаа авъя.

Х.Булгантуяа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир хариулъя.

36 сар тэтгэвэр, цалин, төрийн албан хаагчдын асуудлууд ярилаа шүү дээ. Харин тийм. Энэ чинь Үйлдвэрчний эвлэлийн Ерөнхийлөгч байсан хүн цалин, тэтгэвэр, нийгмийн баталгааны асуудлыг асуух нь тодорхой шүү дээ.

Та бүхэн хэдхэн цаг анхааралтай суугаад, бичиж аваад, ач холбогдол өгөөд нэг хариулаад өгөөч. Бидний чуулганыг их олон хүмүүс үзээд байх шиг байх юм.

Энд зүгээр харилцан яриа өрнөөгүй байхгүй юу. Үнэнийг хэлэхэд. Одоо тас гээд асуухаар энэ хүн чинь дэгийн тухай хуулиа зөрчих гээд байдаг. Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Тэр 36 сарын тэтгэмжтэй холбоотой асуулт асуух бүрд л би хариулна шүү дээ. Хариулахгүй бол тэнд загнуулна. Би.

Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын санг та маш зөв ярилаа. Танд би маш их талархаж байна.

Одо бид нөгөө “GFS 86” /Government Finance Statistics/ системтэйгээ яваад байгаа юм. Хэрвээ дараагийн систем рүүгээ орох юм бол таны яриад байгаа бүртгэлийн асуудлаас бид ер нь ангижраад зөв бүртгэл рүүгээ яваад орох байгаа юм.

Яах аргагүй 24 их наядын ер нь 17 их наяд нь яг урсгал зардал. Зөрүү тэр 8 их наяд нь яг таны хэлж байгаа энэ сангууд байгаа байхгүй юу. Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан хоёр чинь нийлээд бараг ийм болж байгаа юм. Эрүүл мэндийнх нь 2.2, нийгмийн даатгалынх нь 6.6. Нийлээд 8.8 их наяд болоод ингээд нөгөө 24 их наяд гэдэг тоо гараад ирж байгаа юм.

Тэгээд 24-төө хязгаарлагдаад ингээд ерөөсөө цалин, тэтгэвэр, тэтгэмж энэ юмнууд чинь ерөөсөө цаашдаа нэмэгдэх хязгаар нь маш хүнд болж ирнэ. Ер нь ийм бодлогын орон зай байхгүй болж ирж байгаа.

Тэгэхээр бид дараагийн систем рүүгээ орох. Энэ нэлээн нүсэр ажил л даа.

Тэгэхдээ бид зугтаах арга байхгүй. Эндээ бүх төсвийн ерөнхий захирагч нар, бүх яамд, бүх төсвийн шууд захирагч нар энэ дээр ер нь 2-оос 3 жилийн процесс болно. Энэ шилжилт.

Түүний дараа энэ арай зөв хэлбэр лүүгээ ороод явах учиртай. Энэ сэдвийг би ер нь анх удаа энэ зааланд хөндөж байна шүү. Тийм. Ийм зүйл байгаа. Тийм.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Эрүүл мэндийн салбараас асуухад хүндэрсэн байгаа. Би үүнийг анх энэ эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилт орж байхад хэлж байсан

юм. 500 тэрбумын үлдэгдэл байсан. Бүгдийг нь үрж дуусаж байвал маш сайн гэдэг л концепцоор тухайн үед хандсан.

Тийм учраас одоо Эрүүл мэндийн даатгалын сан нэмж төсөв суулгахгүйгээр биеэ даагаад аваад явахад хүндэрнэ.

Түрүүн Б.Жавхлан сайд бас хэллээ. Хувийн эмнэлгүүдэд баахан санхүүжилт өгөөд улсын эмнэлэг нь өгөөгүй орхисон. Тэгээд өнөөдөр ийм асуудал байна гэж Ж.Чинбүрэн сайд хоёулаа хэллээ. Маш хариуцлагагүй асуудал байна гэж би бодож байна. Үүнийг тодруулж мэдээлэл авъя.

Дараагийнх нь орлого талдаа алт тушаалт 4 жилийнхээ өмнөөс бараг 3 дахин буураад 20 гаруй тонн байсан чинь одоо 8 тонн гэж байх юм. Энэ дээр хамгийн өндөр үнэлгээтэй байгаа алтыг яагаад тушаадаг вэ? Хууль хяналтын байгууллага, Сангийн яам энэ дээр яаж ажилладаг юм бэ? Орлогоо бүрэн авч чадаж байна уу, үгүй байна уу гэдгийг би тодруулж асуумаар байна.

Х.Булгантуяа: Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Алт дээр би хариулъя. Ер нь байна шүү дээ. Монгол Улсын хэмжээнд алтны нийт бүртгэгдсэн нөөцийн хэмжээ Оюу Толгойн зэс, алтны ордыг оруулахгүйгээр 494.3 тонн байдаг юм. 85 хувь нь үндсэн орд. 15 хувь нь шороон орд.

Шороон ордоо үндсэндээ бид ухаад дуусаж байна. Одоо шороон ордын агуулга улам буурч байна. Мөн гүн болж байна. Хөрөнгө оруулалт их шаардагдаж байна. Ээгээд энэ хэрээрээ алт олборлолт буурч байгаа. Нэг.

Хоёрдугаарт, алтны үнэ их огцом өсөөд байгаа учраас тушаалт жоохон удааширч байна.

Гуравдугаарт, бид ерөөсөө хайгуулыг нь зөвшөөрч өгөхгүй байна.

Тэгэхээр бид энэ хайгуулаа л нээж нэмэгдүүлэхээс өөр гарцгүй л ийм байдал руу орно.

Дөрөвдүгээрт, алтны хөнгөлөлттэй зээл, валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд бид арга хэмжээ авах ёстой байгаа. Энэ чиглэлд ажил хийгдээд явж байна.

Хулгай зэлгий байгаад байх шиг байна. Энэ дээр нь би нэмээд хариулчихъя. Хугацаа дуусаж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Г.Дамдинням сайдад нэмж минут өгье.

Г.Дамдинням: Тийм. Улсын Их Хуралд “Алт-3” аяны тогтоол ороод ирсэн байгаа.

Энэ тогтоолын нэг заалт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хориг тавьсан. Бусад заалтууд нь энэ дээр маш их хэрэгтэй байгаа юм.

Ер нь алттай холбоотой асуудал ний нуугүй хэлэхэд хууль хяналтын байгууллагууд, тэгээд бусад оролцогч этгээдүүд, орон нутгийнхан гээд энэ хүмүүс нь нийлээд бүр зохион байгуулалттай л ажиллаад байгаа юм. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хууль бус алт олборлолт болон алтны тушаалтай холбоотой асуудал дээр анхаарал тавиад бидний хүч хүрэхгүй байна.

Тэгээд ойрын үед Засгийн газраар асуудал оруулах гээд л бэлдэж байна. Сая Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаар шалгалт хийгээд дууссан. Одоо дараагийн газруудаараа хийгээд дуусаад ороод ирэхээр нь нэгдсэн тайланг нь гаргаж байгаад шийдвэр гаргана гэсэн ийм ажлууд хийгдээд явж байгаа.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Би түрүүн асуусан. Монголбанкнаас асууя.

Бид Ирээдүйн өв сангийнхаа мөнгийг гадаадын Франц, Английн банкнуудад 3 хувиар хадгалсан. Өөрсдөө буцаад гадаадаас хөрөнгө босгохдоо 7, 8 хувиар авч байгаа. Иргэд 18-аас 19 хувь, бизнесийнхэн 20, 30 хувиар авч байгаа.

Тэгээд энэ эх үүсвэрийг буцааж татаж. Нэгдүгээрт, сая Ерөнхий сайд хэллээ. Тэр моргейжийн зээл рүү хийх. Хоёрдугаарт нь, ахмадын тэтгэврийн зээлийг бууруулах, эх үүсвэрийг нь авчирч ирээд шийдэх ийм боломжийг ер нь эрэлхийлж байна уу? Энэ мөнгө яг хаана байгаа вэ? Ямар банканд байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Дараагийнх нь, барилгын юу хийхэд. Би сая Хөвсгөл аймгаар яваад ирэхэд энэ цэвдэгтэй газар байшин барина гэж ерөөсөө тооцдоггүй юм шиг байна лээ л дээ. 9 удаа тендер зарлаад тэнд нь нэгдүгээрт зам бартаа. Хол.

Хоёрдугаарт, цэвдэгтэй учраас ийм төсвөөр хэн ч ордоггүй.

Тийм учраас тэнд үндсэндээ 40, 50 зуух ажилласан сургууль, цэцэрлэг яг хэвээрээ байж байдаг.

Тийм учраас энэ тал дээр Б.Жавхлан сайд барилгынх нь дахин тэр зураг төсөл дээр нь ажиллах, төсвийг нь тавих боломж байна уу?

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Тэр цэвдэгтэй байна уу, үгүй юу. Нөгөө нэг маягийн зургаар гээд тавиулахаар л ийм зовлон үүсэж байгаа шүү дээ. Та энэ дээр цаашдаа маш үлгэр жишээ гишүүн байгаарай. Нэг маягийн зургаар тавиулдаггүй. Эцсийн магадлан гарахаар тэр чинь нэг маягийн зургийг тэр цэвдэгтэй газар барихад нэг төсөв, Сүхбаатар аймагт барихад нэг төсөв, Баян-Өлгий аймагт барихад нэг төсөв. Бүгд өөр өөрөөр гардаг байхгүй юу.

Тийм учраас дахиж л битгий тийм төсөл, арга хэмжээнүүдийг тавьж байгаарай. Түүнээс л болно. Нэгд.

Хоёрт, “Ирээдүйн өв сан”-г хүмүүс мөнгөжөөд ирэхээр нь янз янзаар хараад эхэлж байгаа юм.

Түүнээс биш энэ 2021 онд би төсөв хүлээж авахад энэ чинь хуулган дээр л байсан мөнгө л дөө. Ингээд 2022, 2023, 2024 онуудад бид ээлж дараатайгаар, шат дараатайгаар мөнгөжүүлээд, 2024 онд 1.3 тэрбум долларын “Ирээдүйн өв сан”-г хойч үедээ яг бэлэн болгож үлдээсэн байгаа. Бэлэн болгосон байгаа. Хуулган дээр нь... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Энэ оны төгсгөл рүү 1.5 тэрбум доллар болно. Хойтон 2.2 тэрбум доллар болно.

Тэгээд энэ мөнгийг одоо ингээд мөнгөжихөөр нь тэнд аваачиж хий, авчирч хэрэглэ гээд байгаа юм. Бас тийм амархан дураараа эд биш шүү энэ чинь. Энд авчраад Хөрөнгө оруулалтын сан руу ч юм уу, ийш нь тийш нь хувьцаа аваад тараагаад хаячихаар энэ чинь Монгол Улсын валютын нөөцөд тооцогдохоо больчихно. Одоо энэ чинь Английн Төвбанк, Люксембургийн Төвбанк дээр 4.3-аас 4.4 хувийн өгөөжтэй байж байгаа. Үүнийг ингээд л юу гэдэг юм нэг том өгөөжтэй компанийн хувьцаанд оруулна. Ёстой мөнгө олно. Алаад өгнө. Түүн шиг худлаа юм байхгүй шүү. Бүр юу ч үгүй болно.

Тэгэхээр хамгийн нэгдүгээрт энд олон улсын стандарт зарчим байдаг юм. Яг ийм баялгийн санг нэгдүгээрт найдвартай байлгах хэрэгтэй.

Хоёрдугаарт, хөрвөх чадвартай байлгах хэрэгтэй.

Энэ хоёр нөхцөл биелбээс өгөөж хайж болно гэж байгаа юм. Өгөөж хайж болно. Ингээд найдвартай байж байх хэрэгтэй. Монгол Улсын валютын нөөц... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайдын ярьж байгаа энэ асуудал чухал шүү.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн даатгалын сангийн мөнгө ч гэсэн яг адилхан орлого олох ёстой юм шиг яриад байдаг. Тийм ээ. Энэ бол найдвартай байх, хөрвөх чадвартай байх нь хамгийн чухал. Ашиг олох нь төрийн ажил яг биш. Ялангуяа татвар төлөгчдийн мөнгөөр богино хугацааны байдаг юм уу, урт хугацааны ашиг олох нь бас яг бидний эрхэм зорилго биш шүү.

Дээрээс нь, үүнийгээ авчирч ирээд бас хамаагүй үрэх, зарахаасаа илүүтэйгээр бид үүнийгээ юу гэж бодоод байна вэ гэхээр байгалийн баялаг бидний өөрсдийн бүтээсэн баялаг биш ээ. Үүнийг бид дараа хойч үедээ үлдээх ёстой. Өөрөө өөрсдийнхөө харин хэмжээндээ. Нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх дээрээ өөрснөө анхаарч ажиллах ёстой гэдэг зарчмыг барьж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид тогтвортой бодлогоо барихгүй бол болохгүй. Олон жил Валютын сангийн зүгээс ч гэсэн Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмж. Үүнийг бид хэрэгжүүлээд явж байгаа нь ялангуяа сая манай зээлжих зэрэглэл сайжирч, энэ олон бондуудыг цаг тухайд нь бид дахин санхүүжүүлэхэд маш их тус нэмэр болсон. Монгол Улс өөрөө хуулиа баримтлаад, хуримтлалаа үүсгээд ингээд бүр гадаадад байршуулаад явж байна гэдэг нь.

Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: 2026 оны төсвийн төсөл дээр бид урсгал зардлаа 2025 онтой харьцуулахад 585.0 тэрбум төгрөгөөр өсгөж байна. Төсвийн алдагдал 1.3 их наядтай. Энэ алдагдлаа бид хүүтэй зээлээр санхүүжүүлнэ гэж ярьж байгаа.

Тэгэхээр заавал урсгал зардал буюу цалин, үйл ажиллагааны зардлаа хүүтэй зээлээр санхүүжүүлэх шаардлага байна уу? Үүнийг бид орлогоо нэмэгдүүлж болно. Эсвэл бид зардлаа бууруулж болно. Ийм байдлаар яагаад бодож олоогүй вэ гэдэг нэг ийм асуулт байгаад байна.

Жишээлбэл, газрын төлбөр байна, газрын дуудлага худалдааны орлого байна. Энэ хоёр нийлээд жилдээ Монгол Улс ирэх жил 170.0 тэрбум төгрөг олно гэж тооцсон байна л даа. Гэтэл бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Барилгын салбарын хамгийн үнэтэй зүйл нь газар худалдаж авах асуудал байгаа шүү дээ.

Тэгэхээр бид газар худалдаж байгаа, газрын дуудлага худалдаанаас олж байгаа орлогоо нэмэгдүүлэх ёстой байсан юм биш үү гэсэн нэг ийм асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь, өчигдөр би бас Н.Учрал сайдаас асуусан. Бид одоо энэ гадаадын зээл, тусламжийн ашиглалт муу байна гээд. Энэ жил 2025 онд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл дээр 240.0 тэрбум төгрөгийг

барилга барихад зарцуулсан юм шиг байгаа юм. Тэгсэн мөртлөө 2026 онд болохоор 70 юм уу, 80 тэрбум төгрөг тавьсан. Яагаад буурч байна вэ?

Миний ойлгож байгаагаар эрчим хүчний төслүүд чинь хамгийн үр ашигтай, өгөөжтэй төсөл гэж ярьж байгаа нь логиктой чинь авцалдахгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг тайлбар өгөөч ээ.

Гуравдугаар асуудал. Засгийн газрын өрийн баталгаан дээр 2026 онд Дорнод аймгийн Дорнод бүсийн эрчим хүчний систем компани нийтдээ 28 орчим тэрбум төгрөгийг төлнө гэсэн байна. Гэтэл өнөөдөр Дорнод бүсийн эрчим хүчний систем компани дээр нүүрстэй холбоотой асуудал үүссэн. “Дорнод Мак” гэдэг компани 2025 онд нүүрснийхээ үнийг бараг хоёр дахин өсгөсөн мөртлөө нүүрсээ нийлүүлдэггүй. Нүүрсээ нийлүүлж чадахгүй бол тэр станц чинь цахилгаан үйлдвэрлэхгүй. Зүүн бүсийг цахилгаан үйлдвэрлэж хангаж байж орлого олж тэрнээсээ зээлээ төлөх ёстой. Үүнийг манай Эрчим хүчний сайд мэдэж байгаа юм уу? Өвөлжилтийн бэлтгэл хариуцсан Шадар сайд С.Амарсайхан мэдэж байгаа юм уу? Энэ талаар хариулт өгөөч.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Л.Соронзонболд гишүүнийхээ асуултад хариулъя.

Бид л ер нь гишүүддээ их буруу, дутуу ойлголт өгөөд байх шиг байна.

Тэгэхээр энэ удаагийн алдагдал маань бүтцийг нь хэдүүлээ нэг жаахан задалж хармаар байгаа юм. Алдагдал юунд зориулагдаж байна, ямар эх үүсвэрээр санхүүжигдэж байна гэдгээсээ өөр өөр байгаа юм.

Тэгэхээр энэ удаагийн алдагдал маань цалингаа тавьж чадахгүй, хүүхдийн мөнгөө тавьж чадахгүй алдагдал үүсэж байгаа зүйл огтоос биш. Цалин, хүүхдийн мөнгө, тэтгэвэр, тэтгэмж бүх юмаа бид татварынхаа орлогоор санхүүжүүлээд, цаана нь бүр ашигтай гарч байгаа.

Энэ алдагдал бол зүгээр бүтээн байгуулалт. Цалингаа тавьж чадахгүй. Гаднаас бонд босгоод зээл аваад тэрийгээ санхүүжүүлж байгаа зүйл огт биш. Саяын таны хэлж байгаа Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, нефть боловсруулах үйлдвэр гэх мэт эдгээр төслүүдийгээ цааш нь зогсоохгүй үргэлжлүүлж явах зээлийн ашиглалтаар гарч ирж байгаа алдагдал байгаа юм. 1.5 их наяд нь.

Тэгэхээр энэ бол арай өөр бүтэц байхгүй юу. Өөрөөр хэлбэл Төрийн сан дээр ямар нэг ачаалал ирэхгүй. Энэ алдагдлыг санхүүжүүлэхийн тулд дахиж зээл авах шаардлага байхгүй. Бонд босгох шаардлага байхгүй. Энэ төслүүд маань өөрөө доллароо чирээд ороод ирэх байгаа юм. Бид ашиглалтаа л энэ төсөв дотроо багтааж байгаа ийм л онцлогтой ийм алдагдал байгаа юм.

Тэгэхээр энэ удаагийн алдагдал дээр нэмж зээл санхүүжих ч гэдэг юм уу, өөр өр төлбөр тавих ямар ч шаардлага байхгүй. Тусгай шаардлагууд дээр бүрэн нийцэж байгаа гэж болно.

Эрдэнэбүрэн дээр. Эрдэнэбүрэн дээр ажлын хэсгээс хариулчих.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос хариулъя. Ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Ж.Дэлгэржаргал. Сангийн яам.

Эрдэнэбүрэн усан цахилгаан станцын хувьд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ЭКСИМ банкны нэн хөнгөлөлттэй зээл байгаа. Үүнээс энэ жил эхэлсэн бид урьдчилгаа төлбөрт 30 хувь буюу 271.0 тэрбумыг энэ жилийн ашиглалтаасаа олгосон.

Ирэх онд 1.5 их наядын ашиглалт дотроо Эрдэнэбүрэн дээр 99.0 тэрбумыг хуваарилсан байгаа.

Нөгөө талдаа улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр эрчим хүчний салбарт нийтдээ 669.0 тэрбумын өртөг бүхий төслүүдийг тавьсны нэг нь 130.0 тэрбум нь Эрдэнэбүрэн усан цахилгаан станцын Мянгад чиглэлийн дамжуулах шугамыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мөн зэрэгцээгээр эхлүүлж байгаа.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Л.Соронзонболд гишүүний нэг асуултад хугацаа хүрээгүй дутуу хариулсан байна шүү. Уучлаарай.

Энэ газрын дуудлага худалдаа болбол орлого нь аймаг, орон нутгийн орлого байдаг юм шүү. Аймаг, орон нутгийн. Улсын төсөв рүү ордоггүй.

Тэгэхээр аймаг, орон нутгаас ирсэн төлөвлөгөөгөөр нь л бид төсөвт оруулж байгаа. Одоо тэгээд нэмж тэр газраа худалд, үүнийгээ худалд гэж бид тэгж зохицуулалт хийж чадахгүй. Энэ бол иргэдийн Хурлаараа энэ төлөвлөгөөгөө оруулаад, нэмж хасаад явдаг зохицуулалттай байгаа шүү.

Х.Булгантуяа: Б.Чойжилсүрэн сайд. Зүүн бүсийн Дорнодын цахилгаан станц. Нүүрсээ нийлүүлэхгүй байгаа асуудлаар.

Б.Чойжилсүрэн: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Л.Соронзонболд гишүүн ээ, энэ МАК компани Дорнодын цахилгаан станцад нүүрс нийлүүлэх асуудлаар маргалдаж явж байгаад сүүлийн өдрүүдэд учраа олсон. Одоо ганцхан асуудал л үлдэж байгаа. Чийгшлийн асуудал дээр маргаан гараад байгаа учраас яамнаас ажлын хэсэг өчигдөр, өнөөдөр

Дорнодын цахилгаан станц дээр ажиллаж байна. Ирэх долоо хоногийн нэг дэх, хоёр дахь гэхэд учраа олох байх гэж бодож байна.

Одоо нийлүүлж байгаа компани цаг хугацаандаа яг чанартай тохирсон нүүрсээ нийлүүлж байгаа. Нэмэлт нүүрсний талаар асуудал яригдаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг.

П.Ганзориг: Бид жил болгоны улсын төсвийг батлахдаа ер нь өнгөрсөн жилийнхээ гүйцэтгэл, хэдэн тоонд баригдаж ярьсаар байгаад л тэгээд салбар болгоны асуудлыг нэг гал унтраасан байдлаар баталсаар ирлээ.

Тэгээд одоо сүүлийн 5 жилийг харах юм бол Монгол Улсын төсөв 2021 онд 12 их наяд байсан. Өнөөдөр бид сүүлийн хоёр, гурван жил 30 гаруй их наядын төсөв батлаад сууж байгаа.

Сүүлийн 5 жилд 130 их наядын төсөв баталсан.

Тэгэхдээ сүүлийн 5 жилд яг энэ өссөнөөрөө айл өрх, аж ахуйн нэгжийн ашиг, орлого энэ хэмжээгээрээ 2.8 дахин өссөн үү гэвэл үгүй. Амьжиргаа сайжраагүй.

Тэгэхээр төсвийн орлого тал гэхээсээ илүүтэйгээр оновчтой зарцуулалт тал дээр асуудлууд байна. Тухайлбал, би Засгийн газраас асуумаар байна л даа. Ер нь энэ олон салбарын асуудлыг бид жил болгон жоохон жоохон гал унтраах байдлаар явбал шийдэж чадахгүй.

Тэгэхээр дорвитойхон нэг салбарын асуудлыг барьж аваад нэг жилийнхээ төсөв дээр хоёр, гурван жил дараалуулж байгаад шийдэх ийм бодлого, стратеги байна уу? Тухайлбал, татварын асуудал нэлээн яригдсан. Одоо ингээд эдийн засаг, төсвийн орлого гээд ярихаар уул уурхай, тэгээд бусад салбаруудаа дэмжиж байна гээд хөдөө аж ахуйд нэг баахан урамшуулал, татаас өгч байна. Үр дүн нь тодорхойгүй.

Тэгэхээр урт хугацаанд энэ тогтвортой ажлын байрыг хадгалах, ажлын байр бий болгох, түүгээрээ дамжуулаад орлогыг нь нэмэгдүүлэх, хувийн хэвшил жижиг, дунд бизнесүүдээ дэмжсэн бодлого оруулж ирж болохооргүй байна уу?

Татварын шинэчлэл дээр ганцхан НӨАТ-ын асуудал орж ирсэн. Халамжаас хөдөлмөр лүү шилжье гээд бүгд ярьдаг мөртлөө яг бодит байдал дээрээ төсөв дээрээ болохоор яг ажлын байр бий болгож байгаа, орлого нэмэгдүүлэх, эсвэл цалин, хөдөлмөр эрхлээд цалин авч байгаа хүмүүсийнхээ татварын дарамтыг бууруулдаггүй.

Тэгэхээр энэ дээр хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бууруулах тодорхой хуулийн төслүүдийг Их Хурлаас

гарсан ажлын хэсэг боловсруулаад тавьсан байгаа. Үүнийг аваад оруулаад ирэх ингээд боломж байгаагүй юм уу? Зөвхөн НӨАТ дээр буюу хэрэглээг дэмжсэн татвар дээрээ 100 хувь 3-аас 4 их наяд төгрөг зарцуулж байгаа. Үүнийгээ хуваарилаад явах боломжгүй юу гэж асуумаар байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өнгөрсөн 2025 оны төсөв баталж байхад Улсын Их Хурлаас 52, 54 дүгээр тогтоол баталсан. Төсөв дагуулаад. Энэ дээр бас төсвийн үр ашиг дээр олон чухал асуудлуудыг судалж, үр дүнг нь танилцуул гэж Засгийн газарт үүрэг өгсөн. Түүний нэг нь төсвөөс олгож байгаа олон төрлийн татаас, урамшуулал. Үүний үр дүнг дүгнэж байж дараагийн оны төсөв дээр татаас, урамшууллаа яаж суулгах вэ гэдгээ шийдэх ёстой.

Гэтэл зүгээр жишээ авахад “Шинэ хоршоо” гээд хөтөлбөрт нийтдээ 2 жилийн хугацаанд 840.0 тэрбум төгрөгийн зээл олгосон. Ирэх жил 500.0 тэрбумыг олгоно гээд төсөв дээр суулгасан явж байгаа. Хүүгийн татаасанд нь төсвөөс 110 орчим тэрбум төгрөг өгнө.

Энэ маань яг ажлын байр бий болгоод байгаа юм уу? Зүгээр импортыг нэмэгдүүлээд, хэрэглээг нэмэгдүүлээд, валютын чинь... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Сүүлийн 5 жилийн макро тоог ярих гэж байгаа бол төсвөөс гадна хэдүүлээ GDP-ээ ярих хэрэгтэй. Хэрвээ сүүлийн 5 жилийн төсвийн нэмэгдсэн тоо нь хэрвээ 130, 140 гэж байгаа бол GDP-г бас ярих хэрэгтэй. 500 их наяд гараад явчихлаа шүү дээ. Сүүлийн 5 жилийн нийт нэмэлт. Ийм эдийн засаг дотор явж байгаа.

Харамсалтай нь эдийн засгийн бүтцээ харах юм энэ чинь уул уурхай байгаа юм.

Тэгэхээр эдийн засгаа солонгоруулаагүй цагт эдийн засгийг тэлсэн энэ бүтэц чинь орлого нь буцаад л нөгөө цөөхөн уул уурхайгаараа л дамжиж орж ирнэ. Тэгээд буцаад задарна. Солонгоруулаагүй цагт ерөөсөө ингэж л шахцалдаж явах байгаа юм. Солонгоруулахын тулд хэдүүлээ дэд бүтэц рүүгээ л оруулах хэрэгтэй. Ерөөсөө шинэ юм бодох хэрэггүй.

Тэгэхээр одоо хөрөнгө оруулалтынхаа бүтцийг харах юм бол зөв чиг хандлага руугаа хэдүүлээ явж байгаа. Үүнээсээ хамаагүй их хазайж попорч байгаад алдах вий. Нэг ийм байна.

Төсвийн зарлага талдаа тантай санал олон зүйлтэй нийлж байна. Татаасуудаа бид яг авч байгаа гол гол салбарууд дээрээ үүнийг нэг тусад нь Их

Хурал нэг сонсоосой. Бүр яг сайд нар энэ дээр маш сайн тайлангуудаа тавьж байгаад үүнийг нэг сонсох хэрэгтэй.

52, 54 дүгээр тогтоолын биелэлтийг бид цаг тухай бүрд нь хугацаанд нь Улсын Их Хуралд хүргүүлсэн. Ингээд хэлэлцэж амжихгүй байсан юм байгаа биз дээ. Хаваржингаа улс төржсөн. Хэдүүлээ. Тэгээд өчигдөр ашгүй Байнгын хороогоор хэлэлцэж эхэлж байна.

Үүнийг шаардлагатай бол Их Хурал дээр ч сонсох хэрэгтэй. Хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын багц хуулийг бид бэлдсэн. Улсын Их Хурал дээрээс гарсан ажлын хэсэг дээр бид танилцуулсан. Хоёр талаасаа саналаа нийлүүлээд ер нь өргөн барихад бэлэн болсон байгаа. Ингээд нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд бид бүгдийг нь авч орж амжихгүй шүү дээ. Болохгүй. Хууль тогтоомжийнхоо хуулиар.

Тийм учраас хамгийн их хүлээлттэй байгаа НӨАТ-ын хэсгээ таслаад аваад орж ирж байна. Төсөв дээрээ. Нөгөө хэсгийг нь сая 9 сарын 01-нд хууль өргөн барьсантай зэрэгцээд, төсвийн хуулиа өргөн барьсантай зэрэгцээд бид D-Parliament дээр нөгөө тоолуураа эхлүүлсэн байгаа. Ингээд 60 хоногийн дараагаас өргөн барих хугацаа нээлттэй болж ирнэ. Тэр үед оруулаад ирнэ.

Ингээд харин энэ өндөр өртөгтэй татварын реформыг 2026, 2027, 2028, магадгүй 2029 гээд ингээд бид шат дараатай бага багаар шингээгээд явна. Тэгэхгүй бол орлого буурч байгаа үед, гадна талд ийм эрсдэлтэй үед ийм хүнд өртөгтэй 3.6, 4 их наядын орлого нөлөөтэй ийм реформыг бид дийлэхгүй. Энэ чинь бүр хямралыг бий болгож болзошгүй учраас хэдүүлээ энэ дээр наанатай цаанатай хандах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Тэр татаас авдаг хөтөлбөрүүдээс та хоршоог асуулаа. Хоршоог хариуцаж байгаа сайд нар нь үүнийг хариулчихвал их сайн байна. Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд.

Х.Булгантуяа: Хоёулаа байдаггүй ээ. Тэгэхээр хэн хариулах вэ? Харин тийм. Хүнс, хөдөө аж ахуйн сайдыгаа дууд л даа. Бид сайд нарыг өдөржингөө суухад хэцүү байгаа гээд яг 6 цагтаа тараад, өдөрт нэг цаг цайны завсарлага аваад явж байгаа шүү дээ.

Түүнээс биш шөнөжин, өдөржин явбал. Та хэд чинь 8 цаг битгий хэл хэдхэн цаг тогтвор суурьшилтай сууж чадахгүй юм чинь 8 цаг бол. Бид танаас өөр хүн үлдэхгүй байх аа, Б.Жавхлан сайд аа. Чуулганы танхимд.

Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хоршоо хариуцсан үндэсний хороо ажилласан. Асуудлыг Шадар сайд С.Амарсайхан хариуцаж байгаа шүү дээ.

Тэгэхээр тэр талын нарийн мэдээллийг энд хариуцсан улсууд нь хэлбэл их зүгээр байна. Хэн асуусан юм? П.Ганзориг асуусан юм уу?

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайдаас тодруулъя. П.Ганзориг гишүүний микрофоныг өгөөрэй.

П.Ганзориг: Энэ олон урамшуулал, татаас, хүүгийн хөнгөлөлт гээд. Үүний үр дүнг тэр 52, 54 дүгээр тогтоолоор нарийн дүгнэлтүүд гаргаж байгаад цаашдаа ер нь нэгдсэн бодлогоор цэгцэлж явахгүй бол энэ их зах замбараагүй явж байгаа зүйл болоод байгаа. Үүнтэй холбоотой бид “Шинэ хоршоо” дээр үр дүн асуусан. Үүнийг Шадар сайдаас дараа нь тодруулъя.

Тэгээд түрүүчийн хариулттай холбоотой би Б.Жавхлан сайдаас асуух зүйл байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, дээр нь нэмээд төрийн өмчит компаниудаар дамжуулаад олон хөрөнгө оруулалтууд хийгдэж байгаа.

Энэ нийт хөрөнгө оруулалтын хэмжээ хэдэн хувь нь хөрөнгө оруулалт, хэдэн хувь нь шууд импортоор авч байгаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ болж байгаа вэ? Энэ маань өөрөө шууд очоод валютын нөөцдөө сөрөг нөлөө үзүүлдэг. Дамжаад инфляц, ханш гээд өдөөгдөөд явдаг. Яг энэ дээр яг нарийн ямар судалгаа байна вэ? Хэдэн хувь нь эргээд эдийн засагтаа үржүүлэгч болоод олон дахин эргэж байгаа байгаа вэ? Энэ дээр... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Манай ажлын хэсгээс тоонууд дээрээ бэлдэж байгаарай. Би ерөнхий зарчмын яг схем, бүтцийг нь хэлээдэхье.

Бид Улсын Их Хуралд улсын хөрөнгө оруулалтын тухай хуулиуд өргөн барьсан байгаа. Энэ яг таны саяын хэлж байгаа үүнтэй холбоотой асуудал байгаа юм шүү. Одоо бид цаашдаа ер нь хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд маань маш олон эх үүсвэртэй болж ирж байна. Яг сая таны хэлдэг.

- ▶ Улсын төсвийн хөрөнгө оруулалт.
- ▶ Төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалт.
- ▶ Гаднын шууд хөрөнгө оруулалт.
- ▶ Төр, хувийн хэвшлийн түншлэл.
- ▶ Дотоодын хөрөнгө оруулалтууд гээд.

Ингээд маш олон эх үүсвэрүүдтэй болж ирж байна.

Тэгэхээр цаашдаа энэ дээр суурилсан судалгаануудаа маш их нарийвчлах хэрэгтэй. Үүнийг яг таны хэлсэнчлэн макро шийдвэр гаргахдаа үүнийг маш сайн тооцдог болох хэрэгтэй байна. Ялангуяа төлбөрийн тэнцэл дээр. Бид бүх тоогоо авч харж чадахгүй байгаа.

Тэгэхдээ хөрөнгө оруулалт болгон төлбөрийн тэнцэл дээр хасах дарамттай гэж бас ойлгож болохгүй.

Х.Булгантуяа: 4 номерын ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя. Ж.Дэлгэржаргал. Сангийн яам.

Ер нь нэг барилгын нийт төсөвт өртгийн 43 хувь нь барилгын материалын зардал байдаг. Бусад нь цалин, НӨАТ гээд явдаг. Тээвэр. Энэ 43 хувийн судалгаагаар зүгээр дунджаар 34 хувь нь дотоодын барилгын материалын хэрэгцээгээр хангагддаг. Үлдсэн хувь нь импортоос орж ирдэг гээд. Энэ бүтэц маань өөрөө барилга, байгууламж, эрчим хүчний салбар, зам тээврийн салбар дээр харилцан адилгүй.

Магадгүй зам тээврийн салбар дээр материалын зардал нь барилгаас арай өндөр байх ийм тооцоололтой байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая.

Улсын төсвийг бүтэн өдөр манай гишүүд олон талаас нь нэлээн сайн ярилцаж байна. Өнгөрсөн хавар Улсын Их Хурлаар дэгийн хуульдаа өөрчлөлт оруулаад төсвийг 5 хэлэлцүүлэгтэй болсон. Энэ танилцуулга, хэлэлцүүлэг нэлээн гайгүй үр дүнтэй явж байгаа юм байна.

Энд яригдсан энэ олон сайхан асуудлуудыг яаж энэ бодлогын шийдэл гэдэг юм уу, энэ юмандаа биежүүлж авах юм гэдэг асуудал л эзэнгүй үлдэж байгаа даа.

Ер нь Улсын Их Хурал ямар ч хуулийг хэлэлцэхдээ хэлэлцэх эсэх асуудал дээр гишүүдээс маш олон гоё санаанууд гарч ирдэг. Тэрийг ерөөсөө хэлэлцүүлгийн дараагийн шатуудад анхаарахгүй байгаа.

Уг асуудал ярьсан гишүүн өөрөө идэвх санаачилга гаргаж, зарчмын зөрүүтэй санал гаргавал л сая нэг юм шийдвэрт биежих нөхцөл хангагдаж байгаа. Бусад нь бүгд агаарт сарниж байгаа.

Тэгэхээр үүнийг яаж засах юм гэдэг юмаа Их Хурал, манай холбогдох Байнгын хороод бас анхааралдаа авсан дээрээ. Энэ их цаг зарцуулж ажиллаж байж үүнийг бас нэг жоохон зөв болгомоор байна гэж.

Хөдөө аж ахуйн салбараа хэдүүлээ сайхан дэмжиж байгаа. Манай гишүүддээ би баярладаг. Гэхдээ байгаль дэлхий нэг цагаараа ч байхгүй л байна л даа. Энэ жил ган гачигтай амаргүй л байна. Хэдэн тариаланчид чинь ер нь байдаг мөнгөө газарт хийгээд, халуун наранд цуг шатаачихлаа. Ирэх жил тариалалт хийх ёстой, бид хэд.

Энэ төрийн бодлого тогтворгүй байгаа нь хөдөө аж ахуйн салбарт гай тариад болж өгөхгүй байгаа юм. Тэр гаалийн татварыг чөлөөлсөн хуулийг оройтож бид хүчингүй болгосон ч гэсэн тариаланчдын урам зориг сэргэж, уринш маш их боловсруулалт хийсэн. Ирэх жилд тариалалт хийх хөрсний боловсруулалт буюу уриншаа хийсэн. Одоо түүн дээр юу тариулах юм. Үр хаана байна. Дэмжлэг хаана байна гээд олон асуудлууд байна. Үүнийг төсвийн хэлэлцүүлэг дээр нэлээн тодорхой болгох ёстой. Хөдөө аж ахуйн сайд энэ чиглэл дээр ер нь ямар бодлого чиглэл барьж ажиллаж байна вэ гэдэг нэг ийм зүйлийг зориуд би тодруулж асуумаар байна.

“Хүнсний хувьсгал”-ын хүрээнд 2 том нөөцийн тухай ярьсан.

- Нэг нь, стратегийн нөөц.
- Нөгөөдөх нь, технологийн нөөц гэж.

Хамгийн хэрэгтэй нөөцөө бид бүрдүүлж чадахгүй байгаа. Үрийн нөөц бүрдүүлэлтийн асуудлыг хийхгүй байгаа явдал энэ эрс тэс уур амьсгалтай, уур амьсгалын өөрчлөлт хүчтэй явагдаж байгаа энэ улс оронд бид газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах, дотоодоосоо гурил, гурилан бүтээгдэхүүн, ногооныхоо хэрэгцээг хангахад төвөгшил үүснэ.

Энэ алдааг бид засмаар байна. Энэ дээр ямар бодлого юу байна гэж. Дараагийн нэг асуумаар байна. Б.Жавхлан сайд хариулах юм болов уу? Э.Бат-Амгалан сайд хариулах юм болов уу?

Дуусаагүй барилгууд байгаад байх юм. 80, 90 хувьд хүрсэн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг дуусгах бодлого төсвийн хуулиараа нэгдүгээр эрэмбэд байдаг.

Яг энэ оны хувьд өнгөрсөн онуудад бид эхлүүлсэн төслүүдийг нэлээн дуусгасан. Одоо яг өмнөх онуудад эхлүүлсэн дуусах төслүүдтэй холбоотой

үргэлжлүүлэх санхүүжилтүүд дандаа тусгагдаагүй санхүүжилтүүд нэмэлт санхүүлт байгаа.

Тэгэхээр энэ нэмэлт санхүүжилт дээр Их Хурлын тогтоолын дагуу магадлал нь гарсан ч гэсэн яг Үндэсний аудитын газар нягтлуулах процессууд хийгдэж байгаа. Өргөн барихын өмнө ирсэн нийтдээ 194.0 тэрбум дээр 100 төслийн нэмэлтийг бид тусгаж шийдвэрлэгдсэн. Одоо ирээгүй, манай Сангийн яамнаар хянуулахаар хүргэгдсэн цаана нь 500 гаруй тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийн асуудал байгаа.

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя. Тариа ногоотой холбоотой.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Улсын Их Хурлын баталсан бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд баталсан төсвийн хүрээнд л үйл ажиллагаа явуулж байгаа. Боломжийн татаас дэмжлэгүүд энэ салбарт хэрэгжиж байгаа. Үр дүнгүүд гарч байгаа.

2026 оны тухайд 2025 оноосоо нэлээн багасаж өргөн баригдсан байгаа. Үрийн асуудал дээр онцгой анхаарах ёстой. Энэ жилийн цаг уурын өөрчлөлт зөвхөн Монгол Улс биш дэлхий ертөнц ер нь цаг уурын эрс өөрчлөлтөд хөдөө аж ахуйн салбарууд нэлээн нэрвэгдлээ.

Улс орнууд хөдөө аж ахуйн салбартаа дотоодын нийт бүтээгдэхүүний 1-ээс дээш хувийг, 1-ээс 5, хувийн татаас, дэмжлэгийг үзүүлж явж байна. Манай Монгол Улсын хувьд бидний олгоод байгаа зээл, тусламж маань өөрөө 0.1 хувьтай л дөнгөж байгаа.

Гэхдээ “чамлахаар чанга атга” гэж энэ хэрэгжсэн бодлогууд үр дүнгүүд гараад, салбар нэлээн урам зориг ороод хийе, бүтээе гэсэн ийм хандлага нэлээн бий болж байна.

Ингээд газар тариалан нь босоод ирэхээр түүнийгээ дагаад туслах аж ахуйнууд гахай, тахиа, өндөг, сүү, зөгийн аж ахуйнууд босож байна. Тэжээлийн үйлдвэрүүд бий болж байна. Зөвхөн улаан буудай, үр тариа биш бусад төрлийн тэжээл, ялангуяа экспортын чиг баримжаатай тэжээлийн таримлууд нэмэгдэж байна. Мал аж ахуйгаа эрсдэлээс хамгаалахын тулд тэжээлийн ургамал тарилтууд нэмэгдэж байна. Бусад хүлэмжийн буюу дөрвөн улирлын аж ахуй эрхлэх сонирхлууд бий болж.

Ер нь манай Их Хурлын бодлогоор баталсан хөрөнгө оруулалтын ашиглалтууд нэлээн өндөр. Өгөөж сайтай. Аж ахуйн нэгжүүдэд ажлын байр бий болгосон үзүүлэлт гарч байна. Зөвхөн нэг жилийн хугацаанд тэр 45 мянган ажлын байр энэ бодлогуудын үр дүн нь бий болоод, аж ахуйн нэгжүүд дотоодын хөрөнгө оруулалтууд идэвхжээд яваад байна.

Байгаа төсөв бол нэлээн дутуу. Ирэх жил бид нарт 20-оод мянган тонн үр тариа авах хэмжээний л нөөцтэй төсөв өргөн баригдсан. Шаардлагатай бол үрийн бодлогыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс шийднэ гэж Засгийн газар дээрээ бид тохирсон байгаа. Аль болох л дотроосоо нэг хангах гээд үзнэ.

Тэгээд дутагдлыг Засгийн газрын нөөц хөрөнгө дээр тусгаж тэр үрийн болон импортын улаан буудайн тогтворжуулалтыг шийдэх бололцоотой гэж бид засаг дээрээ ярьж тохирсон байгаа.

Х.Булгантуяа: Ж.Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Төсвийн хэлэлцүүлгийн үед нэмж тодруулах юмнууд гарах байх.

- Улаан буудай бараг 30 гаруй мянган тонн үр дутах юм байна.
- Төмс бараг тэр чигтээ үр дутагдах хэмжээнд очлоо.
- Тэжээлийн ургамал бараг тэр чигтээ үрийн дутагдалд орлоо.

Тэгэхээр бид үрийн бодлого дээр их том анхаарал хандуулж, тэр зах зээлийнх нь жаяг, хуулиар нь хангалтынх нь асуудлыг бий болгох. Түүнд нь жоохон богино хугацаатай дэмжлэгүүд үзүүлэх тухай асуудал байх юм байна. Үүнийг би Хөдөө аж ахуйн яамыг анхаарч ажиллана болов уу гэж бодож байна.

Дараагийн нэг зүйл. Тэр дуусаагүй үйлдвэрлэл дээр тодорхой юм ярья. Ерөнхий юм яриад яах вэ. Эрдэнэсант сумд Эрүүл мэндийн төвийн өргөтгөл баригдаж байгаа юм. 805.0 сая төгрөг дутаад байдаг. Үүнийг дуусгамаар байдаг. Үүнийг анхаарах бололцоо юу байдаг бол?

Дээр нь, Төв аймгийн төв Зуунмодод угсаатны болоод археологийн нэг том музей, улсын хэмжээний музей баригдаж байгаа. Түүнд тодорхой хөрөнгө дутаж байгаа юм... /минут дуусав/

Х.Булгантуяа: Боловсролын сайд. П.Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: Надаас юм асуугаагүй.

Х.Булгантуяа: Соёлын сайдаас байсан уу?

П.Наранбаяр: Тийм.

Х.Булгантуяа: Ч.Ундрам сайд хариулъя.

Ч.Ундрам: Төв аймгийн угсаатны музейн барилга баригдаад гүйцэтгэл нь 80 хувьтай явж байгаа. Тэгээд үлдсэн хөрөнгийг нь энэ жил төсөвт тусгуулахаар

санал Сангийн яаманд хүргүүлсэн. Гэвч манай төсвийн хязгаар болон Засгийн газрын дэвшүүлж байгаа бодлогоос улбаалаад энэ жил өргөн баригдсан төсөвт тусгагдаагүй байгаа.

Гэхдээ нэгэнт баригдаад явж байгаа барилга учраас бид боломж байвал үлдэгдлийн төсөвт тусгуулаад явах хүсэлт салбарын хувьд байгаа.

Х.Булгантуяа: Ж.Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн яамны барилга, байгууламжийн талаар ярьсан уу? Тийм ээ. Тийм. Гишүүдээс ярьсан юуг саналаа өгсөн.

Тэгэхдээ энэ нөгөө шалгуураар явсан. Би одоо эндээс яг хаана байна гэдгийг нь яаж байгаад танд тусгайлан хэлье.

Х.Булгантуяа: Ж.Батжаргал гишүүн нэмж тодруулна.

Ж.Батжаргал: Тэр хэдийгээ тодруулгаар авъя.

Дээр нь урьд өмнө нь ер нь бараг тогтмол ойлголт болсон зүйлүүдийг хэдүүлээ энэ удаа эвдэмгүй байгаа юм. Төсвийн хүрээний мэдэгдлээрээ өсөлт, инфляц энэ тэрээ тодорхой тоо заасан бол буцаагаад тэр хүний худалдан авах чадварыг хадгалахын үүднээс тэр тэтгэвэрийг нь яг тэр түвшинд нь баримаар байна.

Тэгээд үүнийг би төсвийн ажлын хэсэг дээр ярина. Тооцоо, судалгааг нь хийсэн. 60 хэдэн тэрбумын тухай асуудал гарч ирж байна лээ. Үүнийг шийдэж өгөх ёстой. Одоо бид аль болгон энэ чинь өөрсдийнхөө хариуцлагагүй ажилласан ажиллагааг ард түмний нуруун дээр үүрүүлэх вэ дээ. Энэ инфляц гэдэг үндсэндээ тийм л үзэл санаа шүү дээ.

Хүний карманд байгаа мөнгөний худалдан авах чадвар нь тогтвортой хадгалагдаж байх тухай л ойлголт байх ёстой. Үүгээрээ амьдралын чанар нь өөрөө хадгалагдаж явах ёстой. Тэгээд энэ талаасаа асуудалд хандах ёстой. Нэгэнт тогтсон ойлголтыг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Батжаргал гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүд ээ, 18.00 цаг болсон байна.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс, олон нийтийн зүгээс ч гэсэн төсвийн хэлэлцүүлгийг олон нийтийн анхаарлын дунд явуулах зорилгыг тавьж байгаа.

5 үе шаттайгаар анх удаа энэ жилээс авхуулан төсвийг хэлэлцэж байгаатай холбогдуулан 18.00 цагт өнөөдрийн чуулганы хуралдаан дуусаж байна.

Маргааш үлдсэн 20 гаруй гишүүд үргэлжлүүлж 2026 оны төсвийн төсөлтэй холбогдуулан асуулт асуухаар нэрээ өгсөн гишүүд үргэлжлүүлэн асуулт асууна.

Ийнхүү өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөлөө. /алх цохив/

Хуралдаан 6 цаг 51 минут үргэлжилж, 18 цаг 02 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД